



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРООНЫ ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ,
ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

ШИЙДВЭР
СУДАЛГАА

Улаанбаатар хот
2018 он

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРООНЫ
ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ
ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2018 он

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Global Affairs
Canada

Affaires mondiales
Canada



The Asia Foundation

Энэхүү эмхэтгэлийг Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр "Азийн сан"-аас хэрэгжүүлж буй "Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд хэвлэн гаргав.

АГУУЛГА

Өмнөх үг	3
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 02	8
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 03	13
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 04	19
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 06	23
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 07	25
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 16	28
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 10	31
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 13	33
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 15	35
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 18	37
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 19	39
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 30	45
2015 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 32	49
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 17	57
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 20	60
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 07	67
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 05	70
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 09	77
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 02	79
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 16	82
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 17	86
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 19	88
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 21	92
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 25	95
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 26	98
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 28	100
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 27	103
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 32	107

2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 33.....	110
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 34.....	113
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 35.....	118
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 36.....	123
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 37.....	127
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 39.....	133
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 40	137
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 04	140
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 06	147
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 07	149
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 12.....	152
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 17.....	158
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 18	161
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 19	166
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 20	174
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 22	180
2016 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 34	184
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 27.....	187
2017 оны Бүрэлдэхүүний тогтоол Дугаар 26.....	192
Хуульчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ.....	195

ӨМНӨХ ҮГ

Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо нь 2013 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулагдаж 2014 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн албан ёсоор гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан.

2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Азийн сангийн дэд суурин төлөөлөгч Диана Фернандезтай хамтран ажиллахаар “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд хоёр тал хуульчийн ёс зүй ба мэргэжлийн хариуцлагын талаар судалгаа хийж судалгааны дүнд үндэслэн зөвлөмж гаргах, хуульчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, түүний шийдвэрлэлтийн талаар судалж, зөвлөмж гаргах, олон нийтэд сурталчилах зэрэг ажлыг хийхээр тохиролцсоны үндсэн дээр энэхүү этхэтгэлийг толилуулж байна.

Мэргэжлийн хариуцлагын хороо 2014-2017 онд давхардсан тоогоор нийт 933 хуульчид холбогдох 791 гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгах ажиллагаа явуулж 14.8 хувийг харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлж, 40 гаруй хувьд маргаан үүсгэсэн, 45.1 хувьд нь маргаан үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн.

Хуульчийн мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан гэж иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс 2014 оноос 2017 оныг дуустал гаргасан гомдлыг шалгаж Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шийтгэл ногдуулсан тогтоол шийдвэрийг нийтийн хүртээл болгож эмхэтгэн гаргалаа.


Энэхүү эмхэтгэл нь хуульчийн ёс зүйн асуудалтай холбоотой хорооны шийдвэрийг олон нийтэд хүргэх таниулах, хуульчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зэрэг зорилготой.

Эмхэтгэлд багтсан сахилгын шийтгэл ногдуулсан хэргүүд нь хуульчийн ёс зүй, хариуцлагатай холбоотой хууль тогтоомжийг боловсруулах, боловсронгуй болгох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтын гарын авлага болгоход дөхөм болно.

Санамж бичгийн хүрээнд бидний санал санаачлагыг дэмжин хамтран ажиллаж туслалцаа үзүүлсэн Азийн сан, Азийн сангийн суурин төлөөлөгч, дэд төлөөлөгч, Засаглалын хөтөлбөрийн менежер А.Баянмөнх, Засаглалын хөтөлбөрийн ажилтан А.Мандухай нарт баярласан талархсанаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



Т.ГАНБААТАР

ШИЙДВЭРИЙН
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН
ХОРООНЫ
ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хуульч Г.М-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Д.Оюунбат даргалж, гишүүн Б.Бат-Орших, Ө.Одгэрэл, Э.Ариунаа, Л.Амарсанаа нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд нээлттэй явуулж Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс Г.М-д холбогдуулан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгуулах” тухай дүгнэлт үйлдэж ирүүлснийг 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Хуралдааны хэлэлцүүлэгт дараах баримтуудыг хэлэлцүүлэв.

Үүнд: Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ:

Хариуцагч Г.М нь хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2, 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан санаатай гэмт хэргийг үйлдсэн нь тогтоогдсон тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт зааснаар Г.М-н хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгуулах шийдвэр гаргуулах дүгнэлтийг гаргаж байна гэв.

Хариуцагч тайлбартаа: Би 2010 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс аймгийн прокурорын газарт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокуророор томилогдож 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл ажилласан. дүүргийн шүүхийн 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн дугаартай шийтгэх тогтоолоор надад Эрүүгийн хуулийн 268.1, 245.2 дахь хэсгүүдэд зааснаар 1 жил 1 сарын хорих ял оногдуулж тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж шийтгэсэн. Миний бие 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 7 сар 19 хоногийн ял эдлээд 2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 5 сар 11 хоногийн ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан. Энэ үеэс миний биеийг үндсэн ялыг бүрэн эдэлж дууссан гэж үзэх бөгөөд нэмэгдэл ялын хугацааг эндээс тооцогдож эхлэх хуулийн зохицуулалттай. Иймд нэмэгдэл ялыг 2014 оны 1 дүгээр сарын 23-аас 2015 оны 1 дүгээр сарын 23-ны хооронд 1 жилийн хугацаанд үргэлжлэн эдлэгдсэн гэж үзнэ. Мөн тэнссэн 5 сар 11 хоногийн хорих ялын хугацаа дууссан. 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан ял шийтгэлтэй байх хугацаа үргэлжилж байгааг ойлгож байна.

Би 2014 оны 3 дугаар сард Хуульчдын холбоонд хандаж хуульчаар ажиллах эрх авахаар хүсэлт гаргахад УДШ-д хандахыг зөвлөсөн тул УДШ 2014 оны 3 дугаар сард өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрх нээж өгсөн. Гэвч би өнөөдрийг хүртэл өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулаагүй. Би болоод бидний ах дүү нар гүтгэгдэж шийтгүүлсэн талаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хандахаар бэлтгээд байна. Дээрх байдлыг харгалзан үндсэн болон нэмэгдэл ялаа эдэлж дууссан байдалд дүгнэлт хийж хуульчаар ажиллах эрхийг хэвээр үлдээж өгөхийг маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнээс хүсэж байна гэжээ.

Улсын Ерөнхий прокурорын 2010 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 71 тоот тушаалд “Г.М-г 2010 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс Дорнод аймгийн прокурорын газарт хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан хяналтын прокуророор томилсугай” гэжээ.

МУ-ын Ерөнхий прокурорын 2013 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн Б/93 дугаартай тушаалд “..... аймгийн прокурорын газрын мөрдөн байцаах ажиллагааны тусгай хяналт хариуцсан хяналтын прокурор Г.М гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлсэн байх тул Прокурорын байгууллагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4, 44 дүгээр зүйлийн 44.1.4, 44.6, Прокурорын сахилгын дүрмийн 1 дэх хэсгийн 1.3.3 дахь заалт, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2013 оны тоот шийтгэх тогтоолыг тус тус үндэслэн аймгийн прокурорын газрын мөрдөн байцаах ажиллагааны тусгай хяналт хариуцсан Г.М-г 2013 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон прокурорын үүрэгт ажлаас халсугай” гэжээ.

МУ-ын Дээд шүүхийн тамгын газрын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5/3214 тоот албан бичигт “Г.М нь УДШ-ийн тамгын газрын даргын 31 дүгээр тушаалаар 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдөр өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэж..... дугаарт бүртгэгдсэн байна” гэжээ.

Хуульч сонгон шалгаруулах хуульд заасны дагуу авсан хуульчийн дугаартай гэрчилгээнд “Г.М нь 2007 оны хуульчдын сонгон шалгаруулалтад тэнцсэн тул гэрчилгээ олгов. 2008 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр” гэжээ.

Монголын Хуульчдын холбооны албан бичигт “Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Г.М нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөн журмын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны А/160 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар хуульчдын нэгдсэн бүртгэлийн 2746 дугаарт бүртгэгдсэн байна” гэжээ.

..... дүүргийн шүүхийн 2013 оны 6 дугаар сарын 27-ны дугаартай шийтгэх тогтоолд “Г.М-ийг хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлахгүйгээр хээл хахууль авсан, мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн гэм буруутайд тооцсугай, Г.М-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268.1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж нэг жил нэг сарын хугацаагаар хорих ял, 245.2 дахь хэсэгт зааснаар хуульчийн Мэргэжлийн үйл

ажиллагаа эрхлэх эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж нэг жилийн хугацаагаар хорих ял шийтгэж Эрүүгийн хуулийн 57.1 дэх хэсгийг журамлан хөнгөн ялыг хүндэд нь багтааж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар хасаж 1 жил 1 сарын хорих ялыг биечлэн эдлүүлсүгэй” гэжээ.

ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 2А/91 тоот албан бичигт “Г.М нь хорих дугаар ангид биеэр 6 сар 26 хоног, шагналын 23 хоног бүгд 7 сар 19 хоногийн ял эдэлж 2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 5 сар 11 хоногийн ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан байна” гэжээ.

Хариуцагч прокурорын байгууллагат хэрхэн ажиллаж байсан болон эрүүл мэндийн байдал муу байгаа талаар 53 хуудас баримтуудыг тайлбартаа хавсаргаж ирүүлжээ.

Мөн хариуцагч шүүх хуралдаанд оролцохгүй тухай тодорхойлолт гаргасан байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс “Г.М нь хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа санаатай гэмт хэргийг үйлдсэн үндэслэлээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар” дүгнэлт гаргасан ба хариуцагч Г.М “хилс хэрэгт шийтгүүлсэн, дахин шалгуулах гэж байгаа тул дүгнэлтийг зөвшөөрөхгүй” гэж тайлбарлаж байна.

Г.М нь 2010 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс....аймгийн прокурорын газарт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокуророор ажиллаж байхдаа гэмт хэрэгт холбогдож дүүргийн шүүхийн 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн дугаартай шийтгэх тогтоолоор хээл хахууль авсан, мөрдөн байцаалтын ажиллагаанд албан тушаалын байдлаа ашиглан санаатай саад учруулсан гэм буруутайд тооцогдож Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг, 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт тус тус зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж 1 жил 1 сарын хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, 7 сар 19 хоногийн хорих ялыг биечлэн эдлээд 2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 5 сар 11 хоногийн ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан, эрх хасах нэмэгдэл ялын хугацаа 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр дууссан, ялтай байх хугацаа 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл үргэлжилж байгаа нь дүүргийн шүүхийн шийтгэх тогтоол, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдрийндугаартай магадлал, УДШ-ийн 2013 оны 11 дүгээр сарын 06-ны дугаартай тогтоолын хуулбараар тогтоогдсон.

Хариуцагч нь хуульчдын холбоонд гишүүнээр элсэж мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахын өмнө /хуульчаар ажиллаж байхдаа/ гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн нөхцөл байдал тогтоогдож байгааг дүгнэхэд:

- Г.М нь УДШ-ийн тамгын газрын даргын 31 дүгээр тушаалаар 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдөр өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэж дугаарт, Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны А/160 тоот тушаалын 1 дүгээр

хавсралтаар хуульчдын нэгдсэн бүртгэлийн дугаарт тус тус бүртгэгдсэн нь МУ-ын Дээд шүүхийн тамгын газрын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн тоот, Монголын Хуульчдын холбооны 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 2/1096 тоот албан бичгүүдээр нотлогджээ. Иймд Г.М нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан "хуульч"- д тооцогдсон.

- Хариуцагч нь Хуульч сонгон шалгаруулах хуульд заасны дагуу 2007 оны хуульчдын сонгон шалгаруулалтад тэнцэж хуульчийн дугаартай гэрчилгээг 2008 оны 1 дүгээр сарын 10 ны өдөр авсан, тус гэрчилгээг үндэслэн өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэж, хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байх тул Г.М-ийн хуульчаар ажиллах эрхийг 2008 оны 1 дүгээр сарын 10-наас хойш тасралтгүй үргэлжилж байгаа гэж үзнэ.
- Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 1.4 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтад "өмнө нь хуульчийн зөвшөөрөлтэй байсан этгээдэд өмнө явуулсан үйл ажиллагаатай нь холбогдуулж сахилгын шийтгэл оногдуулна" гэж заасан.

Иймд хариуцагч Г.М-ийн зөрчилд хариуцлага тооцох асуудлыг хэлэлцэх үндэслэлтэй болно.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.2 дахь заалтад "Хуульчдын холбоонд гишүүнээр элсэх өргөдөл гаргахдаа ял шийтгэгдэж байгаагүйг нотлох цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг хавсаргана" гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.1.1 дэх заалтад "санаатай гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, эсхүл авлигын болон албан тушаалын хэрэгт буруутгагдаж хууль зүйн хариуцлага хүлээсэн өргөдөл гаргагчид мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзана" гэж тус тус заасан байгаа нь санаатай гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд хуульчаар ажиллаж мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүйг тодорхойлж байна.

Мөн хариуцагч нь хуульчаар ажиллаж байхдаа гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл хүлээсэн нь хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагат сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэхгүй байх тухай Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.2 дахь хэсгийн заалт болон мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, нэр хүндээ эрхэмлэх, хууль дээдлэн ажиллах тухай Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.4, 1,12-ын заалтад тус тус харшилж байна.

Иймд Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн сахилгын шинжээчийн дүгнэлтийг үндэслэлтэй гэж дүгнэв.

"Хуульчаар ажиллаж байхдаа санаатай гэмт хэрэг үйлдсэн" нь хүнд зөрчилд хамаарах тул Г.М-ийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгох үндэслэлтэй болно.

Хариуцагч маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд өөрийн биеэр оролцохгүй тухай бичгээр тайлбар гаргасныг тэмдэглэе.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйл, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 1-5 дахь заалтууд, 6.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэг, Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус зааснаар Б овгийн Г.М-ийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгосугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
3. Хариуцагч эсхүл сахилгын шинжээч бүрэлдэхүүний тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хороогоор дамжуулан давж заалдах гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хуульч Б.Б-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Б.Ундрах даргалж, гишүүн Г.Алтанчимэг, Т.Баярсайхан, Т.Өсөхбөяр, Д.Цэндсүрэн нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс 2015 оны 2 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн, хуульч Б.Б-д холбогдох дүгнэлтийг хянан хэлэлцэв.

Хуралдаанд:

Шинжээч Г.Должинсүрэн,

Гомдол гаргагч Х.М нар оролцож,

Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга Б.Алтаншагай хөтлөв.

ТОДОРХОЙЛОХ НЬ :

Х.М нь Мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн гомдолдоо: Миний хүү М.Г. шүүхээс 2 жилийн хорих ялаар ял шийтгэгдсэн юм. Давж заалдах шатны шүүх ялыг нь хэвээр баталсан. Б.Б өмгөөлөгч Дархан хотод явж байхдаа бидний таньдаг хүнээс энэ талаар олж мэдсэн байдаг. Тэгээд хүүтэй минь уулзаад “Дээд шүүхэд би чамайг өмгөөлж, баталгаатай гаргаж чадна” гэж хэлсэн байсан. Би хүүтэйгээ очиж уулзах үед хүү маань “та энэ хүнийг өмгөөлөгчөөр аваарай би таны утасны дугаарыг өгсөн байгаа” гэж хэлсэн. 2014 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Б.Б нь над руу утсаар ярьж манай гэрт 12.00 цагийн үед ирсэн. Тэгээд “...би, аймагт прокуророор ажиллаж байсан... Дээд шүүхэд миний найзууд нэг ангийн хүмүүс бий... 5 сая төгрөг өгчих...” гээд н.Н зэрэг гурван хүний нэр хэлсэн. Би 5 сая төгрөгийг хүүг маань гаргаж өгөөд ав гэсэн утгатай зүйл хэлэхэд “..эхлээд 2.5 сая төгрөг авна, мөнгийг Дээд шүүхийн найз нартаа өгнө..хамт хоол идэнгээ яаж зохицуулахаа ярьж тохирно...” гэж байсан. Тэр өдрийнхээ 13 цагийн үед өмгөөлөгч Н.Н-ын өрөөнд очиж гэрээ хийсэн. Гэрээ хийсний дараа мөнгө авна гэсэн тул би тэтгэвэрийн зээл авсан. Би хаана уулзах талаар асуухад Их дэлгүүрийн гадаа байдаг асарт хүрээд ир гэхээр нь очиж 2.5 сая төгрөгөө өгсөн. Тэрээр “...одоо 16.40 болж байна амжих юм байна...” гэж байсан. Б.Б мөнгөө аваад явах үед нь би араас нь холхон дагаж явсан чинь Дээд шүүхийн байшин руу биш Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын баруун талд явж байсан удалгүй өөдөөс гараад ирсэн. Тэгээд “...та яаж яваа юм...” гэж надаас асуухаар нь би “Н.Н. өрөөнд очно...” гэж хэлээд зөрж явсан. Тэр орой Б.Б над руу утсаар залгаад “...хүмүүстэйгээ хоол идээд яаж зохицуулахаа ярилцаад сууж байна...” гэж байсан. Түүнээс хойш утсаар ярих үед “...та санаа зоволтгүй тохирсон байгаа...” гэдэг байсан.

Энэ үед хүүгийн маань өргөдлийг Дээд шүүхээс буцаачихсан дахин бичих гэж байсан үе л дээ. 6-р сарын 20-ны үед Дүүргийн шүүхээс хэрэг буцаж ирсэн, одоо архивт хийх гэж байгаа тухай дуулаад би Б.Б-ай ярихад "...би сая Дээд шүүхээс гараад явж байна 3 хоногийн дараа шүүх хурал болно..." гэж хэлэхэд нь би "...өргөдөл буцаж ирсэн гэж дүүргээс ярилаа..." гэсэн чинь Б.Б утсаа тасалчихсан. Утсаар залгаад мессеж бичээд ч холбогдож чадаагүй. Холбогдохоор оршуулганд явж байгаа эсхүл дүү нь осолд орсон зэрэг шалтгаан хэлдэг. Нэг өдөр утас руу нь залгахад "...Дээд шүүх рүү явж байна гарч ирээд ярина..." гээд над руу залгаагүй. Б.Б надтай утсаар ярьж уулзаж учир зүйгээ олж болох байтал тэгээгүй. Худал хэлж хүний нэр барьж итгүүлсэнд нь гомдолтой байна. Дээд шүүхтэй холбоотой нь үнэн бол ноцтой юм шүү. 2.5 сая төгрөгийг минь өгвөл гомдлоо авч болох юм..." гэжээ. /хх 7-9/

Х.М Мэргэжлийн хариуцлагын хорооны хуралдаан дээр гаргасан тайлбартаа: Б.Б өөрөө ирсэн бол нүүр нүүрээ хараад ярих нь амар байлаа. Эзгүй байгаа хүний талаар ярих надад жаахан эвгүй байна. Уг нь энд уулзах юм гэж бодож байсан юм. Би болсон зүйлийн талаар бүгдийг нь бичээд өгсөн байгаа. Болсон зүйлийг нүүр нүүрээ харж байгаад ярьвал надад сэтгэлд өвдөх зүйл алга. Итгэх эсэх нь та бүхний асуудал юм. Энэ яаж үүссэн гэхээр давж заалдах шатны шүүхээр анхан шатны шүүхийн шийдвэр батлагдаад миний хүү ял эдлэхээр явсан. Өмгөөлөгч Б.Б Дархан хотод нэг хэрэг өмгөөлөхөөр очсон байдаг. Манай хүүгийн найз тэнд байдаг. Түүнтэй тааралдсан юм билээ. Тэгээд болсон зүйлийн талаар сонсоод "...би ахыг чинь аварна. Чи тэр хүүгийн аавд хэл. Би очиж уулзая..." гээд манай хүүтэй очиж уулзсан байгаа юм. Тэр хорих ангийн дарга нь манай бага хүүгийн нэг ангийн хүн. Б.Б тэнд аж ахуйн дарга хийж байсан юм билээ. Би түүнээс Б.Б-н талаар асуугаад боломжийн гайгүй хүн юм байна гэж ойлгосон. Б.Б манай хүү дээр очоод "...би чамайг баталгаатай гаргаж чадна. Чи аавдаа хэл 5 сая төгрөг өг гэж хэл..." гэсэн юм билээ. Улсын Дээд шүүхэд Нямжав гэсэн хүний нэр хэлсэн мөн ангийн гэсэн бил үү нутгийн ч гэсэн бил үү 2 хүний нэр хэлж байсан. Хэний нэр хэлсэнг одоо би санахгүй байна. Найзууд тэгээд 14 хоногийн дотор шүүх хурал хийлгэнэ гэж байсан. Тэр үед Б.Б-аас архи үнэртэж байсан. Намайг итгүүлсэн. Манай гэрт 12 цаг болж байсан байх, ирсэн. Тэгээд орой 5 цаг гэхэд мөнгөө авах талаар намайг тулгаж шаардаад байсан. Тэгээд би хөгшний нэр дээр 2 банкнаас 2 сая гаруй төгрөг авсан. Тэгээд хаана очиж өгөх вэ? гэхэд Их дэлгүүрийн баруун урд буланд пиво уудаг асар байгаа тэнд хүрээд ир гэсэн. Тэгээд би тэнд нь очсон, 4 цаг 45 минут болж байсан байх. Тэгсэн би одоо энэ мөнгийг аваад явлаа. Одоо Дээд шүүх орно гэсэн. Тэр хүмүүстэй өгч, авалцах юм байна гэж би ойлгосон. Тэгээд явахад нь би араас нь дагаж явсан. Тэрээр Мэргэжлийн хяналтын баруун талаар шүүхийн булан тойрсон. 2 минут болсон уу үгүй юу буцаад гараад ирсэн. Тэгээд намайг хараад та яаж яваа тухай асуусан. Би манай өмгөөлөгч Н.Н хажуу талын байранд байдаг талаар хэлсэн. Тэгээд орой 7 цаг болж байхад залгаад "...би найзуудтайгаа хоол идээд сууж байна нөгөө асуудлаа тохирсон. Та санаа зоволтгүй..." гэсэн. Тэгээд тэрнээс хойш утсаар 4-5 удаа ярьсан хүрээд ир гэдэг хэрнээ очихоор байдаггүй. Энэ асуудал миний хөнгөн хуумгай байдлаас боллоо. Миний сэтгэл санааны байдлыг далимдуулаад ийм хүнд би ашиглууллаа. Хэрэв Б.Б энд байсан бол би хэлмээр байна. Хүмүүсийн

ажил төрлийн нэрийг барьж ийм ажил хийсэн. Хэд хэдэн удаа холбогдоход ямар нэг шалтаг хэлдэг. Хүн осолд ороод гэмтэл дээр байна гэхээр нь очсон чинь худлаа байсан. Ингээд би залилуулсан гэдгээ ойлгосон..." гэв.

Хариуцагч Б.Б нь 2014 оны 02 дугаар сарын 04-ний өдөр гаргасан тайлбартаа: Иргэн Х.М-тай 2014 оны 7 сард хүү М.Г-д эрх зүйн туслалцаа үзүүлэх, хяналтын шатны шүүх хуралд оролцохоор гэрээ байгуулан ажилласан болно. Гэрээ байгуулах үед 2.5 сая төгрөг авсан бөгөөд гэрээ байгуулсны дараа Улсын Дээд шүүхэд очиж М.Г-ийн материалтай танилцаж энэ тухай Х.М-д мэдэгдэж, зөвлөгөө өгч байсан. Мөн шүүх хуралд хамт оролцох өмгөөлөгч Н.Н. тай санал бодлоо солилцож хүсэлт санал бичгээр боловсруулан өгч байсан. Г-ийн хамаатан Н.Н өмгөөлөгчтэй байнга уулзаж байсан тул Х.М-тай уулзах шаардлага байхгүй байсан гэж үзэж байна. Н.Н өмгөөлөгч Дээд шүүхэд гаргасан өргөдлөө буруу гаргасан учир шүүх хурал хийхгүйгээр хэргийг анхан шатны шүүхэд шилжүүлээд Дээд шүүхийн бүх шүүгч нар амралтаа авсан. Энэ үед Х.М нь утсаар байнга ярьж, мессеж бичиж хүүг нь гаргаагүй тул /сахилгын хороонд гомдол гаргах/ дарамталж байсан. Миний хувьд хувийн ажлаар хөдөө явах, эмнэлэгт хэвтэх зэргээр шалтгаантай байсан бөгөөд хяналтын шатны шүүх хурал болсныг мэдээгүй, хамт оролцох өмгөөлөгч Н.Н нь мэдэгдээгүй юм. Иймд эдгээр бүх нөхцөл байдлыг харгалзан миний эрх зүйн байдлыг дордуулахгүй шийдвэр гаргаж өгнө үү. Миний ээжийн бие муу сахиуртай байгаа тул хуралд оролцох эсэхээ тухайн үед нь шийдвэрлэх болно гэжээ.

Хариуцагч Б.Б нь 2014 оны 01 дүгээ сарын 28-ны өдөр өгсөн тайлбартаа: М.Г хоёр өмгөөлөгч авсан байсан. Би Дээд шүүхэд хэргийн материалтай нь танилцсан, мөн хүсэлт бичиж өгсөн. Хэргийг хөнгөрүүлж өгөх боломжтой гэсэн утгаар нь хүсэлт өгсөн. Хүсэлтийн хариуг авахаар очиход М.Г өмгөөлөгчид хариу өгсөн талаар хэлсэн. М.Г-тай уулзахад тэрээр "...би өөрийнхөө хүсэлтийн хариуг авсан таны хариуг аваагүй..." гэж хэлсэн. Би Дээд шүүхийн хуралд ороогүй учир нь Дээд шүүх хурал хийгээгүй, хэргийг анхан шатны шүүхэд шилжүүлсэн байсан. Х.М над руу утсаар залгах үед би утсаа авч байсан, сүүлдээ больсон. Би хөлсийг 5.000.000 төгрөгөөр тохироод 2.500.000 төгрөг урьдчилгаанд авсан. Шийдвэр хэвээр батлагдах юм бол мөнгийг нь буцааж өгнө гэж хэлсэн. Хүмүүстэй хоолонд орно гэж хэлсэн нь үнэн. Би хурал болсоныг мэдээгүй, хэвээр батлагдсаныг ч мэдээгүй. Мөнгийг нь би өгнө. Өмгөөлөгч М.Г-тай уулзаж байснаас Х.М-тай уулзаагүй нь үнэн. Яагаад Дээд шүүхээс хэрэг нь анхан шатны шүүх рүү буцсан юм бол гэж бодоод уулзаж байсан. Би хавтаст хэрэгтэй танилцах, түүвэр хийж авах, өмгөөлөгч М.Г-тай уулзах хүсэлт бичиж өгөх байдлаар оролцсон. Өмгөөлөгч М.Г хурал болох талаар надад хэлээгүй учир би Дээд шүүхийн хуралд оролцож чадаагүй гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ:

Хуульч Б.Б нь хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж үйлчилгээний хөлсөнд иргэн Х.М-аас 2.500.000 төгрөг авсан боловч хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйл 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн эсэхийг тогтоолгоно гэв.

Б.Б-д холбогдох маргааны баримтад буй Н.Н-ын тайлбарт "...хэргийн материалтай танилцсан эсэхийг нь мэдэхгүй байна. Баяраа өмгөөлөгч бид хоёр, 2 удаа гомдол гаргасан. Б.Б өмгөөлөгч 2 дахь гомдол дээр санал өгч байсан. Гэхдээ гомдолд гарын үсэг зураагүй..." гэжээ. /хх 10-11/

Х.М өмгөөлөгч Б.Б нарын хооронд 2014 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний 2.1 дэх хэсэгт "...энэхүү гэрээгээр өмгөөлөгч нь Цагдаагийн газарт шалгагдаж буй М.Г-д холбогдох эрүүгийн хэрэгт холбогдсон байцаан шийтгэх ажиллагаанд холбогдогч нарын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хэргийн талаар хууль зүйн туслалцаа үзүүлж, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд өмгөөлөгчөөр ажиллахтай холбогдсон асуудал болон талуудын гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, хүлээх хариуцлага зэрэгтэй холбогдох харилцааг зохицуулна...", 3.2 дахь хэсэгт "...үйл ажиллагаандаа аль болох түргэн шуурхай байх зарчмыг баримтална... шийдвэрлүүлж байгаа асуудлын талаар үйлчлүүлэгчдээ танилцуулж байна...", 5 дугаар зүйлд "...өмгөөллийн хөлсөнд 5 сая төгрөг төлнө, урьдчилгаа 2.5 сая төгрөг гэрээ байгуулах үед төлнө... 2.5 сая төгрөг М.Г суллагдсан нөхцөлд төлнө..." гэж тус тус заасан. /хх4 /

Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны-р шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн дугаар албан бичигт "Тус шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 199 дүгээр шийтгэх тогтоолтой М.Г-т холбогдох эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч Б.Б оролцоогүй байна. Харин гомдол гаргагч Х.М-тай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан байх тул гэрээг хуулбарлан хүргүүлэв" гэжээ./хх14/

ҮНДЭСЛЭХ НЬ:

Х.М нь өмгөөлөгч Б.Б-д зохих хариуцлага хүлээлгэх мөн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу өгсөн 2 500 000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгийг буцааж авах гомдол гаргасан бөгөөд үндэслэлээ "...Б.Б үйлчилгээ үзүүлээгүй, мөнгө авснаас хойш уулзаагүй... хяналтын шатны шүүхэд гомдол хүсэлт бичиж өгөөгүй... хяналтын шатны шүүхээс хэргийг хэлэлцэхгүйгээр анхан шатны шүүхэд буцаасан байхад энэ талаар ч мэдээгүй байсан... хяналтын шатны шүүхийн шүүгч нартай найз...хүүг хорихоос гаргаж өгнө...хүмүүстэй хоол иднэ гэх зэргээр худал хэлж залилж мөнгө авсан..." гэж тайлбарлав.

Б.Б Х.М нь гомдолд тайлбар өгөхдөө "...эрх зүйн туслалцаа үзүүлэх, хяналтын шатны шүүх хуралд оролцох гэрээ байгуулж ажилласан... Дээд шүүхэд очиж хэргийн материалтай танилцсан, хүсэлт бичиж өгсөн боловч хариуг нь М.Г өмгөөлөгчид өгсөн гэж надад хэлсэн. 2.500.000 төгрөг урьчилгаанд авсан. Би бусадтай хоолонд орох талаар хэлсэн нь үнэн ...мөнгийг нь би өгнө..." гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч нь Б.Б-ийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн гэж үзсэн байна.

Өмгөөлөгч Б.Б нь Х.М-тай 2014 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж, хяналтын шатны шүүх хуралдаанд М.Г-ийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар тохирч, өмгөөллийн хөлс болгож 2.500.000 төгрөгийг авсан нь тогтоогдсон бөгөөд энэ талаар Х.М, Б.Б нар маргаагүй болно.

Б.Б М.Г-ийн эрх ашгийг хамлаалах, түүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар Х.М-тай гэрээ байгуулж 2.5 сая төгрөг авсан боловч гэрээний 3.2.1, 3.2.4-т заасан үүргээ биелүүлээгүй буюу хяналтын шатны шүүхэд хэргийг шийдвэрлүүлэхэд чиглэгдсэн, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах ажиллагаа явуулаагүй, шүүхээр шийдвэрлүүлж байгаа асуудлын талаар үйлчлүүлэгчдээ танилцуулаагүй болох нь нотлогдсон тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн дүгнэлтийг үндэслэлтэй байна гэж үзлээ. Хариуцагч нь хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчихгүй байх тухай Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсгийн заалт болон мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, нэр хүндээ эрхэмлэх, шуурхай, зохион байгуулалттай ажиллах тухай Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 заалтыг тус тус зөрчжээ.

“...Дээд шүүхийн шүүгч нарыг таньж мэддэг, найз нөхдийн холбоотой, хорих ялыг тэнсүүлэх, хоол идэх зэрэгт мөнгө хэрэгтэй гэж ярьж урьдчилгаа хөлс 2.5 сая төгрөг авсан ...” гэсэн агуулгатай Х.М-ийн гомдолд хариуцагч тайлбар өгөөгүй тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн энэ үйл баримтыг Б.Б хүлээн зөвшөөрсөн гэж үзлээ. Хариуцагчийн гаргасан энэхүү үйлдэл нь хуульчийн үнэнч шударга байдалд сөргөөр нөлөөлөх үйлдэл тул үүнийг хүнд зөрчилд хамааруулах үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Б.Б нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байх тул түүний хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр жилийн хугацаагаар хүчингүй болгох нь зөв гэж бүрэлдэхүүн үзлээ.

Үйлчлүүлэгчээсээ авсан мөнгөө буцаан өгөх талаар хариуцагч тайлбартаа дурдсан тул 2 500 000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгийг Х.М-д төлөхийг Б.Б-д даалгах нь Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 5.6 дугаар зүйлийн 1-н “...үйлчлүүлэгчээс хүлээн авсан эд хөрөнгийг хариуцагч нөхөн төлөхийг зөвшөөрсөн тохиолдолд бүрэлдэхүүн нь тухайн хохиролыг нөхөн төлөхийг даалгаж болно...” гэснийг зөрчихгүй болно.

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4-р зүйлийн 1, 14.5, 14.6-р зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ НЬ :

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 хэсэг, Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар

Б.Б-ийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай хүчингүй болгосугай.

2. Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан Х.М-д 2 500 000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөг буцааж төлөхийг Б.Б-д даалгасугай.
3. Маргааны материалд нэг ширхэг CD /Б.Б-тай утсаар ярьсан бичлэг/ хавсаргасан байгааг дурдсугай.
4. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурьдсугай.
5. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 04

Улаанбаатар

хот

Л.Э-т холбогдох маргааныг шийдвэрлэсэн тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Д.Байгалмаа даргалж, гишүүн Л.Болд, Т.Өсөхбаяр, Х.Цогтсайхан, Ц.Оч нарын бүрэлдэхүүнтэй тус хорооны танхимд хийсэн хуралдаанд:

Сахилгын шинжээч: Г.Должинсүрэн,

Гомдол гаргагч: Н.Л,

Нарийн бичгийн дарга: Б.Алтаншагай нарыг оролцуулан

Иргэн Н.Лхагвасундуйгаас өмгөөлөгч, хуульч Л.Э-т холбогдуулан гаргасан гомдлыг шалгаад Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн гаргасан 2014 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн МД1502 дугаартай Сахилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийг 2015 оны 2 дугаар сарын 05-ны өдөр тус маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд ирүүлснийг хүлээн авч, гишүүн Ц.Очийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Хариуцагч: Х овогт Л-ийн Э нь , оны 4 дүгээр сарын 19-ний өдөр төрсөн, настай, эмэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Монголын Хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч, аймгийн Сайнцагаан сум, дугаар баг, Айраг..... тоотод оршин суух хаягтай, /регистрийн дугаар НЭ...../,

Өмгөөлөгч Л.Э нь 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.2.1, 181.2.5 дахь хэсэгт заасан Ц.Б-нд холбогдох эрүүгийн хэргийн хохирогч Н.Д-ын өмгөөлөгчөөр оролцохоор иргэн Д.С-тай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан боловч ямарч ажиллагаанд оролцоогүй, хууль зүйн туслалцаа үзүүлээгүй. Дээрх үйлдлийн улмаас иргэн Д.С нь өмгөөллийн хөлсөнд өгсөн 600.000 төгрөгөөр хохирсон маргаанд холбогджээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээчээс өмгөөлөгч Л.Э-ийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1,27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн гэж мэргэжлийн дүгнэлт гарган ирүүлжээ.

Сахилгын шинжээч Г.Должинсүрэн хуралдаанд гаргасан тайлбартаа: Өмгөөлөгч Л.Э нь эрүүгийн 201401010099 дугаартай хэрэгт хохирогч Н.Д-ын өмгөөлөгчөөр оролцохоор хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөнд иргэн Л.С-аас 600.000 төгрөг авсан атлаа хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй, хохирогчийн байцаалтанд суугаагүй, шүүх хуралдаанд болон бусад байцаан

шийтгэх ажиллагаанд оролцоогүй нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн болох нь тогтоогдож байх тул Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Хүлээн авч шийдвэрлэж өгнө үү гэв.

Гомдол гаргагч Н.Л нь Монголын Хуульчдын холбоонд гаргасан гомдол болон маргаан шийдвэрлэх хуралдаанд гаргасан тайлбартаа:

“...Миний төрсөн дүү нь хүнд зодуулсны улмаас өмгөөлөгч авах шаардлагатай гэж үзэж Л.Э өмгөөлөгчтэй холбогдсон. Өмгөөлөгч гэх эмэгтэй нь 70 гарсан 2 хөгшинтэй болсон процессыг хагас дутуу ярилцаж, сонсоод “би ойлголоо, өмгөөлж чадна. Мөнгөө даруйхан урьдчилж өг” гэсэн. Үүний улмаас аав маань тэтгэврийн зээл урьдчилан авч, 600.000 төгрөгийг бэлдэж тавьсан. Тэгээд тэр оройдоо Л.Э өмгөөлөгч нь аавынд очиж гэрээ гэх зүйл байгуулан 600.000 төгрөгийг аваад явсан байсан. Энэ өдрөөс хойш эцэг, эхтэй дахиж холбоо бариагүй, байцаагчтай нь ч хэргийн талаар асууж тодруулаагүй. ...Улмаар өмгөөлөгч Л.Э-тай манай нөхөр цаг болзож уулзахад “байцаагчтай чинь очиж уулзсан” гэж худлаа ярьж байсан. Тэгэхэд нь “та ингэж худлаа хэлж болохгүй, эцэг эхийн минь мөнгийг буцааж өг” гэхэд “би энэ заваан хэргийг өмгөөлж чадахгүй, одоогоор надад бэлэн мөнгө байхгүй байна. Мөнгийг чинь өнөө маргаашиггүй өгнө” гэхээр нь би баримт хийлгэж, тамга даруулсан. Бид мөнгө өгнө гэсэн өдөр нь залгахад тэр утсаа огт авахгүй, ажил дээрээ ч ирдэггүй болсон. Би энэ өмгөөлөгчийг хуулийн байгууллагын албан ёсны өмгөөлөгч мөн эсэх, мөн бол түүний энэ зүй бус үйлдлийг нь таслан зогсоож, бидний хохирлыг барагдуулж өгнө үү...” гэв.

Хэрэгт авагдсан болон хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтууд болох:

Иргэн Д.С-аас гомдол гаргагч Н.Л-д итгэмжлэн олгосон итгэмжлэл /хуудас 4/,

Өмгөөлөгч Л.Э-н 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр мөнгө буцааж өгөх талаар үйлдсэн баримтын хуулбар /хх-5/,

Өмгөөлөгч Л.Э-н иргэн Д.С-тай байгуулсан 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ /хх-6-7/,

Гэрч Н.Д-ыг асуусан тэмдэглэл /хх-11-12/,

Хуульчдын нэгдсэн бүртгэлд Л.Э-ийг бүртгэсэн анкет,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийндугаартай шийтгэх тогтоол болон шүүх хуралдааны тэмдэглэл /хх-19-28/, эрүүгийн хэргийн хохирогч Н.Д-ыг байцаасан тэмдэглэл /хх-17-18/,

Мэргэжлийн хариуцлагын хорооноос өмгөөлөгч Л.Э-ийг хороонд дуудсан, утсаар ярьсан талаарх, оршин суугаа газрыг тодруулах эрэн сурвалжлах ажиллагаа хийсэн талаарх тэмдэглэл /х-31-32, 43-44/,

Монголын Хуульчдын холбооны 2015 оны 1 Дүгээр сарын 26-ны өдрийн 2/120, 2/117 тоот албан бичиг зэргийг шинжлэн судлав.

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч Л. Э нь Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А/147 дугаар тушаалаар хуульчдын нэгдсэн бүртгэлийн.....дугаарт, Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн ... дугаарт бүртгэгдсэн хуульч, өмгөөлөгч болох нь тогтоогджээ.

Гомдол гаргагч Н.Л-аас гаргасан гомдлын дагуу Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр маргаан үүсгэж өмгөөлөгч Л.Э-ийг маргаанд холбогдуулан тайлбар авах, зохих эрх үүргийг нь танилцуулж маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, сахилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийг гардуулж, хуралдааны товыг мэдэгдэх зэрэг зорилгоор түүний хаягийг тодруулах, эрэн сурвалжлах ажиллагааг 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 2015 оны 2 дугаар сарын 26-ныг хүртэл хугацаанд удаа дараа хийж, түүнтэй утсаар холбогдсон боловч Л.Э нь маргаан шийдвэрлэх хуралдаанд хүрэлцэн ирээгүй байна.

Хэрэгт авагдсан Сахилгын шинжээчээс хариуцагч Л.Э-ийг дуудсан, утсаар ярьсан тэмдэглэлүүдээр /х-31-32, 43-44/ түүнийг дуудах ажиллагааг 23 удаа хийсэн байхад маргаан шийдвэрлэх хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь түүний байхгүйд холбогдох маргааныг шийдвэрлэх хангалттай үндэслэл болно гэж бүрэлдэхүүн дүгнэсэн болно.

Өмгөөлөгч Л.Э нь 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр эрүүгийн дугаартай хэрэгт хохирогч Н.Д-ын өмгөөлөгчөөр оролцохоор хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг иргэн Л.С-тай байгуулж, үйлчилгээний хөлсөнд түүнээс 600.000 төгрөгийг хүлээж авсан атлаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримлах дүрмийг зөрчиж өөрийн үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй, эрүүгийн хэргийн хохирогч Н.Д-ыг асуусан байцаалт, шүүх хуралдаан болон байцаан шийтгэх бусад ажиллагаанд огт оролцоогүй болох нь хэрэгт авагдсан, хуралдаанаар хэлэлцсэн дараахь баримтууд:

Өмгөөлөгч Л.Э-ийн иргэн Д.С-тай байгуулсан 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ /хх-6-7/, 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр мөнгө буцааж өгөх талаар үйлдсэн баримт /хх-5/, хохирогчийг байцаасан тэмдэглэл /хх-17-18/, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 472 дугаартай шийтгэх тогтоол болон шүүх хуралдааны тэмдэглэл /хх-19-28/,

Гомдол гаргагч Н.Л "...Миний төрсөн дүү Д нь хүнд зодуулсны улмаас өмгөөлөгч авах шаардлагатай гэж үзэж Л.Э өмгөөлөгчтэй холбогдож уулзсан. Гэтэл өмгөөлөгч Л.Э нь "энэ хэрэгт өмгөөлөгч авах шаардлагатай, би өмгөөлж болж байна. 1.000.000 төгрөгөөр өмгөөлнө. Урьдчилгаа 600.000 төгрөгийг бэлд" гэсэн. Үүний улмаас аав Намжил маань тэтгэврийн зээл урьдчилан авч, 600.000 төгрөгийг гэрээ байгуулан өмгөөлөгч Л.Э өгсөн. Энэ өдрөөс хойш эцэг, эхтэй дахиж холбоо бариагүй, байцаагчтай нь ч хэргийн талаар асууж тодруулаагүй, ямарч ажиллагаа хийгээгүй болно. Иймд хуулийн дагуу хариуцлага тооцож өгнө үү..." /хх-9/,

Гэрч Н.Д-ын "...Өмгөөлөгч Л.Э-тай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсанаас хойш 1 удаа байцаалт өгсөн бөгөөд өмгөөлөгч Л.Э нь тус байцаалтанд байгаагүй. Ямар нэг хууль зүйн туслалцаа үзүүлээгүй, алга болсон..." /хх-11- 12/ гэх тайлбарууд зэргээр тогтоогдсон байна.

Мөн өмгөөлөгч Л.Э нь хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр Д.С-аас ажлын хөлсөнд урьдчилан авсан 600.000 төгрөгийг буцааж төлөөгүй байгаа бөгөөд өөрийн биеэр маргаан шийдвэрлэх хуралдаанд оролцоогүй тул түүнийг уг төлбөрийг буцааж төлөхийг зөвшөөрсөн гэж үзэж Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн хохирлыг нөхөн төлөхийг хариуцагчид даалгах боломжгүй байна гэж үзлээ.

Иймд Хуульч, өмгөөлөгч Л.Э нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсэгт заасан "...Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих...", мөн хуулийн 27.1.2 дахь хэсэгт заасан "...хуульчийн үнэнч, шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх...", Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 дахь хэсэгт заасан "...мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх...", 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "...хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн болох нь тогтоогдсон тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т заасны дагуу Л.Э-ийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж хариуцлага ногдуулахаар маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрлэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4, 14.5, 14.6 дугаар зүйлд заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Өмгөөлөгч Л-ийн Э-ийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоосугай.
2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т зааснаар Л.Э-ийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
3. Энэхүү тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд гомдол гаргах эрх бүхий этгээд тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хаалттай сануулах тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн “Сахилгын шинжээчийн 0013 дугаар санал”-ын талаар зөвлөлдөөд

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 0013 дугаар саналд: “Хариуцагч Ш.О, эрүүгийн хэргийн холбогдогч М.Б-ыг өмгөөлж хууль зүйн туслалцаа үзүүлэх явцдаа, Эрүүгийн хэргийн анхан шатны 01 дүгээр шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, хуралдаанд оролцох боломжгүйгээ урьдчилж бичгээр шүүхэд мэдэгдээгүй зэргээр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан нь нотлогдсон, хариуцагч гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад хохирол учраагүй байх тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Ш.О-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна” гэжээ.

Өмгөөлөгч Ш.О Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан хүсэлтдээ: “Миний бие өмгөөлөгч Ш.О нь М.Б-д холбогдох холбогдох хэрэгт өмгөөлөгчөөр оролцох байсан ба энэ тухайгаа тухайн шүүхэд бичгээр санал хүсэлт гаргаагүй нь миний буруу. Тухайн үед биеийн байдал муу, олон жилийн хугацаанд булчирхайн хавдар өвчнөөр өвчилж байгаад эмчийн хяналтад эмчилгээ хийлгэх шаардлагатай байсан тул шүүх хуралд суугаагүй болно. Энэ үйлдэл нь буруу ба дахин ийм алдаа дутагдал гаргахгүй ажиллана. Иймд эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хаалттай сануулж өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Хариуцагч Ш.О нь Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 01 дүгээр шүүхэд 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр товлогдсон Б.Б нарт холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралд өвчтэй гэсэн шалтгаанаар ирээгүй, 2014 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 13 цагт товлогдсон шүүх хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй нь “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана”, 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхолоо тэргүүнд

тавих, ... шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн болох нь Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны дүгээр шүүхийн шүүгчийн 2014 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Шүүх хуралдаан хойшлуулах тухай” дугаар захирамж, мөн өдрийн Б.Б нарт холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл, өмгөөлөгч Ш.О-н үйлчлүүлэгч М.Б-ын ээж гэрч Х.М-ын тайлбар, хариуцагчийн өөрийнх нь мэдүүлэг болон бусад бичгийн нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Хариуцагч Ш.О нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч байгаа, чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад хохирол учруулаагүй зэрэг байдлыг харгалзан Сахилгын шинжээчээс ирүүлсэн Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар хариуцагч Ш.О-д хаалттай сануулах шийтгэл ногдуулах санал ирүүлсэн нь үндэслэлтэй байна гэж бүрэлдэхүүн үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 10.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8-д заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д зааснаар хуульч Ш.О-д “хаалттай сануулах” шийтгэл ногдуулсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Хаалттай сануулах тухай

Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээч Т.Жадамбаагаас Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх 5 дугаар бүрэлдэхүүнд 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн “Сахилгын шинжээчийн 0023 дугаар санал”-ын талаар зөвлөлдөөд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Сахилгын шинжээч Т.Жадамбаагийн 2015 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 0023 дугаар саналд:

Хариуцагч: Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо,дүгээр хороолол, ...дүгээр байрнытоотод ам бүл дөрвүүл амьдрах, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, 1980 онд төрсөн, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн нэгдсэн бүртгэлийн.... дугаарт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн ...дугаарт тус тус бүртгэгдсэн Г овогт Г.Н нь 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр үйлчлүүлэгч С.Я-г авахаар ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих 461 дүгээр ангийн байранд согтуугаар нэвтрэн харуул хамгаалалтын ажилтантай зохисгүй харьцсан болохыг:

1. ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих ангийн даргын 1/589 дугаар албан бичигт: “... өмгөөлөгч Г.Н нь 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 11 цаг 25 минутад согтууруулах ундаа хэрэглэсэн байдалтай уулзалтын байр уруу нэвтрэх үед нь харуул хамгаалалтын ажилтан шаардлага тавихад эсэргүүцэж, хэл амаар доромжилсон үйлдэл гаргасан...” тул холбогдох арга хэмжээ авч хариуг ирүүлнэ үү.” гэснээр
2. Цагдан хорих дүгээр ангийн гадна харуул хамгаалалтын ажилтан С.Б: “... өмгөөлөгч Г.Н согтууруулах ундаа хэрэглэсэн байдалтай, гуйвж дайван ...эргэлт уулзалтын зал уруу орох гэхэд нь “та согтуу байна, ийшээ орж болохгүй” гэхэд “... зүгээр байгаарай, яагаад оруулахгүй новшроод байгаа юм бэ? Гэхээр нь “Та ямар шалтгаанаар орох гээд байгаа юм бэ? Баримт бичгээ үзүүлчих” гэхэд “сүртэй юм бэ? Ахлах дэслэгчээ наад бичсэн юмаа өгчих, би ураад хаячихая” гээд давшлаад байсан” гэсэн тодорхойлолт гаргаснаар
3. Хариуцагч Г.Н-ээс: “...С.Я нь нэг сарын баривчлах ял шийтгүүлж хугацаа нь 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дууссан. Ар гэрийнх нь журмыг нь мэдэхгүй учир цагдан хорих төвөөс гаргаад өгөөч гэж гуйхаар нь дүгээр ангид очсон. Тэр үед 1 шил пиво уусан байсан. дүгээр ангид очоод шалганаар нэвтрэх ороод хүсэлтээ гаргаад 2 цаг шахам хүлээсэн. Хүлээж байхдаа хүнээ гарч ирж байна уу гэж лавлахад та юм уусан юм уу гэхэд нь 1 пиво уусан гэдгээ хэлсэн. Гараад байж бай гэхээр нь гадаа үүдэнд зогссон. Шалганы ажилтан баримт

бичгээ үзүүл гэхээр нь үзүүлсэн. Бүртгэж аваад рапорт бичихээр нь янз бүрийн асуудал үүсгээгүй, ингэж рапорт хөтлөх шаардлага байна уу. Ураад хаячихвал яасан юм бэ? Гэхэд асуудал үүсгэхгүй бүртгэж байна,” гэсэн.

Би, н.Б ахлах дэслэгчид “Би урьд нь цагдаагийн байгууллагад ажиллаж байсан, хүнээ хурдан авмаар байна.” гэж хэлсэн. Пиво ууж Цагдан орих байранд нэвтэрсэн үйлдэл нь ёс зүйн хувьд буруу учир гэм буруугаа хүлээн зөвшөөрч байна...Хаалттай сануулах шийтгэл хүлээх хүсэлтэй...” гэсэн агуулгатай тайлбар өгсөн зэрэг баримтаар нотолсон гэж үзлээ.

Хариуцагч Г.Н нь дээр дурдсан үйлдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хуульч нь...аливаа этгээд, олон нийттэй мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцана. Хуульч нь ажил үүргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад хохирол учраагүй байх тул Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Г.Н сахилгын “Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргав” гэжээ.

Өмгөөлөгч Г.Н Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан хүсэлтдээ: Г овогтой Н миний бие 2014 оны 4 дүгээр сард шүүхэд төлөөлөх эрхийн дугаарт бүртгүүлсэн. Иймд өмгөөллийн ажиллагаа гүйцэтгэж явж байхдаа 2014 онд үйлчлүүлэгч Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 1 1-д зааснаар 1 сарын баривчлах ялаар шийтгүүлж, энэ ялын хугацаа нь 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дуусгавар болж ар гэрийнхний зүгээс хорих 461 дүгээр ангиас цуг яваад гаргалцаад өгөө ч гэсэн хүсэлт тавьж явсан.

Тухайн үед хорих дүгээр ангируу явна гэсэн ажлын төлөвлөгөө байхгүй байсан учир найзтайгаа нэг нэг пиво уусан байсан учир гайгүй байлгүй гээд хүнээ дуудуулан хүлээж байх зуур хамгаалалтын ажилтан та согтууруулах ундаа хэрэглэсэн байна гээд гадаа гарч хүлээхийг шаардсан шаардлагыг нь хүлээж авсан.

Гэхдээ миний энэ пиво ууж Цагдан хорих байранд нэвтэрсэн үйлдэл нь мэргэжлийн хувьд хариуцлагагүй үйлдэл гаргасан учир гэм буруугаа хүлээн зөвшөөрч байна.

Иймээс Монгол Улсын Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д зааснаар хаалттай сануулах хариуцлага хүлээлгүүлэх хүсэлтэй байна. 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдөр 11 цагт хэргийн материалтай танилцсан. Цаашид мэргэжлийн хариуцлагын зөрчил гаргахгүй ажиллана.” гэжээ.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Хуульч Г.Н нь 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өөрийн үйлчлүүлэгч С.Я-ыг авахаар ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих дүгээр ангийн байранд согтуугаар нэвтрэн харуул, хамгаалалтын ажилтантай зохисгүй харьцаж Хуульчийн

мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4-р зүйлийн 2 дахь хэсгийн “Хуульч нь ...аливаа этгээд, олон нийттэй мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцана. Хуульч нь ажил үүргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэнэ” гэж заасныг зөрчсөн болох нь Цагдан хорих 461 дүгээр ангийн гадна харуул хамгаалалтын ажилтан С.Баярмагнайн тодорхойлолт, ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих дүгээр ангийн даргын 1/589 дүгээр албан бичиг, Прокурорын газрын 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дугаар танилцуулга, хариуцагчийн өөрийнх нь мэдүүлэг болон бусад бичгийн нотлох баримтуудаар тогтоогдсон байна.

Хариуцагч Г.Н нь гаргасан зөрчлөө шудрагаар хүлээн зөвшөөрч байгаа, чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад хохирол учруулаагүй зэрэг байдлыг харгалзан Сахилгын шинжээчээс Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2-р зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар хариуцагч Г.Н-д сахилгын хаалттай сануулах шийтгэл ногдуулах санал ирүүлснийг үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2-р зүйлийн 2.1, 2.2, 2.3, 10.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д зааснаар хуульч Г овогт Г.Н-д “Хаалттай сануулах” шийтгэл ногдуулсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Л.Амарсанаа даргалж, гишүүн Б.Бат-Орших, Ө.Одгэрэл, Э.Ариунаа, Д.Оюунбат нарын бүрэлдэхүүнтэйгээр сахилгын шинжээчээс хуульч М.А-д "Хаалттай сануулах" сахилгын шийтгэл хүлээлгэх саналыг хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүнд сахилгын шинжээч 0020 дугаартай саналыг 2015 оны 03 дугаар сарын 04-ний өдөр гаргахдаа:

ХУД-ийн 15-р хороо, байрнытоотод оршин суух, эрэгтэй, онд төрсөн, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нэгдсэн бүртгэлийнрт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийнрт тус тус бүртгэлтэй, Т овогт М.А нь иргэн П.А-г өмгөөлөх буюу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаар Цагдан хорих дүгээр ангид нэвтрэхдээ гар утсаа хураалгалгүй орж, үйлчлүүлэгч П.А-г ар гэрийнхэнтэй нь утсаар яриулсан нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэр биелүүлэх тухай хууль, Хууль зүйн сайдын 2013 оны А/75, 2014 оны А/209 дүгээр тушаалаар батлагдсан журамд захирагдаагүй үйлдэл буюу Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн 26.1.1-д заасан зөрчил гэж үзлээ.

Хариуцагч гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад хохирол учруулаагүй байх тул Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч М.А-д сахилгын "Хаалттай сануулах" шийтгэл оногдуулах санал гаргав гэжээ.

Хариуцагч М.А- нь Мэргэжлийн хариуцлагын хороонд тайлбар гаргахдаа:

Н.Э гэдэг хүн туслаач гэхээр нь өмгөөлөгчөөр ажиллахаар болж, 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хорих дүгээр ангид очиж П.А-тай уулзсан. Хоригдож байгаагаа ээждээ хэлье гэхээр нь утсаа спикер дээр нь таьж байгаад ээжтэй нь яриулсан. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд утсаа хураалгаж, энэ талаар тайлбар бичиж өгсөн.

Хоригдогчийг утсаар яриулж болохгүй гэдгийг мэднэ. Буруу зүйл хийснээ ойлгож байна. Дахин ийм үйлдэл гаргахгүй.

Надад үүсгэсэн маргааныг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, “хаалттай сануулах” арга хэмжээ авч өгнө үү гэжээ.

Маргааны материалд авагдсан бичгийн нотлох баримтуудыг шинжлэн судлаад

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч М.А нь Хуульчийн нэгдсэн бүртгэлийн.....дугаарт, Монгол Улсын Дээд шүүхийн өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн ...дугаарт тус тус бүртгэгдсэн нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Хуульчийн гэрчилгээ эзэмшигчийг хуульчийн нэгдсэн бүртгэлд бүртгэснээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан “хуульч”-д тооцно” гэж зааснаар хуульчид тооцогдсон болох нь Монголын хуульчдын холбооны Тамгын газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 2/201 дугаар албан бичиг “/мм-ийн 11/-ээр нотлогдоно.

Хуульч М.А нь 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Хорих 461 дүгээр ангид нэвтэрч өөрийн үйлчлүүлэгч П.А-тай уулзахдаа гар утсаараа ар гэрийнхэнтэй нь яриулсан зөрчил гаргасан болох нь Нийслэлийн прокурорын газрын танилцуулга /мм-ийн 6,7/, үйлчлүүлэгч П.А-ийн гаргасан тодорхойлолт /мм-ийн 9/, хариуцагч М.А-ын өөрийнх нь Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбар / мм-ийн 13,14/, Хорих дүгээр ангид гаргасан тодорхойлолт /мм-ийн 15/, Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан хүсэлт /мм-ийн 16/ зэрэг бичгийн нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Дээрх үйлдэл нь:

Хууль зүйн сайдын 2013 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3-т “Хорих байранд нэвтрэх эрх бүхий албан тушаалтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, уулзалтаар ирэгсдийг металл мэдрэгч хаалгаар, эд зүйлсийг рентген хяналтын төхөөрөмжөөр оруулж, хорих байранд хориглосон эд зүйл болон гар утсыг хураан авч, тэмдэглэл үйлдэж, гарахад нь буцаан олгоно”,

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.5 дугаар зүйлийн 2.8-д заасан “ хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зорилготой үйл ажиллагаанд оролцох”,

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д заасан Хуульч Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон Хуульчийн Мэргэжлийн дүрэмд захирагдах”,

27 дугаар зүйлийн 27.1.1-д “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах...” зэрэг хууль, дүрэм болон журмыг зөрчсөн байна гэж үзэх үндэслэлтэй.

Хариуцагч М.А-д сахилгын шийтгэл ногдуулахдаа гаргасан зөрчил түүний хэр хэмжээ, учруулсан болон учруулж болохуйц хор уршиг, гаргасан зөрчилдөө гэмшиж, хуульчийн хувьд хандаж буй хандлага, хувийн байдал, сахилгын шинжээчийн санал зэргийг харгалзан үзэх нь зөв гэж маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн дүгнэж байна.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.6-д заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлд тус тус зааснаар Т боржигон овгийн М.А-д “Хаалттай сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
3. Энэхүү тогтоолыг хариуцагчид хүргүүлэхийг мэргэжлийн хариуцлагын хорооны Ажлын албанд даалгасугай.
4. Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан шийдвэрлэх журмын 17.1 дүгээр зүйлийн 1-д зааснаар сахилгын шинжээч, хариуцагч нь тогтоолыг эс зөвшөөрвөл гардаж авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сахилгын шинжээчийн дүгнэлтийг хянасан тухай

Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны 4-р бүрэлдхүүний гишүүн Ц.Давхарбаяр, Б.Ундрах, Г.Алтанчимэг, Т.Баярсайхан, Т.Өсөхбаяр нар нь Цагдан хорих-р ангийн даргын 2014 оны 11 сарын 03-ны өдрийн 1/589 дугаар бүхий албан тоот, Нийслэлийн прокурорын газрын 2015 оны 1 сарын 7-ны өдрийн 6/43 дугаар бүхий албан тоот, прокурорын газрын тоот танилцуулга, Хуульчдын холбоо, түүний тамгын газрын хүсэлтийг үндэслэн, дугаар бүхий шүүхэд төлөөлөх эрхийн үнэмлэх бүхий хуульч, өмгөөлөгч М.Т-н үйлдэлд шалгах ажиллагаа явуулсан, Мэргэжлийн хариуцлагын хорооны Ажлын албаны сахилгын шинжээчийн 2015 оны 3 сарын 5- ны өдрийн 0021 тоот “Сахилгын шинжээчийн санал”-ыг 2015 оны 3 сарын 10-ны өдөр хүлээн авч, хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Хариуцагч, хуульч, өмгөөлөгч М овогтой Т нь 2014 оны 10 сарын 1-ний өдөр ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461-р ангийн уулзалтын өрөөнд үйлчлүүлэгчтэйгээ уулзахдаа “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”-ыг зөрчсөн зөрчлийг шалгуулахаар, Цагдан хорих-р анги, прокурорын газраас Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд хүсэлт ирүүлсэн байна.

Үүний дагуу Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Т.Жадамбаа 2015 оны 1 сарын 27-ны өдөр маргаан үүсгэжээ.

Хариуцагч хуульч-өмгөөлөгч М овогтой Т нь 2014 оны 10 сарын 1-ний өдөр ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461-р ангийн уулзалтын өрөөнд үйлчлүүлэгчтэйгээ уулзахдаа, харуул, хамгаалалтын ажилтан С.Б гар утсаа үлдээх шаардлага тавьсныг үл биелүүлэн, цагдан хоригдож байгаа этгээдийг утсаар яриулсан болох нь цагдан хоригдож байгаа Б.М-ийн тайлбар /г.м-ийн 9 х, 17 х/, өмгөөлөгч М.Т-ийн тайлбар /г.м-н 10 х/, Цагдан хорих-р ангийн гадна харуул хамгаалалтын офицер С.Б-ийн тодорхойлолт, тайлбар /г.м-ийн 14 х-16 х./, өмгөөлөгчийн дуудах хуудас /г.м-ийн 19 х-20 х/, зэрэг баримтуудыг үндэслэн үзвэл, цагдан хорих, байрны тогтоогдсон дотоод журмыг зөрчин, хоригдож байгаа этгээдийг өөрийн утсаар аавтай нь яриулсан байна.

Мэргэжлийн хариуцлагын хорооны Ажлын албаны сахилгын шинжээч уг гомдлыг хүлээн авч хянан, 2015 оны 3 сарын 5-ы өдөр сахилгын “Хаалттай сануулах шийтгэл” ногдуулах 0021 тоот санал гаргасан байна.

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Ажлын албаны шинжээчийн сахилгын Хаалттай сануулах шийтгэл ногдуулах санал болон гомдлын материалд цугларсан бичгийн бусад баримтыг судлан үзээд:

ХЯНАСАН нь:

Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн, сахилгын шинжээч шалгах ажиллагаа явуулсан байх ба маргааны материалд цугларсан баримтанд үндэслэн үзвэл, уулзалтын өрөө рүү нэвтрэх гар утас, цүнхээ үлдээх шаардлагыг өмгөөлөгч нь биелүүлээгүй, цагдан хоригдож байгаа үйлчлүүлэгч Б.М-тай уулзахдаа гар утсаар яриулсан болох нотлох баримт, хариуцагчийн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн тайлбар зэргээр нотлогдож байна. Харин хамгаалалтын албаны ажилтныг хэл амаар доромжлосон зөрчил нь нотлох баримтаар тогтоогдохгүй байна.

Хууль зүйн сайдын 2013 оны А/75 тоот тушаалаар батлагдсан “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”, мөн Хууль зүйн сайдын 2014 оны А/209 тоот тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам”, “Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхийг хангах талаарх ШШГЕГ, Монголын Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хороо хоорондын санамж бичиг” зэрэг эрх зүйн актуудыг үндэс болгон маргааныг хянан үзвэл, өмгөөлөгч хорих байранд нэвтрэхдээ гар утсаа хураалгах, гарахдаа авах зохицуулалттай байгаа тул шинжээчийн гаргасан санал үндэслэл бүхий байна.

Өмгөөлөгч М.Т нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26-р зүйлийн 26.1.1-д заасан “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон Хуульчийн Мэргэжлийн дүрэмд захирагдах”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4-р зүйлийн 1.4.1-ийн 1.3-д заасан “шударга ёсыг баримтлах”, 1.4-ийн “хууль дээдлэх”, 1.6-ийн “зарчимч байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Гэхдээ энэхүү зөрчлийг гаргасан болохоо хуульч, өмгөөлөгч М.Т нь хүлээн зөвшөөрсөн, чин сэтгэлээсээ гэмшсэн, бусдад хохирол учруулаагүй байна.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4-т заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульч, өмгөөлөгч М.Т нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26-р зүйлийн 26.1.1, 29-р зүйлийн 29.1.1, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4-р зүйлийн 1.4.1-ийн 1.3, 1.4, 1.6 дахь заалтыг баримтлан, Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан шийдвэрлэх дүрмийн 2.2-ийн 2-т заасны дагуу сахилгын “Хаалттай сануулах шийтгэл” оногдуулсугай.
2. Гомдол гаргагч ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих-р анги, Нийслэлийн прокурорын газарт тогтоолын хувийг хүргүүлэхээр Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албанд даалгасугай.
3. Энэхүү тогтоолыг гомдол гаргагч, хариуцагч эс зөвшөөрвөл, тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Хороонд гомдол гаргах эрхтэйг дурьдсугай.
4. Гомдлын материал /нийт 31 хуудас/-ыг Хорооны ажлын албанд хүргүүлсүгэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 03 сарын 27 өдөр

Дутаар 13

Улаанбаатар хот

Хаалттай сануулах тухай

Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээч Т.Жадамбаагаас Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх 3 дугаар бүрэлдхүүнд 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн “Сахилгын шинжээчийн 0019 дугаар санал”-ын талаар зөвлөлдөөд

ТЭМДЭГЛЭХ нь:

Сахилгын шинжээч Т.Жадамбаагийн 2015 оны 03 дугаар сарын 3-ны өдрийн 0019 дугаар саналд:

Хариуцагч: Чингэлтэй дүүргийн 17-р хороо. Сурагчийн 75-р гудамжнытоотод ам бүл гурвуул амьдрах, эрэгтэй, онд төрсөн \РД: \, дээд боловсролтой, хуульч мэргэжилтэй, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нэгдсэн бүртгэлийн-рт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн-рт тус тус бүртгэгдсэн, Б овогт Ч.Н нь үйлчлүүлэгч Н.М-тай Цагдан хорих дүгээр ангийн ганцаарчлан уулзах өрөөнд 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдөр уулзахдаа “Затзипд” ОТ-Е 1200 маркийн утас дамжуулан өгсөн болох нь :

1. Цагдан хорих дүгээр ангийн шуурхай бүлгийн ахлагч В.Ч-ын Мэргэжлийн хариуцлагын хороонд бичгээр гаргасан тайлбарт “...өмгөөлөгчийн уулзалтын байранд хоригдогч Н.М өөрийн өмгөөлөгч Ч.Н-тай уулзаад гарч ирэхэд нь үзлэг хийхэд ОТ-Е 1200 маркийн гар утас биедээ нуусан байсан нь илэрсэн. Камерийг буцаан шалгахад өмгөөлөгч Ч.Н цаасанд ороон торны завсраар өгсөн байсан.” гэснээр
2. Гэрч Н.М-аас: “2014 оны 12 дугаар сарын 26-ны өглөө 10 цагаас өмгөөлөгч Н.Н-аас гар утас авсан. Шуурхай бүлгийн Н.Ч ахлагчид хураалгасан.Манай эхнэр л оруулаад өгөөч гэж гуйгаад өмгөөлөгчид гар утас өгсөн юм шиг байна билээ” гэсэн тайлбар тодорхойлолт гаргаснаар
3. Хариуцагч Ч.Н-с: “...2014 оны 12 дугаар сарын 26-нд хууль зүйн туслалцаа үзүүлж байсан Н.М-тай уулзах үед түүний эхнэр “ манай нөхөр ФМ сонсдог юм. Үүнийг оруулаад өгөөч “гээд скочдсон зүйл өгөхөөр нь Н.М-д дамжуулж өгсөн. Би гар утас гэдгийг мэдээгүй, ФМ л гэж ойлгосон. Гэвч энэ асуудалд би буруутай гэдгээ ойлгож байна.” гэснээр тус тус нотлогдсон гэж үзлээ.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэр биелүүлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “хорих байранд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “хорих байрны дотоод журам”-ыг дагаж мөрдөнө.” гэж заасны дагуу Хууль зүйн

сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан “хорих байрны дотоод журам”-ын арван нэг дэх хэсгийн 11.3-т “хорих байранд нэвтрэх эрх бүхий ... өмгөөлөгч, уулзалтаар ирэгсдийг металл мэдрэгч хаалгаар, эд зүйлсийг хяналтын төхөөрөмжөөр оруулж хорих байранд хориглосон эд зүйл болон гар утсыг хураан авч тэмдэглэл үйлдэж, гарахад нь буцаан олгоно.” гэж тус тус заасан байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, мөн хэсгийн 26.1.1-д “Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах нийтлэг үүрэг хүлээнэ: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон Хуульчийн мэргэжлийн дүрэмд захирагдах” гэж заажээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч Ч.Н нь иргэн Н.М-ыг өмгөөлөх буюу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зорилгоор 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Цагдан хорих дүгээр ангид нэвтрэхдээ гар утас хураалгалгүй үйлчлүүлэгч Н.М-д дамжуулан өгсөн нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, хууль зүйн сайдын 2014 оны А/209 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчсөн үйлдлийг гаргасан байх ба энэ үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, мөн хэсгийн 26.1.1-д заасан зөрчил гэж үзлээ.

Хариуцагч Ч.Н нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч байгаа, чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад хохирол учруулаагүй зэрэг байдлыг харгалзан Сахилгын шинжээчээс Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг 3.3. дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар хариуцагч Ч.Н-д сахилгын хаалттай сануулах шийтгэл ногдуулах санал ирүүлснийг үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэг, 10.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8-д заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д заасныг баримтлан хуульч Б овогт Ч.Н-д “ хаалттай сануулах шийтгэл ногдуулсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Хаалттай сануулах тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд ирүүлсэн “Сахилгын шинжээчийн 0037 дугаар санал”-ын талаар зөвлөлдөөд

ТЭМДЭГЛЭХ нь:

Сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналд: “...” ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч С.Ү нь “Рөүт трейдинг” ХХК-тай өдөр тутмын үйл ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах явцдаа Т.Г-ын нэхэмжлэлтэй “Рөүт трейдинг” ХХК-ийн хариуцагчаар татагдсан иргэний хэрэгт “...” ХХН-ийн хуульч, өмгөөлөгч нарыг удирдлага зохион байгуулалтаар хангаж чадаагүйгээс “Рөүт трейдинг” ХХК-ийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн байх тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон С.Ү-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна” гэжээ.

“...” ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч С.Ү Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан хүсэлтдээ: “Миний бие нь Рөүт трейдинг ХХК-ийн давж заалдах гомдлыг хугацаа хожимдуулсан асуудалд Өмгөөллийн “...” ХХН-ийн гүйцэтгэх удирдлагын хувьд хариуцлага алдсанаа хүлээн зөвшөөрч байна. Надад хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

“...” ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч С.Ү нь “Рөүт трейдинг” ХХК-тай өдөр тутмын үйл ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах явцдаа Т.Г-ын нэхэмжлэлтэй “Рөүт трейдинг” ХХК-ийн хариуцагчаар татагдсан иргэний хэрэгт “...” ХХН-ийн хуульч, өмгөөлөгч нарыг удирдлага зохион байгуулалтаар хангаж чадаагүйгээс “Рөүт трейдинг” ХХК-ийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн алдаа гаргаж Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм зөрчихийг... хориглоно” гэснийг, “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд нийцүүлэн хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах талаар чармайн ажиллана” гэснийг зөрчсөн болох нь “Рөүт трейдинг” ХХК-ийн гомдол, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, Т.Г-ын нэхэмжлэлтэй “Рөүт трейдинг” ХХК-д холбогдох хэргийг

шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, түүнд бичсэн давж заалдах гомдол, "...“ ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч С.Ү нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч байгаа, чин сэтгэлээсээ гэмшсэн зэрэг байдлыг харгалзан Сахилгын шинжээчээс ирүүлсэн Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар түүнд хаалттай сануулах шийтгэл ногдуулах санал ирүүлсэн нь үндэслэлтэй байна гэж бүрэлдэхүүн үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2.1,2.3, 10.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8-д заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д зааснаар "...“ ХХН-ийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч С.Ү-д “Хаалттай сануулах” шийтгэл ногдуулсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Хаалттай сануулах тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд ирүүлсэн “Сахилгын шинжээчийн 0025 дугаар санал”-ын талаар зөвлөлдөөд

ТЭМДЭГЛЭХ нь:

Сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналд “Хуульч, өмгөөлөгч Т.Б нь хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг иргэн Г. Н-тай бичгээр байгуулаагүй, өмгөөлөгчөөс татгалзах тухай үйлчлүүлэгч мэдэгдэх хүртэл хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй нь нотлогдсон, хариуцагч гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч, чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас иргэн Г.Н 250.000 төгрөгөөр хохирсон, хариуцагч уг гомдлыг сайн дураараа барагдуулсан байх тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Т.Б-д сахилгын “Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч Т.Б нь иргэн Г.Н-тай түүний ажлаас халагдсан асуудалд өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэхээр харилцан тохиролцож Г.Н-аас ажлын хөлсөнд 250.000 төгрөг авсан боловч хууль зүйн туслалцаа үзүүлээгүй, гэрээг бичгээр байгуулаагүй үйлдэл гаргасан байх ба энэ үйлдлээрээ, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн **2^А. 1.1** “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах, хатгах...” хориглоно,

“Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хуульч нь Мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана. 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэснийг тус тус зөрчсөн гэж үзлээ.

Хариуцагч Т.Б нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч байгаа, чин сэтгэлээсээ гэмшсэн, уг зөрчлийн улмаас бусдад учирсан хохирлоо барагдуулсан зэрэг байдлыг харгалзан Сахилгын шинжээчээс Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар хариуцагч

Т.Б-д сахилгын хаалттай сануулах шийтгэл ногдуулах санал ирүүлснийг үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэг, 10.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8-д заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д заасныг баримтлан хуульч М. овогт Т.Б-д “Хаалттай сануулах” шийтгэл ногдуулсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 06 сарын 26-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатархот

Хуульч Г.Н-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Х.Цогтсайхан даргалж, гишүүн Л.Болд, Ц.Өрнөндэлгэр, Ц.Оч, Ц.Сумъяа нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр ирүүлсэн, хуульч Г.Н-д холбогдох дүгнэлтийг хянан хэлэлцэв.

Хуралдаанд:

Шинжээч Г.Должинсүрэн оролцож,

Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга Г.Урангоо хөтлөв.

ТОДОРХОЙЛОХ нь :

1. Гомдол гаргагч Б.Ц тус хороонд гаргасан гомдолдоо: “Б овогтой Ц миний бие ...нөхөр Н.Ө-аас салах болсон тул өмгөөлөгч авах шаардлага гараад өмгөөлөгч Г.Н-тэй гэрээ хийж өмгөөлж өгөхөөр болоод 150.000 төгрөг, 075 Улаанбаатар /14000/ төгрөгний үнэтэй архи аваад бүгд 164.000 төгрөг авсан үлдсэн 36.000 төгрөгийг өмгөөлсний дараа авахаар тохиролцоод бүгд 200.000 төгрөгөөр өмгөөлж өгөхөөр болоод явсан чинь тухайн үед нь утсаа авахгүй ямар ч холбоо барих боломжгүй болоод дахин өмгөөлөгч авч шүүх ажиллагаа дууссан учир ...энэ хүнд зохих ёсны арга хэмжээ авч, иргэн миний хохироосон мөнгийг авч өгнө үү” гэжээ /хх 2 хуудас/

2. Гомдол гаргагч Б.Ц тус хороонд өгсөн тайлбартаа: “ 2014 оны 11-р сар орчмын үед Г.Н гэдэг өмгөөлөгч нь миний ээж Н.Б бид хоёрын хамт ажиллуулдаг хүнсний дэлгүүрт өөрийн өмгөөлөгчийн цэнхэр өнгийн үнэмлэхээ /иргэний үнэмлэх шиг жижигхэн/ барьцаанд тавьсан байсан. Тухайн үед нөхрөөсөө салах гэж байсан мөн хуулийн ямар нэг мэдлэг байхгүй учраас дээрх барьцаанд тавьсан байсан өмгөөлөгчийн үнэмлэхний эзэн болох Г.Н-тэй утсаар нь холбогдож хууль зүйн зөвлөгөө авья гэж дуудсан. Гэтэл Г.Н 22:00 цаг өнгөрч байх үед /яг хэдэн сарын хэдний өдрийг сайн санахгүй байна/ эхнэртэйгээ хамт орж ирсэн. Би өөрөө ажлаа хийж байсан учраас ээж өмгөөлөгч Н-тэй уулзаад Иргэний журмаар гэр бүлээ салгуулахад яадаг ийдэг талаар асууж лавласан. ... 2014 оны 12-р сарын 25-ны өдөр дээрх асуудалд Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан нэмж 100.000 төгрөгийг бэлнээр мөн 0.75 литрийн Улаанбаатар архи /тухайн үед 14.000 төгрөгөөр зарагдаж байсан/ нэг ширхэгийг тус тус авсан. 2014.12.26-ны өдөр Гэрээг миний бие өөрөө шүүхэд гаргаж өгсний маргааш өдөр нь Шүүхээс намайг дуудсан. Шүүхэд би өөрөө гомдол гаргаад тэмдэгтийн хураамжаа төлсөн байсан. Шүүх хуралдаан дээр

өмгөөлөгчөөр өмгөөлүүлнэ гэсэн байр суурьтай л байсан. Шүүхээс дуудсан өдөр өмгөөлөгч Г.Н-тэй холбогдож “Шүүхээс дуудсан, та завтай бол өнөөдөр шүүх дээр очооч ээ” гэж хэлсэн. Тэгсэн чинь өмгөөлөгч Г.Н “Чи ганцараа битгий очоорой, хамт явна шүү, Шүүхийн туслах ажилтан /нэрийг нь сайн санахгүй байна/ -тай ярьчихсан, Ц-ыг би өөрийг нь дагуулж очно гээд хэлчихсэн байгаа” гэж хэлсэн. Тэгээд л утас нь холбогдохгүй, гэрээнд бичсэн байсан утасны дугаар нь ч холбогдохгүй байсан. ...2015 оны 01-р сарын 14-ны өдөр шүүх хуралдаантай, өмгөөлөгч байвал хамт ирээрэй, өөрөө шаардлагагүй гэж үзвэл ганцаараа ирээрэй гэж хэлсэн. Ингээд залгаад байхад утас нь огт холбогдохгүй салгаатай байсан. Шүүх хурал болох гээд Цацралтуяа гэдэг өмгөөлөгчийг авч ороод хуралдаан шийдвэрлэгдэж гэр бүлээ цуцлуулсан” гэх тайлбар /хх 6-8 хуудас/

3. Хариуцагч Г.Н тус хороонд өгсөн тайлбартаа: “2014 оны 11 сард гомдол гаргагч Ц-ын ээж надтай холбогдож охиноо нөхрөөс нь салгах хүсэлтэй байна. Та завтай бол миний ажилладаг дэлгүүр дээр ирж хууль зүйн зөвлөгөө өгөөч гэсэн. Тэгэхээр нь дэлгүүр дээр нь уулзахад “Өөрийг чинь албан ёсоор өмгөөлөгчөөр авах хүсэлтэй байна, гэрээгээ байгуулья” гэсэн. Тэрний дагуу өмгөөллийн хөлсийг 200.000 төгрөгөөр тохиролцоод урьдчилж 164.000 төгрөгийг авсан. Тэгээд өөрийн буруутай үйлдлийн улмаас Эрх зүйн туслалцаа үзүүлж чадаагүй. ...Хөдөө гадаа ажлаар яваад, мөн эхнэр төрөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх боломж бүрдээгүй. Амаар 2 удаа, утсаар 4-5 удаа хууль зүйн зөвлөгөөг өгсөн ба өөрийнхөө зардлаар байгаа газарт нь очиж хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулж байсан. Түүнээс Шүүхэд бичгээр албан ёсоор хүсэлт гаргаж өгсөн асуудал байхгүй. ... Цаашдаа дээрх алдаа оноогоо бүрэн ухамсарлаж засаж залруулан ажиллана. Мөн мэргэжлийн үйл ажиллагааг явуулахдаа ямар нэг зөрчил дутагдал гаргалгүй хичээж хуульчийн нэр хүндийг өргөж ажиллана. Өөрийнхөө буруутай үйлдлийг ойлгож байна. ... Нийт 164.000 төгрөгөөс гомдол гаргагч Б.Ц-д 140.000 төгрөгийг 2015 оны 04-р сарын 01-ний өдрийн 12:00 цагт өгсөн. Үлдсэн 24.000 төгрөгийг гомдол гаргагч Н.Ц Эрх зүйн зөвлөгөө авсан гэж өөрөө шийдээд авахаас татгалзсан. Өөрөө ч энэ тухай танай Хороонд хүсэлт бичиж өгч ямар нэг гомдол саналгүй болсон. ...Би өөрийнхөө хийсэн буруутай үйлдлээ ойлгож ухамсарлаж байна. Цаашид хуульч хүнийхээ зүгээс Мэргэжлийн хариуцлагын зөрчлийг гаргахгүйгээр хичээж ажиллана. Гэм буруугаа ойлгож байна. Бүрэлдэхүүний хуралдаанд биеэр оролцохгүй өөр хэлэх зүйл байхгүй” гэх тайлбар /хх 10-12 хуудас/

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ:

1. Өмгөөлөгч Г.Н нь иргэн Б.Ц-ын нэхэмжлэлтэй хариуцагч Н.Ө-аас салах тухай гэр бүлийн маргаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор харилцан тохиролцож хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан өмгөөллийн хөлсөнд 164.000 төгрөг авсан атлаа хууль зүйн туслалцаа үзүүлээгүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн эсэхийг тогтоолгоно.

2. Хариуцагч Г.Н нь гомдол гаргагч Б.Ц-д 140.000 төгрөг төлсөн, гомдол гаргагчийг гомдол саналгүй болгосон байгаа болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Б.Ц нь өмгөөлөгч Г.Н-д зохих хариуцлага хүлээлгэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу өгсөн 164 000 төгрөгийг буцааж авах гомдол гаргасан бөгөөд үндэслэлээ: “Өмгөөлөгч Н-тэй гэрээ хийж өмгөөлж өгөхөөр болоод 150.000 төгрөг, 0,75 Улаанбаатар /14000/ төгрөгний үнэтэй архи аваад бүгд 164.000 төгрөг авсан үлдсэн 36.000 төгрөгийг өмгөөлсний дараа авахаар тохиролцоод бүгд 200.000 төгрөгөөр өмгөөлж өгөхөөр болоод явсан чинь тухайн үед нь утсаа авахгүй ямар ч холбоо барих боломжгүй болоод дахин өмгөөлөгч авч шүүх ажиллагаа дууссан” гэж тайлбарлав.

Г.Н, Б.Ц-ын гомдолд тайлбар өгөхдөө: “2014 оны 11 сард Б.Ц-ын ээж надтай холбогдож охиноо нөхрөөс нь салгах хүсэлтэй дэлгүүр дээр нь уулзахад “Өөрийг чинь албан ёсоор өмгөөлөгчөөр авах хүсэлтэй байна, гэрээгээ байгуулья” гэсэн. Тэрний дагуу өмгөөллийн хөлсийг 200.000 төгрөгөөр тохиролцоод урьдчилж 164.000 төгрөгийг авсан. Тэгээд өөрийн буруутай үйлдлийн улмаас Эрх зүйн туслалцаа үзүүлж чадаагүй.” гэжээ.

Өмгөөлөгч Г.Н нь иргэн Б.Ц-тай 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, гэр бүлийн маргаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор харилцан тохиролцож, өмгөөллийн хөлсөнд 164.000 төгрөг авсан атлаа хууль зүйн туслалцаа үзүүлээгүй болох нь тогтоогдож байх тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн дүгнэлтийг үндэслэлтэй байна гэж үзлээ.

Г.Н нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн байх тул түүний шүүхэд төлөөлөх эрхийг 6 сарын хугацаатай түдгэлзүүлэх нь зөв гэж бүрэлдэхүүн үзлээ.

Хариуцагч Г.Н нь Б.Ц 140.000 төгрөг төлсөн, гомдол гаргагч гомдол, саналгүй болно.

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4-Р зүйлийн 1, 14.5, 14.6-р зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь :

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.2 хэсэг, Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Г.Н-н шүүхэд төлөөлөх эрхийг 6 сарын хугацаатай түдгэлзүүлсүгэй.
2. Хариуцагч Г.Н нь гомдол гаргагч Б.Ц 140.000 төгрөг төлсөн, гомдол гаргагч гомдол саналгүй болохыг дурдсугай.
3. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурьдсугай.
4. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл оногдуулах тухай

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн Э.Ариунаа даргалан гишүүн Т.Өсөхбаяр, Ц.Оч, Б.Бат-Орших, Ц.Давхарбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр Сахилгын шинжээчээс хариуцагч, хуульч Б.Э-д сахилгын "Хаалттай сануулах" шийтгэл хүлээлгэх санал гаргасныг холбогдох нотолгоо баримтын хамт 2015 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэж зөвлөлдөөд

ТОДОРХОЙЛОХ нь:

Хариуцагч: оны 03 дугаар сарын 31-ний өдөр төрсөн /РД:/ Эрэгтэй. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуульчдын нэгдсэн бүртгэлийн-дугаарт, шүүхэд төлөөлөх эрх бүхий хуульчдын бүртгэлийн дугаарт тус тус бүртгэгдсэн. Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч ажилтай Б овогт Б.Э.

Сахилгын шинжээчийн 2015 оны 07 дугаар сарын 22-ны өдрийнтоот саналд:

Хариуцагч Б.Э нь Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон Б.Т-д хууль зүйн туслалцаа үзүүлэхээр 2015-03-05-ны өдөр гэрээ байгуулан өмгөөлөгчөөр ажиллах явцдаа түүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх анхан шатны шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 25, 2015 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн шүүх хуралдаанд оролцох боломжгүйгээ урьдчилж бичгээр шүүхэд мэдэгдээгүй, уг хуралдаануудад хүндэтгэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй болох нь дараахи баримтуудаар нотлогджээ. Үүнд:

1. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн 2015- 06-11-ний 1013 тоот албан бичигт: "...шүүгдэгч М овогт Б Т-д эрх зүйн туслалцаа үзүүлэхээр томилогдсон өмгөөлөгч Б.Э нь 2015 оны 05 дугаар сарын 25, 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд зарлагдсан шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй байх тул зөрчлийг хянан шалгаж хариуцлага тооцуулахаар уламжлав. Жич: Хувийг Монголын Хуульчдын Холбоонд." гэжээ.
2. Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны дүгээр шүүхээс, Б.Т нарт холбогдох эрүүгийн дугаартай хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг хойшлуулсан тухай 2015-05-25-ны өдрийн 354, 2015-06-08-ны өдрийн 391 дугаар тогтоолууд
3. Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны товыг мэдэгдсэн тухай баримтууд,
4. Хариуцагч Б.Э-ээс: "Хэнтий аймагт хувийн ажлаар яваад машин эвдэрсэн болон өвчний улмаас шүүх хуралдаануудад оролцож чадаагүй. Энэ тухай баримт байхгүй. Хуралдаанд оролцож чадахгүйгээ шүүгчийн туслах, нарийн бичгийн

даргад мэдэгдээгүй. Миний бие цаашид хариуцлагатай байх ба дахин алдаа гаргахгүй. Гэм буруугаа хүлээн зөвшөөрч байгаа тул “Хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү.” гэсэн агуулгатай тайлбар гаргаснаар

5. Б.Э нь Б.Т-д хууль эрх зүйн туслалцаа үзүүлэхээр байгуулсан гэрээ
6. Б.Э нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн тухай Хуульчдын холбооны 2/603 тоот албан бичиг зэрэг болно.

Эдгээр баримтуудаас үндэслэн:

Хариуцагч Б.Э-г, өөрийн үйлчлүүлэгчид холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан хэлэлцэх 2 удаагийн буюу 2015-05-25, 2015-06-08-ны өдрийн шүүх хуралдаануудад оролцоогүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 242 дугаар зүйлийн 242.1 дэх хэсэгт заасан “...өмгөөлөгч...шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж бичгээр шүүхэд заавал мэдэгдэх...”, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 болон 26.1.1-д заасан “Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ... Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Хуульчийн мэргэжлийн дүрэмд захирагдах” гэсэн үүргээ тус тус үл биелүүлэн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан гэж үзлээ. /Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/

Хариуцагч зөрчил гаргаснаа шударгаар хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ гэмшин цаашид дахин зөрчил гаргахгүйгээ илэрхийлсэн, “үйлчлүүлэгч, олон нийт, хууль зүйн тогтолцоо, эсхүл мэргэжлийн нэр хүндэд бодьтой хохирол” учирсан нь тогтоогдоогүй тул Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Б.Э-нд сахилгын хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргав.” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч Б.Э шүүгдэгч Б.Т-д хууль эрх зүйн туслалцаа үзүүлж өмгөөлөхөөр гэрээ байгуулсан боловч анхан шатны шүүх Б.Т нарт холбогдох эрүүгийн хэргийг 2015 оны 05 дугаар сарын 25, 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд хянан хэлэлцэхэд оролцоогүй, тухайн хуралдаануудад оролцох боломжгүйгээ урьдчилж шүүхэд бичгээр мэдэгдээгүй нь эрүүгийн хэргийн анхан шатны дүгээр шүүхийн /тухайн үеийн нэрээр/ Ерөнхий шүүгчийн 1013 тоот албан бичиг, мөн шүүхийн 2015- 05-25-ны өдрийн 354, 2015-06-08-ны өдрийн 391 дүгээр тогтоолууд, хэргийн оролцогч нарт шүүх хуралдааны товыг мэдэгдсэн тухай баримтууд, хариуцагч Б.Э-ээс гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрсөн тайлбарууд зэргээр нотлогдсон байх ба маргаан шалгах ажиллагааг тогтоосон журмын дагуу явуулжээ.

Хариуцагч Б.Э дээрх үйлдлээрээ ЭБШХ-ийн 242 дугаар зүйлийн 242.1 дэх хэсэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн 26.1.1- д заасан үүргээ биелүүлээгүй буюу Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил гаргасан, хариуцагч гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч гэмшиж байгааг харгалзан түүнд сахилгын “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үзлээ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 10.12 дугаар зүйлийн 4, 14.4, 14.5, 14.6 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, мөн хэсгийн 29.1.1-д заасныг баримтлан хуульч Б.Э-нд “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулсугай.
2. Зөрчлийн товч агуулгыг Хуульчдын холбооны цахим хуудаст нийтэлж болохыг дурдсугай.
3. Энэ тогтоолыг Б.Э-д гардуулан өгөхийг Ажлын албанд даалгасугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 11 сарын 19

Дугаар 30

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Ё.Э-нд холбогдох Маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Б.Цолмонбаатар даргалж, гишүүн С.Буд, Д.Байгалмаа, Л.Данзанноров, Е.Сагсай нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс ирүүлсэн өмгөөлөгч Ё.Э-нд холбогдох 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн дүгнэлтийн дагуу Я.Я-ийн гомдлыг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Япон Улсын иргэн Я.Я тус хороонд гаргасан гомдолдоо: "...улсын иргэн Я.Я миний бие 2012 онд анх Монгол улсад хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар болж иргэн Жүгдэрээс үнээний ферм болон тариалангийн 200 га газрыг хөрөнгө оруулж худалдан авсан юм. Гэтэл тухайн үед хамтран ажиллаж байсан иргэн Т.Э-тэй эд хөрөнгийн маргаан үүсч өмгөөлөгч Ё.Э-ыг өмгөөлөгчөөр авсан. Тухайн үед Ё.Э-ыг миний хамтран ажиллаж байсан Ж.Н танилцуулж дагуулж ирсэн. Ж.Н нь үнээний ферм, 200 га газар зарсан Жүгдэрийн хүү юм. Тус өмгөөлөгч болон н.Ж, Н.Н нар нь эртний танил нөхдүүд юм.

Өмгөөлөгч Ё.Э нь 2012 оноос 2014 оны 8 сар хүртэл шүүх хурал болж байгаа мэтээр надад ойлгуулсан. 2014 оны 8 сард шүүх хурал дууссан. Шүүхийн шийдвэр таны талд гарсан. Одоо эд хөрөнгөө буцаан авахын тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 4.9 сая төгрөг төлчихвөл тэр дороо шууд танай нэр дээр болно" гэж хэлсний дагуу төлсөн. 11 сарын 8-ны өдөр тус өмгөөлөгчтэй уулзахад "10 сард шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт төлөх төлбөр 4.9 сая төгрөгийг төлчихсэн байгаа, одоо удахгүй танай нэр дээр шилжинэ, одоо бараг шилжсэн байгаа" гэсэн боловч, 2015 оны 1 сар дуустал нэр дээр шилжээгүй байсан.

2012 оноос 2013 онд тус өмгөөлөгчид 10 гаран сая төгрөгийг өмгөөллийн хөлсөнд төлсөн. Мөн дээрээс нь нэмж өмгөөллийн хөлс төл, тэгвэл одоо ажиллагаа хийнэ гэсний дагуу нэмж мөнгө төлсөн. Тус өмгөөлөгчид 2014 оны 10 сараас 2015 оны 1 сард өмгөөлөгчийн хөлсөнд нийт 11.500.000 төгрөг төлсөн.

Уг өмгөөлөгч нь 2014 онд ямар нэг шүүх хурал болоогүй байсныг болсон мэтээр ярьж намайг хууран мэхэлж байсныг сүүлд мэдсэн. Мөн өмгөөлөгч Ё.Э нь миний түүнд итгэж итгэмжлэл өгсөнийг далимдуулан миний зөвшөөрөлгүйгээр нэхэмжлэлийн шаардлагыг өөрчилж хамтран ажиллах гэрээний маргаан биш газрын эзэмших эрх болон өмчлөх эрх шилжүүлсэнтэй холбогдох маргаан болгон өөрчилж шүүхэд хандсанаар миний бие 70 сая төгрөг болон хамтран ажиллах

гэрээнд оруулсан өөрийн хөрөнгийг нэхэмжлэх боломжгүй болсон. Үүний үр дүнд миний бие 70 сая төгрөгийн хохирол амсаад байна. Одоогийн байдлаар Ж-ээс үнээний ферм, 200 га тариалангийн газрыг 70 сая төгрөгөөр худалдан авч, Ж-т 70 сая төгрөг төлсөн ба эд хөрөнгө одоогийн байдлаар Ж-ийн эзэмшилд очсон байдалтай байна.

Тус өмгөөлөгч нь 2014 оны 8 сараас 2015 оны 2 сарын 12 хүртэл янз бүрийн шалтгаан тоочин ямар ч өмгөөллийн ажиллагаа явуулаагүй, утсаа ер авахгүй байсаар 2015 оны 2 сар хүргэсэн. Би удаа дараа танд ямар нэг шалтгаан байвал бид өөр арга бодъё гэдгээ хэлсэн боловч хийнэ гэж хэлсээр 2 сарын 12-ны өдөр болсон.

Хуульч хүн болохоор нь Ё.Э-нд эцсийг нь хүртэл итгэсэн. Энэ өмгөөлөгч хэргийг өмгөөлж өгөх нь битгий хэл намайг маш хүнд байдалд оруулж, их хэмжээний хохирол учруулсан ба залилан мэхлүүлсэндээ туйлын их гомдолтой байна. Монголын Хуульчдын холбоо энэ асуудлыг үнэн зөв, чин шударгаар шийдэж өгнө гэдэгт итгэж байна.

Мөн Өмгөөлөгч Ё.Э нь удаа дараа намайг хууран мэхэлж, ёс зүйгүй үйлдэл гаргаж, хуульч хүнд байж боломгүй залилан мэхлэх үйлдэл хийсэнд туйлын гомдолтой байна" гэжээ.

..... Улсын иргэн Я.Я-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Т тус хороонд ирүүлсэн болон хуралдаанд гаргасан тайлбартаа: "Бидний зүгээс Ё.Э-нд анх хандахдаа 200 га тариалангийн газар болон үхрийн фирмийг Т.Э-ээс буцаан авах хүсэлтэй байгаагаа хэлж өмгөөлөгчөөр авсан. ... 2013 оны 10 сард шүүгчийн захирамж гарснаас хойш бараг 1 жилийн дараа "Шүүх хурал сая л дууслаа, шүүхэд ялсан. 4.9 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт төлчихвөл шууд нэр дээр чинь болно" гэсний дагуу 2014 оны 10 сарын 6-нд Ё.Э-нд 4.9 сая төгрөгийг төлсөн. "Би очиж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 10 сард 4.9 сая төгрөгөө төлчихсэн, надад баримт нь байгаа, одоо бараг нэр дээр чинь болж байгаа байх гэж хэлж байсан" гэжээ.

Хариуцагч Ё.Э тус хороонд өгсөн тайлбартаа: Дээр дурдаад байгаа мөнгө нь Шүүхийн шийдвэр гарчихсан учраас өгсөн авсан зүйлээ буцаахаар болсон гэтэл анх Я.Я нь н.Э нэр дээр болгочихсон байсан учраас шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт н.Э болон түүний өмгөөлөгч Г хүсэлт гаргаж шийдвэр гүйцэтгэлд ажиллагаа хийлгүүлэхээр хандсан байсан. Энэ тухай н.Ц хэлээд гүйцэтгэх баримтыг буцаалгах тухай хүсэлт гаргасан. Т.Ц буцаахыг зөвшөөрч албан тоотоор надад хариу өгсөн. Хоёр газрын чинь гэрчилгээг танай нэр дээр шилжүүлэхийн тулд 70 сая төгрөгийн 7 хувь болох 4.900.000 төгрөгийг төлж ажиллагаагаа хийлгэ гэсэн санал тавьсан. Энэ тухай Я-д хэлтэл зөвшөөрөөгүй. Тэр хооронд сумын Засаг даргаас 190 га газрыг чөлөөлөх мэдэгдлийг н.Ж хоёр удаа өгсөн байсан. Үүнийг н.Я ч мэдэж байгаа. Тэгээд 2014 оны 10 сард н.Я ирээд дээрх саналыг зөвшөөрөөд н.Т-аар дамжуулан 4.900.000 төгрөгийг өгсөн. Дээрх мөнгийг шууд аваачаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын данс руу шилжүүлэх боломжгүй. Учир нь дээрх нөхцөл байдлыг судлаж нягтлаад тушаана гэж бодож байсан. Тэгээд л бие өвдөөд өнөөдрийг хүрсэн. Тухайн мөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын данс болон ямар нэг албан тушаалтанд өгөөгүй. Дээрх 4.900.000 төгрөг нь надад бэлнээр

байгаа. Энэ мөнгийг Я.Я-тай өөртэй нь уулзаж байж өгнө. Я.Я руу цахим шуудан илгээхээр орчуулагчид текстээ өгчихсөн байгаа. Орчуулж дуусахаар Я.Я-ийн хаяг руу илгээнэ. Тухайн захидалд Я.Я-ийн дансны дугаарыг нь аваад мөнгийг данс руу нь хийхээр бичигдсэн байгаа” гэжээ.

..... аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны 2015 оны 04 сарын 21-ний өдрийн албан бичиг: Төв аймаг дахь Сум дундын дугаар шүүхийн шүүгчийн 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 418 дугаар захирамжийг гүйцэтгэх ажиллагааг 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс үүсгэсэн ба гүйцэтгэх баримт бичигт 70.000.000 төгрөгийн үнийн дүн заагдаагүй байсан тул энэ үнийн дүнгийн 7 хувь буюу 4.900.000 төгрөг төлөх шаардлага Ё.Э-нд тавих үндэслэлгүй байна. Ё.Э нь тус албатай урамшуулал, зардлын гэрээ байгуулаагүй, улмаар 2014 оны 05 дугаар сарын 19-нд гүйцэтгэх бичиг баримтыг буцаалгах хүсэлт гаргаж, тус алба 2014 оны 05 дугаар сарын 23-нд гүйцэтгэх бичиг баримтыг буцаасан гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ: “Хариуцагч Ё.Э-н нь ...Улсын иргэн Я.Я-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ж.Э холбогдох иргэний хэрэгт оролцохдоо иргэн Я.Я-оос “Шүүх хурал дууссан, шүүхийн шийдвэр таны талд гарсан. Одоо эд хөрөнгөө буцаан авахын тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 4.900.000 төгрөг төлчихвөл тэр дороо шууд таны нэр дээр /200 га газар/ болно” гэж худал хэлэн 4.900.000 төгрөг авсан, түүнийгээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар тушаагаагүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1, 27.1.2, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дугаар зүйлийн 1.12 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн зөрчсөн эсэхийг тогтоолгоно гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Япон улсын иргэн Я.Я анх аймагт Хөдөө аж ахуйн чиглэлээр аж ахуй эрхлэхээр Монгол улсын иргэн Т.Э-тэй хамтран ажиллах болж 70 сая төгрөг нийлүүлсэн, Т.Э нь иргэн Л.Ж-ээс үнээний ферм, тариалангийн газар худалдан авсан байдлууд хэргийн баримтаар тогтоогдож байна.

Гэвч хамтран ажиллаж байсан Т.Э-тэй эд хөрөнгийн маргаан үүсч, үүнийг шийдвэрлэх ажилд 2012 оноос өмгөөлөгч Ё.Э-ыг эрх зүйн туслалцаа авч ажиллуулах болсон байна. Өмгөөлөгч Ё.Э нь Я.Я төлөөлж Төв аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхэд Т.Э, Л.Ж нарын хооронд хийгдсэн 2011 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 190 га газар эзэмших эрх шилжүүлсэн гэрээ, 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 5000 га газар худалдах худалдан авах гэрээг тус тус хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл гаргаж, хэрэг энэ хугацаанд 2 удаа анхан шатны шүүхээр хэлэлцэгдэн, тус шүүхийн шүүгчийн 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 418 дугаар захирамжаар дээрх гэрээнүүдийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэгчийн шаардлагыг хариуцагч Т.Э, Л.Ж нар зөвшөөрснийг баталж, хэлцлээр шилжүүлсэн зүйлээ харилцан буцаан өгөх, буцаан өгөх боломжгүй бол үнийг өгөхөөр шийдвэрлэгдсэн байна. Энэ тухай холбогдогч, оролцогч нар тайлбарласан ба шүүхийн шийдвэрүүд байна.

..... аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн байх ба Ё.Э нь тус албатай урамшуулал, зардлын гэрээ байгуулаагүй, улмаар 2014 оны 05 дугаар сарын 19-нд гүйцэтгэх бичиг баримтыг буцаалгах хүсэлт гаргаж, тус алба 2014 оны 05 дугаар сарын 23-нд гүйцэтгэх бичиг баримтыг буцаасан нь талуудын тайлбар, дээрх албаны албан бичгээр тогтоогдож байна.

Гэтэл Ё.Э нь эд хөрөнгөө буцаан авахын тулд Шийдвэр гүйцэтгэх албанд 4.900.000 төлөх ёстой гэж Я.Я-оос 2014 оны 10 дугаар сарын 16-нд 4.900.000 төгрөгийг авсан, Шийдвэр гүйцэтгэх албанд тушаагаагүй, түүнд тушаах шаардлага байгаагүй нь тогтоогдож байна.

Өмгөөлөгч Ё.Э Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих... хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх... хориглоно”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 “Мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх” гэснийг тус тус зөрчсөн байх тул түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь :

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар Ё.Э-нд “Нээлттэй сануулах” шийтгэл ногдуулсугай.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурьдсугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2015 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Ц.Б-т холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Г.Ганзориг даргалж, гишүүн Д.Цэндсүрэн, Б.Баатар, Э.Золзаяа, Л.Амарсанаа нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн өмгөөлөгч Ц.Б-т холбогдох дүгнэлтийг хянан хэлэлцэв.

Хуралдаанд сахилгын шинжээч Г.Должинсүрэн,
хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

БНХАУ-ын иргэн н.Э тус хороонд гаргасан гомдолдоо: “БНХАУ-ын иргэн Э. миний бие Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Ц.Б-тай харилцан тохиролцож, хууль зүйн туслалцаа авахаар болсон болно. Хуульч, өмгөөлөгч Ц.Б дараахь ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тохирсон болно. “Үндэс” ХХК-ийн гүйцэтгэх захирал байсан.

Б овогтой Э-ыг хайж олоод тус компаний тамга, үүсгэн байгуулах үндсэн бичиг баримтуудыг гаргуулан авч, Улсын бүртгэлд тус компанийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчээр Энхбаярыг бүртгүүлж, нэг гишүүнтэй компани болгох, үүний дараа тус компанийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу албан ёсоор татан буулгах, “Үндэс” ХХК-ийн БНХАУ-д болж буй шүүх хуралд Монголын талын бүх бичиг баримтыг бүрдүүлж, оролцохоор харилцан тохиролцож, үйлчилгээний хөлсөнд 3000 ам доллар авсан юм. Гэтэл өмгөөлөгч Ц.Б нь 2014 оны 08 дугаар сарын 12-ны өдөр болсон шүүх хуралд оролцоогүй, уг хугацааг болтол бидэнтэй нэг ч холбогдоогүй, шүүхийн маргаанд оролцоогүй ялагдсан болно. Мөн Ц.Б нь дээрх компанийн бичиг баримтуудаас гадна миний хөрөнгө оруулагчийн бичиг баримт Монголд оршин суух үнэмлэх зэргийг авч, одоог болтол өгөхгүй байгаа юм. Иймд хуульч Ц.Б нь дээрх өмгөөлөгчийн хувьд тохиролцсон ажлаа огт хийгээгүй тул холбогдох арга хэмжээг авч, миний бичиг баримтууд болон ажлын хөлсөнд өгсөн 3000 ам.долларыг гаргуулж өгөхийг хүсье.” гэжээ. /ММ-н 3-р хуудас/

БНХАУ-ын иргэн Э тус хороонд гаргасантайлбартаа: Миний найз “Ирээдүй ” компаний захирал н.Д анх зуучилж өгсөн юм. Гэрээ хийх гэсэн боловч өмгөөлөгч Ц.Б-ын өөрийнх нь авч ирсэн гэрээ нь шаардлага хангаагүй, үсгийн фонд нь танигдахгүй байсан. Надад итгэж болно гэж хэлсэн. ... “Үндэс” гэдэг компаний холбогдох баримт бичгийг

Б.Э гэдэг манай компанид гүйцэтгэх захирал хийж байсан хүн манай компанийн бичиг баримтыг аваад алга болсныг олуулах, хоёрт нь “Үндэс” компанийг миний нэр дээр болгуулах хэрэв болохгүй бол уг компанийг татан буулгуулах гэсэн 2 ажил тохиролцсон. ... Өмгөөлөгч Ц.Б надад хариулахдаа би дээрх 2 асуудлыг чинь 10 хоногийн дотор шийдэж өгнө гэж хэлсэн. Та надад итгэж болно гэж хэлсэн. Гэвч асуудлыг шийдэж чадаагүй. Элчин сайдын яаманд очиж “Үндэс” компани нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг гэсэн бичиг баримт авах байсан ч итгэмжлэл байхгүй н.Ц гэдэг “Ирээдүй” компаний ажилтныг явуулсан байсан. Би өмгөөлөгч Ц.Б-т албан ёсоор итгэмжлэл өгсөн байсан өөрийнх нь хариуцлагагүй үйлдлээс болж би одоо хүртэл “Үндэс” компани нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг гэсэн баримт бичгээ авч чадаагүй л байна. ... Эхлээд 1 мянган долларыг Улаанбаатарын Төмөр замын вокзал руу өмгөөлөгч Ц.Б өөрөө ирж авсан. 2 мянган долларыг нь сүүлд Замын цагдаагийн хажуу дахь ХААН банкны захирал С.Э дамжуулж өгсөн. ... Надад хууль зүйн туслалцаа үзүүлээгүй ямар нэгэн мэдээлэл өгч байгаагүй. 2 мянган ам доллар авахаасаа өмнө бол өдөр болгон шахуу ярьж байсан боловч 2 мянган доллар авснаас хойш надтай утсаар ярихаа больсон. Саяхан 2014 оны 11 дүгээр сарын 04-нд надтай өмгөөлөгч Ц.Б утсаар ярьсан. Ярихдаа маргааш бичиг баримтыг чинь өгнө гэсэн боловч дахиад л өгөөгүй алга болсон. Одоо би хуульчид итгэх итгэлээ өмгөөлөгч Ц.Б-аас болж алдаад байна. ... Нэгд БНХАУ-д байгаа 4 хувьцаа эзэмшигчээс 2 хувьцаа эзэмшигч надтай холбогдуулж гомдол гаргасан байгаа тэр хэрэгт надад холбогдох баримт бичгийг өмгөөлөгч Ц.Б тохиролцсон ёсоор олж өгч чадаагүйн улмаас би уг маргаанд ялагдсан” гэсэн байна. / ММ-н 6-8-р хуудас/

БНХАУ-ын иргэн н.Э тус хороонд гаргасан нэмэлт тайлбартаа: БНХАУ-ын иргэн н.Э миний гомдолтой Монголын Хуульчдын Холбооны гишүүн, өмгөөлөгч Ц.Б-т холбогдох гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор хариуцагчаас 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр авсан тайлбартай танилцлаа. Энэхүү тайлбартай холбогдуулан дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. Ц.Б нь: “2013 оны 11 дүгээр сарын сүүл 12 дугаар сарын эхээр “Үндэс” ХХК-н талаар судалгаа хийх. Тодруулбал, БНХАУ-ын иргэн н.Э, нэр бүхий БНХАУ-ын иргэд хамтарч “Үндэс” ХХК Монгол улсад үүсгэн байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг тогтооход шаардлагатай судалгаа хийх болон “Үндэс” ХХК-н Хятад хөрөнгө оруулагчдын хоорондын маргаан БНХАУ-ын Хөх хотын шүүхэд хянагдаж байгаа гэж тайлбарлаад энэ маргаанд ач холбогдолтой “Үндэс” ХХК-д хөрөнгө оруулагч гэдгээ нотлуулахаар баримт бичиг цуглуулахаар хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг аман байдлаар тохиролцсон” гэжээ. Миний бие нь МУ-д бизнесийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор БНХАУ-ын 4 иргэн, МУ-ын 3 иргэнтэй хамтран компани байгуулахаар тохиролцож, улмаар БНХАУ-ын 2 хөрөнгө оруулагч нь тус бүр 50.000.00 /тавин мянга/ америк доллар буюу нийт 100.000.00 /нэг зуун мянга/ америк долларыг компани байгуулж, хамтарч ажиллах зорилгоор өгсөн. Ийнхүү Монгол улсад бизнесийн үйл ажиллагаа явуулах үүднээс 2010 оны 8 дугаар сард Ш.Ц-аас 50,000.00 /тавин мянган / америк доллараар “Үндэс” ХХК-ийг худалдан авч, МУ-ын иргэн Б.Э-ыг гүйцэтгэх захирлаар томилсон. 2011 оны 3 дугаар сараас “Үндэс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Э нь компанийн бүх баримт бичиг, тамга тэмдэг мөн хятад

талын 2 хөрөнгө оруулагчийн тус компанийн данс руу шилжүүлсэн 100.000.00 /нэг зуун мянга/ америк долларыг компанийн данснаас авч, алга болсон. Ингээд миний бие нь МУ-ын иргэн Б.Э-ыг олох шаардлага үүссэн бөгөөд "Ирээдүй" ХХК-ийн захирал М.Д-т учир явдлаа хэлж, М.Д-аар дамжуулан өмгөөлөгч Ц.Б-тай танилцаж, Ц.Б, Б.Э-ыг олуулахаар тохиролцож, түүнтэй ажлын хөлсийг 3,000.00 /гурван мянга/ америк доллараар тохиролцож, урьдчилгаа төлбөрт 1.000.00 /мянга/ америк долларыг бэлнээр өгсөн.

2. Ц.Б нь: "2014 оны 1-р сарын 07-нд гэхэд тодорхой нотлох баримтыг бүрдүүлсэн. Үүнд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Э нь надад итгэмжлэл олгосон. Үүнээс өмнө итгэмжлэл олгоогүй байсан учраас би төлөөлөх эрхгүй байсан учраас тодорхой ажиллагаа хийж чадаагүй, 2013 оны 12-р сарын 27-ны өдрөөс Баянзүрх дүүргийн татварын хэлтэс, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүсэлт гаргаж "Үндэс" ХХК-н холбогдолтой баримтыг хуулбарлаж авсан. 2014 оны 01-р сарын 03-ны 1/140 дугаартай Санхүүгийн мэргэшсэн үйлчилгээний төвөөс хүсэлт гаргаж санхүүгийн дүгнэлт гаргуулсан. Энэ дүгнэлтээр бол "Үндэс" ХХК Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байсан болон нэр бүхий хятад иргэд хөрөнгө оруулагч мөн гэдгийг нотолсон нотолгоо юм. Мөн 2014 оны 01-р сарын 07-ны өдөр Татварын албаас "Үндэс" ХХК-н Хятад хөрөнгө оруулагч нарыг дуудуулсан мэдэгдлийг хүсэлт гаргаж авсан. 2014 оны 01-р сарын 07-ны өдөр Ц.Б миний бие өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй болохыг Хөх хотын шүүхэд нотлох шаардлагатай гэж н.Э орчуулуулсан. 2014 оны 01-р сарын 09-ний өдөр шүүх хуралдаан хойшилсон учир би Хөх хотод шүүх хуралдаанд оролцох шаардлага байгаагүй. Дээрх миний хийсэн ажлын үр дүн бол н.Э-ын хүсэж байсан ажлын үр дүн мөн" гэжээ. /ММ-н 77-р хуудас/

2011 оны 6 дугаар сарын 27-нд "Өвсний Үндэс" ХХК-д хөрөнгө оруулалт хийсэн БНХАУ-ын 2 иргэнтэй миний бие нь БНХАУ-д уулзсан бөгөөд тэд бидний хөрөнгө оруулсан мөнгөөр МУ- д компани байгуулсан уу? байгуулсан бол компанийн бичиг баримт нь байна уу? гэсэн. Энэ үед надад Монгол улсад компани байгуулсан гэдгийг нотлох, тухайн хөрөнгө оруулагч нарт үзүүлэх ямар нэгэн баримт бичиг байхгүй байсан тул бидний хооронд маргаан үүсч, улмаар БНХАУ-ын шүүхэд 2012 оны 11 дүгээр сард энэ асуудлаар Хятад талын 2 хөрөнгө оруулагч нэхэмжлэл гаргасан. Шүүх хуралдааныг 2014 оны 4 сар хүртэл хойшлуулсан бөгөөд энэ хугацаанд шүүхээс компани байгуулсан гэдгээ нотлох баримт материал олж ирэх боломжийг надад өгсөн.

Намайг БНХАУ-д байхад өмгөөлөгч Ц.Б утсаар холбогдож үлдэгдэл мөнгөө өгчих, Б.Э-ыг бараг олсон гэсний дагуу ХААН банкны салбарын захирал ажилтай н.Э-аар дамжуулан түүнд үлдэгдэл 2.000 .00 /хоёр мянга/ америк долларыг өгүүлсэн. Гэвч Ц.Б нь 2014 оны 2 дугаар сараас холбоо тогтоох боломжгүй болж алга болсон. Ц.Б миний бие нь тухайн үед "Үндэс" ХХК-тай холбоотой өөрт байсан зарим баримт бичгийг өгсөн байсан бөгөөд миний өгсөн дээрх баримт бичгүүд болон ажлын хөлс 3.000.00 /гурван мянга/ америк долларыг Ц.Б нь аван алга болсон.

Мөн БНХАУ-д болох шүүх хуралд ирж оролцох шаардлагатай болохыг Ц.Б-т хэлж байсан. Гэвч н.Б ирж оролцоогүй болно.

Үүнээс болж миний бие нь Монгол улсад компани байгуулсан гэдгээ нотлох боломжгүй болж БНХАУ-ын шүүхийн шийдвэрийн дагуу Хятад талын 2 хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө болох 100,000.00 /нэг зуун мянга/ америк доллар болон олох байсан орлого 25.000 /хорин таван мянга/ америк доллар нийт 125.000.00 /нэг зуун хорин таван мянга/ америк долларыг тухайн 2 хөрөнгө оруулагчид төлсөн.

3. Ц.Б нь: "Үндэс" ХХК-н Хятад хөрөнгө оруулагч нар Монгол улсад ирж байж дээрх ажиллагаа хийгдэх боломжтой гэдгийг тайлбарлаж хэлсэн. Энхбаярын хэлж байгаа шиг тохиролцоо хийгдээгүй. Б.Э-аас материал авах тухай тохиролцоо хийгдээгүй. Би энэ хүнтэй уулзаагүй" гэжээ.

Миний зүгээс Ц.Б-тай "Үндэс" гэдэг компаний холбогдох бичиг баримтыг Б.Э нь гэдэг манай компанид гүйцэтгэх захирал хийж байсан хүн аваад алга болсныг олуулах, "Үндэс" компанийг өөрийн нэр дээр шилжүүлэх хэрэв болохгүй бол уг компанийг татан буулгуулах гэсэн ажил"-ыг тохиролцсон. Энэхүү ажлыг Ц.Б нь хийхээр тохиролцож хөлсийг миний бие бүрэн өгсөн.

4. Ц.Б нь: "1000 доллар өмгөөлөгчийн ажлын хөлсөнд тооцоогүй, надад бол бэлгэнд өгсөн мөнгө гэж ойлгож байсан. 2000 доллар дээр бол би Э-ын төлөөлөн өгсөн хүнд гарын үсэг зурж өгсөн" гэжээ. /ММ-н 78-р хуудас/

Ц.Б-аар Б.Э-ыг олуулахаар тохиролцож, түүнтэй ажлын хөлсийг 3,000.00 /гурван мянга/ америк доллараар тохиролцож, урьдчилгаа төлбөрт 1,000.00 /нэг мянга/ америк долларыг бэлнээр өгсөн. Намайг БНХАУ-д байхад өмгөөлөгч Ц.Б утсаар холбогдож үлдэгдэл мөнгөө өгчих, Б.Э-ыг бараг олсон гэсний дагуу Хаан банкны салбарын захирал ажилтай Э-аар дамжуулан түүнд үлдэгдэл 2,000.00 /хоёр мянга/ америк долларыг өгүүлсэн. 2,000.00 /хоёр мянга/ долларыг авсан тухай баримт байгаа.

5. Ц.Б нь: "Үйлчлүүлэгчийн хүсэлтээр бичгээр хийгээгүй юмаа. Би гэрээг бичгээр хийх шаардлагатай гээд гэрээний төслийг явуулж байсан" гэжээ. /ММ-н 78-р хуудас/

Ц.Б-тай тухайн үед гүйцэтгэх ажлын талаар тохиролцож гэрээ байгуулах саналыг миний зүгээс тавьсан. Надад интернетээс буулгасан нэг материал зарахтай холбоотой /бизнесийн/ гэрээний загвар авчирч өгсөн. Үүнийг нь би энэ гэрээ чинь хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ биш байна гэхэд Ц.Б нь эхлээд ажлаа эхлүүлж байа, дараа нь гэрээгээ байгуулъя, надад хятад хэл сайн мэддэг дүү байгаа дараа нь орчуулаад танд өгье гэсэн.

2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 80 дугаартай нотариатчаар батлуулсан итгэмжлэхийн тухайд: Энэхүү итгэмжлэлийг миний бие нь Ц.Б-т олгоогүй болно. Итгэмжлэлд гарын үсэг зурах үед би ямар агуулгатай баримт бичигт гарын үсэг зурж байгаагаа мэдээгүй, мөн итгэмжлэх гэдгийг нь ч мэдээгүй байсан бөгөөд сүүлд итгэмжлэхэд гарын үсэг зурснаа мэдсэн. Тухайн үед Ц.Б нь надаар гарын үсэг зуруулж аваад сүүлд нотариатаар гэрчлүүлсэн байна. Энэхүү хуурамч итгэмжлэхийг ашиглаж Ц.Б нь маш олон хууль бус үйлдэл хийж байсныг сүүлд мэдсэн болно.

Ц.Б нь Монголын Хуульчдын Холбоонд УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас хуулбарлаж авсан хэд хэдэн баримт бичиг гаргаж өгсөн байх ба

материалуудтай нь танилцаж үзвэл доорх баримт бичгүүд нь миний өөрийн өгсөн материалууд байсан болно.

Үүнд: дугаартай “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ”-ний хуулбар-/1 хуудас/

..... дугаартай “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ”- ний хуулбар- /1 хуудас/

- Magicchoice санхүүгийн мэргэшсэн үйлчилгээний төвөөс 2014 оны 01 дүгээр сарын 03- ны өдөр “Үндэс” ХХК-ийн удирдлагад ирүүлсэн 1/430 тоот “хараат бус аудигорын тайлан” хүргүүлэх тухай албан бичгийн хуулбар - /1 хуудас/

Үндэс ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - /2 хуудас/

- Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдпагын анкетын хуулбар - /6 хуудас/ Б.Э-ын иргэний үнэмлэхийн хуулбар - /1 хуудас/

- БНХАУ-ын иргэн / Е /нарын гадаад паспортын хуулбар - /1 хуудас/

- БНХАУ-ын иргэн G.Y нарын гадаад паспортын хуулбар - /1 хуудас/

- БНХАУ-ын иргэн C.J нарын гадаад паспортын хуулбар - /1 хуудас/

- БНХАУ-ын иргэн C.L нарын гадаад паспортын хуулбар - /1 хуудас/ гэжээ.

/ММ-н 13-16-р хуудас/

“Интернэйшнл Инвестмент Менежмент Консалтинг” ХХК-ын ТУЗ- ийн дарга тус хороонд ирүүлсэн тайлбартаа: Миний бие Шинэ Зеланд Улсаас Монгол Улсад цагаачилж байгаа... болно. 2013 оны 12 сард Манай компанийн гүйцэтгэх захирал н.Э нь 2010 онд байгуулагдсан “Үндэс” ХХК-ын бүхий л бичиг баримт, шүүхэд бэлтгэх материал, гүйцэтгэх захирал байсан Б.Э-ыг олж ирэх зэрэг асуудлыг өмгөөлөгч Ц.Б-т найдаж албан ёсоор гэрээ хийж үйлчлүүлэхээр ярилцаж тохиролцсон ба тухайн үед Ц.Б нь “гэрээг би бэлтгэе” хэмээн хэлсэн. Тухайн үед бид ажлаа нэн яаралтай явуулахын тулд Улаанбаатар вокзалын хажууд Арьсан эдлэл зардаг дэлгүүрийн үүдэнд урьдчилгааны 1000 доллартай тэнцэх төгрөгийг Ирээдүй ХХК-ын захирал Даваажавар тоолуулан Ц.Б-т гардуулж өгсөн. Даваажав захирал нь Ц.Б өмгөөлөгчид тухайн мөнгийг тоолон өгсөн байна. Миний бие Манж үндэстэн ба би Монгол оронд хайртай учир Монголд ирж бүтээн байгуулалт хийж байна. Монгол орны маргаашийн ирээдүй болох багачууд хүүхдүүдэд өөрийн хөрөнгөөр цэцэрлэг барьж өгч байгаа болно. Иймээс Монгол оронд миний хувиас Хуульчдын холбоонд дэвшүүлж буй санал бол нэн ялангуяа хуульч хүн бол нэг улс орны зөв замаар явуулах хамгийн үүрэг хариуцлагатай хүмүүс болно. Ц.Б өмгөөлөгч бол нэгдүгээрт хэлсэндээ хүрдэггүй, амалсан ажлаа гүйцэтгэдэггүй, хүний ажилд гай болж, урьдчилгаа болгон өгсөн мөнгийг бэлэглэсэн хэмээн хэлж байгаад ихэд гайхаж байна. Хоёрдугаарт 80-дугаар тоот нотариат бид нарыг гадаад оронд байх хойгуур бидний нэрийг ашиглан маш олон хуурамч нотариат хийсэн байна” гэжээ. /ММ-н 17-р хуудас/

Дүүргийн дугаар прокурорын газрын хяналтын прокурор А.А-ийн 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1174 дугаартай Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай прокурорын тогтоолд: “БНХАУ-ын иргэн Э нь “2013 оны 12 дугаар сараас

2014 оны 2 дугаар сар хүртэлх хугацаанд Замын Цагдаагийн хажууд болон Баянгол дүүргийн дугаар хороонд байрлах "Ирээдүй" ХХК-ийн байранд өмгөөлөгч Ц.Б "Үндэс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Э-ыг хайж олон, компанийн тамга, үндсэн бичиг баримтуудыг гаргуулан авах, компанийг 1 гишүүнтэй болгож, улмаар татан буулгах, "Үндэс" ХХК-ийн БНХАУ-д болж буй шүүх хуралд Монгол талын бүх бичиг баримтыг бүрдүүлж оролцох зэрэг үүргийг гүйцэтгүүлэхээр үйлчилгээний хөлсөнд 3000 /гурван мянга/ ам.долларыг өгсөн боловч өмгөөлөгч үүргээ гүйцэтгээгүй залилсан" гэх гомдлыг гаргажээ. Гэмт хэргийн талаарх гомдлын дагуу шалгасан материалыг хянахад өмгөөлөгч Ц.Б нь ямар нэгэн гэрээгүйгээр иргэн н.Э-аас 3000 ам.долларыг авсан болох нь н.Э, Ц.Б нарын тайлбар, мөнгө хүлээлцсэн баримт зэргээр тогтоогджээ.

Өмгөөлөгч Ц.Б нь н.Э-тай амаар тохиролцсоны дагуу өөрийнх нь хүсэлтээр зарим ажиллагааг гүйцэтгэн дээрх мөнгийг зарцуулснаас гадна өөрөөсөө 400-500 мянган төгрөгийг энэ үйл ажиллагаанд зориулсан гэсэн тайлбарыг өгч байгаа боловч хууль зүйн туслалцаа үзүүлсэн болон өмгөөллийн үйл ажиллагаа явуулсан, мөн иргэнээс бэлнээр авсан мөнгийг хэрхэн зарцуулсан зэргийг баримтаар нотлоогүй байна.

Ц.Б-ын дээрх үйлдэлд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй боловч мөн хуульд заасан хөнгөн гэмт үйлдсэнээс хойш эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн байх тул байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал илэрч байна" гэжээ. / ММ-н 52-53 хуудас/

Хариуцагч Ц.Б тус хороонд өгсөн тайлбартаа: 2013 оны 11 сарын сүүл 12 сарын эхээр "Үндэс" ХХК-н талаар судалгаа хийх тодруулбал БНХАУ-ын иргэн н.Э, нэр бүхий БНХАУ-ын иргэд хамтарч "Үндэс" ХХК Монгол улсад үүсгэн байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг тогтооход шаардлагатай судалгаа хийх болон "Үндэс" ХХК-н Хятад хөрөнгө оруулагчдын хоорондын маргаан БНХАУ-н Хөх хотын шүүхэд хянагдаж байгаа гэж тайлбарлаад энэ маргаанд ач холбогдолтой Үндэс ХХК-д хөрөнгө оруулагч гэдгээ нотлуулахаар баримт бичиг цуглуулахаар хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг аман байдлаар тохирсон. ... 2014 оны 1 дүгээр сарын 07-нд гэхэд тодорхой нотлох баримтыг бүрдүүлсэн. Үүнд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр н.Э нь надад итгэмжлэл олгосон. Үүнээс өмнө итгэмжлэл олгоогүй байсан учраас би төлөөлөх эрхгүй байсан учраас тодорхой ажиллагаа хийж чадаагүй, 2013 оны 12-р сарын 27-ны өдрөөс Баянзүрх дүүргийн татварын хэлтэс, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүсэлт гаргаж "Үндэс" ХХК-н холбогдолтой баримтыг хуулбарлаж авсан, 2014 оны 01-р сарын 03-ны 1/430 дугаартай Санхүүгийн мэргэшсэн үйлчилгээний төвөөс хүсэлт гаргаж санхүүгийн дүгнэлт гаргуулсан. Энэ дүгнэлтээр бол "Үндэс" ХХК Монгол улсад үйл ажиллагаа явуулж байсан болон нэр бүхий Хятад иргэд хөрөнгө оруулагч мөн гэдгийг нотолсон нотолгоо юм. Мөн 2014 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Татварын албаас "Үндэс" ХХК-н Хятад хөрөнгө оруулагч нарыг дуудуулсан мэдэгдлийг хүсэлт гаргаж авсан. 2014 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Ц.Б миний бие Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй болохыг Хөх хотын шүүхэд нотлох шаардлагатай гэж н.Э орчуулуулсан. 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр шүүх хуралдаан хойшилсон учир би Хөх

хотод шүүх хуралдаанд оролцох шаардлага байгаагүй. Дээрх миний хийсэн ажлын үр дүн бол н.Э хүсэж байсан ажлын үр дүн мөн байсан. ... "Үндэс" ХХК-н Хятад хөрөнгө оруулагч нар Монгол улсад ирж байж дээрх ажиллагаа хийгдэх боломжтой гэдгийг тайлбарлаж хэлсэн. Э-ын хэлж байгаа шиг тохиролцоо хийгдээгүй. Б.Э-аас материал авах тухай тохиролцоо хийгдээгүй. Би энэ хүнтэй уулзаагүй. ...1000 доллар өмгөөлөгчийн ажлын хөлсөнд тооцоогүй, надад бол бэлгэнд өгсөн мөнгө гэж ойлгож байсан. 2000 доллар дээр бол би н.Э-ын төлөөлөн өгсөн хүнд гарын үсэг зурж өгсөн. ...Үйлчлүүлэгчийн хүсэлтээр бичгээр хийгээгүй юмаа" гэжээ. /ММ-н 76-78-р хуудас/

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ: Гомдол гаргагч БНХАУ-ын иргэн н.Э болон хариуцагч

Ц.Б-ын тайлбар, бусад бичгийн нотлох баримтаар өмгөөлөгч Ц.Б нь БНХАУ-ын иргэн Э-тай /Э/ "Үндэс" ХХК-ийн гүйцэтгэх захирал байсан Б овогтой Э-ыг хайж олоод тус компаний тамга, үүсгэн байгуулах үндсэн бичиг баримтуудыг гаргуулан авч, улсын бүртгэлд тус компаний хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчээр Э-ыг бүртгүүлж, нэг гишүүнтэй компани болгох, үүний дараа тус компанийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу албан ёсоор татан буулгах, "Үндэс" ХХК-ийн БНХАУ-д болж буй шүүх хуралд Монголын талын бүх бичиг баримтыг бүрдүүлж, оролцохоор харилцан тохиролцож үйлчилгээний хөлсөнд 3000 ам доллар авсан атлаа тохиролцсон ажил үйлчилгээг гүйцэтгээгүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг бичгээр байгуулаагүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1,1-д "Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах, хатгах", 27.1.2-т "хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардпагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх", Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1-д "Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана", 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна" гэж заасныг тус тус зөрчсөн эсэхийг тогтоолгоно гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Гомдол гаргагч БНХАУ-ын иргэн н.Э нь өмгөөлөгч Ц.Б-ыг өмгөөлөгчийн хувьд тохиролцсон ажлаа огт хийгээгүй тул холбогдох арга хэмжээг авч өөрийн бичиг баримтууд болон ажлын хөлсөнд өгсөн 3000 ам долларыг буцааж авах гомдол гаргасан бөгөөд үндэслэлээ гэрээ хийх гэсэн боловч надад итгэж болно, дараа нь гэрээгээ байгуулъя гээд бичгээр гэрээ байгуулаагүй ... "Үндэс" ХХК-ийг миний нэр дээр болгуулна, хэрэв болгохгүй бол уг компанийг татан буулгуулна, мөн БНХАУ-д болох "Үндэс" ХХК-д холбогдох шүүх хуралд оролцож миний эрх ашгийг хамгаална гэсэн боловч шүүх хуралд оролцоогүй" гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.

Өмгөөлөгч Ц.Б нь БНХАУ-ын Э-ын гомдолд тайлбар өгөхдөө: "Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг аман байдлаар тохирсон, үйлчлүүлэгчийн хүсэлтээр бичгээр хийгээгүй юм ... 2014 оны 1 сарын 7 гэхэд тодорхой нотлох баримтыг бүрдүүлсэн, Баянзүрх дүүргийн татварын хэлтэс, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүсэлт гаргаж, "Үндэс" ХХК-ийн холбогдолтой

баримтыг хуулбарлаж авсан ... Санхүүгийн мэргэшсэн үйлчилгээний төвд хүсэлт гаргаж санхүүгийн дүгнэлт гаргуулсан ..., би Хөх хотод шүүх хуралдаанд оролцох шаардлага байгаагүй. Дээрх миний хийсэн ажлын үр дүн бол н.Э хүсэж байсан ажлын үр дүн байсан. Өмгөөлөгчийн ажлын хөлсөнд 2000 доллар авсан, 1000 долларыг бэлгэнд өгсөн мөнгө гэж ойлгосон” гэж тайлбарласан байна.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч нь хариуцагч Ц.Б-ыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1,2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн гэж үзсэн байна.

Хариуцагч Ц.Б нь БНХАУ-ын иргэн н.Э-ын эрх ашгийг хамгаалах, түүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцсон боловч бичгээр гэрээ байгуулаагүй болох нь нотлогдсон тул Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэснийг зөрчсөн болох нь тогтоогдож байна гэж бүрэлдэхүүн дүгнэв.


Өмгөөлөгч Ц.Б нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах, хатгах”, 27.1.2-т “хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэснийг тус тус зөрчсөн байх тул түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.

Гомдол гаргагч БНХАУ-ын иргэн н.Э-ын Ц.Б-аас 3000 ам долларыг гаргуулж өгнө үү гэсэн асуудал нь Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүн шийдвэрлэх харьяаллын асуудал биш байх тул энэ тухай нэхэмжлэлээ холбогдох шүүхэд хандан шийдвэрлүүлэх боломжтой гэж бүрэлдэхүүн үзлээ.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар Ц.Б-т “Нээлттэй сануулах” шийтгэл ногдуулсугай.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурьдсугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Хаалттай сануулах тухай

Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх 5 дугаар бүрэлдэхүүн иргэн Н.Ц-с өмгөөлөгч Д.Н-т холбогдуулан гаргасан гомдолд сахилгын шинжээч Г.Должинсүрэн шалгалтын ажиллагаа явуулаад өмгөөлөгч Д.Н-т 0116 дугаартай хаалттай сануулах санал бичин холбогдох баримт сэлтийн хамт ирүүлснийг 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч судлаад

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Иргэн Н.Ц-с: “Вояж” ХХК нь 4 машин нүүрсний тээвэрт явуулж орлого олдог байсан ба нүүрсний тээвэрлэлт орон даяар зогссон, нэхэмжлэгч тал болох “ММК” ХХК нь байгуулсан гэрээгээ зөрчин манай компаний үйл ажиллагаа үндсэндээ зогсонги байдалд ороод байгаа., ММК нь манай компаниас төлбөрийн үлдэгдлийг гаргуулахаар Дүүргийн иргэний хэргийн дүгээр шүүхэд нэхэмжлэл гаргасан. Манай компани өмгөөлөгч Д.Н, Ш.Э нартай гэрээ байгуулан өмгөөллийн хөлсийг төлж ажилласан.... Гэтэл өмгөөлөгч Д.Н, Ш.Э нар нь иргэний хэргийн давж заалдах шатны дугаар шүүхийн шүүх хуралд оролцоогүй гэж хэлсэн бөгөөд давж заалдах гомдлоо хамгаалаагүй, мөн давж заалдах шатны шүүхээс магадлалаа аваад Д.Цэ надад танилцуулаагүй. ... Ирээд уулзах гэтэл шүүх хуралтай байна, би өөрөө таныг дуудна гэсээр байгаад 2014 оны 10 дугаар сарын 03-нд уулзсан. Дараагийн шатанд гомдол гаргаж эцсийг нь хүртэл явъя гэхэд гомдол гаргах хуулийн хугацаа хэтэрсэн байна, мөн энэ хэрэг одоо явахгүй, даваад ч нэмэргүй гэж хэлсэн. Хяналтын журмаар гомдол гаргах хугацаа 10 дугаар сарын 01-нд байсныг би сүүлд мэдсэн. ... өмгөөлөгч Д.Н, Ш.Э нарын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж “Вояж” ХХК болон иргэн Н.Ц би хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй болж маш их төлбөр төлөх болоод байна. Иймд өмгөөлөгч Д.Н, Ш.Э нарт хариуцлага тооцож өгнө үү” гэжээ. / ММ-н 1,2-р хуудас/

Иргэн Д.Ц тус хороонд гаргасан тайлбартаа: “Би “ММК” компаний нэхэмжлэлийн дагуу шүүхийн үйл ажиллагаанд өмгөөлөгч Ш.Э-г итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, өмгөөлөгч Д.Н бүх шатны шүүхэд оролцуулахаар үйлчилгээний хөлсөнд 2,5 сая төгрөг төлж хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллахаар тохиролцсон. Анхан болон давж заалдах шатны шүүхэд энэ хэргээр хоёр өмгөөлөгч оролцсон. Шүүхийн шийдвэр хууль зүйн үндэслэлгүй гарсан. Хяналтын шатны тэр хуралд би өөрөө орж тайлбар хэлж болох уу? гэж Ш.Э өмгөөлөгчид 9 дүгээр сарын 22-нд хэлсэн. Тэгэхэд өмгөөлөгч Ш.Э шүүгчээс зөвшөөрөл авбал таныг оруулна та өөрөө орж болно гэж хэлсэн. Тэгэхээр нь би 9 дүгээр сарын 25-нд Увс аймгаас Улаанбаатар хотод ирсэн. 9 дүгээр сарын 26-нд утсаар үдээс өмнө залгахад

өмгөөлөгч Ш.Э утас холбогдохгүй байсан тул өмгөөлөгч Д.Н дугаарын утас руу залгаад “Би Увс аймгаас хүрээд ирлээ гэхэд та байж бай би өнөөдөр шүүх хуралтай гэж хэлсэн тул уулзаж чадаагүй. 9 дүгээр сарын 28, 29-ний аль нэгэнд нь өмгөөлөгч Н өрөөнд очсон.” ... Дахин утсаар ярихад та хүрээд ир гэсэн тул би 10 дугаар сарын 01-нд өрөөнд нь очсон. ... Би хяналтын шатны журмаар гомдол бичье гэж хэлсэн. ... өмгөөлөгч Н хугацаа хэтэрсэн байна 2 удаа шүүхийн шийдвэр гарсан тул одоо ороод ч энэ хэвээр гарна гэж хэлсэн. Би тооцооны алдааг залруулах ёстой байсан гэж хэлэхэд би хэлсэн нөгөө талдаа шийдээд байна болохгүй байна гэж хэлсэн. /ММ-н 16-р хуудас/

3. Хариуцагч Д.Н тус хороонд өгсөн тайлбартаа: “Вояж” ХХК-ийн захирал Н.Ц-тэй “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г өмгөөлөгч Ш.Э хамтаар байгуулж, ажлын хөлсийг хуваан авч шүүхийн ажиллагаанд хамтран оролцсон байхад ганц надад холбогдуулан шийдвэрлэх нь үндэслэлгүй гэж үзэж байна. Н.Ц гэгч нь 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр дахин гомдол гаргахгүй, автомашинаа зарж байж үлдэгдэл өрөө төлнө, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд Ш.Э-г өмгөөлөгчөөр авна гэж анх 27 хуудас материал, үлдэгдэл мөнгөний 1.000.000 төгрөгийг буцаан авахаар болж байснаа нэмж 4ш автомашинтай холбоотой 42 хуудас материалыг авч бүгд 69 хуудас материал болгон авч явсан” гэсэн тайлбар,

4. Хариуцагч Д.Н тус хороонд дахин өгсөн тайлбартаа: “Хуульч өмгөөлөгч Д.Н би “Вояж” ХХК-д хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ хийсний үндсэн дээр Сүхбаатар дүүргийн шүүхэд /хуучин нэрээр/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцсон билээ. “Вояж” ХХК-ийн захирал Н.Ц нь холбогдохгүй, зөвлөж ярилцах гэхээр хөдөө Увс, Өмнөговь аймаг руу явчихдаг байснаас Ш.Э өмгөөлөгч бид өөрсдөөсөө мөнгө гаргаж давж заалдах гомдлыг шүүхэд өгч байсан. Хяналтын гомдол гаргах хугацаа дөхсөн байхад бас л Увс аймагт барилга барьж байгаа гээд ирэхгүй, тэмдэгтийн хураамжаа ч төлөхгүй байснаас хугацаа өнгөрсөн хойно буюу 10 дугаар сарын 1-нд ирлээ гээд холбогдох баримтуудаа, мөнгөө авсан болно. Хэдийгээр хяналтын гомдол хэтэрсэн /1 хоног/ байгаа ч үйлчлүүлэгчийн зүгээс хийж гүйцэтгэх /тэмдэгтийн хураамж төлөх ажлаа хийлгүй өөртөө анхаарал тавихгүй байсан нь нөлөөлсөн гэж үзэж байна. Миний цаашдын ажил, эрүүл мэндээ ч бодсон нэг хоног хугацаа хэтрүүлсэндээ гэмшиж ойлгож байгаа ба цаашид анхаарч ажиллаж зөрчил дутагдалгүй байхаа илэрхийлж байна. Иймд хаалттай сануулах арга хэмжээ авна уу” гэсэн тайлбар,

5. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны дүгээр шүүхийн шүүгчийн 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дугаартай “Хяналтын журмаар гомдол гаргах хугацаа сэргээхээс татгалзах тухай” захирамж,

6. Өмгөөлөгч Д.Н иргэн Н.Ц байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ бусад бичгийн нотлох баримтууд цуглажээ.

ХЯНАВАЛ:

Иргэн Н.Ц нь Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд өмгөөлөгч Д.Н хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан атлаа хяналтын шатны шүүхэд гомдол гаргалгүй гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх

шалтгаангүй, өөрт нь мэдэгдэлгүй хэтрүүлж мэргэжлийн хариуцлага алдсанаас хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй болж, улмаар компани нь их хэмжээний төлбөр төлөх болсон гэсэн агуулгатай гомдол гаргажээ.

Гомдлын материалд “Вояж” ХХК-ны захирал Н.Ц, өмгөөлөгч Д.Н нарын байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх 02/10 дугаартай гэрээ өмгөөлөгч Д.Н давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр гардан авсан тухай баримт болон 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Н.Ц гарын үсэгтэй төлбөр тооцоог дуусгаж ... шийдвэр, магадлал ... захирамж нийт 69 хуудас материал, 1,0 сая төгрөгийн хамт буцаан авсан гэсэн тодорхойлолт авагдсан байна.

Н.Ц гомдол, хариуцагчийн тайлбар, шалгалтаар тогтоогдсон үйл баримтаас үзвэл өмгөөлөгч Д.Н нь Иргэний хэргийн давж заалдах шатны дугаар шүүхийн “ММК” ХХК-ийн нэхэмжлэлтэй, “Вояж” ХХК-д холбогдох иргэний хэрэг, маргааныг давж заалдах журмаар хянасан 835 дугаар магадлалыг хүлээн авснаар хяналтын журмаар гомдол гаргах хугацаа тоологдож эхэлсэн байх бөгөөд “Вояж” ХХК-тай байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр хариуцагчийн өмгөөлөгчөөр бүх шатны шүүхэд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр үүрэг хүлээсэн атлаа хяналтын шатны шүүхэд хандах гомдлын хугацааг хэтрүүлсэн хойно буюу 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдөр өмгөөллийн хөлсний зарим хэсгийг буцаан өгч гэрээг дуусгавар болгосон нь “Вояж” ХХК-ийн захирал Н.Ц цаашид шүүхийн шийдвэрт хяналтын журмаар гомдол гаргах боломжгүй байдалд хүргэсэн нь хариуцагч Д.Н 2015 оны 12 дугаар сарын 11-нд Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбар, бусад бичгийн нотлох баримтаар нотлогдож байна.

Дээрх нөхцөл байдал нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нийцэхгүй тул сахилгын шинжээчийн “Хаалттай сануулах шийтгэл” оногдуулах саналыг үндэслэлтэй байна гэж үзлээ.

Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан хариуцагч Д.Н-т “Хаалттай сануулах шийтгэл” ногдуулсугай.
2. Гомдол гаргагч энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл захирамжийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор гомдлоо Ажлын албаар дамжуулан Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргах эрхтэй болохыг дурьдсугай.
3. Захирамжийг Н.Ц-д хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Д.Г-д холбогдох маргааны тухай

Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх дөрөвдүгээр бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Д.Даваасүрэн даргалж, гишүүн Г.Эрдэнэбат, Д.Цэндсүрэн, Т.Өсөхбаяр, Д.Оюунбат нарын бүрэлдэхүүнтэй, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Т.Жадамбаагаас ирүүлсэн, өмгөөлөгч Д.Г-д холбогдох 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн МД15/16 дугаартай дүгнэлтийн дагуу сахилгын шинжээч Т.Жадамбаа, гомдол гаргагч Д.О, хариуцагч Д.Г-т, хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан нарыг оролцуулан иргэн Д.О, Д.Б нараас өмгөөлөгч Д.Г-д гаргасан гомдлыг Монголын Хуульчдын Холбооны хуралдааны танхимд нээлттэй хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Д.О-с Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдол болон гомдлын талаар маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд гаргасан тайлбартаа: Өмгөөлөгч Д.Г миний хүү А.У-д холбогдох хэрэгт өмгөөлөгчөөр ажилласан боловч үйлчилгээ үзүүлж чадаагүй. Өмгөөлөгч хүн өмгөөлж байгаа хүнийхээ төлөө бүхнээ зориулах ёстой гэж боддог. Гэтэл хүүг маань хэргээ хүлээ гэж ятгасаар байгаад хийгээгүй хэрэгт ял шийтгүүлсэн. Хүүг чинь тэнсэнтэй гаргана гэж хуурсан, хүү чинь шоронд очоод анусдуулна гэж айлган сүрдүүлсэн. Бидэнтэй өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг бичгээр байгуулаагүй. Гэтэл өмгөөллийн хөлсөнд 400.000 төгрөг авчихаад юу ч хийгээгүй. Бид амьдралын боломжгүй, хөдөөнөөс ирээд орох орон ч үгүй байна. Иймд Д.Г-с 400.000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэв.

Иргэн Д.Б Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдолдоо: Өмгөөлөгч Д.Г-д 1.000.000 төгрөг төлсөн боловч надад эрх зүйн туслалцааг сайн үзүүлж чадаагүй гэж үзэж байна. Надаар зочид буудлын төлбөр, таксины мөнгийг төлүүлж, архи пиво бэлдүүлсэн, өмгөөлөгч согтуу байсны улмаас шүүх хуралдаанд оролцоогүй учир шүүх түүнийг 192.000 төгрөгөөр торгосныг надаар төлүүлэх болсон. Замын зардал, хоол хүнсэнд 300.000 төгрөг төлсөн. Ажлаа хийж шүүх хуралд оролцох гэж байж нууц амрагаа дагуулж ирээд түүнтэйгээ Булган аймаг уруу зугаалахаар явахдаа зардлаа надаар төлүүлэх ёстой юм уу, ийм ёс зүй байдаг юм уу. Булган явахад таксины жолоочид нь 55.000 төгрөг төлсөн. Сэтгэл санаа, эдийн засгийн тал дээр их гомдолтой гэжээ.

Хариуцагч Д.Г маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд гаргасан тайлбартаа: Миний бие Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.6-д заасан гэмт хэрэгт холбогдсон А.У, Э.Д нарыг өмгөөлөн 2015 оны 07 дугаар сарын 23-ны өдөр шүүх хуралдаанд оролцсон. Уг хэрэгт миний бие дараахь байр суурьтай оролцсон.

Э.Д-ийн хувьд бусдыг бүлэглэн хүчиндсэн болох нь нотлох баримтаар хангалттай нотлогдож, тогтоогдоогүй тул цагаатгах, А.У-н хувьд, хохирогч эрүүгийн хэрэг үүссэн үеэс А.У-г шууд зааж “анх хоолой боож ухаан алдуулан хүчиндсэн” хэмээн тогтвортой мэдүүлэг өгсөөр ирсэн тул А.У-ыг 126.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрч өөрийн гэм бурууг ойлгон хохирлыг бүрэн барагдуулж хохирогчийн зүгээс гомдол саналгүй болсон тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлд заасан нөхцөл байдал бий болж ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулан улмаар тэнсэж болох, ингэснээр А.У-н эрх зүйн байдлыг дээрдүүлэх боломжтой гэдгийг олж хараад хичээн ажилласан боловч А.У түүний эх Д.О нар хохирогчийг элдвээр доромжлон сүрдүүлсний улмаас хохирогч А.У шүүх хуралдаан дээр “гомдолтой, тархи толгой өвдөж байна, эмчилгээ хийлгэхэд мөнгө хэрэгтэй.” гэснээс шүүхийн шийдвэр миний санаж төлөвлөсний дагуу гараагүй. Давж заалдах шатны шүүх хуралдаанаас өмнө хохирогчийн зүгээс дэмжлэг авах зорилгоор Э.Д-н ар гэрийнхнээс 1,5 сая төгрөг авч хохирогчид өгөөд А.У-н өмнөөс уучлал гуйснаар гомдол саналгүй гэсэн тодорхойлолт гарган нотариатаар гэрчлүүлэн шүүхэд өгсөн. Гэвч А.У, Э.Д нар миний давж заалдсан гомдлын эсрэг утга бүхий гомдол гаргасныг, тэд надаас татгалзах үед мэдсэн. А.У-н эх Д.О миний байр суурийг дэмжиж өөрөө хөөцөлдөн татгалзлыг болиулаад 2015 оны 09 дүгээр сарын 10-нд давж заалдах шатны шүүх хуралдаан болж А.У, Э.Д нар онлайнгаар “Би хийгээгүй хэргийн төлөө ял авсан. Өмгөөлөгч намайг хэргээ хүлээ гэсэн” гэж мэдүүлснээр шийтгэх тогтоол хэвээр үлдсэн. А.У гомдлоо өөрөө бичих мөрөөрөө бичихгүй Э.Д-д гай болсон. Тэдэнтэй уулзахад хоёулаа хүлээн зөвшөөрч гэмшдэг. Д.О надтай хэзээ ч гэрээ бичгээр хийх нөхцөлд уулзаж байгаагүй. Гэрээ байгуулаагүй нь үнэн. Тэр намайг өмгөөлөгчөөр авах эсэх болон хэнд уурлаад байгаа нь мэдэгдэхгүй явсаар байгаад миний дансанд 400.000 төгрөг шилжүүлсэн байсан. Д.О гомдолдоо намайг “Хүүхэд чинь шоронд анусдуулна хэмээн дарамталсан” гэж бичсэнийг гайхаж байна. Мааньт Зүүнхараад давтан хэрэгтнүүд ял эдэлдэг тул тэнд очуулахгүйн тулд сайныг бодож өөр ангид хуваарилуулахыг зөвлөж байсныг мушгиж байгаа юм болов уу. Миний бие А.У нарын эрх зүйн байдлыг дээрдүүлэх гэж хуулийн дагуу ажилласан. Д.О гомдол өсөрхсөн шинжтэй, үнэнд үл нийцсэн, хууль зүйн үндэслэлгүй байх тул үнэн зөвийг тогтоож өгнө үү гэв.

Д.Б-н гаргасан гомдлын тухайд: Миний бие 2014 оны эхээр СБД-ийн Цагдаад Д.Б-г Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т заасан гэмт хэрэгт шалгагдаж байхад нь өмгөөлөн зөвлөгөө өгч хэрэг нь хэрэгсэхгүй болгосон үеэс танина. 2015 оны 07 дугаар сарын 20-дын үеэр Д.Б Эрдэнэтээс ярьж “Намайг өмгөөлж өгөөч, 1.000.000 төгрөг шилжүүлнэ” гэсэн хүсэлт тавьсан. Хүсэлтийг хүлээн авч, Д.Б мөнгөө шилжүүлсэн. Д.Б өмнөх өмгөөлөгчөөс татгалзаж намайг авсан нь шүүх хурал хийлгэхгүй хугацаа хожих зорилготой байсан нь ойлгомжтой байсан. 2015 оны 08 дугаар сарын 10-нд намайг Эрдэнэтэд очиход Д. шүүх хуралд очихгүй байхыг гуйгаад хойшлуулах боломж гаргахыг хүссэнээр нь “би замд очиж яваа” гэж хэлүүлэн Д.Б-г шүүх рүү явуулсанд тэр өөрөө шүүх хуралд очоогүй гээд түүнийг цагдан хорьсон. Энэ тухай Д.Б надад мэдэгдсэн. Би гомдол гаргаж баримтуудыг хавсарган Ерөнхий шүүгчид гомдол гаргаж, хэргийн материалтай танилцсан.

Анх удаа хүндэвтэр хэрэгт холбогдсон байсан тул хохирлыг барагдуулж хохирогч нарыг гомдол саналгүй болговол Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлээр тэнсэх боломжтой гэдгийг Д.Б-д зөвлөн хохирогч нартай ярьж тохирсон. 2 дахь удаагаа 2015 оны 08 дугаар сарын 20-нд шүүх хуралд оролцохоор Эрдэнэт орж цагдан хоригдож байгаа Д.Б 3 дахь удаагаа уулзаж, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх, хохирлыг төлүүлэх боломжийг гаргахаар ярьж тохирон шүүхэд хүсэлт гаргаснаар шүүх хүсэлтийг хүлээн авч батлан даалтад гаргаж хуралдааныг 2015 оны 09 дүгээр сарын 11-нд хийхээр хойшлуулсан. Д.Б “найз нар АНУ-аас таны дансанд мөнгө шилжүүлнэ, түүнийг хохирогч нарт өгье.” гэсэн. 2015 оны 09 дүгээр сарын 11-нд Эрдэнэт рүү явсан. Шүүх хурал болохын өмнө Д.Б “Мөнгө шилжиж ирсэн, 2-3 хоногийн дараа бэлэн болно.Та хуралд бүү суу, дахин нэг удаа хойшлуулж тус бол” гэж гуйсан. Би мөн л замд машин саатсан гэж худал хэлүүлээд өөрөө үлдэж Д.Б шүүх рүү явсан. Гэтэл хохирогч нараас утсаар “Таныг буудалд хүүхэнтэй шал согтуу босож чадахгүй байна гэж Д.Болормаа хэлээд таныг 192.000 төгрөгөөр торгосон” гэж мэдэгдснээр би шүүх дээр очиж шүүгч Ж.Б уулзаж болсон явдлаа хэлээд Д.Б уулзахад надаас уучлалт гуйж торгуулийг төлнө гэсэн. Ингээд хурал хойшилсон. Түүнээс хойш хохирогчид өгөх мөнгө нь байхгүй, хугацаа явсаар шүүх хурлыг 2015 оны 10 дугаар сарын 05-нд хийх болж би Эрдэнэтэд очсон. Мөн л хурал хийлгэхгүй, “өөрийн төрсөн дүүгээ залилангийн хэрэгт бүлэг болгон оруулж хэргийг мөрдөн байцаалтад буцаалгаж өг” хэмээн хүн чанаргүй, баримтгүй, биелэх боломжгүй хүсэлт тавихаар нь боломжгүй гэдгийг хэлээд “хурал хойшлуулах ганц арга нь надаас татгалзан орон нутгаасаа өөр өмгөөлөгч авах хүсэлтээ гарга” гэж зөвлөсөн. Энэ дагуу шүүх хурал дээр Д.Б ярьж хуралдаан хойшилсон. Энэ хурал одоо ч хийгдээгүй байгаа. Өмгөөллийн хөлснөөс гадна Улаанбаатар хотоос Эрдэнэтэд ирэх буцах, буудлын хөлс, хоол унаа зэргийн зардал, Эрдэнэт-УБ хотын хооронд нааш цааш явах унаа зэргийг Д.Болормаа хариуцахаар анхнаасаа тохирсон. Гэвч Д.Б амьдралын боломж хүнд гэдэг нь мэдэгдсэн тул тэрээр хоёр удаа л буудлын хөлс төлсөн. Бусдыг би өөрөө төлсөн. Надад зардлын нэг ч мөнгө өгөөгүй. Торгуулийн мөнгийг өөрийн туслах М-р шилжүүлсэн. Хамт явсан хүүхэн гэдэг нь, замын унаанд найзынхаа дүүтэй таарч тэр шөнө 01.00 цагийн үед Булган явах унаагүй, таньдаг хүн байхгүй гээд надаас туслалцаа хүсэхээр нь би өглөө унаанд суулгаж явуулсан. Би өөрөө таксины мөнгийг төлсөн. Би яах гэж Эрдэнэт рүү 5 удаа ажпаа алдаж явсан бэ. Би хуульд заасны дагуу өмгөөлж, тохирсон хөлсөө авсан. Намайг яаж ажилласныг мэдсээр байж ор үндэслэлгүй гүтгэж бичсэнд гомдолтой байна. Иймд хуулийн дагуу шалгаж үнэн зөвийг олж өгнө гэдэгт итгэж байна гэв.

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч хуульч өмгөөлөгч Д.Гг Эрүүгийн хэргийн яллагдагч А.У-д хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ гэрээг бичгээр байгуулалгүй Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэснийг, Д.Б-с, өөрт холбогдох хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг “ямар нэг аргаар хойшлуулж” удаашруулах хууль бус “үйлчилгээ” хүссэнд татгалзгүйгээр хүлээн авч Орхон аймаг дахь Сумдын дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 08 дугаар сарын 10, 2015 оны 09 дүгээр

сарын 11-ний өдрийн шүүх хуралдаанд санаатайгаар оролцоогүй, мөн шүүхийн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн шүүх хуралдаанд, өөрөөсөө татгалзахыг Д.Б-д урьдчилан зөвлөж татгалзан гаргуулах зэргээр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн хэсгийн 2.1-т... “Хуульч нь дараахь нөхцөлд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй...Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлснээр хууль эсхүл энэ дүрмийг зөрчихөөр бол...”, 4.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хэсгийн 2.1, 2,8-д... “Өмгөөлөгчид дараахь үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно...үндэслэл бүхий татгалзал гаргаснаас бусад тохиолдолд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх байгууллагын өмнө хүлээсэн үүргээ санаатайгаар үл биелүүлэх...хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зорилготой үйл ажиллагаанд оролцох” гэснийг тус тус зөрчсөн байна гэж үзэн мэргэжлийн дүгнэлт үйлдсэн байна.

Тус маргаантай холбоотойгоор маргааны материалд авагдсан гомдол гаргагч Д.О-г, Д.Б нарын гомдол, хүсэлт, 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн НМ-02 тоот маргааныг нэгтгэх тогтоол, хариуцагчаас Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээчид өгсөн тайлбар,,, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2015 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн тоот шийтгэх тогтоол, өмгөөлөгч Д.Г-с 2015 оны 08 дугаар сарын 18-ны өдөр эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдол, эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 708 тоот магадлал, Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагчийн 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн тэмдэглэл, Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дугаартай шүүх хуралдааныг хойшлуулах тухай шүүгчийн захирамж, аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгдэгч Д.Б, Б.Э нарт холбогдох эрүүгийн тоот хэргийг 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцсэн шүүх хуралдааны 306, 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хэлэлцсэн 323, 2015 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцсэн 372, 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хэлэлцсэн 418 дугаартай тэмдэглэлүүд, мөн шүүхийн 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 306, 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 323 дугаартай шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, шүүх хуралдааныг хойшлуулах тухай шүүгчийн захирамжууд, тус шүүхийн 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 67 дугаартай хүсэлт шийдвэрлэсэн тухай захирамж, хариуцагчид холбогдох маргааны зарим хэсгийг хэрэгсэхгүй болгох тухай 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоол зэрэг маргааны материалд авагдсан баримтуудыг шинжлэн судлав.

ҮНДЭСЛЭХ нь:

Д.Г нь 2013 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 754 тоот Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, 2013 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 216 тоот шүүхэд төлөөлөх эрх авсан болох нь Монголын Хуульчдын холбооны 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 2/930 тоот албан бичгээр нотлогдож байх тул “Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журам”-ын 1.4-т заасан хариуцагчаар оролцох этгээд мөн болно.

Өмгөөлөгч Д.Г А.У, Э.Д нарын эрх ашгийг хамгаалж, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож, улмаар ЭХТА-ийн 126 дугаар зүйлийн 126.2.6 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн эрүүгийн 2015250000956 тоот хэрэгт өмгөөлөгчөөр оролцсон болох нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2015 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 955 тоот шийтгэх тогтоол, өмгөөлөгч Д.Г-с 2015 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдол, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 708 тоот магадлал, гомдол гаргагч, хариуцагч нарын тайлбараар тогтоогдож байна.

Тэрээр А.У, Э.Д нарын өмгөөлөгчөөр оролцож хууль зүйн туслалцаа үзүүлсэн нь дээрх баримтуудаар тогтоогдож байгаа боловч эрүүгийн хэргийн яллагдагч А.У-д хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ бичгээр байгуулаагүй болох нь гомдол гаргагч Д.О, хариуцагч Д.Г нарын тайлбараар тогтоогдож байх ба энэ нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна" гэснийг зөрчсөн нь нотлогдож байна.

Харин өмгөөллийн үйл ажиллагаа явуулахдаа Д.О-т ...хүүг чинь тэнсэнтэй гаргана гэж хуурсан, хүү чинь шоронд очоод анусдуулна гэж айлган сүрдүүлсэн гэх байдал, Д.-с...Өмгөөлөгч Д.Г эрх зүйн туслалцааг сайн үзүүлж чадаагүй, замын зардал, хоол хүнсэнд 300.000 төгрөг, Булган аймаг уруу зугаалахаар явсаны 55.000 төгрөг, торгуулийн 192.000 төгрөгийг би төлсөн гэх үйл баримтууд нотлогдоогүй гэж Хариуцагчид холбогдох маргааны зарим хэсгийг хэрэгсэхгүй болгох тухай 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоол гарсныг дурдах нь зүйтэй.

Гомдол гаргагч Д.О өмгөөллийн хөлсөнд төлсөн 400.000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэх бөгөөд тэр талаарх асуудлаар иргэний журмаар жич шийдвэрлүүлэх эрх нээлттэй байна.

Д.Г нь эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хүрээнд Д.Б 2015 оны 08 дугаар сарын 06-ны өдөр түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, өмгөөлөх, зөвлөгөө өгөхөөр гэрээ байгуулж, Д.Б, Д.Г мөн өдөр өмгөөллийн хөлсөнд 999.500 төгрөг шилжүүлсэн нь дээрх гэрээ, Д.Г-н Төрийн банк дахь тоот дансны баримтаар нотлогдож байгаа болно.

Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, шүүгдэгч Д.Б, Б.Э нарт холбогдох хэргийг 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцэж, "...шүүгдэгч Д.Б, өмгөөлөгч Д.Г нар шүүх хуралдааны тов авсан боловч хүрэлцэн ирээгүй байна." гээд Д.Б цагдан хорьж, хуралдааныг 2015 оны 08 дугаар сарын 20-нд товлож, мөн шүүхийн 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 323 дугаар захирамжид..."Шүүгдэгчийн өмгөөлөгч Д.Г шүүх хуралдаанд"...Д.Б-ийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж өгнө үү. Учир нь хохирогч нарын хохирлоос чадлынхаа хэмжээгээр барагдуулах бодолтой байгаа гэв." гэж дурдаад шүүх хуралдааныг 2015 оны 09 дүгээр сарын 11 хүртэл хойшлуулсан нь 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 306 дугаар шүүх хуралдааны тэмдэглэл, 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 323 дугаартай шүүгчийн захирамжаар нотлогдож байна.

Тус шүүхийн 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 372 дугаар шүүх хуралдааны тэмдэглэлд: "...өмгөөлөгч Д.Г ... нарт шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч...хүрэлцэн ирээгүй..." гэсэн байх ба хуралдаан даргалагч, шүүгдэгч Д.Б "өмгөөлөгч чинь яасан юм бэ?" гэж асуухад Д.Б.. "Өчигдөр орой ярихад 8.00 цагт Улаанбаатараас Эрдэнэт рүү гарч байна гэж хэлсэн. Би...орой ирсэн юм байх гэж бодсон чинь машин нь замдаа эвдэрсэн гэж байна." Гэж хариулсныг болон Д.Г 192.000 төгрөгөөр торгох, хуралдааныг 2015 оны 10 дугаар сарын 05 хүртэл хойшлуулах шийдвэр гаргасныг тус тус тэмдэглэсэн байна.

Түүнчлэн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн шүүх хуралдааны дугаар тэмдэглэлд.. "Шүүгдэгч Д.Б-с: Миний бие УБ хотоос өмгөөлөгч авсан. Өмгөөлөгчид төлбөрөө төлөөд гэрээгээ хийчихсэн байгаа. Өмгөөлөгч хол байдаг тул уулзахад хэцүү...эрхээ хамгаалуулж...хууль зүйн туслалцаа авч...санасандаа хүртэл өмгөөлүүлж чадахгүй байна... Би өмгөөлөгчөөсөө татгалзаж байна... Даргалагчаас: Шүүгдэгчийн өмгөөлөгч өмнөх шүүх хурал хойшилсноос нэг цагийн дараа шүүх дээр ирж уулзсан. Өмгөөлөгчийн машин эвдрээд Хонгор суманд байна гээд хурал хойшилсон. Яагаад ингэж худлаа хэлээд байна вэ? гэхэд Шүүгдэгч Д.Б: Д.Г өмгөөлөгч согтуу байсан гэв. Даргалагчаас: Согтуу өмгөөлөгч нэг цагийн дараа над дээр ирж уулзах уу? гэхэд Шүүгдэгч Д.Б: Согтуу, хүүхэнтэй буудалд байсан. Өмгөөлөгчөө та хэлээч гэв....Даргалагчаас: Өмнөх шүүх хуралдаанд өмгөөлөгчийн дансанд 9.0 сая төгрөг орсон. Өмгөөлөгч ирээгүй байна гэж хэлж байсан. Энэ талаар өмгөөлөгчид тайлбар байна уу? гэхэд Шүүгдэгчийн өмгөөлөгч Д.Г: Миний дансанд мөнгө ороогүй... тухайн үед надад худал хэлсэн байсан. Та шүүх хуралд битгий оч. Хүмүүс одоо л мөнгө өгөх гээд байна. Шүүх хуралдааныг хойшлуулах хэрэгтэй байна гэхээр нь өөрөөсөө татгалзахыг Д.Б-д зөвлөж татгалзан гаргуулсан гэж тэмдэглэснээр нотлогдож байх тул Д.Б-с, өөрт холбогдох хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг "ямар нэг аргаар хойшлуулж" удаашруулах хууль бус "үйлчилгээ" хүссэнд татгалзалгүйгээр хүлээн авч аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 08 дугаар сарын 10, 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн шүүх хуралдаануудад санаатайгаар оролцоогүй, мөн шүүхийн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн шүүх хуралдаанд, өөрөөсөө татгалзахыг Д.Б-д урьдчилан зөвлөж татгалзан гаргуулах зэргээр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн хэсгийн 2.1-ийн "Хуульч нь дараахь нөхцөлд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй...Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлснээр хууль эсхүл энэ дүрмийг зөрчихөөр бол...", 4.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хэсгийн 2.1, 2.8-ын "Өмгөөлөгчид дараахь үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно...үндэслэл бүхий татгалзал гаргаснаас бусад тохиолдолд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх байгууллагын өмнө хүлээсэн үүргээ санаатайгаар үл биелүүлэх... хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зорилготой үйл ажиллагаанд оролцох" гэснийг тус тус зөрчсөн гэм буруутайд тооцож, түүнд зохих шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй гэж үзэв.

Өмгөөлөгч Д.Г холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлын талаарх баримт маргааны материалд авагдаагүй байна.

Бүрэлдэхүүн тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ хариуцагч Д.Г нь сахилгын зөрчлийг анх удаагаа гаргасныг харгалзсан болно.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Өмгөөлөгч Д.Г-г “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2, 2.2 дугаар зүйлийн 2, 2.14 дүгээр зүйлийн 2, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар “Нээлттэй сануулах шийтгэл” ногдуулсугай.
2. Тогтоолыг Холбооны тогтмол хэвлэл цахим хуудсанд нийтлэхийг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албанд үүрэг болгосугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны сарын 26 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Ю.Г-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Г.Эрдэнэбат даргалж, гишүүн Д.Даваасүрэн, Д.Оюунбат, Т.Өсөхбаяр, Д.Цэндсүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс ирүүлсэн, өмгөөлөгч Ю.Г-д холбогдох 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн МД16/01 дугаартай дүгнэлтийн дагуу сахилгын шинжээч Г.Должинсүрэн, хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан нарыг оролцуулан иргэн Д.Б-өөс гаргасан “Өмгөөлөгч Ю.Г нь давж заалдахаар боллоо гээд 200.000 төгрөг авсан атлаа давж заалдах гомдол гаргаагүй, шүүх хуралд ороогүй” гэх гомдлыг Монголын Хуульчдын Холбооны хуралдааны танхимд нээлттэй хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Д.Б хороонд гаргасан гомдолдоо: “2014 оны 1-р сард аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч Ю.Г-тэй гэрээ хийж төлбөрт 500.000 төгрөг өгсөн 2014 оны 4-р сард хурал зарласан боловч өмгөөлөгчийн буруугаас 2 удаа хойшилсон. ... 5-р сарын эхэнд шүүх хурал болж 4- сар баривчлах ялаар шийтгүүлсэн. Манай хүү Д.Б нь давж заалдахгүй гээд надыг хотруу буцаасан. 2014 оны 5 дугаар сарын 23-нд өмгөөлөгч Ю.Г нь надтай утсаар ярьсан “Би Д.Б уулзлаа. Давж заалдахаар болсон. Хоног хугацаа нь дуусах гээд байна. Өнөөдөр 200.000 төгрөг шилжүүл” гээд дансны дугаар өгсөн. Би сандарч барьцааны зээлийн газраас зээл авч тэр өдөр нь Г-н Хаан банкны тоот дансанд шилжүүлсэн. Хэд хоногийн дараа хүү Д.Б надтай утсаар ярьсан. Ю.Г нь манай хүүтэй уулзаагүй байсан. Ю.Г намайг залилсаныг ойлгосон. Би Ю.Г-тай олон удаа утсаар ярьсан. Миний дансыг олон удаа авсан боловч одоо хүртэл өгөөгүй, утсаа авахаа больсон” гэжээ. /ММ 3-р хуудас/

Хариуцагч Ю.Г сахилгын шинжээчид өгсөн тайлбартаа: “...Тиймээ Д.Б давж заалдах тухай ярилцсаны үндсэн дээр аавтай нь утсаар яриад давж заалдах хуралд оролцох хөлс болох 200.000 төгрөг авсан нь үнэн. Ингээд Д.Б дээр давж заалдах өргөдөл дээр юу бичмээр байна санаа оноогоо нэмэрлээч гэж очиж уулзсан. Тэгсэн “Д.Б надтай цуг ял шийтгүүлсэн Д.Б давж заалдах гомдол гаргахгүй гэсэн тиймээс намайг битгий гомдол гаргаач” гэж гуйсан учраас давж заалдах гомдол гаргахаа больё гэж хэлсэн тэгээд больсон 200.000 төгрөг авсан байснаа буцааж өгөөгүй байсан нь миний буруу, энэ нь Д.Б-д итгэсэн, түүнийг зохицуулчих байх гэж итгэсэн хэнэггүй зангаас боллоо. Тэрнээс надад бусдаас 200.000 төгрөг залилан мэхлэж авах санаа зорилго байгаагүй. Би өнөөдөр Д.Б-н хувийн дансанд 220.000 төгрөг шилжүүлсэн байгаа” гэжээ. /ММ 12-13-р хуудас/

Хариуцагч Ю.Г маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд гаргасан тайлбартаа: “Сүүлд нь гэрээ хийчихье. Нэмж, хачирлах юм байна уу гэсэн чинь за гэрээ хийгээд яахав. Давж заалдах шаардлага байхгүй гэж Д хэлсэн. Тэгээд гэрээ хийгээгүй. Ааваас чинь би 200.000 төгрөг авчихсан. Буцааж өгөх үү гэсэн чинь тэр яахав, би аавтай яриад тохиролцчихно. Одоо ганцхан сар үлдлээ гэсэн юм. Тэгээд аав нь надтай утсаар яриагүй, Д ч над руу ярихгүй болохоор нь за тэгээд өнгөрсөн юм байлгүй дээ гээд назгайрсан нь бол миний буруу байгаа юм. Түүнээс би 200.000 төгрөг аваад ашиглая гэсэн ашиг сонирхол надад үнэхээр байхгүй” гэжээ. /ММ 57-р хуудас/

Мэргэжлийн Хариуцлагын Хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ:

“Өмгөөлөгч Ю.Г нь Б.Д нарт холбогдох эрүүгийн хэрэгт Б.Д-ийн өмгөөлөгчөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байхдаа Б.Д-ийн төрсөн эцэг Д.Б-с “Би Д-тай уулзлаа. Давж заалдахаар болсон. Хоног хугацаа дуусах гээд байна. Өнөөдөр 200.000 төгрөг шилжүүл” гэж худал хэлэн 200.000 төгрөг авсан атлаа давж заалдах гомдол гаргаагүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх... хориглоно” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна” гэжээ. /ММ 46-48-р хуудас/

Тус маргаантай холбоотойгоор маргааны материалд авагдсан гомдол гаргагчийн гомдол, хүсэлт, хариуцагчаас Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээчид өгсөн тайлбар, сахилгын шинжээчийн 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн эрүүгийн дугаартай Б.Д, Б.Б нарт холбогдох эрүүгийн хэрэгт үзлэг хийсэн тухай тэмдэглэл, Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагчийн 2015 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн тэмдэглэл, Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан Б.Ц-ийн тайлбар, Орхон аймгийн прокурорын газрын архивт хадгалагдаж буй Б.Д, Д.Б нарт холбогдох Эрүүгийн тоот хэргээс хуулбарлан авсан өмгөөлөгч Ю.Г-н хүсэлт, шүүх хуралдааны тэмдэглэл, 2014 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн 89 дугаартай Сум дундын дүгээр шүүхийн тогтоол зэрэг маргааны материалд авагдсан баримтуудыг шинжлэн судаллаа.

ҮНДЭСЛЭХ нь:

Өмгөөлөгч Ю.Г нь иргэн Б.Д-ийн эрх ашгийг хамгаалахаар гэрээ байгуулан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байсан нь Б.Д-г яллагдагчаар байцаасан тэмдэглэл, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн тогтоол, холбогдох тайлбар, баримтуудаар нотлогдож байна. Мөн тэрээр хуульчдын нэгдсэн бүртгэлийн дугаарт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн дугаарт бүртгэлтэй болох нь Монголын Хуульчдын Холбооны 2016 оны 01 дүгээр сарын 8-ны өдрийн 2/56 тоот албан бичгээр нотлогдож байх тул “Монголын Хуульчдын Холбооны Маргаан хянан шийдвэрлэх журам”-ын 1.4-д заасан хариуцагчаар оролцох этгээд мөн болно.

Мэргэжлийн Хариуцлагын Хорооны Сахилгын шинжээч нь хуульч, өмгөөлөгч Ю.Г-г “Б.Д нарт холбогдох эрүүгийн хэрэгт Б.Д-ийн өмгөөлөгчөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байхдаа Б.Д-ийн төрсөн эцэг Д.Б-с “Би Д-тай уулзлаа. Давж заалдахаар болсон. Хоног хугацаа дуусах гээд байна. Өнөөдөр 200.000 төгрөг

шилжүүл” гэж худал хэлэн 200.000 төгрөг авсан атлаа давж заалдах гомдол гаргаагүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардпагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх хориглоно” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй гэж үзэн мэргэжлийн дүгнэлт үйлдсэн байна.

Өмгөөлөгч Ю.Г нь өөрийн үйлчлүүлэгч Б.Д-аас өмгөөллийн үйлчилгээний хөлсөнд 500.000 төгрөгийг авч түүний төрсөн дүү Д.Ц-тай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байсан боловч гэрээнээс гадуур Б.Д-ийн төрсөн эцэг Б.Б-с “давж заалдах гомдол гарган гэж 200.000 төгрөг авсан боловч давж заалдах гомдол гаргаагүй нь эрүүгийн дугаартай Д.Д нарт холбогдох эрүүгийн хэргээс авсан баримт, сахилгын шинжээчийн хэрэгт үзлэг хийсэн тэмдэглэл, гомдол гаргагчийн тайлбар, бусад бичгийн баримтуудаар нотлогдож байна.

Түүний энэ үйлдэл нь “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2-т заасан “Хуульч үндэслэлгүйгээр хөлс зардал тогтоох, авахыг хориглоно”, 2.2 дугаар зүйлийн 2-т “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэснийг тус тус зөрчсөн зөрчлийн шинжтэй байна гэж бүрэлдэхүүн дүгнэлээ.

Маргааны материалд авагдсан, хуралдааны явцад шинжлэн судлагдсан баримтуудаар хуульч, өмгөөлөгч Ю.Г-г “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2-т заасан “Хуульч үндэслэлгүйгээр хөлс зардал тогтоох, авахыг хориглоно”, 2.2 дугаар зүйлийн 2-т “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэж заасныг тус тус зөрчсөн гэм буруутайд тооцож, түүнд зохих шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй байна.

Өмгөөлөгч Ю.Г-д холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлын талаарх баримт маргааны материалд авагдаагүй байна.

Бүрэлдэхүүн тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ хариуцагч Ю.Г нь сахилгын зөрчлийг анх удаагаа гаргасан, гомдол гаргагч Д.Б-д 220.000 төгрөг төлсөн байдлыг тус тус харгалзсан болно.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Өмгөөлөгч Ю.Г-г “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2 -т “Хуульч үндэслэлгүйгээр хөлс зардал тогтоох, авахыг хориглоно”, 2.2 дугаар зүйлийн 2-т “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэж заасныг тус тус зөрчсөнд тооцож, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар “Нээлттэй сануулах шийтгэл” ногдуулсугай.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүй, эд мөрийн баримтаар 1 ширхэг CD авагдсаныг дурдсугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Ч.Э-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Д.Байгалмаа даргалж, гишүүн С.Буд, С.Амардэлгэр, Е.Сагсай, Л.Данзанноров нарын бүрэлдэхүүнтэйгээр Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс ирүүлсэн, өмгөөлөгч Ч. Э-д холбогдох 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн МД15/12 дугаартай дүгнэлтийн дагуу сахилгын шинжээч Г.Должинсүрэн, хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан нарыг оролцуулан иргэн Б.М, Б.М нарын гаргасан хүнд гэмт хэрэгт холбогдон сэтгэл санааны хямралтай, хууль эрхийн туслалцаа хүсч очиход ... далимдуулан худал ярьж, заль зохион биднээс 10 сая төгрөг авч хуульч өмгөөлөгч хүнд баймгүй ёс зүйн алдаа гаргасан” гэх гомдлыг Монголын Хуульчдын Холбооны хуралдааны танхимд нээлттэй хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Б.М тус хороонд гаргасан гомдолдоо:

“Б.М миний төрсөн эгч Б.М нь эрүүгийн хэрэгт холбогдсоны улмаас эрх зүйн туслалцаа авч өмгөөлүүлэхээр Дархан уул аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч Ч.Э гэдэг хүнийг авсан юм.

Би энэ хүнтэй очиж уулзан гэрээ хийж, өмгөөллийн хөлс 2,500,000 төгрөгийг төлөхөөр болж ажил эхэлсэн. Гэтэл Ч.Э нь эгч М-ийг байнга өрөөндөө дуудан уулзаж “Чи 10 жилээс дээш ялтай, үүнийг чинь би аргалж өгье, 1 жилийн хорих ялыг 1 сая төгрөгөөр бодож шүүгчид өгч ялгүй гаргана. 10 сая төгрөгийг чинь бүрэлдэхүүнд орох 2 шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нарт бүгдэд нь л өгч байж нааштай шийдэгдэнэ, ялгүй гаръя гэвэл даруйхан мөнгөө олж авах хэрэгтэй” гээд байхаар нь бид хүний хашаа байшинг барьцаалан зээл авч 10 сая төгрөгийг бэлнээр Ч.Э-н өрөөнд өөрт нь тоолж өгсөн.

Гэвч энэ өмгөөлөгч ямар ч эрх зүйн туслалцаа үзүүлж ажиллахгүй, мөнгө авснаас хойш “би аргалж байгаа санаа зоволтгүй” гэдэг үгээр халхавчилж хэрэг асуудлын талаар уулзаж ярилцах нь цөөрч сүүлдээ бултаж зайлах маягтай болж ирсэн. Бид аргагүйн эрхэнд шүүхийн шатнаас дахин өөр өмгөөлөгч авч шүүх хуралд оролцсон.

Ч.Э-ээс мөнгөө буцаан авахыг хүсэхэд өөдөөс уцаарлан сүүлдээ бүр утсаа ч авахгүй, бултаж зугтан өдийг хүрлээ. Эгч маань шүүхээс 10 жилийн хорих ял сонсон, давж заалдсан ба хэрэг нь мөрдөн байцаалтанд буцаж, одоо эргээд анхан шатны шүүх дээр ирчихээд байна.

Ч.Э өмгөөлөгчөөс 10 сая төгрөгөө буцаан авч эрүүгийн хэргийн хохирол мөн сүүлд авсан өмгөөлөгчийнхөө хөлс мөнгийг төлөх ёстой байтал одоо болтол авч чадахгүй маш ихээр хохирч явна.

Эгч маань хүнд гэмт хэрэгт холбогдон сэтгэл санааны хямралтай, хууль эрхийн туслалцаа хүсч очиход нь үүнийг нь далимдуулан худал ярьж, заль зохион биднээс 10 сая төгрөг авч хуульч өмгөөлөгч хүнд баймгүй ёс зүйн алдаа гаргачихаад юу ч болоогүй юм шиг ажлаа хийн биднийг хохироосоор байна. Ч.Э нь албан тушаалын байдлаа ашиглан бусдад итгэл үнэмшил төрүүлэн худлаа ярьдаг, зальтай хүн болох нь тодорхой болж өөрөө ч цагдаагийн байгууллагад иймэрхүү асуудлаар шалгагдаж байгаа юм байна. Иймд ёс зүйгүй зальхай хуульч өмгөөлөгч Ч.Э-д зохих арга хэмжээг авч, бидний 10 сая төгрөгийг маань буцаан өгүүлнэ үү” гэжээ. /М/М 2-р хуудас/

Иргэн Б.М тус хороонд гаргасан гомдолдоо: “Б.М миний бие эрүүгийн хэрэг холбогдсоны улмаас эрх зүйн туслалцаа авч өмгөөлүүлэхээр аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч Ч.Э гэдэг хүнийг авсан юм. Би энэ өмгөөлөгчтэй ээжийнхээ дүү болох н.Н эгчээр дамжуулан анх уулзсан. Тухайн үед өрөөндөө дуудаж уулзаад надад туслаж чадна гэдгээ амлаж байсан. Өмгөөлөгчийн хөлс яг тодорхой тохирч гэрээ хийгээгүй, өөрөө явцын дунд болох байхаа гэж хэлдэг байсан.

Дараа нь намайг дуудан Шүүх хуралд орохын өмнө гэрээ гэсэн цаасан дээр гарын үсэг зуруулж хавтаст хэрэгт маань хийсэн. Би энэ хүнд боломжоороо бага ч гэсэн бэлэн мөнгө өгдөг байсан, амьдралыг чинь мэднэ, эгчийн чинь найз учир Н-г бодоод чамд туслаж чадна гэдэг байсан учир бид маш ихээр итгэж байсан. Давхар өмгөөлөгч авъя гэж хэлэхэд надад итгэ, давхар өмгөөлөгчийн хэрэг байхгүй гэж хэлсэн. Надтай ярихдаа чиний зүйл анги маш хүнд доод тал нь 10-15 жилийн ялтай гэдэг, дор хаяж 10 жил учир аргалах хэрэгтэй гэдэг байсан. Цагдаа, прокурорын шатанд ярьж асуудлыг шийдэж өгнө гээд 1,000,000 төгрөг хэрэгтэй байна гэхэд нь олж өгч байсан, энэ мөнгийг баримттай данс руу нь хийж өгсөн.

Дараа нь дахин дуудаад овоо нааштай байгаа, одоо Ерөнхий шүүгчтэй уулзан ярьсан, 1 жилийн ялыг 1 сая төгрөгөөр хаадаг юм дор хаяж 10 саяыг өгөхгүй бол болохгүй нь дээ гэж хэлсэн. Би гэр бүлтэйгээ ярилцан, тухайн үед бүгдээрээ хэцүү байсан учир, энэ хүнд байдлаас гарчуул дараа нь болох байх гэж ярилцсан. Тэгээд Н эгчийн хашаа байшин, мөн ээжийн хамаатан болох ах эгчийн хашаа байшин, мөн ээжийн хамаатан болох ах эгчийн хашаа байшин барьцаалан Хаан банкинд тавьж 10 сая төгрөг зээлж авсан. Энэ мөнгийг Ч.Э өмгөөлөгчийн дансруу хийх гэсэн боловч, манай гэрт бэлнээр аваад ир гэж хэлсэн. Бид баримт авч үлдэхийн тулд гэрлүү нь орохдоо утсаа унтрааж бичлэг хийж авсан. Энэ бичлэг бидэнд байгаа .

Гэвч энэ өмгөөлөгч мөнгө авснаасаа хойш би аргалж байгаа санаа зоволтгүй, гэдэг үгээр тайвшруулж байсан, хэрэг асуудлын талаар уулзах нь цөөрч, ямар ч туслалцаа үзүүлж ажиллахгүй, уулзах нь цөөрч, сүүлдээ бултаж, зайлах маягтай болж ирсэн. Хамгийн сүүлчийн шүүх хуралд эгч нь ямар ч байсан асуудлыг яриад тохирчихсон, миний бие өвдөөд байна эгч таньдаг өмгөөлөгч рүүгээ ярьсан байгаа

энэ хүнтэй очиж уулзаад хуралдаа орчих гэж хэлсэн, би ч итгэсэн. н.О өмгөөлөгчтэй уулзан гэрээ хийж “200,000 төгрөгөөр” хуралдаа орсон. Хэрэгтэйгээ танилцаж амжаагүй гэдгээр хурал хойшлогдож, намайг Хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан.

Бид байдал биш болсоныг мэдээд шүүхийн шатанд дахин өөр өмгөөлөгч авч, шүүх хуралд орсон. Тэгээд би 2014 оны 12 сарын 11-ний өдөр 10 жилийн хорих ялаар шийтгүүлж 2 сар хоригдож байгаад сайн өмгөөлөгчийн буянд давж заалдсан ба миний хэрэг мөрдөн байцаалтанд буцсан билээ. Одоо өмгөөлж байгаа өмгөөлөгч шиг надтай тулж ажиллаагүй, хууль ёсны дагуу ажиллаагүйд нь би өмгөөлөгч Ч.Э-д маш их гомдолтой байна. Намайг хууль мэдэхгүйг далимдуулж надаар, энэ хүн маш их тоглосон байна.

Ч.Э-ээс мөнгө буцаан авахыг хүсэхэд өдөөс уцаарлан би хийх юмаа хийсэн гэж хэлээд утсаа ч авахаа байсан. Бид одоо банкинд 10 сая төгрөг төлөх гэж сард 560,000 төгрөг хийдэг, энэ хүнд байдлаас гарч чадахгүй маш ихээр хохирч байна. Би хүнд хэрэгт холбогдоно сэтгэл санааны хямралтай, үүнийг далимдуулж худал ярьж заль зохион, биднээс “12,000,000 төгрөг” авч хуульч өмгөөлөгч хүнд баймгүй ёс зүйн алдаа гаргачихаад юу ч болоогүй юм шиг ажлаа хийн биднийг хохироосоор байна.

Иймд ёс зүйгүй зальтай хуульч өмгөөлөгч Ч.Э-д зохих арга хэмжээг нь авч, надаас авсан 12 сая төгрөгийг маань буцаан өгүүлнэ үү.

Энэ муухай ажилдаа зүгээр ажлаа хийж байгаа, төрийн албан хаагчдын нэр сүрийг барьж худал хэлж байсныг нь бодохоор гомдолтой байна” гэжээ. /ММ 3-5-р хуудас/

Хариуцагч Ч.Э Мэргэжлийн хариуцлагын хороонд бичгээр гаргасан тайлбартаа: “УБ хотын иргэн Б.М гаргасан гомдолтой танилцаад дараах тайлбарыг гаргаж байна. ЭХ-ийн 148-р зүйлийн 148.4-т заасан гэмт хэрэгт холбогдсон Б.М-н нагац эгч, миний багын найз Б.Н-ийн хүсэлтээр би Б.М-ийн холбогдсон хэрэгт өмгөөлөгчөөр ажиллахаар болсон.

Гомдол гаргагчийн бичсэнээр би энэ хүнтэй нэг ч удаа уулзаж, ярилцаж, түүнтэй гэрээ хэлцэл хийгээгүй. Өөрөөр хэлбэл 2,500,000 төгрөгийг өмгөөллийн хөлс авах талаар тохиролцсон зүйл огт байхгүй. 2013 оны 12-р сараас 2014 оны 12-р сар хүртэлх хугацаанд би үйлчлүүлэгчдээ хууль зүйн зөвлөгөө өгөх, мөрдөн байцаалтанд оролцох, шүүх хуралд оролцох зэргээр өөрийн эрх хэмжээнд ажлаа хийж гүйцэтгэж байсан. Өргөдөлд дурдсанаар Б.М нь энэ хугацаанд өөрийн биеэр байж, үзэж харж, сонссон мэтээр намайг гүтгэж бичжээ. Б.М нь өөрөө хүссэн үедээ л миний ажлын байранд ирж уулздаг байсан болохоос миний зүгээс байнга дуудан, мөнгө төгрөг нэхэж дарамталсан зүйл огт үгүй билээ.

Өмгөөллийн хөлсний хувьд Б.М-н холбогдсон хэрэг онц хүнд гэмт хэрэг учир хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу 10 сая төгрөг тохиролцож, түүний нагац эгч Г.Н надад төлсөн болохоос Б.г, Б.М нарын хувьд нэг ч төгрөг өгөөгүй.

Б.М тайлбарт надад 1 сая гаруй төгрөг өгсөн мэт худал хэлжээ. Энэ мөнгөний тухайд анх өмгөөллийн ажиллагааг эхэлмэгц өмгөөллийн хөлсний урьдчилгааг өгөхийн тулд “Таван Толгой” (Оюу толгой)-д ажилладаг гэх эрэгтэй дүүгийнхээ цалингийн зээлийн үлдэгдлийг хаагаад танд 500,000 төгрөг ч болов нэмж аваад өгье гэж хэлж надаас 1 сая төгрөг 2-3 хоногийн хугацаатай гэж авсанаа хожим намайг гүтгэхдээ ашиглана гэж тухайн үед надад огт бодогдоогүй.

Бүтэн жилийн хугацаанд Б.М уулзаж, ярилцаж, харилцаж байхдаа гаднаа ноомой даруухан мэт дүр эсгэчээд, дотроо ямар айхтар бодол санаатай, худалч, зальтай болохыг нь таньж мэдсэнээ хэлэхийг хүсч байна.

Миний хувьд Б.М эрх зүйн байдлыг дордуулахгүй тулд, түүнд хохирол төлбөрөө төлж барагдуулах боломж олгох зорилгоор шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт удаа дараа гаргаж байсан, мөн өвчний учир хэвтэн эмчлүүлэх, шүүх бүрэлдэхүүний өөрчлөлт, шүүгч нарын ээлжийн амралт зэрэг шалтгаануудаар хурал хойшлогдож, түүнд хохирол төлбөрөө төлөх хангалттай хугацаа боломж олгогдож байсныг хэлэхэд илүүдэхгүй байх.

Ингээд 2014 оны 12-р сард Б.М нь хохирол төлбөрөө төлж барагдуулаагүй, мөн миний эрүүл мэндийн байдал хүнд байсан зэргээс би түүнийг өмгөөлөхөөс татгалзаж, эгчээс нь авсан өмгөөлөлийн хөлсөө буцаан төлнө гэж хэлээд, өөр өмгөөлөгч авахыг зөвлөсөн.

Гомдол гаргагчийн өргөдөлд дурдсанаар “утсаа авахгүй байх, бултаж зугатах, уулзахгүй байх” зэрэг нэг ч үйлдэл хийгээгүй бөгөөд миний ажлын байр түрээсийнх байсан.

2014 оны сүүлийн хагас жилд өвчний учир ажлаа хийж чадахгүйгээс түрээсийн байраа өгсөн хэдий ч, миний багын дотно найзын маань дүү гэдэг утгаар нь би түүнийг гэртээ хүлээж авч уулздаг байсан.

Б.М асуудлаар би эгч Г.Н нь уулзаж харьцаж байсан болохоос, энэ гомдол гаргагчийг хараа ч үгүй, танилцаачгүй, харин ч онц хүнд гэмт хэрэгт холбогдсон учир ар гэрийнхэнтэй нь, тухайлбал ээж болон нөхрөө уулзуулаач гэж удаа дараа Б.М хэлэхэд янз бүрийн шалтаг тоочин уулзуулдаггүй байсан.

10 сая төгрөгөөр залилуулж хохирлоо хэмээн Цагдаагийн газарт гомдол гаргасныг хэрэг үүсгэн шалгаад, хэрэгсэхгүй болгосон.

Би Г.Н-д 10,000,000 (Арван сая) төгрөгийг бүрэн төлж барагдуулсан. Надад Б.М, Б.М нарт төлөх төлбөр байхгүй.

Харин найзын хувьд итгэж, найдаж мөн хүн амын орлогын албан татвараас зайлсхийж, “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-дээ өмгөөллийн хөлсөө тусгаагүй буруугаа хүлээж зөвшөөрч, үүндээ зохих хариуцлага хүлээхэд гомдолгүй” гэжээ. /ММ 10- 12-р хуудас/

Хариуцагч Ч.Э нь Сахилгын шинжээчид өгсөн тайлбартаа: “...

2014 оны 12-р сард ... товлогдсон хурлаас 2 өдрийн өмнө манай гэрт М, Н хоёрыг дуудаж ирүүлээд М-с хохирол мөнгө яах гэж байна... Хохирол мөнгө төлж чадахгүй

юм бол би хуралд чинь орж чадахгүй ээ, би бас бие муу байна. Чи хэрвээ ял авах юм бол би сэтгэл санаа болон биеийн хувьд дийлэхгүй ээ” ... Гэрээ байгуулъя гэсэн болохоор яараад нэг гэрээнд нарийн зүйл тусгаж өгөөгүй байгуулсан. Гэрээнд мөнгө тусгаагүй нь миний буруу. Хүн амын орлогын албан татвар төлөхөөс зайлсхийх гэж гэрээнд мөнгө тусгаж өгөөгүй ээ” гэжээ. /ММ 14-15-р хуудас/

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ: ...“Хариуцагч Ч.Э, Б.М-г холбогдох эрүүгийн хэрэгт Б.М-н өмгөөлөгчөөр ажиллахдаа хууль зүйн үйлчилгээний хөлс 10.000.000 төгрөг авсан боловч гэрээнд тусгаагүй, татвар төлөхөөс зайлсхийсэн хууль бус үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийн зөрчих ...хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх... хориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.4 дүгээр зүйлийн 2 “Хуульч нь үндэслэлгүй хөлс, зардал тогтоох, авахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй” гэжээ. /ММ 97-99-р хуудас/

Тус маргаантай холбоотойгоор маргааны материалд авагдсан гомдол гаргагч болон хариуцагчаас Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээчид өгсөн тайлбарууд, хариуцагчийн бичгээр гаргасан тайлбар,аймгийн Цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх тасагт шалгагдаж байсан Ч.Э нарт холбогдох Эрүүгийн тоот хэргээс хуулбарлан ирүүлсэн Эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол, иргэн Б.М-с Ч.Э-д болон Б.Б гэгчид шилжүүлсэн мөнгөний баримтууд, иргэн Б.М-н ХААН банкин дах тоот дансны дэлгэрэнгүй хуулга, Ч.Э-н хохирогчоор болон сэжигтнээр өгсөн мэдүүлгүүд, гомдол шалгах ажиллагааны явцад Ч.Э-ийн Цагдаагийн байгууллагад өгсөн тайлбар, Г.Н-ийн хохирогчоор болон сэжигтнээр өгсөн мэдүүлгүүд, Б.М-н гэрчээр болон сэжигтэн, яллагдагчаар байцаагдсан байцаалтын тэмдэглэлүүд, гэрч Б.П-н мэдүүлэг,....аймгийн прокурорын газрын 2015 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн “Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” 149 дүгээр тогтоол зэрэг маргааны материалд авагдсан баримтуудыг шинжлэн судаллаа.

ҮНДЭСЛЭХ нь:

Өмгөөлөгч Ч.Э нь иргэн Б.М-н эрх ашгийг хамгаалахаар гэрээ байгуулан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байсан нь 2014 оны 1 сарын 28-ны өдөр Б.М-г сэжигтнээр дахин байцаасан болон яллагдагчаар байцаасан тэмдэглэлүүд, холбогдох тайлбар, баримтуудаар нотлогдож байна. Мөн тэрээр хуульчдын нэгдсэн бүртгэлийн дүгээрт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн дугаарт бүртгэлтэй болох нь Монголын Хуульчдын Холбооны 2015 оны 05 сарын 21-ний өдрийн 2/432 тоот албан бичгээр нотлогдож байх тул “Монголын Хуульчдын Холбооны Маргаан хянан шийдвэрлэх журам”-ын 1.4-д заасан хариуцагчаар оролцох этгээд мөн болно.

Мэргэжлийн Хариуцлагын хорооны сахилгын шинжээч нь хуульч, өмгөөлөгч Ч.Э-г Б.М-ийн өмгөөлөгчөөр ажиллахдаа хууль зүйн үйлчилгээний хөлс 10 000 000 төгрөг авсан боловч гэрээнд тусгаагүй, татвар төлөхөөс зайлсхийсэн хууль бус үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27-р зүйлийн 27.1.1, “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих ...-ийг хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч

шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх ... хориглоно”, “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2 -д “Хуульч үндэслэлгүйгээр хөлс зардал тогтоох, авахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй гэж үзэн мэргэжлийн дүгнэлт үйлдсэн байна.

Өмгөөлөгч Ч.Э нь өөрийн үйлчлүүлэгч Б.М-ээс өмгөөллийн үйлчилгээний хөлсөнд 10 000 000 төгрөгийг авсан гэх боловч энэ талаар үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээнд огт тусгаагүй нь түүний өөрийнх нь бичгээр гаргасан тайлбар, мөн Б.М-ийн тайлбар болон Эрүүгийн тоот хэргээс хуулбарлан авсан баримтуудаар нотлогдож байна.

Маргааны материалд нотлох баримтаар “... 1 жилийн ялыг 1 сая төгрөгөөр хаадаг” /ММ 3-р хуудас, Б.М-ийн гомдол/, “...10-аас дээш жилийн ялтай ... учраас 10 саяар тогтоож байгаа” /ММ 24, 25, хуудас, Ч.Э-ийн мэдүүлэг/, “... 10 сая төгрөг өгчих, тэгвэл 1 жилийн ялыг 1 000 000 төгрөгөөр тооцож ялгүй гаргуулж өгье” /ММ 3-р хуудас, Г.Н-ийн мэдүүлэг /, “... 1 жилийн ялыг 1 сая тооцно гэж хэлсэн...” /ММ 29-р хуудас, Б.М-ийн мэдүүлэг/ зэрэг авагдсан байна. Эдгээр баримтуудаас үзэхэд Ч.Э нь хууль зүйн туслалцааны төлбөрт авсан гэх 10 000 000 төгрөгийн хэмжээг тодорхойлохдоо Б.М-ийн холбогдсон хэрэгт оногдуулж болзошгүй ялын 1 жилийг 1 000 000 төгрөгөөр тооцон тогтоосон гэж үзэхээр байгаа бөгөөд үүнийг “Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм” -ийн 2.4-ийн 2.1- 2.9-д заасан хүчин зүйлсийг харгалзан, үндэслэлтэй тогтоосон гэж үзэхээргүй байна.

Түүний энэ үйлдэл нь “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2 -д заасан “Хуульч үндэслэлгүйгээр хөлс зардал тогтоох, авахыг хориглоно” гэсэн зөрчлийн шинжтэй байна гэж бүрэлдэхүүн дүгнэсэн болно.

Тэрээр хүн амын орлогын албан татвар төлөхгүй байх зорилгоор иргэн Б.М байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээндээ төлбөрийн хэмжээг тодорхой тусгаагүй хэмээн тайлбарлажээ. Энэ нь Ч.Э-ийн хувьд иргэний үүргээ биелүүлээгүй, татварын хууль тогтоомжийн зөрчлийн шинжтэй байх боловч Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах, Мэргэжлийн Хариуцлагын хорооны хянан шийдвэрлэх зөрчлийн шинжтэй үйлдэл биш өөр байгууллага харъяалан шийдвэрлэх асуудал юм.

Иймд Мэргэжлийн Хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн Ч.Э-ийн татвар төлөхөөс зайлсхийсэн асуудлыг харъяалан шийдвэрлэх, дүгнэлт өгөх боломжгүй гэж үзлээ.

Маргааны материалд авагдсан, хуралдааны явцад шинжлэн судлагдсан баримтуудаар хуульч, өмгөөлөгч Ч.Э-г Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27-р зүйлийн 27.1.1, “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих ...-ийг хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх ... хориглоно”, “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2 -д “Хуульч үндэслэлгүйгээр

хөлс зардал тогтоох, авахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн гэм буруутайд тооцож, түүнд зохих шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй байна.

Өмгөөлөгч Ч.Э-д холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлын талаарх баримт маргааны материалд авагдаагүй байна.

Бүрэлдэхүүн тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ хариуцагч Ч.Э нь сахилгын зөрчлийг анх удаагаа гаргасан байдлыг харгалзсан болно.

Гомдол гаргагч Б.М-н зүгээс гаргаж буй “... өмгөөлөгч Ч.Э-ээс 12 000 000 /арван хоёр сая/ төгрөгийг буцаан өгүүлнэ үү” гэсэн гомдлын шаардлага нь Мэргэжлийн Хариуцлагын Хорооны бүрэлдэхүүн шийдвэрлэх асуудал биш байх тул Б.М нь нотлох баримтаа бүрдүүлэн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхтэй байна.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Өмгөөлөгч Ч. Э-г Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27-р зүйлийн 27.1.1, “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих ...-ийг хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх ... хориглоно”, “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийн 2.4 дүгээр зүйлийн 2-д “Хуульч үндэслэлгүйгээр хөлс зардал тогтоох, авахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөнд тооцож, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар “Нээлттэй сануулах шийтгэл” ногдуулсугай.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тогтоогдоогүй, эд мөрийн баримтаар авагдсан зүйл байхгүйг дурдсугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх гуравдугаар бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Д.Цэндсүрэн даргалж, гишүүн М.Алдар, Ч.Хосбаяр, Л.Амарсанаа, Т.Баярсайхан нарын бүрэлдэхүүнтэйгээр, хуралдааны нарийн бичгийн даргаар А.Хуланг оролцуулан, сахилгын шинжээчээс, хариуцагч, өмгөөлөгч Д.Д-д “хаалттай сануулах” сахилгын шийтгэл оногдуулах санал гаргасан маргааныг хорооны хуралдааны танхимд хянаж зөвлөлдөөд

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.М-с: “...Хэргийн давж заалдах шатны шүүхээс “Нэхэмжлэгчийн өмгөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдлын дагуу аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг 2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 13 цаг 30 минутад товлон зарласан. Тухайн өдөр нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс “Д.Д нь өвчтэй байгаа ба шүүх хуралдаанд өмгөөлөгчтэйгээ оролцох хүсэлтэй тул хойшлуулж өгнө үү” гэсэн хүсэлтийг ирүүлжээ. Хүсэлтэд хавсарган ирүүлсэн эмнэлгийн магадлагааг хянан үзэхэд ажлаас чөлөөлсөн хугацаа ойлгомжгүй, огноог гараар засварласан байх магадлалтай, түүнчлэн Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн албан бичигт “Тус эмнэлгийн эмчийн үзлэгийн маягтанд шивэгдэж, тэмдэглэгдээгүй” тухай дурджээ. Иймд өмгөөлөгч Д.Д-н хуурамч баримт бүрдүүлэн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг зөрчсөн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулсан зөрчил гаргасан гэж үзэж байгаа тул зохих журмын дагуу шалган шийдвэрлэнэ үү” гэжээ.

Хуульч, өмгөөлөгч Д.Д Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбартаа: “...Б эмчийг гуйж акт авсан нь үнэн ...хэвтрийн дэглэм сахих хэмжээнд хүрээгүй байсан гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Иймд надад хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэжээ.

Сахилгын шинжээч маргааныг хянан үзээд: “хариуцагч Д.Д нь ...Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.3 дугаар зүйлийн 1.2 “...хуурамч нотлох баримтыг зориуд гаргаж өгөх”-ийг хориглоно гэснийг...зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, уг зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирол байхгүй” гээд хариуцагчид “Хаалттай сануулах шийтгэл” оногдуулах санал” гаргасан байна.

Сахилгын шинжээчийн цуглуулсан баримт сэлтийг бүрэлдэхүүн хянаад:

ҮНДЭСЛЭХ нь:

Гэрч С.С-аас: "...надад хууль зүйн туслалцаа хэрэгтэй байсан учраас Д.Д өмгөөлөгчөөр авсан...манай өмгөөлөгч шүүх хуралд орж чадэхгүй гэхээр...би... магадлагаа энэ тэр өгөхгүй болохгүй, өмгөөлөгчгүй...шүүх хурал хийнэ гээд байсан гэж сануулаад Б эмчээс магадлагаа авч шүүхэд өгсөн.", Гэрч С.Б-с "...миний таньдаг С... "Нийгмийн даатгалын мөнгө авахгүй, манай найз хэд хоног ажилдаа очоогүй юм магадлагаа бичээд өг" гэхээр нь бичиж өгсөн" гэсэн тайлбаруудыг Мэргэжлийн хариуцлагын хороонд тус тус гаргаснаас үзэхэд хариуцагч, өмгөөлөгч Д.Д нь хуурамч баримт бичиг бүрдүүлэн "...шүүхийг мэхлэн..." хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулсан нь тогтоогдсон байх бөгөөд энэхүү үйлдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Өмгөөлөгч нь хувийн сонирхлоо тэргүүнд тавих,...шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно." гэснийг зөрчсөн байна.

Хариуцагч, өмгөөлөгч Д.Д нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч гэмшин цаашид зөрчил гаргахгүйгээ илэрхийлсэн, дурдсан зөрчлийн улмаас "үйлчлүүлэгч, олон нийт, хууль зүйн тогтолцоо..."-нд хохирол учруулсан нь тогтоогдоогүй байх тул сахилгын шинжээчийн саналыг үндэслэлтэй гэж үзлээ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 3.6 дугаар зүйлийн 1, 10.11 дүгээр зүйлийн 4, 14.4, 14.5, 14.6 дугаар зүйлүүдийг удирдлага болгон

ТОГТООХ нь

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.1.1, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн хариуцагч, өмгөөлөгч Д.Д-д "хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
3. Тогтоолыг хариуцагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.
4. Сахилгын шинжээч, хариуцагч нар тогтоолыг эс зөвшөөрвөл гардаж авсанаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хариуцлага хүлээлгэх тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх гуравдугаар бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Д.Цэндсүрэн даргалж, гишүүн, Ч.Хосбаяр, Л.Амарсанаа, М.Алдар, Т.Баярсайхан нарын бүрэлдэхүүнтэйгээр, хуралдааны нарийн бичгийн даргаар А.Хуланг оролцуулан, сахилгын шинжээчээс хариуцагч өмгөөлөгч К.С-д “Хаалттай сануулах” хариуцлага хүлээлгэх санал гаргасан маргааныг хорооны хуралдааны танхимд гишүүн Л.Амарсанаагийн илтгэснээр хянаж зөвлөлдөөд

Иргэн Г.Ц тус хороонд гаргасан гомдол, тайлбартаа: “Миний төрсөн дүү Г.Г нь 2013 онд Ц.О-д 15 сая төгрөг зээлдүүлээд...мөнгөө авах гэж жил гаруй хөөцөлдсөн ... 2014 оны 12 дугаар сард дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан...Хэргийг өөрийнхөө өмнөөс хөөцөлдүүлэн хурдан шуурхай...дуусгуулах зорилгоор...С-ийг өмгөөлөгчөөр авч гэрээ хийх үед нь би байлцсан...Түүний...дансанд 750 000 төгрөг шилжүүлж итгэмжлэл хийж өгсөн. Бид өмгөөлөгчдөө итгээд л байгаад байсан. Хэрэг яаж шийдсэнийг мэдэх гэж дүү хотод ирээд өмгөөлөгчтэй уулзаж чадаагүй. Өмгөөлөгчтэй холбогдож чадахгүй болохоор дүү “шийдвэр гүйцэтгэл дээр очоод асуу” гэхээр нь шийдвэр гүйцэтгэгч У-аас лавласан...С-тэй 2014 оны 12 дугаар сарын 17- ны өдөр гэрээ хийж ажил эхлүүлсэн боловч тодорхой ажил хийхгүй хугацаа алдаж ...миний дүү 15 сая төгрөгөөр хохироод дээрээс нь өмгөөлөгчийн хөлсөнд 750 000 төгрөг өгч давхар хохирч байна. Өмгөөлөгч нь гэрээнийхээ дагуу ажил хийгээгүй, элдэв шалтаг ярьж өдий хүрсэн тул...зохих арга хэмжээг авч үйлчилгээний хөлсийг барагдуулж өгнө үү” гэжээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Хариуцагч, өмгөөлөгч К.С Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбартаа:“...би үйлчлүүлэгч Г-ийн хүсэлтээр хариуцагч Ц.О-ын гэрийн хаяг, оршин суугаа хаягийг тогтоож, биечлэн уулзаж улмаар Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2-р шүүхэд нэхэмжлэл бичиж шүүх хурал хийлгэсэн...Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн. Ц.О шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байсан тул би албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг шүүхэд гаргаснаар шийдвэр гарч...НШГА-ны шийдвэр гүйцэтгэгч У-д байгаа. Би шийдвэр гүйцэтгэгч У-тай байнга холбоотой ажиллаж байгаа ...хаалттай сануулах арга хэмжээ авахыг хүлээн зөвшөөрч байна” гэжээ.

Сахилгын шинжээчээс, “...өмгөөлөгч К.С-ийн үйлдэл нь ...Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “хуульч зөвхөн үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй зөвшөөрлөөр хэрэг маргааныг эвлэрүүлэн

шийдвэрлүүлэх ажиллагаа явуулна”, 2.3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт “хууль эсхүл энэ дүрэмд заасны дагуу мэдээлэлтэй зөвшөөрөл шаардлагатай аливаа шийдвэр нөхцөл байдлын талаар үйлчлүүлэгчид мэдэгдэх”, 1.3 дахь хэсэгт “үйлчилгээний явцын талаар тухай бүр үйлчлүүлэгчдээ мэдээлэх”, 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ эрх ашиг сонирхолд нийцүүлэн хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах талаар чармайн ажиллана” гэж заасныг тус тус зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч...учруулсан хохирлын 700000 төгрөгийг...төлсөн байх тул” гээд К.С-д “хаалттай сануулах” хариуцлага хүлээлгэх санал гаргажээ.

Сахилгын шинжээчийн санал, цуглуулсан баримтуудыг хянаад

ҮНДЭСЛЭХ НЬ:

Хариуцагч, өмгөөлөгч К.С иргэн Г.Г-т “Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г 2014 оны 12 дугаар сарын 17-нд байгуулж өмгөөллийн хөлсөнд 750 000 төгрөгийг мөн өдөр бэлэн бусаар авчээ.

Дээр дурдсан гэрээний 2.2-ын /Өмгөөлөгчийн үүрэг/ 2.2.1-д “Гэрээнд заасан асуудлаар үйлчлүүлэгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, уг асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн шүүх ажиллагааны бүх шатанд болон бусад ажиллагаануудад үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж тохиролцжээ.

Гэвч, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2015 оны 11 дүгээр сарын 20- ны өдрийн 3/40370 тоот албан бичигт “...шүүхийн 2015 оны 01- дүгээр сарын 29- ний өдрийн 786 дугаар шийдвэрээр Ц.О-с 15 116 475 төгрөг гаргуулж Г.Г-т олгохоор шийдвэрлэсэн. Дээрх шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд К.С-ийн зүгээс өнөөдрийн байдлаар хүсэлт гомдол гаргаж байгаагүй...” гэснээс үзэхэд хариуцагч, өмгөөлөгч К.С гэрээгээр хүлээсэн дээр дурдсан үүргээ биелүүлээгүй, энэ үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн 38.1.1-д заасан “үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга хэрэгслийг ашиглан бүрэн тууштай хамгаалах” гэснийг болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн гэж үзлээ.

Түүнчлэн хариуцагч, өмгөөлөгч К.С нь иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар үйлчлүүлэгчдээ мэдэгдэж байгаагүй нь цуглуулсан баримтуудаар тогтоогдсон, хариуцагч дээрх эс үйлдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 -ийн “хууль эсхүл энэ дүрэмд заасны дагуу мэдээлэлтэй зөвшөөрөл шаардлагатай аливаа шийдвэр, нөхцөл байдлын талаар үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.” гэснийг зөрчсөн, энэ талаар сахилгын шинжээчээс гаргасан санал үндэслэлтэй байна.

Харин, Г.Г-с К.С-д олгосон 2014 оны 12 дугаар сарын 16-ны итгэмжлэлд “... нэхэмжлэгчийн өмнөөс ...эвлэрлийн гэрээ байгуулах... бүрэн эрхийг...олгож байна.” гэсэн байх тул сахилгын шинжээчээс К.С-ийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 4 хэсэгт заасныг зөрчсөн гэсэн нь үндэслэлгүй болно.

К.С нь гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрч гэмшиж байгаа, үйлчлүүлэгчийнхээ өмнөөс нэхэмжлэл гаргаж хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэн улмаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамж гаргуулсан, өмгөөллийн хөлсөнд авсан мөнгөө эргүүлэн төлсөн зэргийг бүрэлдэхүүн харгалзан үзэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 3.6 дугаар зүйлийн 1,10-12 дугаар зүйлийн 4, 14.4, 14.5, 14.6 дугаар зүйлүүдийг удирдлага болгон

ТОГТООХ нь

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, мөн хэсгийн 29.1.1, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1-д тус тус зааснаар хариуцагч, өмгөөлөгч К.С-д “Хаалттай сануулах шийтгэл” оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
3. Тогтоолыг хариуцагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.
4. Сахилгын шинжээч, хариуцагч нар тогтоолыг эс зөвшөөрвөл гардаж авсанаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Хуульч Ү.А холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Б.Бат-Орших даргалаж гишүүн Ц.Сумъяа, Ж.Энхчулуун, Ц.Өрнөндэлгэр, Э.Золзаяа нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимд хаалттай явуулж хуульч Ү.А-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналыг холбогдох нотолгоо баримтын хамт гишүүн Б.Бат-Оршихын илтгэснээр хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн саналд:

“Хариуцагч Ү.А нь эрүүгийн дугаартай Л.Б-д холбогдох эрүүгийн хэрэгт хохирогчийн өмгөөлөгчөөр ажиллаж байх явцдаа Л.Б ээж С.Т-тай 2016 оны 1 дүгээр сарын 13-нд утсаар ярихдаа “... би танай хүүгийн хохирогчийн ах байна, зүв зүгээр байсан хүүхдийг танай хүү аймшигтайгаар зодож танхайрсан байна...”, би бол хуульч хүн, танай хүүг би Монголын хамгийн дээд зэргийн шоронд явуулна, тэгээд тэндээ ялаа эдлээд дуусан дуустал нь би өөрөө хяналт тавиад, би хүүг чинь охин болгуулаад гаргаж ирнэ. Би харин ч нэг чадна шүү ... би ингэхийн тулд хуульч мэргэжил эзэмшсэн ...” гэж сүрдүүлж, дарамталсан үйлдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хуульч нь бусад хуульч, аливаа этгээд, олон нийтийн мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцана”, “хуульч ажил хэргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэнэ”, 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульч нь өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг этгээдтэй түүний хуульчийг байлцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой асуудлаар харилцахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул түүний үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон Хариуцагч Ү.А-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна” гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Гомдол гаргагч С.Т тус хороонд гаргасан гомдолдоо: С.Т ... миний том хүү Л.Б нь 2016 оны 1 дүгээр сард өөрийн нэг найзтайгаа маргалдаж улмаар түүний нүүрэн

тус газар гараараа цохиж түүний биед хүндэвтэр гэмтэл учруулж, эрүүгийн хэрэгт сэжигтэнээр тооцогдон шалгагдаж байгаа билээ. ... Гэтэл хэрэг болоод удаагүй байхад, гэсэн дугааруудаас миний гар утас руу Ү.А гэдэг хүн залгаад өөрийгөө хуульч хүн байна гэж танилцуулсан бөгөөд надад хандан "... гичий, нохой минь... би танай хүүгийн хохирогчийн ах байна, зүв зүгээр байсан хүүхдийг танай хүүг би Монголын хамгийн дээд зэргийн шоронд явуулна, тэгээд тэндээ ялаа эдлээд дуусан дуустал нь би өөрөө хяналт тавиад, би хүүг чинь охин болгуулаад гаргаж ирнэ. Би харин ч нэг чадна шүү... би ингэхийн тулд хуульч мэргэжил эзэмшсэн..." гэх мэтээр намайг загнаж, сүрдүүлж хэд хэдэн удаа залгаж ярьсан. ... өмгөөлөгч Ү.А-н үйлдэлд танай холбоо зохих ёсны шалгалтыг явуулж энэ хүний хуульчийн эрхийг хасаж, дахин хуульчийн нэр барьж бусдыг сүрдүүлэхээс нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг өвч өгнө үү" гэжээ. /ММ-н 4-6 хуудас/

2. Хариуцагч Ү.А тус хороонд өгсөн тайлбартаа: "... уулзаж байгаагүй, утсаар 2 удаа ярьж байсан. Нэг өдөр 2 удаа би өөрөө залгаж ярьсан санагдаж байна. Эхний удаа А-ний хохиролын мөнгийг төлүүлэх гэж ярьсан. Энэ хохиролын мөнгө бодит хохирол нь 1.500.000 төгрөг байсан, батлагдсан буюу эмчийн баталгаажуулсан хохирол нь 8.000.000 орчим төгрөг болсон гэсэн. Гэхдээ би мөнгөн дүн яриагүй, миний Б-ий ээжтэй ярих болсон шалтгаан нь А-ний ээж нь хохирлыг барагдуулмаар байна чи яриадхаач гээд хэлсэн. Тэгээд л би ярьсан. Бид 2 цуг өссөн болохоор янз бүрийн юм болохоор би л явдаг юм. Мөн энэ удаа ярихдаа, би хүүхдийнх нь ёс суртахуун, үйлдсэн хэргийнх нь тухай ярьсан, зодчихоод буудлаар цусыг нь гаргаад явсан байдаг болохоор эмнэлгийн тусламж үзүүлээгүй тухай ярьсан тэгээд тасалсан. 2 дахь удаагаа ярих болсон шалтгаан нь Б нь манай дүү А-тэй уулзсан ч байдаг билүү ярьсан ч байдаг билүү юм болсон байдаг юм. Тэгээд ээж Б нь нөгөөх чинь ахиад А-ийг дарамталсан байна гэж надад юм хэлсэн. Ингээд би Б-ий ээж рүү нь ахиад залгаж ярьсан. Ингэж ярихдаа хүүдээ А.Э-г битгий дарамтал гэж хэл гэж хэлсэн, мөн танай хүүхэд чинь тэнсэнтэй учраас хохирлыг төлүүлээд аятайхан дуусгачихгүй гэж ярьсан. Нээрээ 3 удаа залгасан юм байна. Маргааш өдөр нь над руу ээж С.Т нь залгаад би чиний бичлэгийг хийсэн, Хуульчдын холбоонд чинь өгнө, танайх юмаа бас аятайхан дуусгачихгүй гээд бас намайг буцаагаад дарамталж эхэлсэн Тиймээ миний ярьсан хэлсэн бүгд мөн байна. Би бол сэтгэл хөдлөлөө барихгүй. Ийм юм ярьсандаа гэмшиж байгаа.

Ярих болсон шалтгаан нь миний цэвэр сэтгэл хөдлөлтэй холбоотой. Учир нь тэр хэрэг болсон өдөр цус нөжийг нь гаргаад дүү минь явсан байна" гэжээ. /ММ-н28-31-р хуудас/

3. Хариуцагч Ү.А тус хороонд гаргасан хүсэлтдээ: "Хуульч Ү.А миний бие Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчаар ажилладаг бөгөөд надад холбогдуулан гаргасан гомдолд дурьдсан асуудал болон тус гомдлын үндсэн дээр хийгдсэн шинжээчийн дүгнэлтийг мөн адил бүрэн хүлээн зөвшөөрч байгаа дээр тус дүгнэлтэнд гаргахгүй болно. Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж хаалттай сануулга өгч асуудлыг минь зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү" гэжээ. /ММ-н 32-32-р хуудас/

4. Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагчийн 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн тэмдэглэл, С.Т-с гаргаж өгсөн CD-ний бичлэгт үзлэг хийж, өмгөөлөгч Ү.А-тай ярьсан утасны ярианы тэмдэглэл /ММ-н 34-36-р хуудас/
5. Эрүүгийн дугаартай хэргээс хуулбарлаж авсан баримтууд /ММ-н 19-27-р хуудас/
6. С.Т, Ү.А нарын утсаар харилцсаны бичлэг бусад бичгийн нотлох баримтууд зэрэг болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс “Ү.А нь Л.Б-д холбогдох эрүүгийн хэрэгт хохирогчийн өмгөөлөгчөөр ажиллаж байх явцдаа Л.Б-ний ээж С.Т-тай 2016 оны 1 дүгээр сарын 13-нд утсаар ярихдаа ...сүрдүүлж дарамталсан байна гэх үндэслэлээр хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах” санал гаргасан ба хариуцагч Ү.А нь “...надад холбогдуулан гаргасан гомдолд дурьдсан асуудал болон тус гомдлын үндсэн дээр хийгдсэн шинжээчийн саналыг мөн адил бүрэн хүлээн зөвшөөрч байгаагийн дээр тус саналд гомдол гаргахгүй болно. Хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэж тайлбарлажээ.

Өмгөөлөгч Ү.А нь Л.Б-д холбогдох эрүүгийн дугаартай хэрэгт холбогдогчийн өмгөөлөгчөөр ажиллаж байх явцдаа Л.Б-ний ээж С.Т-тай 2016 оны 01 дүгээр сарын 13-нд утсаар ярихдаа “би хохирогчийн ах байна, зүв зүгээр байсан хүүхдийг танай хүү аймшигтайгаар зодож танхайрсан байна..., би бол хуульч хүн, танай хүүг би Монголын хамгийн дээд зэргийн шоронд явуулна, тэгээд тэндээ ялаа эдлээд дуусан дуустал нь би өөрөө хяналт тавиад, би хүүг чинь охин болгуулаад гаргаж ирнэ. Би харин ч нэг чадна шүү... би ингэхийн тулд хуульч мэргэжил эзэмшсэн...” гэж сүрдүүлж дарамталсан үйлдэл нь гомдол гаргагч С.Т-н гомдол болон түүний нөхөр С.Л-н тайлбар, хариуцагчийн гэм буруугаа хүлээсэн тайлбар, хүсэлт, Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагчийн 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн тэмдэглэл зэргээр тус тус нотлогдож байна.

Ү.А нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, шүүхэд төлөөлөх эрхтэй болох нь Монголын Хуульчдын холбооны тамгын газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 14-ний 2/209 албан бичгээр тогтоогдсон.

Хариуцагч Ү.А үйлдэл нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хуульч нь бусад хуульч, аливаа этгээд, олон нийттэй мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцана. Хуульч ажил хэргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэнэ”, 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хуульч нь өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг этгээдтэй түүний хуульчийг байлцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой асуудлаар харилцахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн, энэ нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

Ү.А нь Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь

заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн байх тул сахилгын шинжээчийн "хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай" саналыг үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Хариуцагч нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг хүлээн авсан, хүлээн авснаас хойш тухайн саналыг зөвшөөрсөн буюу тухайн маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй байх тул сахилгын шинжээчийн саналыг бүрэлдэхүүн хянан үзэж хуралдаан хийхгүйгээр зөвлөлдөж шийдвэрлэх үндэслэлтэй нь Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудад тодорхойлогджээ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1 дэх хэсгийн 29.1.1, Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Ү.А-д "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл тогтоол гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.
3. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтаар 1 ширхэг CD авагдсан, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүй болохыг тус тус дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Б. Н-т холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Г.Ганзориг даргалж, гишүүн Г.Алтанчимэг, Э.Ариунаа, Б.Баатар нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн өмгөөлөгч Б.Н-т холбогдох дүгнэлтийг хянан хэлэлцэв.

Хуралдаанд сахилгын шинжээч Г.Должинсүрэн, гомдол гаргагч М.О, хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

1. Иргэн М.О тус хороонд гаргасан гомдол болон Хорооны хуралдаанд гаргасан тайлбартаа: “Б.Н-т 2015 оны 6 сард 500.000 төгрөг төлж, Дээд шүүхийн хуралдаанд өмгөөлөгчөөр оролцуулахаар тохирсон боловч тэрээр хуралдаанд оролцоогүй. Дахиж 300.000 төгрөг нийт 800.000 төгрөгийн төлбөр авсан боловч ямар ч үйлчилгээ үзүүлээгүй, гэрээ ч хийгээгүй. Зохих арга хэмжээ авч, миний мөнгийг буцаан олгохыг хүсье гэжээ.
2. Хариуцагч Б.Н хороонд гаргасан тайлбартаа: Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ хийсэн, 800.000 төгрөг үйлчилгээний төлбөрт авсан. Дараа нь М.О өөрөө өөр өмгөөлөгч авсан байсан. Би зохих журмын дагуу туслалцаа үзүүлсэн гэжээ.
3. Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн дүгнэлтэд, хариуцагч Б.Н нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1, 2.4 дүгээр зүйлийн 2, 4.2 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт заасныг тус тус зөрчсөн гэж дурдсан байна.
4. Б. Н-т хуралдаанд оролцохыг мэдэгдсэн боловч ирээгүй байна.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Б.Н нь иргэн М.О-с хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээний төлбөрт Улаанбаатар хотноо, 2015 оны 6 сард нийт 800.000 төгрөг авсан боловч тэрээр шүүх хуралдаанд оролцоогүй, гэрээ байгуулаагүй зэрэг нь Б.Н, М.О нарын мэдүүлэг, маргаан шалгасан материалд авагдсан гэрч О.Б-н мэдүүлэг, мөнгө хүлээн авсан баримт зэргээр нотлогдож байна. Б.Н нь ийнхүү, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна” гэсэн заалтыг түүнчлэн, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “...хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх зөрчил

үйлдэхийг "...хориглох" талаарх заалтыг тус тус зөрчсөн байх тул түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Иргэн М.О-н , Б.Н-с 800.000 төгрөгийг гаргуулах хүсэлт нь Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүн харьяалан шийдвэрлэх асуудал биш байх бөгөөд тэрээр энэ тухай нэхэмжлэлээ холбогдох шүүхэд гаргаж, шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар Б. Н-т "Нээлттэй сануулах шийтгэл" ногдуулсугай.
2. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Хуульч Ю.Т-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн Д.Ганзориг даргалж, гишүүн Б.Баатар, Э.Ариунаа, Г.Аптанчимэг, Ө.Одгэрэл, нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимд зөвлөлдөн хуульч Ю.Т-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Эрдэнэсүрэнгийн саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн саналдаа: Хариуцагч Ю.Т нь иргэн Д.У-тай 2015 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөнд 500.000 төгрөг авч, үйлчлүүлэгчийн өвчний карт, хөлний зураг зэргийг аваад холбоо барихгүй сураггүй болсон, иргэн Э.Х-с үйлчилгээний хөлсөнд 500.000 төгрөг авч, яллагдагчийн байцаалтад нэг удаа суусан, утсаа авдаггүй, ярьдаггүй, шүүх хуралд оролцоогүй зэрэг байдлаар Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан нь нотлогдсон, хариуцагч гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар хариуцагч Ю.Т-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Гомдол гаргагч Д.У гомдолдоо: "...Ю.Т нь утсаа авдаггүй...хөл муу, нялх хүүхэдтэй учраас өмгөөлөгч авсан боловч утсаа авдаггүй сураггүй болсон...эрх зүйн туслалцаа үзүүлэх битгий хэл карт, хөлний зураг авч яваад асуудлыг удаашруулж чирэгдэл болсон...гэжээ." /ММ-ын 5-р хуудас/
2. Гомдол гаргагч Э.Х гомдолдоо: "...өмгөөлөгч Ю.Т 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Чингэлтэй дүүргийн Цагдаагийн дугаар хэлтсийн байранд гэрээ хийсэн юм ...миний төлбөр болох 500.000 төгрөгийг авсан ...Ю.Т нь мөнгө авсан өдрөөсөө хэл сураггүй эргэж ярих ч үгүй болохоор нь миний бие, аав Э, өвөө Ж нар хэд хэдэн удаа ярих гэсэн боловч ихэнх тохиолдолд утсаа авахгүй байсан ...2016.02.03-ны өдрийн шүүх хуралд ч ирээгүй" гэжээ. /ММ-ын 17-р хуудас/
3. Гомдол гаргагч Э.Х 2016.02.26-ны өдөр өгсөн тайлбартаа: "...миний өвөө 2016.01.08-ны өдөр Ю.Т өмгөөлөгчид 500.000 төгрөгийг бэлнээр өгсөн. Тэгээд л ерөнхийдөө мөнгөө аваад алга болсон ...надад холбогдох хэрэг мөрдөн

байцаалтын шатнаас прокурорын хяналт, шүүхийн хяналт зэрэгт шилжихэд очиж хэрэгтэй танилцаагүй, ганц ч ирээгүй. Өмгөөлөгч Ю.Т-с болж 2016.02.03-ны өдөр...хэрэг хойшилсон...гэрээ хийх талаар ярих гээд удаа дараалан залгахад утсаа аваагүй. Байцаалт болгонд өмгөөлөгчгүй оролцож байсан. Хууль зүйн зөвлөгөөг амаар 2 удаа өгсөн". /ММ-ын 28-р хуудас/

4. Гэрч Д.Ж тайлбартаа: "...Ю.Т гэдэг хүнийг 2016.01,05-ны өдөр өмгөөлөгчөөр авахаар Чингэлтэй дүүргийн Цагдаагийн-р хэлтсийн байрны давхарт коридорт уулзалдаж тохиролцсон. 500.000 төгрөгийг өөрөө бэлнээр уулзаад цаасан дээр мөнгө төгрөг хүлээж авлаа гэж бичээд гарын үсэг зураад явсан ...Х-г байцаалт өгөх үед энэ хүн нэг л удаа байцаалтад сууж оролцсоноос өөр ямар ч туслалцаа үзүүлж, байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй" /ММ-ын 30-р хуудас/
5. 2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн ...286 дугаар шүүгчийн захирамжид. ...Шүүгдэгч Х-с миний бие өөрийн өмгөөлөгч Ю.Т-оос татгалзаж байна. Учир нь Ю.Т өмгөөлөгч миний эрх ашгийг хамгаалахгүй байна гэж үзэж байгаа тул өөр өмгөөлөгч авах хүсэлттэй байна" гэсэн хүсэлт гаргасныг хүлээн авч, шүүгдэгчийг өмгөөлүүлэх бололцоогоор хангах нь зүйтэй гэж шүүх үзэв гэжээ." /ММ-ын 51-р хуудас/
6. Эрүүгийн тоот хэрэгт: "... шинжээчийн дүгнэлт танилцуулсан 2015.12.01-ний өдрийн тэмдэглэлд өмгөөлөгч О.Т нь "шинжээчийн дүгнэлттэй танилцлаа" гэж бичиж гарын үсэг зурсан, Мөрдөн байцаах ажиллагааг дуусгаж, хэргийн материалыг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод танилцуулсан 2015.12.01-ний өдрийн тэмдэглэлд "хэргийн материалтай танилцлаа, прокурорын шатанд хүсэлт гаргана" гэж бичиж гарын үсэг зурсан". /ММ-ын 41-42-р хуудас/
7. Эрүүгийн дугаартай Х-т холбогдох хэрэгт: "2015.12.31- ний өдрийн яллагдагчаар байцаасан тэмдэглэлд өмгөөлөгч Ю.Т байлцсан хэсэгт гарын үсэг зурсан байна". /ММ-ын 58-62-р хуудас/
8. Хариуцагч Ю.Т 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өгсөн тайлбартаа: "...иргэн Д.У асуудал дээр бол би хууль зүйн туслалцаа үзүүлсэн. Хэргийн материалтай танилцаад нэмэлт ажиллагаа хийлгүүлэх хүсэлт гаргаж байсан. Иргэн Д.У –тай 2015 оны 11 дүгээр сарын 03-нд хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ хийсэн. Шүүх шинжилгээний хүрээлэнд дахин шинжилгээ хийлгэх гээд шаардлагатай нотлох баримтуудыг нь би өөрөө хөөцөлдөж явж олж аваад шүүх эмнэлэгт өгч гэмтлийн зэргийг нь хүндэвтэр болгон гаргуулсан. Д.У бол надаас “өдөр шөнөгүй явж хохирлыг нь барагдуулахыг хүсдэг” байсан. Д.У-д би 3 асуудал дээр зөвлөгөө өгсөн. 1.Тэтгэмжийн асуудалд, 2. Хүүхэд нь хүний машин эвдсэн асуудалд, 3.Эрүүгийн хэрэгт хохирогчоор оролцсон асуудал зэрэгт нь би хууль зүйн туслалцаа үзүүлсэн... “...иргэн Э.Х нь намайг өмгөөлөгчөөрөө авсан. Хэзээ өмгөөлөгчөөр авсныг нь санахгүй байна. Тухайн үед авсан байсан таслан сэргийлэх арга хэмжээг нь өөрчилж цагдан хорих гэж байхад нь би байцаагчтай нь уулзаж болиулсан, байцаалтад нь сууж хэргийн материалтай танилцсан юм. Э.Х нь “намайг байцаагчтайгаа байнга уулзаж бай” гэдэг шаардлага тавьдаг

байсан. Ингээд хэрэг нь шүүх дээр шилжсэний дараа хэргийн материалтай танилцъя гэсэн чинь хэрэг дөнгөж ирсэн учраас танилцуулахгүй гэсэн. Тэгээд л байж байсан чинь шүүх хурал маргааш болно гэж Х утсаар хэлэхээр нь би “шүүх хурал маргааш болох гэж байхад надад хэлээд байхдаа яадаг юм бэ” гээд би “өмгөөлөгч ирээгүй өмгөөлөгчтэй хуралд орно” гээд хойшлуулчих гэж хэлсэн. Тэгээд ч би тэр үед өөр газар шүүх хуралтай байсан юм.

Ингээд дараа нь Э.Х өөрөө залгаад “би өөр өмгөөлөгч авахаар боллоо гэхээр нь өөр өмгөөлөгч авуул хэлээрэй намайг уулзуулаарай гэж хэлсэн боловч уулзуулаагүй, зураг эмнэлгийн карт 2 нь хавтаст хэрэгт нь байгаа. Баянзүрх дүүргийн хэрэг бүртгэгч М дээр зураг, карт 2 нь үлдсэн байхад нь би очиж аваад А гэдэг байцаагчид нь өгсөн юм. Би өмгөөлөх ажиллагаагаа дутуу хийж Э.Х-ын шүүх хуралд оролцоогүй, Д.У-д үзүүлсэн үйлчилгээгээ дутуу орхигдуулснаа хүлээн зөвшөөрч байна. Эдгээр хүмүүсийг хохиролгүй болгоноо” гэжээ. /ММ-ын 33-р хуудас/

9. Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагчийн тэмдэглэл болон бусад бичгийн нотлох баримтууд маргааны материалд авагдсан байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч Ю.Т нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2,-т заасан “хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана.”, 2.3 дугаар зүйлийн 1.3-т “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх” гэж заасныг тус тус зөрчсөн болох нь Д.У, Э.Х нарын гомдол, тайлбар, гэрч Д.Ж-н тайлбар,,, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн “Хуралдаан хойшлуулах тухай” 2016 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 286 дугаар захирамж, мөн өдрийн хуралдааны тэмдэглэл, хариуцагчийн өөрийнх нь тайлбар болон бичгийн бусад нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Энэ зөрчил нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна. Хариуцагчид сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай мэдэгдлийг 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөр огноолон хүргүүлсэн, 14 хоногийн дотор тухайн саналыг эс зөвшөөрч маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй байна.

Хариуцагч Ю.Т нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн зэрэг байдлыг харгалзан Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар хариуцагч Ю.Т-д хаалттай сануулах шийтгэл

оногдуулах санал ирүүлсэн нь үндэслэлтэй байна гэж бүрэлдэхүүн үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.4, 14.5, 14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1,-д зааснаар Ю.Т-д “хаалттай сануулах шийтгэл” оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Хуульч Г.И-д хаалттай сануулах хариуцлага хүлээлгэх тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Е.Сагсайн илтгэснээр гишүүн Ц.Өрнөндэлгэр, С.Амардэлгэр, Ө.Одгэрэл, Т.Өсөхбаяр нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч Г.И-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

Хариуцагч Г.И нь,, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа эрүүгийн дугаартай А.Э-д холбогдох эрүүгийн хэрэгт шүүгдэгчийн өмгөөлөгчөөр оролцож байхдаа 2016 оны 03 дугаар сарын 16, 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй байна.

Хариуцагч Г.И нь дээрх үйлдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана", 4 дүгээр зүйлийн 4.2.2 "Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, өөртөө эсхүл үйлчлүүлэгчдээ санхүүгийн ашигтай байдал бий болгох, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Иймд Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг үндэслэн өмгөөлөгч Г.И-н үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Г.И-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв. Үүнд:

.....,, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч М.А-аас гаргасан хүсэлтэндээ:

“Тус шүүхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсэгт зааснаар яллагдагчаар татах тогтоол баталж ирүүлсэн А овогт А-ийн Э-д холбогдох эрүүгийн дугаартай хэрэг хянагдаж байна. Шүүгдэгчийн өмгөөлөгч Г.И /ҮДН№1642/ нь 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн шүүх хуралдааныг эрүүл мэндийн шалтгааны улмаас, 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн шүүх хуралдааныг,, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүх хуралдаан давхацсан шалтгаанаар 2 удаа хойшлуулсан болно. Хүсэлтэнд хавсаргасан үндэслэл муутай, шаардлага хангахгүй баримт байна. Тухайлбал “Тойгийн тал” ХХК-ий “Sky international” эмнэлэг ажлаас чөлөөлсөн магадлагаа олгохдоо 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2016 оны 03 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл 10 хоногоор олгосон байна. Шүүгчийн туслах Д.М өмгөөлөгч Г.И-ндугаарын утас руу 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдөр залгаж “...таны эмнэлэгт хэвтсэн гэх баримт дутуу байна, та өвчний түүхээ хуулбарлаад авч ирж өгнө үү, боломжгүй бол явуулаарай гэхэд за ойлголоо, Э сая надруу ярьж, хэлсэн, эмнэлгээс гараад хэргийн материалтай танилцъя, очно” гэсэн боловч ирээгүй, баримтаа авч ирж өгөөгүй, хэргийн материалтай танилцаагүй.

Мөн 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн шүүх хуралдаанд,, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн “шүүх хуралдааны тов мэдэгдэх тухай” баримтыг хүсэлтийн хамт ирүүлсэн нь учир дутагдалтай байна. Эхний шүүх хуралдаан хойшлох үед өөрийнх нь хүсэлтийн дагуу хуралдааныг 14 хоног хойшлуулсан байтал дараагийн шүүх хуралдааныг дахин хйошлуулж, шүүн таслах ажиллагаанд зориуд саад учруулж байна гэж үзэх үндэслэлтэйг үүгээр уламжилж байна.” гэжээ. /ММ-н 2-3-р хуудас/

Хариуцагч Г.И тус хороонд гаргасан тайлбартаа:

“Монголын Хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч би,, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа А.Э-ны өмгөөлөгчөөр оролцох хуралдаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг 2 удаа хойшлуулсан нь үнэн болно. Хаалттай сануулахад татгалзах зүйлгүй” гэсэн байна. /ММ-н 22-р хуудас/

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс “Г.И нь,, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа эрүүгийн дугаартай А.Э-д холбогдох эрүүгийн хэрэгт шүүгдэгчийн өмгөөлөгчөөр оролцож байхдаа 2016 оны 03 дугаар сарын 16, 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй үндэслэлээр түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах” санал гаргасан ба хариуцагч Г.И “Би шүүх хуралд хүндэтгэх шалтгаангүй оролцоогүй буруугаа ойлгож гэмшиж байгаа тул хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэж тайлбарлаж байна.

Г.И нь Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн, учруулсан хохирлоо нөхөн төлсөн байх тул сахилгын шинжээчийн “хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай” саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Хариуцагч нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авсан, хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн саналыг зөвшөөрсөн буюу тухайн маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй байх тул сахилгын шинжээчийн саналыг бүрэлдэхүүн хянан үзэж хуралдаан хийхгүйгээр зөвлөлдөж шийдвэрлэх үндэслэлтэй нь Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудад тодорхойлогджээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар хариуцагч Г.И-д "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Хуульч Д.Ч-д хаалттай сануулах хариуцлага хүлээлгэх тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Ц.Оч илтгэснээр гишүүн Б.Ундрах, Ц.Давхарбаяр, Б.Бат-Орших, Д.Байгалмаа нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч Д.Ч-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Эрдэнэсүрэнгийн саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

Хариуцагч: Хэнтий аймгийн Хэрлэн сум дугаар багт нөхөр, хүүхдүүдийн хамт амьдрах, эмэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, оны Хэнтий аймагт төрсөн, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн нэгдсэн бүртгэлийн 1358 дугаарт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн 1233 дугаарт тус тус бүртгэгдсэн Их Хиад овогт Д.Ч нь иргэн Л.Г-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөнд 1.000.000 төгрөг авсан атлаа эрх зүйн туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй болох нь маргааны материалын хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар нотлогдсон гэж үзлээ.

Хариуцагч Д.Ч нь дээр дурдсан үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д “хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал...”, 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх хэсэгт “...бүрэн, тууштай хамгаалах”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “гэрээгээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд өөрөө санаачлан үйлчлүүлэгчийнхээ эрх ашиг сонирхолд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж болно”, 2.3 дугаар зүйлийн 1.3-д “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх”, 1.4 дэх хэсэгт “үйлчлүүлэгчийн мэдээлэл хүссэн үндэслэл бүхий хүсэлтийг шуурхай хангах” гэж заасныг тус тус зөрчсөн ба гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн тул Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Д.Ч-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцээд

Үүнд:

1. Гомдол гаргагч Г гомдолдоо: "...өмгөөлөгч Д.Ч-с хууль зүйн туслалцаа авахаар гэрээ хийж өмгөөллийн хөлсөнд 2013 оны 4 дүгээр сарын 16-нд 1.000.000 төгрөг урдчилгаа болгон шилжүүлж өгсөн. Гэтэл Д.Ч өмгөөлөгч эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй, хуульд заасны дагуу өмгөөллийн ямар ч ажиллагаа хийж өгөөгүй. Цагдан хорих төвийн захиргаанд Д.Ч өмгөөлөгчтэй уулзуулж өгөөч гэсэн хүсэлтийг удаа дараа бичгээр гаргасан боловч Д.Ч өмгөөлөгч над дээр нэг ч удаа ирээгүй..." гэжээ.
2. Гомдол гаргагч Л.Ч гомдолдоо: "...би 2013 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Д.Ч-с хууль зүйн туслалцаа авахаар харилцан тохиролцож Д.Ч өмгөөлөгчийн хүссэнээр өмгөөллийн хөлсөнд 1.000.000 төгрөгийг шилжүүлсэн. Гэтэл Д.Ч өмгөөлөгч нь утсаа салган, бидэнд хууль зүйн туслалцаа үзүүлээгүй тул бидний өмгөөллийн хөлсөнд төлсөн мөнгийг буцааж олгуулж өгнө үү. Д.Ч өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлээгүй гэдгээ хүлээн зөвшөөрч удаа дараа шаардуулан байж 200.000 төгрөгийг бидэнд 2016 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр өгсөн. Миний дүүг ядарч явахад нь санхүүгийн давхар хүнд байдалд оруулж 1.000.000 төгрөгийг нь өмгөөлөл хийж өгнө хэмээн авч залилж хохироосон тул энэ хүнд хууль зүйн дагуу зохих хариуцлагыг тооцож, бидний гомдлыг барагдуулж өгнө үү" гэжээ.
3. Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд: "...үйлчлүүлэгч Л.Г ...өмгөөлөгч Монгол Улсын хуульд заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа явуулж үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаална..." гэрээ хийсний дараа өмгөөллийн хөлсний 50 хувь төлөх ба үлдэх 50 хувийг шүүх хуралдаанд орохын өмнө төлж дуусгасан байна" гэжээ.
4. аймгийн цагдаагийн газрын дахь цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч З.М-с ирүүлсэн албан тоотод: "...Эрүүгийн тоот хэрэгт яллагдагчаар шалгагдаж байгаа Л.Г-н өмгөөлөгч Д.Ч-н гаргасан гомдол хүсэлтүүд болон байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон тэмдэглэлүүд байхгүй болохыг мэдэгдье" гэжээ.
5. Хариуцагч Д.Ч тайлбартаа "...эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг 2011 оны хийсэн ба өөрсдийнх нь хүсэлтээр гэрээг хийсэн Г-г цагдан хориотой батлан даалтад гаргаж хэрэг дээр 7-8 зүйл шалгуулахаар тэр үед ажиллаж байсан Мөрдөн байцаагчид бичгээр гаргасан боловч энэ хүсэлтийг тэр үед ажиллаж байсан мөрдөн байцаагч хэрэгт хавсаргаагүй сая мэдсэн. Хэргийг сэргээж шалгаж өг гэж өмгөөлөгчийн зүгээс шахаагүй Г над руу нэг ч удаа яриагүй. Гэтэл 2015 оны 12 дугаар сарын хорин хэднээр эгч нь гэнэт ярьсан. Бид хотоос өмгөөлөгч авсан төлсөн хөлсөө авна гэсэн. Тэр үед миний хувьд оны сүүлээр 2 ч удаа эмнэлэгт хэвтэж эрүүл мэндийн байдлаас болж ажил хийж чадаагүй. Миний хувьд төлсөн төлбөрийг өгөхгүй гээгүй. Эрүүл мэндийн байдлаас болоод ажил хийж чадахгүй байгаа. үлдсэн төлбөрийг боломжоороо төлнө. Энэ асуудал дээр хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс "Хариуцагч Д.Ч нь иргэн Л.Г-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөнд 1 000.000 төгрөг авсан атлаа эрх зүйн туслалцаа

үзүүлэх үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах санал гаргасан ба хариуцагч Д.Ч "...энэ асуудал дээр хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү" гэж тайлбарлаж байна.

Хариуцагч Д.Ч нь иргэн Л.Г хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөнд 1.000.000 төгрөг авсан атлаа эрх зүйн туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй болох нь Л.Г, Л.Ч нарын гомдол, Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ хариуцагч Д.Ч-н гаргасан тайлбар, Хэнтий аймгийн цагдаагийн газрын Бор-Өндөр дахь цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч З.М-с ирүүлсэн албан тоот зэрэг маргааны материалд авагдсан баримтуудаар тус тус нотлогдож байна.

Хариуцагч Д.Ч-н үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д "хуульчийн үнэнч шударга итгэл даах байдал, 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх хэсэгт "...бүрэн, тууштай хамгаалах", Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт гэрээгээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд өөрөө санаачлан үйлчлүүлэгчийнхээ эрх ашиг сонирхолд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж болно", 2.3 дугаар зүйлийн 1.3-д "үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх", 1.4 дэх хэсэгт үйлчлүүлэгчийн мэдээлэл хүссэн үндэслэл бүхий хүсэлтийг шуурхай хангах" гэж заасныг тус тус зөрчсөн үйлдэл мөн гэж дүгнэв.

Энэ зөрчил нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

Д.Ч нь Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргарзны зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн байх тул сахилгын шинжээчийн "хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай" саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорсоны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1 Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйл н 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорос I маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Д.Ч-д "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.

2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Хуульч М.Н-т холбогдох гомдлын тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх гуравдугаар бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Ц.Давхарбаяр даргалж, гишүүн Д.Байгалмаа Б.Ундрах, Ц.Оч, Б.Бат-Орших нарын бүрэлдэхүүнтэйгээр Хуульчдын холбооны хурлын танхимд явуулж, иргэн Б.Н-н гомдлыг шалгасан Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 44 дугаартай саналыг хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Б.Н-с “Өмгөөлөгч М.Н-тай 2015 оны 3 сарын 13-нд гэртээ уулзаад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150-р зүйлийн 150.3-т заасан хэрэгт холбогдсон миний охин Б.С-н хэргийг өмгөөлж өгөөч гээд 100.000 төгрөг эхний удаа өгсөн. Хэд хоногийн дараа Б.Н утасдаж, ..прокурортой уулзана, ...одоо урьдчилгаа нэг сая төгрөг өг гэхээр нь гудамжинд бэлнээр тоолж өгсөн, ямар нэг баримт үйлдээгүй. Тэр өдөртөө ярина гээд алга болсон, утас нь холбогдохгүй байдаг, Эрдэнэт хотод байна, завгүй байна, эмнэлэгт хэвтсэн гэх зэргээр өдий хүртэл холбоо бариагүй. Хэрэгтэй ч танилцаагүй, мөрдөн байцаагчтай ч уулзаагүй, өмгөөлөгчөөр ажиллаагүй тул өгсөн нэг сая нэг зуун мянган төгрөгийг гаргуулан өгч хохиролгүй болгож өгнө үү гэсэн гомдол Монголын Хуульчийн Холбооны гишүүн, шүүхэд төлөөлөх эрхийн...тоот үнэмлэхтэй хуульч, өмгөөлөгч М.Н-д холбогдуулан, 2016 оны 4 сарын 12-ны өдөр Монголын Хуульчийн Холбоонд гаргажээ.

Хариуцагч М.Н Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбартаа: “... тухайн үед ээжийгээ сахиад завгүй байсны улмаас үйлчилгээ үзүүлж чадаагүй, хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож чадаагүй. Хохирлыг төлж барагдуулсан, тухайн үед утсаа алдсан байсан тул холбогдож чадаагүй, хаалттай сануулах арга хэмжээ авахад татгалзах зүйлгүй” гэжээ.

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч гомдлыг шалгаад 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 44 дугаартай санал гарган “хуульч, өмгөөлөгч М.Н Б.С-д холбогдох эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцохоор харилцан тохиролцон Б.С-н ээж Б.Н-ээс 1 100 000 төгрөг авсан боловч хууль зүйн туслалцаа үзүүлээгүй байгаа нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12, 1.7 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул түүний үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзэж Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмыг үндэслэн хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргажээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хуульч М.Н нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150-р зүйлийн 150.3-т заасан хэрэгт холбогдон шалгагдаж байсан иргэн Б.С-д эрх зүйн туслалцаа үзүүлэхээр Б.С-н ээж Б.Н-тэй харилцан тохирч, 1 100 000 төгрөгийг 2015 оны 3 сарын 13-нд авсан байна.

Гэвч төлбөрийг авсаны дараа эрүүгийн хэрэгтэй танилцаагүй, байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй болох нь гомдол гаргагчийн тайлбар /г.м 3-4 х/, мөн хуульч, өмгөөлөгч М.Н-н тайлбараар /г.м 10 х/ нотлогдож байна.

Хуульчийн холбоонд гаргасан гомдолд, Мэргэжлийн хариуцлагын хороо 2016 оны 4 дүгээр сарын 19-нд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64-р зүйлийн 64.1, 64.2 Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 8.8-р зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн маргаан үүсгэж шалгах ажиллагааг явуулжээ.

Гомдол гаргагч "...эрх зүйн туслалцаа авахын тулд өгсөн төлбөрөө буцаан авч, хохирол барагдуулах" үүднээс гомдол гаргасан байх ба Мэргэжлийн хариуцлагын хорооноос шалгах ажиллагааг явуулахаас өмнө хуульчөмгөөлөгч М.Н 2016 оны 4 сарын 16-ны өдөр гомдол гаргагч Б.Н-д ХААН банкны дансаар нь дамжуулан 1 000 000 төгрөгийг төлсөн нь баримтаар /г.м 4-6 х/ тогтоогдож байна.

Төлбөрийг буцаан төлсөн байх боловч харилцан тохиролцсоны дагуу хууль зүйн үйлчилгээ огт үзүүлээг/й, хувийн байдлын улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй байгаа талаар мэдэгдээгүй зэрэг нь хуульч, өмгөөлөгч М.Н нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12 "мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх", 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "хуульч үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс хууль болон гэрээгээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд өөрөө санаачлан үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцэх мэргэжлийн үйл ажилагаа явуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 44 дугаартай саналыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4, 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн 1, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар хариуцагч М.Н-т "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай..
2. Энэ тогтоолыг гомдол гаргагч, хариуцагч нарт хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Ц.Э-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Э.Ариунаа даргалж, гишүүн Б.Ундрах, Д.Даваасүрэн, Т.Баярсайхан, Ж.Энхчулуун нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс ирүүлсэн, өмгөөлөгч Ц. Э-д холбогдох, 2016 оны 06 дугаар сарын 03 өдрийн 004 дугаартай дүгнэлтийг хянан хэлэлцэв.

Хуралдаанд сахилгын шинжээч Г.Должинсүрэн, хариуцагч Ц.Э, хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан нар оролцов.

Иргэн И.А нь тус хороонд гаргасан гомдолдоо:

"... Миний нөхөр болох Э.Б-д холбогдох хэргийг өмгөөлүүлэхээр Ц.Э-д өмгөөлөгчтэй гэрээ хийж урьдчилгаа 1 сая төгрөг өгсөн, 2015 оны 6 сарын 30 өдөр болсон Нийслэлийн давж заалдах шатны шүүх хуралд Ц.Э өмгөөлөгч бараг дүр үзүүлж оролцсон, хурал завсарлаад шийдвэр танилцуулах үед орж ирээгүй нь хариуцлагагүй үйлдэл гаргаж бидэнд үл хүндэлж байгаа юм.

... 2015 оны 12 сарын 4 өдөр дээд шатны хурал болоход Ц.Э өмгөөлөгч согтуу ирж оролцох гэж оролдсон ч үүдний хамгаалагч нар оруулаагүй,... Ц.Э нь хэрвээ эрүүл байсан бол шүүх хуралд оролцож суусан бол ядаж жилийг нь багасгаж 551.1 гэсэн зүйлээр жил багасах боломж байсан.

... удаа дараа хариуцлагагүй үйлдэл гаргаж, үйлчлүүлэгч биднийг үл хүндэтгэж, бидний зовлонгоор тоглож байгааг үндэслэн Ц.Э өмгөөлөгчийн эрхийг нь цуцлаж өгнө үү..." /хх 3-5 дугаар хуудас/ гэжээ.

Хариуцагч Ц.Э тус хороонд өгсөн тайлбартаа:

"Ц.Э миний бие иргэн Э.Б-тай хууль зүйн туслалцаа үзүүлэхээр ар гэрийхэн болон өөртэй нь харилцан тохиролцон "Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай" гэрээ байгуулж үйлчлүүлэгч Э.Б-ны эрх ашгийг хамгаалсан, гэрээнд болон холбогдох хуулиудад заасан журмын дагуу шүүхийн шатанд эрх зүйн туслалцаа үзүүлсэн. Гэтэл үйлчлүүлэгчээс гомдол гаргахдаа намайг залилан мэхэлсэн мөн эрх зүйн туслалцааг хангалттай үзүүлээгүй гэж баримтжуулаагүй, нотолгоогүй зүйл ярьж намайг гүтгэн миний нэр хүндийг гутааж байгаад маш их гомдолтой байна.

... Хяналтын шатны шүүхэд би 2 удаа гомдол гаргасан, Э.Б нь өршөөлийн хуульд хамрагдан ялаас нь 2 жил хасагдсан. Өршөөлөөр орсон ялтанд давхар ЭХ-ийн Ерөнхий ангийн 551 -р зүйл үйлчлэхгүй болсон тул миний гомдлыг хүлээж аваагүй.

“Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай” гэрээний 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгчийн зүгээс Э.Б болон И.А-д эрх зүйн туслалцаа үзүүлж байгаа ажлын эцсийн үр дүнгийн талаар ямар нэг амлалт өгөөгүй бөгөөд түүнд холбогдох хэргийг шийдвэрлэх ажиллагаанд бусад гэрээ байгуулсан цагаас хуульд заасан эрүүгийн Байцаан Шийтгэх Хуулинд заасны дагуу ямар байдлаар оролцох ёстой байдаг журмын дагуу л оролцон, хангалттай эрх зүйн туслалцаа үзүүлсэн” /хх 20 дугаар хуудас/ гэжээ.

Мэргэжлийн Хариуцлагын Хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ:

Ц.Э дээрх үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийн зөрчих... хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх... хориглоно”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 “мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 1.4 дүгээр зүйлийн 2 “Хуульч нь бусад хуульч, аливаа этгээд, олон нийттэй мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцана. Хуульч ажил үүргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэн”, 1.7 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт заасан “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шийдвэрлүүлэхээр шилжүүлсүгэй /хх 73-77 дугаар хуудас/” гэжээ.

Хариуцагч Ц.Э хуралдаан дээр гаргасан тайлбартаа:

“... Шүүх хуралдааны тухай ярихад 13 цаг 30 минутад орох байсан, хоолонд орчихоод би 13 цаг 40 минут гээд жаахан хоцроод очсон. Гэтэл тахарын албаны жижүүр оруулахгүй гээд маргалдаад орох гэсэн чинь оруулаагүй, намайг согтуу байна гээд оруулаагүй. Би согтуу байгаагүй, ... ганц шил пиво уух нь уусан л даа...” гэв.

Хуралдаанаар 16/008 дугаартай маргааны материалд авагдсан бичгийн нотлох баримтуудыг шинжлэн судалсан болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Өмгөөлөгч Ц.Э нь эрүүгийн хэргийн холбогдогч Э.Б-н өмгөөлөгчөөр ажиллаж байхдаа 2015 оны 12 сарын 15 өдөр Улсын Дээд Шүүхийн эрүүгийн тэнхимийн хяналтын шатны шүүх хуралдаанд согтууруулах ундааны зүйл /пиво/ хэрэглэсэн байдалтай очсоноос түүнийг шүүх хуралдаанд оролцуулаагүй, түүний энэ үйлдлийн улмаас хяналтын шатны шүүх хуралд үйлчлүүлэгч Э.Б-н өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх нь зөрчигдсэн болох нь хуралдаан дээр хариуцагчийн гаргасан тайлбар болон гэрчүүдийн мэдүүлэг, бусад нотлох баримтаар тогтоогдож байна.

Ц.Э Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох “Хуульчийн мэргэжлийн дүрмийн зөрчих ...” /27.1.1/, “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх” /27.1.2/ үйлдэл хийсэн,

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 “мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 1.4 дүгээр зүйлийн 2 “Хуульч нь бусад хуульч, аливаа этгээд, олон нийттэй мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцана. Хуульч ажил үүргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэн”, 1.7 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт заасан “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана” гэснийг тус тус зөрчсөн гэж үзсэн сахилгын шинжээчийн Мэргэжлийн дүгнэлт үндэслэлтэй байна. Иймд өмгөөлөгч Ц.Э-д харицлага хүлээлгэх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэлээ.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан Ц.Э-д “Нээлттэй сануулах шийтгэл” ногдуулсугай
2. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд Хороогоор дамжуулан гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Хуульч Ж.Б-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Т.Өсөхбаяр даргалж, гишүүн С.Амардэлгэр, Ц.Өрнөндэлгэр, Е.Сагсай, Х.Цогтсайхан нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанд:

Шинжээч Б.Эрдэнэсүрэн, нарийн бичгийн дарга А.Хулан нарыг оролцуулан,

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 005 тоот мэргэжлийн дүгнэлт үйлдсэн, хуульч Ж.Б-д холбогдох материалыг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн С.Д Мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн гомдолдоо: "...Өмгөөлөгч Ж.Б-р өөрийн хүүхэд Д.С-г өмгөөлүүлэхээр тохиролцон 2016 оны 3 дугаар сарын 29-ний өглөө гэрээ хийсэн болно. Гэрээ хийхдээ 1.000.000 төгрөгөөр тохирч, эхний удаа 250.000 төгрөг өгсөн ба дараа нь дахин нэмж 500.000 төгрөг өгч, гэрээний хуудас дээр бичүүлж гарын үсгээ зурж баталгаажуулсан болно. ...Ж.Б өмгөөлөгч бидний итгэлийг алдаж, хүүхэдтэй бидний унаагаар 2 удаа очиж уулзсан боловч байцаагчтай нь нэг ч удаа уулзаагүй, уулзаж өгөөч гэж дахин дахин шаардуулаад шаардлага хүлээж аваагүй бөгөөд бүр утсаа ч авахаа болиод, сүүлдээ биднээс зугтаагаад олдохоо больсон тул бид өөртэй нь утсаар ярьж гэрээгээ цуцалсан болно. Ж.Б өмгөөлөгчөөс гэрээгээ цуцласан тул өмгөөлөгчийн хөлс болох 600.000 төгрөгийг эргүүлэн авахаар хойноос нь хөөцөлдөөд олохоо болилоо. Бидний утсыг авдаггүй, хааяа нэг өөр хүний утсаар холбогдоход худлаа яриад биднээс зугтаад байгаа тул энэ хүнийг олж өгч, хохирлыг гаргуулж өгнө үү" гэжээ.

Хариуцагч Ж.Б гаргасан тайлбартаа: "...Ц.Д 4 дүгээр сарын эхээр манай гэрийн гадаа ирээд 250.000 төгрөг өгсөн. Тухайн үед гэрээ хийгээгүй. Энэ 250.000 төгрөгийн 150.000 төгрөгийг нь аваад 100.000 төгрөгийг нь Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн бичиг хүргэгч зарлага П.Б-т өгсөн. Дээрх мөнгийг хэрэг олж өгсөн гэсэн утгаар /П.Б өөрөө өгчих гэж гуйсан учраас/ өгсөн. ... А.Л-с Цамбагаравын ойролцоо 500.000 төгрөг бэлнээр тоолж авсан. А.Л дээрх 500.000 төгрөгийг өгөхдөө миний нөхөр Ө.У-г өмгөөлж өгөөрэй гэж хэлээд 500.000 төгрөг өгсөн. Гэрээг сүүлд нь бас хийсэн. Гэрээнд 1 сая төгрөгөөр Ө.У-г өмгөөлнө гэж тохиролцоод урьдчилгаа 500.000 төгрөгийг нь авсан. ...Манай нөхрийг өмгөөлж өгөөрэй гэж л дээрх мөнгийг өгсөн. ... Байцаагчтай утсаар ярьсан боловч гадуур ажилтай гээд уулзаж чадаагүй. Дараа нь Цагдан хорих төв дээр очиж, ... Д.С, Ө.У нартай уулзсан. Өөр ямар нэг ажиллагаанд оролцоогүй. ..." гэжээ.

Гэрч А.Л тайлбартаа: "...Ж.Б өмгөөлөгч Д.С очиж уулзахдаа манай нөхөр Ө.У уулзсан байсан. ...Ж.Б өмгөөлөгч "би одоо завтай байна, нэг дэх өдөр очиж Ө.У уулзахдаа гэрээгээ үзүүлнэ" гээд байсан. Тэгэхээр нь би байгаа газар нь буюу Цамбагаравын тэнд байдаг үсчин дотор очиж уулзаад гэрээ байгуулж, бэлнээр 500.000 төгрөг өгсөн. Гэрээг нэг хувь хийсэн, ... надад бол гэрээ өгөөгүй. Ж.Б өмгөөлөгч надад ярихдаа "одоо би байцаагчтай нь очиж уулзана, батлан даалтад гаргах талаар хөөцөлдөнө" гэж ярьж байсан. Гэрээ хийснээсээ хойш манай нөхөртэй нэг ч очиж уулзаагүй, байцаагчтай ч уулзаагүй. Ж.Б өмгөөлөгч рүү залгаагаар утсаа авахгүй, нэг бол согтуу, нэг бол хөдөө явж байна гэж ярьдаг байсан. ... Ж.Б өмгөөлөгчид 500.000 төгрөг өгөөд нөхрөө өмгөөлж өгөөрэй гэсэн чинь ямар ч ажил хийхгүй, утсаа авахгүй байхаар нь аргаа бараад өөр өмгөөлөгч авахаар болсон. Тэгээд манай хадам ээж Ө Ж.Б өмгөөлөгч рүү залгаад "бид нар өөр өмгөөлөгч авахаар боллоо, танд өгсөн 500.000 төгрөгийг Д.С-н өмгөөллийн хөлс рүү шилжүүлэе, болох уу" гэсэн чинь "болно" гэж хэлсэн байсан.... Надад болон манай нөхөр Ө.У-д хууль зүйн туслалцаа үзүүлээгүй. ..." гэжээ.

Гэрч Д.С тайлбартаа: "... ямар ч байсан 2 удаа ирж уулзсан. Эхний уулзалтад би чиний өмгөөлөгч байна, одоохондоо хэргийн материалтай танилцаж, байцаагчтай уулзаагүй байна, ... гэж байсан. Мөн "санал гомдол юу байна, гэрийнхэндээ юу гэж хэлүүлэх үү, байцаалт өгөх болвол энэ дугаарыг өгөөрэй" гээд надад утасныхаа дугаарыг бичиж өгсөн. Дараагийн уулзалтад "таныг солих гэж байгаа гэсэн" гэсэн чинь "тийм юм яриагүй шүү дээ, яагаад тэгсэн юм бол" гэж байсан. Надтай тийм тодорхой дэлгэрэнгүй юм яриагүй дээ..." гэжээ.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн дугаар хэлтсийн мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Г тайлбартаа: "...эрүүгийн тоот хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах хугацаанд С-г 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр сэжигтнээр тооцон байцаалт авах үед болон 2016 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр яллагдагчаар татан байцаалт авах үед өмгөөлөгч байлцуулахгүй гэх талаар дурдаж байцаалт өгсөн байна. Өмгөөлөгч Ж.Б-ны зүгээс мөрдөн байцаалтын ажиллагааны явцад ямар нэгэн хүсэлт бичгээр гаргаагүй" гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ: "...Ж.Б нь иргэн Д.С, Ө.У нарт хууль зүйн туслалцаа үзүүлнэ гэж иргэн Ц.Д, А.Л нартай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, нийт 750.000 төгрөг бэлнээр авсан боловч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй. Мөн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй иргэн П.Б ашиг хувааж буюу хэрэг олж өгсний хөлсөнд 100.000 төгрөг өгсөн зэрэг үйлдлүүд нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.2-т "Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх", 36 дугаар зүйлийн 36.9-д "Өмгөөлөгч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээдтэй хамтарч ашиг хуваах байдлаар өмгөөллийн үйлчилгээ явуулж болохгүй", 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн 38.1.1-д "Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга хэрэгслийг ашиглан бүрэн тууштай хамгаалах", Хуульчийн

мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д “Үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх”, 1.4-д “Үйлчлүүлэгчийн мэдээлэл хүссэн үндэслэл бүхий хүсэлтийг шуурхай хангах” гэж заасныг тус тус зөрчсөн” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн С.Д нь өмгөөлөгч Ж.Б-д хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу өгсөн 750.000 төгрөгийг буцааж авах гомдол гаргасан бөгөөд үндэслэлээ “... хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй, мөнгө авснаас хойш уулзаагүй ...” гэжээ.

Хуульч Ж.Б нь гомдолд тайлбар өгөхдөө “... мөнгө авсныхаа дараа эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан. ... Байцаагчтай утсаар ярьсан боловч гадуур ажилтай гээд уулзаж чадаагүй. Дараа нь Цагдан хорих төв дээр очиж, ... Д.С, Ө.У нартай уулзсан. Өөр ямар нэг ажиллагаанд оролцоогүй. ...” гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.2-д “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”, 36 дугаар зүйлийн 36.9-д “Өмгөөлөгч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээдтэй хамтарч ашиг хуваах байдлаар өмгөөллийн үйлчилгээ явуулж болохгүй”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн 38.1.1-д “Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга хэрэгслийг ашиглан бүрэн тууштай хамгаалах”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д “Үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх”, 1.4-д “Үйлчлүүлэгчийн мэдээлэл хүссэн үндэслэл бүхий хүсэлтийг шуурхай хангах” гэж заасныг тус тус зөрчсөн” гэж үзсэн байна.

Өмгөөлөгч Ж.Б нь иргэн Ц.Д 2016 оны 03 дугаар сарын 29- ний өдөр “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж, Д.С-н эрх ашгийг хамгаалах, эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар тохирч, өмгөөллийн хөлс болгож 750.000 төгрөгийг авсан нь тогтоогдсон бөгөөд Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилын шинжээч маргаан үүсгэсний дараа өмгөөлөгч Ж.Б нь Ц.Д-д 750.000 төгрөгийг буцаан өгчээ.

Ж.Б нь Д.С-н эрх ашгийг хамгаалах, түүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар С.Д-тэй гэрээ байгуулж, 750.000 төгрөг авсан боловч гэрээний 3.1-т заасан үүргээ биелүүлээгүй буюу мөрдөн байцаалтын үед үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах ажиллагаа явуулаагүй болох нь нотлогдсон тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн дүгнэлтийг үндэслэлтэй байна гэж үзлээ.

Хуульч Ж.Б нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.2, 36 дугаар зүйлийн 36.9, 38 дугаар зүйлийн 38.1, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.4 дэх хэсгийг тус тус зөрчсөн байх тул түүнд нээлттэй сануулах арга хэмжээ авах хууль зүйн үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт, Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Ж.Б-д “Нээлттэй сануулах шийтгэл” ногдуулсугай
2. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Хуульч Б.Л-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх дөрөвдүгээр бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Ц.Давхарбаяр даргалж, гишүүн Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, Д.Оюунбат, Г.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр Хуульчдын холбооны хурлын танхимд зөвлөлдөж, иргэн Д.Б, Т.Б, П.Н, П.Ц, П.Ц нарын гомдлыг шалгасан Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 9 дүгээр сарын 8-ний өдрийн 076 дугаартай саналыг хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Д.Б, Т.Б нараас “Иргэн Д.Б-н нэхэмжлэлтэй УБСЕГ-т холбогдуулан гаргасан маргаанд Б.Л өмгөөлөгчийн гэрээ байгуулан, төлбөрийг шилжүүлэн авсан боловч ...чирэгдүүлж, цаг алдуулж, хавтаст хэрэгтэй танилцалгүй биднийг хохироож, ёс зүйгүй ажилласан...хуралд оролцолгүй, хурлыг хуралдуулж, илт хууль бусаар шүүхийн шийдвэрийг нөгөө талд гаргуулж хохироосон, хуулийн дагуу арга хэмжээ авч, миний өгсөн 300 000 төгрөгийг буцаан гаргуулан өгнө үү... гэсэн гомдлыг 2016 оны 6 сарын 2-нд Хуульчдын холбоонд гаргажээ.

Мөн 2016 оны 6 сарын 27-нд, “өндөр настан Н, түүний дүү Ц, Цо нарын эзэмшил газрыг Б, Ба, Г нараас чөлөөлүүлэхээр өмгөөлөгч Л-тэй өмгөөллийн гэрээ хийж, 300 000 төгрөг төлсөн боловч ...9 сарын дараа шүүхэд материал өгсөн, дутуу материал цуглуулж, хууль бус бусармаг үйлдэл хийн, хууран мэхлэн 1 000 200 төгрөгийг паспорт барьцаалан авч, олон сараар хохироосон...улмаар иргэн Н-ийн газар дээр Г, Ба нар нь буугаагүй...нь шүүхээр тогтоогдож, хэргээ татан авлаа. Энэ нь өмгөөлөгч Л-ийн буруутай үйлдэл...асуудлыг өөр шүүгчид өгч дахин мөнгө авах гэсэн.. цаг хугацаа алдуулж хохироосон...хууль бус үйлдлийг шалган, өмгөөлөх эрхийг хасуулах арга хэмжээ авч өгөх, 700 200 төгрөг гаргуулж өгнө үү” гэсэн гомдлыг шүүхэд төлөөлөх эрхийн тоот үнэмлэхтэй хуульч, өмгөөлөгч Б.Л-д холбогдуулан, П.Н, П.Ц, П.Ц нар Монголын Хуульчдын Холбоонд гаргажээ.

Хариуцагч Б.Л Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбартаа: “...Б-тай гэрээ байгуулан төлбөр авсан...шүүхэд байгаа хэргийн материалтэй танилцсан, зарим материалыг хуулбарлан шүүх хуралд орох бэлтгэлээ бүрэн хангасан... шүүх хуралд оролцохоор 3 удаа захиргааны хэргийн анхан шатны шүүхэд очсон боловч хойшилж байсан...сүүлд 5 сарын 30-д болох хуралдаанд БГД- ийн цагдаагийн-р хэлтэс дээр ...насанд хүрээгүй хохирогч Ху-ийн байцаалтанд суугаад явсан боловч маш их түгжрэлтэй, машин явж болохгүй 17 цагийн үед шүүх дээр ирсэн боловч хурал эхлээд удсан учир шүүх хуралд оролцож чадаагүй. Зориуд санаатай хурал тасалсан, илт хууль бусаар нөгөө талд Г гаргуулахаар шүүхэд нөлөөлсөн зүйл

байхгүй, ...цагийг зөв тооцож чадалгүй, ажлаа зөв зохицуулж чадаагүйгээс хуралд орж чадалгүй, туслалцаа бүрэн үзүүлж чадаагүй минь үнэн учир авсан мөнгөө буцааж өгөхөд татгалзах зүйлгүй.. орой гэрийн утас руу залгаад “шүүх миний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгочихлоо, чи ирсэнгүй” гэхээр нь “давж заалдах гомдлыг нь бичээд өгье, хуралд ороод өгье” гэсэн чинь утсаа тасалсан... гэжээ.

Н-н гомдлын талаар гэвэл би хийх ёстой ажлаа хийсэн ба жаахан удаашралтай байсан болохоос биш зохих үйлчилгээ үзүүлсэн. Гурван иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлсэн...Үйлчилгээний хөлс гэж 700 000 төгрөг...тэмдэгтийн хураамж гэж 210 000 төгрөг авсан, тэмдэгтийн хураамжинд 140 000 төгрөг төлсөн, Н-тэй гэрээгээ дүгнээд 280 000 төгрөгийг суутган, буцаагаад 500 000 төгрөг өгсөн...Шадивлангийн тэнд байдаг газрын маргаантай асуудал байсан...ирж очих зардлыг өөрөөсөө гаргаж байсан...намайг их хөөцөлдөж байсныг хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан нь мэдэж байгаа...Н нь өөрөө гомдол саналгүй гэдэг...ах дүү гурвын газрын маргаантай асуудал байсан.. тус тусдаа гэрчилгээтэй, газар чөлөөлүүлэх айлууд нь тус тусдаа.. тэгээд л тус тусад нь нэхэмжлэл гарган, тэмдэгтийн хураамж төлсөн... үндэслэлгүйгээр 700 200 төгрөг нэхсэн, энэ нэхээд байгаа мөнгийг нь би иргэний шүүхээр шийдвэрлүүлнэ...хийх ажиллагааны 50 хувийг гүйцэтгэсэн, үлдэгдэл ажиллагаа шүүхийн шатанд хийгдэх ажиллагаа байсан боловч хөлсний дөрөвний нэг хувийн суутгасан, хуульчийн ёс зүйг санаатай зөрчсөн ноцтой зөрчил гаргаагүй, гомдлыг хэрэгсэхгүй болгон, хохирлын асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр буцааж өгнө үү” гэжээ.

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч гомдлыг шалгаад 2016 оны 9 дүгээр сарын 8-ний өдрийн 076 дугаартай санал гарган “хариуцагч Б.Л Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27-р зүйлийн 27.1.2, 38-р зүйлийн 38.1.1, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1.2, 2.3-р зүйлийн 2.3.1.3 болон 2.3.1.4 дэх заалтыг зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлсөн байх тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмыг үндэслэн хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргажээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хуульч Б.Л нь иргэн Д.Б-тай захиргааны хэрэгт өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг 2016 оны 4 сарын 11-нд байгуулан, 300 000 төгрөгийн урьдчилгаа төлбөр авсан байна /г.м 13х, 16х/.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн материалтай танилцах, хүсэлт гаргах зэргээр ажиллагаанд оролцож байсан бөгөөд харин 2016 оны 5 сарын 30-ны өдрийн хуралдаанд оролцоогүй болох нь гомдол гаргагчийн тайлбар /г.м 14х/, мөн хуульч-өмгөөлөгч Б.Л-н тайлбар /г.м 10 х/, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэл /г.м 18-28х/, өмгөөлөгчөөс шүүхэд гаргаж байсан хүсэлт /г.м 32-40х/ зэргээр нотлогдож байна.

Хуульчдын холбоонд тухайн иргэний гаргасан гомдолд, Мэргэжлийн хариуцлагын хороо 2016 оны 06 дугаар сарын 21-нд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64-р зүйлийн 64.1, 64.2 Монголын Хуульчийн Холбооны Мэргэжлийн

хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 8.8-р зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн маргаан үүсгэж шалгах ажиллагааг явуулжээ.

Гомдол гаргагч "...хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч, өгсөн 300 000 төгрөгийг буцаан гаргуулан авах" үүднээс гомдол гаргасан байх ба Мэргэжлийн хариуцлагын хорооноос шалгах ажиллагааны явцад, хуульч-өмгөөлөгч Б.Л 2016 оны 7 сарын 22-ны өдөр 300 000 төгрөгийг Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагч Б-д хүлээлгэн өгсөн нь баримтаар /г.м 54 х/ тогтоогдож байна.

Хуульч Б.Л нь мөн иргэн П.Н, П.Ц, П.Ц нартай өмгөөллийн гэрээ байгуулан, 920 000 төгрөг авсан, мөн уг гэрээний төлбөрийн тооцоог хийсэн болох нь өмгөөлөгч Б.Л-н тайлбараар /г.м 60х, 62х/ тогтоогдож байна. Гомдол гаргагчийн өмгөөлөгчтэй байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ гомдлын материалд авагдаагүй байна.

Хуульчийн холбоонд тухайн иргэний "...700 200 төгрөгийг гаргуулан, асуудлыг шийдвэрлэж, өмгөөлөх эрхийг хамгаалуулах арга хэмжээ авч өгөх" тухай гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороо 2016 оны 07 дугаар сарын 8-нд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64-р зүйлийн 64.1, 64.2 Монголын Хуульчийн Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 8.8-р зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн маргаан үүсгэн, 2016 оны 7 сарын 8-ны өдрийн 7 тоот тогтоолоор Д.Б нарын гомдлын материалтай нэгтгэсэн байна.

Төлбөрийг буцаан төлсөн байх боловч гэрээний дагуу хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй хуульч-өмгөөлөгч Б.Л-н уйлдэл нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12 "мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх", 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "хуульч үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс хууль болон гэрээгээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд өөрөө санаачлан үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцэх мэргэжлийн үйл ажиллагаа явуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 076 дугаартай саналыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4, 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Б.Л-д "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Хуульч С.Т-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Ч.Хосбаяр илтгэснээр гишүүн Г.Алтанчимэг, Г.Ганзориг, Ц.Давхарбаяр, Д.Оюунбат нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч С.Т-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

“Хариуцагч С.Т нь 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 10 цагт зарлагдсан байсан А.Б нарт холбогдох эрүүгийн анхан шатны шүүх хуралд шүүгдэгч С.Э, Ө.Б нарын өмгөөлөгчөөр оролцох байсан боловч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй байна. Хариуцагч С.Т нь дээрх үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Мэргэжлийн дүрмийг зөрчих ... хориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1-т “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалтай ажиллана”, 4.2 дугаар зүйлийн 2-т “Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, өөртөө эсхүл үйлчлүүлэгчдээ санхүүгийн ашигтай байдал бий болгох, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул түүний үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-т заасныг удирдлага болгон хариуцагч С.Т-д сахилгын хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна” гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв.

Үүнд:

Гомдол гаргагч М.А тус хороонд гаргасан гомдолдоо:

“...Тус шүүхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсэгт зааснаар А.Б, А.Ц, 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар Ц.Г, Ө.Б, С.Э, П.Б, П.А нарт тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн дугаартай хэрэг хянагдаж байна. Шүүгдэгч С.Э, Ө.Б нарын өмгөөлөгч С.Т-д 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 10.00 цагаас зарлагдсан шүүх хуралдааны товыг мэдэгдсэн байтал тус

өдрийн шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, уг өмгөөлөгчийн дугаарын утас холбогдох боломжгүй байгаа нь шүүхийг үл хүндэтгэж, шүүн таслах ажиллагаанд зориуд саад учруулсан байна. Иймд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэн хариуг ирүүлнэ үү...". /ММ-н 4-р хуудас/,

Хариуцагч С.Т тус хороонд ирүүлсэн тайлбар болон хүсэлтдээ: "Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс гаргасан гомдолтой танилцлаа. Тус шүүхэд 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хэлэлцэх байсан Ө.Б нарт холбогдох хэрэгт шүүгдэгч Ө.Б-н өмгөөлөгчөөр оролцох байсан боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд очиж амжаагүй болно. Учир нь миний хадам ээж н.Х-н биеийн байдал муу байгаагийн улмаас Сэлэнгэ аймгийн Мандал суманд очиж урд шөнө нь Улаанбаатар хот руу буцсан боловч ирж амжилгүй машинд эвдрэл гарсан учраас хоцорсон болно. Миний бие тус шүүх хуралдаанд очиж амжаагүй боловч дараагийн зарлагдсан хуралд шүүгдэгчийн өмгөөлөгчөөр ажиллаж оролцсон ба хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан болно. С.Т би Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр очиж чадаагүй гэм буруутай үйлдлээ хүлээн зөвшөөрч байна. Өмгөөлөгчийн ёс зүйн хувьд мэргэжлийн үүргээ ухамсарлаж цаашид ийм зөрчил гаргахгүй тул нэг удаа сануулах арга хэмжээ авч өгнө үү. Чин сэтгэлээсээ гэмшиж байгаа тул өмгөөлөгчийн зүгээс хаалттай сануулах арга хэмжээ авахад татгалзах зүйлгүй болно" гэжээ /ММ-н 12-14/,

Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дугаартай "шүүх хуралдааныг хойшлуулах тухай" шүүхийн тогтоолд:

"Шүүгдэгч Ө.Б, С.Э нарын өмгөөлөгч С.Т нь шүүх хуралдааны товыг мэдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй болно. Иймд шүүгдэгч нарыг өмгөөлүүлэх эрхээр хангаж, шүүх хуралдааныг хойшлуулах нь зүйтэй" гэжээ. /ММ-н 8-р хуудас/

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс "С.Т нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж шүүгдэгчийн өмгөөлөгчөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй гэх үндэслэлээр түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах" санал гаргасан ба хариуцагч Ш.Т "Би шүүх хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй буруугаа ойлгож гэмшиж байгаа тул хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү" гэж тайлбарлаж байна.

Өмгөөлөгч С.Т нь шүүгдэгч Ө.Б, С.Э нарт хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцож, эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцсон ба уг хэргийг 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 9 цаг 00 минутад шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай товыг 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдөр шүүхээс түүнд мэдэгдсэн боловч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь гомдол гаргагч М.А-н гомдол, хариуцагчийн гэм буруугаа хүлээсэн тайлбар, дүүргийн эрүүгийн

хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 22 дугаартай “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” шүүхийн тогтоол, хэргийн оролцогчдод шүүх хуралдааны товыг мэдэгдсэн /танилцуулсан/ тухай баримт зэргийн хуулбаруудаар тус тус нотлогдож байна.

С.Т нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, шүүхэд төлөөлөх эрхтэй болох нь Монголын хуульчдын холбооны тамгын газрын даргын 2016 оны 7 дугаар сарын 4-ний 2/551 албан бичгээр тогтоогдсон.

Хариуцагч С.Т-н үйлдэл нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалтай ажиллана”, 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, өөртөө эсхүл үйлчлүүлэгчдээ санхүүгийн ашигтай байдал бий болгох, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн үйлдэл мөн гэж дүгнэв.

Энэ зөрчил нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

С.Т нь Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшиж байх тул сахилгын шинжээчийн “хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай” саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Хариуцагч нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг 2016 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр хүлээн авсан, хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн саналыг зөвшөөрсөн буюу тухайн маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй байх тул сахилгын шинжээчийн саналыг бүрэлдэхүүн хянан үзэж хуралдаан хийхгүйгээр зөвлөлдөж шийдвэрлэх үндэслэлтэй нь Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1,2 дахь заалтуудад тодорхойлогджээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар С.Т-д "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Хуульч Б.У, Б.Э нарт холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Э.Золзаяагийн илтгэснээр гишүүн Г.Эрдэнэбат, Ж.Энхчулуун, Э.Ариунаа, Б.Баатар нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч Б.У, Б.Э нарт хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

Хариуцагч Б.У, Б.Э нар нь-ийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа эрүүгийн дугаартай П.Э, С.А нарт холбогдох эрүүгийн хэрэгт шүүгдэгч С.А, П.Э нарын өмгөөлөгчөөр оролцож байхдаа 2016 оны 6 дугаар сарын 2, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрүүдэд тус тус товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 “Мэргэжлийн дүрмийг зөрчих... хориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, өөртөө эсхүл үйлчлүүлэгчдээ санхүүгийн ашигтай байдал бий болгох, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул Б.У, Б.Э нарын үйлдлийг Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон Хариуцагч Б.У, Б.Э нарт сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв. Үүнд:

1.-ийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.Д 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 3/619 дугаарт албан бичигт: “.....,, дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 844 дүгээр шүүгчийн захирамжтай, П.Э, С.А нарт холбогдох хэргийг прокурор Р.О бичсэн 2016. оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 9 тоот эсэргүүцлээр

хянаж буй бөгөөд хэргийг хэлэлцэх давж заалдах шатны шүүх хуралдаан 2016 оны 6 дугаар сарын 2-ны өдөр, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрүүдэд тус тус товлогдож, хуралдааны зарыг өмгөөлөгч Б.У-т 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр, 2016 ны 6 дугаар сарын 6-ны өдөр тус тус мэдэгдсэн.

Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Б.У нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, 40.1.4 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд заавал оролцохоор байх бөгөөд түүнд 2016 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн шүүх хуралдааны товыг мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшилж, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдөр товлогдсон, уг өдөр өмгөөлөгч Б.У нь тус шүүхэд хүрэлцэн ирсэн боловч шүүх хуралдаан болохоос өмнө хаяж явж шүүх хуралдааны ажиллагааг дахин 2 дахь удаа хойшлуулж, П.Э, С.А нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байна.

Өмгөөлөгч Б.У нь хуульчийнхаа хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, 40.1.4 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа тохиолдолд өмгөөлөгч шүүх хуралд заавал биечлэн оролцохыг мэдэх үүрэгтэй болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 242 дугаар зүйлд “Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж бичгээр шүүхэд заавал мэдэгдэх хуулийн үүрэгтэй” гэж заажээ.

Иймд Хууль зүйн туслалцааны төвийн дүүрэг дэх салбарын улсын өмгөөлөгч Б.У шүүхийг үл хүндэтгэн, үйлчлүүлэгчдээ хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлж, шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулж бусад оролцогчдыг чирэгдүүлж, бухимдуулж буй асуудлыг нь ёс зүйн зөрчилд тооцуулахаар холбогдох баримтыг хүргүүлэв” гэжээ. /ММ-н 3-р хуудас/

2.-ийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.Д 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 3/619 дугаарт албан бичигт: “....., дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 844 дүгээр шүүгчийн захирамжтай, П.Э, С.А нарт холбогдох хэргийг прокурор Р.О-н бичсэн 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 9 тоот эсэргүүцлээр хянаж буй бөгөөд хэргийг хэлэлцэх давж заалдах шатны шүүх хуралдаан 2016 оны 6 дугаар сарын 2-ны өдөр товлогдсон боловч өмгөөлөгч Б.У хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйн улмаас шүүх хуралдаан хойшилж, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдөр товлогдож, уг шүүх хуралдаан дээр өмгөөлөгч Б.Э-д товыг мэдэгдсэн.

Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Э нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, 40.1.4 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдаанд заавал оролцохоор байх бөгөөд түүнд 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн шүүх хуралдааны товыг мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулж, П.Э, С.А нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байна. Өмгөөлөгч Б.Э нь хуульчийнхаа хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, 40.1.4 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа тохиолдолд өмгөөлөгч шүүх хуралд заавал биечлэн оролцохыг мэдэх үүрэгтэй болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 242 дугаар зүйлд “Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж бичгээр шүүхэд заавал мэдэгдэх хуулийн үүрэгтэй” гэж заажээ.

Иймд Хууль зүйн туслалцааны төвийн дүүрэг дэх салбарын улсын өмгөөлөгч Б.Э шүүхийг үл хүндэтгэн, үйлчлүүлэгчдээ хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлж, шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулж бусад оролцогчдыг чирэгдүүлж, бухимдуулж буй асуудлыг нь ёс зүйн зөрчилд тооцуулахаар холбогдох баримтыг хүргүүлэв” гэжээ. /ММ-н 4-р хуудас/

3. Хариуцагч Б.У тус хороонд ирүүлсэн тайлбартаа: “Б овогтой У би 2016 оны 6 дугаар сарын 2, 9-ний өдөр Нийслэлийн давж заалдах шатны шүүх хуралд ирээгүй тул өөрийн үйлдэлдээ гэмшиж байгаа, дахин ийм алдаа гаргахгүй тул хаалттай сануулж өгнө үү” гэжээ. /ММ-н 18-р хуудас/
4. Хариуцагч Б.Э тус хороонд ирүүлсэн тайлбартаа: “Өмгөөлөгч Б.Э миний бие Нийслэлийн давж заалдах шатны шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь үнэн болно. Миний бие зүрх судасны өвчтэй ба энэ талаар тухайн үед нотлох баримтгүй байсан болно. Мөн энэ үеүүдэд анхан шатны шүүх хуралдаан хойшилсон ба ЭБШХ-н 77-р зүйлд зааснаар торгуулийн арга хэмжээ авсан болно. Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзнэ үү. Миний бие дээрх асуудалд гэмшиж байгаа болно. Иймд хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэх тайлбар, /ММ-н 14-р Хуудас/
5.-ийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 2, 6 дугаар сарын 9-ний өдрийн 38, 41 дугаартай “Шүүх хуралдаан хойшлуулах тухай” тогтоол. /ММ-н 5-6-р хуудас/,
6. Шүүх хуралдааны тов мэдэгдсэн тухай шүүгчийн туслах М.Т 2016 оны 5 дугаар сарын 30, 6 дугаар сарын 6-ны өдрийн “Утсаар ярьсан тэмдэглэл”. /ММ-н 7-8-р хуудас/
7. 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн тайлбар, дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Р.О тайлбар бичгийн нотлох баримтуудыг хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс “Б.У нь-ийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа эрүүгийн дугаартай П.Э, С.А нарт холбогдох эрүүгийн хэрэгт шүүгдэгч С.А-н өмгөөлөгчөөр оролцож байхдаа 2016 оны 6 дугаар сарын 2, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрүүдэд тус тус товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй.

Хариуцагч Б.Э нь-ийн эрүүгийн давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа эрүүгийн дугаартай П.Э. С.А нарт холбогдох эрүүгийн хэрэгт шүүгдэгч П.Э өмгөөлөгчөөр оролцож байхдаа 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдөр товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй үндэслэлээр хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах” санал гаргасан ба хариуцагч Б.У нь “Би Эрүүгийн анхан шатны дүүрэгт 2016 оны 06 сарын 02, 09-ны өдөр-ийн давж заалдах шатны шүүх хуралдаанд ирээгүй тул өөрийн үйлдэлдээ гэмшиж

байгаа, дахин ийм алдаа гаргахгүй тул хаалттай сануулж өгнө үү” гэж тайлбарлаж байна.

Өмгөөлөгч Б.Э нь 2016 оны 6 сарын 9-ний өдрийн-ийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй байх ба шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь үнэн болно. Миний бие дээрх асуудалд гэмшиж байгаа болно. Иймд хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү гэж тайлбарласан байна.

Өмгөөлөгч Б.У нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдөр иргэн С.А хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулж С.А-д холбогдох эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцсон,-ийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн шүүх хуралдааны товыг 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн шүүх хуралдааны товыг 2016 оны 6 дугаар сарын 6-ны шүүхээс түүнд мэдэгдсэн, шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй үндэслэлээр П.Э, С.А нарт холбогдох эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг хойлшлуулж шийдвэрлэсэн байна.

Өмгөөлөгч Б.Э Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн шүүх хуралдааны товыг 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр, 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн шүүх хуралдааны товыг 2016 оны 6 дугаар сарын 6-ны шүүхээс түүнд мэдэгдсэн, шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй үндэслэлээр П.Э, С.А нарт холбогдох эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг хойлшлуулж шийдвэрлэсэн байна.

Хариуцагч Б.У, Б.Э нарын үйлдэл нь хариуцагчийн гэм буруугаа хүлээсэн тайлбар, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний хуулбар,-ийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 38 дугаартай шүүх хуралдааныг хойлшуулах тухай тогтоол , 2016 оны 6 сарын 9-ний өдрийн 41 дугаартай шүүх хуралдааныг хойлшуулах тухай Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол, 2016 оны 5 сарын 30, 2016 оны 6 сарын 6-ны өдрийн шүүгчийн туслахын утсаар ярьсан тэмдэглэл зэргийн хуулбарууд бусад бичгийн нотлох баримтуудаар тус тус нотлогдож байна.

Хариуцагч Б.У, Б.Э нарын үйлдэл нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалтай ажиллана” гэснийг тус тус зөрчсөн үйлдэл мөн гэж дүгнэв.

Энэ зөрчил нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

Б.У, Б.Э нар нь Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн байх тул сахилгын шинжээчийн “хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай” саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Хариуцагч Б.У, Б.Э нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авсан, хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн саналыг зөвшөөрсөн буюу тухайн маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй байх тул сахилгын шинжээчийн саналыг бүрэлдэхүүн хянан үзэж хуралдаан хийхгүйгээр зөвлөлдөж шийдвэрлэх үндэслэлтэй нь Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудад тодорхойлогджээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь.

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Б.У, Б.Э нарт "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Ч.Б-т холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Ж.Эрдэнэбат даргалж, гишүүн . Ариунаа, Өсөхбаяр, С.Амардэлгэр, Е.Сагсай нарын бүрэлдэхүүнтэйгээр Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгээс ирүүлсэн өмгөөлөгч Ч.Б-т холбогдох 2016 оны 02 дугаар сарын 3-ны өдрийн 002 дугаартай дүгнэлтийн дагуу сахилгын шинжээч Г.Должинсүрэн, хуралдааны нарийн бичгийн дарга А.Хулан, хариуцагч Б, гомдол гаргагч Н.Г оролцуулан иргэн Н.-Гн гаргасан “Өмгөөлөгч Ч.Б нь иргэн Н.Г нэхэмжлэлтэй Л.А холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байхдаа үйлчлүүлэгч Н.Г-д хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан” гэх гомдлыг тус холбооны хуралдааны танхимд нээлттэй хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Иргэн Н.Г тус хороонд гаргасан гомдолдоо: “Ч.Б 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Н.Г нэхэмжлэлтэй Л.А-д холбогдох иргэний хэрэгт өмгөөлөгчөөр оролцуулахаар “Иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г байгуулж, гэрээний төлбөр болгон гэрээний үнийн дүнгийн 10 хувиар тооцон 1 000 000 төгрөгийг төлсөн боловч Иргэний хэргийн анхан шатны дугаар шүүхийн 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 09:00 цагт товлогдсон шүүх хуралдаанд ирээгүй бөгөөд “би чамайг өмгөөлөхөөс татгалзаж байна” гэж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй.

Түүнчлэн иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч талаас гаргасан сөрөг нэхэмжлэлийн талаар мэдэгдээгүй, хариу тайлбар гаргаж өгдөг талаар хэлээгүй, хэлж яриагүй зүйлээ хэлсэн хэмээн гүтгэж, хэл амаар доромжилсон, хэргийн хүрээнд явуулж байгаа ажлынхаа явц, нөхцөл байдлын талаар мэдэгддэггүй, үйлчлүүлэгч намайг байнга дарамталж, дээрэлхэх зэрэг зохисгүй үйлдлүүдийг удаа дараа гаргаж, цаашид хуульчдад итгэх итгэл алдарч байна. Иймд удаа дараа ёс зүйгүй үйлдэл гаргаж, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг үл хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хуульч Ч.Б-т зохих хариуцлагыг тооцон миний төлсөн үйлчилгээний хөлсний урьдчилгаа 1 000 000 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэжээ.

Хариуцагч Ч.Б тус хороонд гаргасан тайлбартаа: “Н.Г нь шүүхийн шийдвэрийн дагуу шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргуулсан төлбөрийг үндэслэн өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүсэлт гаргасан бөгөөд урьдчилгаа 500 000 төгрөг авч ажлаа явуулахыг зөвшөөрсөн.

Шүүх хуралдаанаас өмнө 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Төв аймагт эрүүгийн хэргийн шүүх хуралдааны үеэр удаа дараа утсаар залгасан. Би түүн рүү шүүх хуралдаан завсарлахад залгахад “га миний хэргийг чадах юмуу” гэж басамжилсан байдлаар харьцсан. Маргааш нь түүнтэй уулзаж түүний удаа дараа гаргаж байгаа зохисгүй үйлдэл, басамжлал, доромжлолыг цаашид хүлээн зөвшөөрч ажиллах боломжгүй, гэрээг цуцалж цаашид ажиллахгүй гэдгээ албан ёсоор хэлж товлогдсон шүүх хуралдаанд очих боломжгүй гэдгээ хэлсэн. Түүнтэй байгуулсан гэрээг цуцалсан тул өөр өмгөөлөгч авах талаар зөвлөсөн. Гэтэл тэрээр намайг эзгүйд “Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх тухай” мэдэгдэх хуудсыг ширээн дээр орхиод явсан байсан.

Н.Г хэргийн талаар болон шүүх хуралдааны процесс, мэтгэлцэх талаар зааж зөвлөж өгдөг байсан ба тэрээр нэг хэлсэн зүйлийг маш олон удаа дахин дахин давтан асуудаг юм. Тэр бүгдэд миний зүгээс уйгагүй тайлбарлаж хэлж өгдөг байсан. Түүний нэг гол санаа нь өөрийнхөө хууль бус үйлдлийг хэрхэн өөртөө ашигтайгаар шийдвэрлүүлэх талаар надаар хэлүүлэх гэж оролддог байсан бөгөөд цүнхэн дотроо бичлэг хийж байсан нь мэдэгдсэн тул түүнтэй байгуулсан гэрээг өмнө нь цуцалсан. Гэтэл надаас уучлалт гуйж, дахиж ямар нэгэн буруу зүйл хийхгүй гэдгээ амлаж, нэмж 500 000 төгрөг урьдчилгаа болгон төлж ажлаа дахин явуулсан.

Н.Г нь надтай ханддаг шиг хуульч нартай харилцвал тэр итгэл алдах бус түүнд итгэл алдрах нөхцөл байдал бий болно. Бидний хооронд үүссэн маргаан, гэрээ цуцалсантай холбогдуулан хариуцлага тооцох асуудлыг холбогдох баримтыг шалгаж эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ. Харин урьдчилгаа төлбөр гаргуулах эсэх асуудал нь миний ажлыг үнэлж, дүгнэж шийдвэрлэдэг байгууллагын ажил болно” гэжээ.

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ: “Өмгөөлөгч Ч.Б нь иргэн Н.Г нэхэмжлэлтэй Л.А-д холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байхдаа үйлчлүүлэгч Н.Г-д хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих ... хориглоно”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.14 дүгээр зүйлийн 1 “Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуульч хэрэг маргааныг бүрэн шийдвэрлэж дуусахаас өмнө үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно” гэдгийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй” гэжээ.

Маргааны материалд авагдсан талуудын тайлбар, 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ,,, дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс Н.Г нэхэмжлэлтэй, хариуцагч Л.А-д холбогдох иргэний хэргээс хуулбарлан ирүүлсэн Н.Г-н гаргасан нэхэмжлэл, 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн сөрөг нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлага, 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн сөрөг нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлагыг өмгөөлөгч Ч.Б-т гардуулсан баримт, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны дугаар шүүхийн 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дугаар тогтоол,

шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн тогтоол гардуулсан тухай баримт, 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн мэдэгдэх хуудас, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2015 оны 5 дүгээр сарын 06-ны өдрийн дугаар тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэл, Н.Г-н 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдөр шүүхэд гаргасан хүсэлт, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн дугаар тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэл,,, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн шүүх хуралдааны тэмдэглэл, 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн шүүхэд төлөөлөх итгэмжлэл зэрэг баримтуудыг шинжпэн судлаад

ҮНДЭСЛЭХ НЬ:

Өмгөөлөгч Ч.Б нь 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдөр иргэн Н.Г “Н.Г нэхэмжлэлтэй Л.А-д холбогдох иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г байгуулсан байна. Мөн тэрээр хуульчдын нэгдсэн бүртгэлийн дугаарт, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн дугаарт бүртгэлтэй болох нь Монголын Хуульчдын Холбооны 2016 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 2/55 тоот албан бичгээр нотлогдож байх тул “Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журам”-ын 1.4-д заасан хариуцагчаар оролцох этгээд мөн болно.

Мэргэжлийн Хариуцлагын хорооны Сахилгын шинжээч нь өмгөөлөгч Ч.Б нь иргэн Н.Г нэхэмжлэлтэй Л.А холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байхдаа үйлчлүүлэгч Н.Г хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих ... хориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.14 дүгээр зүйлийн 1-д “Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуульч хэрэг, маргааныг бүрэн шийдвэрлэж дуусахаас өмнө үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй гэж үзэн мэргэжлийн дүгнэлт үйлдсэн байна.

Өмгөөлөгч Ч.Б нь үйлчлүүлэгч Н.Г-аас “Иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г байгуулахдаа 500 000 төгрөг, 2014 оны 10 дугаар сарын 7-нд Хаан банкаар Ч.Б өмгөөллийн хөлс болох 1 000 000 төгрөгийг шилжүүлсэн үүнээсээ 2014 оны 10 дугаар сарын 27-нд 500 000 төгрөгийг Н.Г нь буцаан авсан гэдэг нь оролцогчдын тайлбар, нотлох баримтуудаар тогтоогдож байгаа бөгөөд оролцогчид 1 000 000 төгрөгийг өгсөн, авсан гэдэгтээ маргалдаагүй байна.

Иргэний хэргийн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр зохицуулагдсан өмгөөллийн хөлсний талаарх асуудал нь Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 1.4 дүгээр зүйлд заасан Хорооны хянан шийдвэрлэх маргаанд харъяалагдахгүй болно.

Өмгөөлөгч Ч.Б нь 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр гаргасан сөрөг нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлагыг 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр гардан авсан байна. Мөн 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр шүүгчийн захирамжинд гаргасан гомдлыг хянан хэлэлцэх шүүх хуралд өмгөөлөгч Ч.Б оролцсон нь Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны дугаар шүүхийн 2015 оны

4 дүгээр сарын 10-ны өдрийн 102/ШТ2015/00294 дугаар тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэлээр тогтоогдож байна.

2015 оны 5 дугаар сарын 11-нд товлон зарлагдсан шүүгчийн захирамжинд гаргасан гомдлыг хянан хэлэлцэх шүүх хуралдаанд өмгөөлөгч Ч.Б ирээгүй нь 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн мэдэгдэх хуудас, Н.Г-ийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдөр шүүхэд гаргасан хүсэлт, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны дугаар шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн дугаар тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэл зэргээр нотлогдож байна.

2015 оны 9 дугаар сарын 29-нд товлон зарлагдсан шүүх хуралдаанд өмгөөлөгч Ч.Б ирээгүй нь оролцогчдын тайлбар,,, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлээр нотлогдож байна.

Өмгөөлөгч Ч.Б нь би Н.Г 2015 оны 9 дугаар сарын 29-нд гэрээгээ цуцалж цаашид ажиллахгүй гэдгээ албан ёсоор хэлсэн гэж мэдүүлж байгаа боловч Иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний 1.4-т "Гэрээний гүйцэтгэлийн явцад аль нэг тал гэрээг дуусгавар болгох, цуцлах тухай хүсэлт гаргавал нөгөө талдаа бичгээр санал, хүсэлт, үндэслэлээ бичиж өгнө. Үүнийг хүлээн авсан тал ажлын тав хоногт багтаж хариу өгнө. Хариуг хугацаандаа өгөөгүй тохиолдолд гэрээг ... цуцалсан гэж үзнэ. Хэрэв гэрээ цуцлах тохиолдолд бодитойгоор хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээнээс хамаарч төлбөрийг төлөх бөгөөд үндэслэлгүй цуцалсан тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй" гэж заасан атлаа гэрээ цуцлах тухай санал, хүсэлт, үндэслэлээ бичиж өгөөгүй, тооцоо нийлээгүй байна.

Н.Г нь 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн шүүхэд төлөөлөх итгэмжлэлээр Б.А-г,, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа Н.Г-н нэхэмжлэлтэй Л.А холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулахаар болсон байна.

Өмгөөлөгч Ч.Б нь иргэн Н.Г нэхэмжлэлтэй Л.А-д холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байхдаа үйлчлүүлэгч Н.Г-д хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 "Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих ... хориглоно", Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.14 дүгээр зүйлийн 1 "Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуульч хэрэг маргааныг бүрэн шийдвэрлэж дуусахаас өмнө үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно" гэдгийг тус тус зөрчсөн буруутайд тооцож, түүнд зохих шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Өмгөөлөгч Ч.Б-т холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлын талаарх баримт маргааны материалд авагдаагүй болно.

Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Өмгөөлөгч Ч.Б Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 “Хуульчийн Мэргэжлийн дүрмийг зөрчих ... хориглоно”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.14 дүгээр зүйлийн 1-д “Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуульч хэрэг, маргааныг бүрэн шийдвэрлэж дуусахаас өмнө үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөнд тооцож Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар “Нээлттэй сануулах шийтгэл” ногдуулсугай.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүй болохыг дурдсугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Өмгөөлөгч К.С-т холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Ц.Оч даргалж, гишүүн М.Алдар, Д.Даваасүрэн, Т.Баярсайхан, Л.Данзанноров нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанд:

сахилгын шинжээч Б.Эрдэнэсүрэн,

нарийн бичгийн дарга А.Хулан нарыг оролцуулан,

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн МД/16/007 тоот мэргэжлийн дүгнэлт үйлдсэн, хуульч К.С-т холбогдох материалыг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын хуульчдын холбооны 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 2/218 тоот албан бичгээр “БГД, 11 дүгээр хороо, Хас банкны гудамж тоотод оршин суугч иргэн Ц овогтой Э нь өмгөөлөгч К.С /Бүртгэлийн дугаар:, Шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн дугаар:Д холбогдуулан гаргасан байна. Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.7 дахь заалтыг үндэслэн өмгөөлөгч К.С нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэхийг шалгуулах асуудлаар иргэн Ц.Э-ээс гаргасан гомдлыг зохих журмын дагуу шалган, шийдвэрлэж өгөхийг хүсье” гэх хүсэлтийг Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасныг хорооны сахилгын шинжээч хүлээн авч 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр М16/018 тоот тогтоолоор маргаан үүсгэжээ.

Иргэн Ц.Э гаргасан гомдолдоо: “...Ц.Э би Эрүүл мэндийн төвд Хүний нөөцийн менежерээр ажиллаж байгаад 2013 оны 7 дугаар сарын 30-ны өдөр ажлаасаа халагдсан. Шат шатны шүүхэд гомдлоо гаргаснаар 2014 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хурлын дугаар тогтоол миний талд гарч ажилдаа эргүүлэн тогтоогдож, 10.319.300 төгрөгийн нөхөн олговор, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийх шийдвэр гарсан билээ. Нөхөн олговор болох 10.319.300 төгрөгийг 7 дугаар сарын 1-ний өдөр олгосон боловч нийгмийн даатгалын дэвтрийн нөхөн бичилтийг одоо хүртэл хийгээгүй, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй. ...7 дугаар сарын 3-нд өмгөөлөгч К.С над руу залган “Чи мөнгөө авсан уу, би чамд олгуулж өглөө шүү, харин чиний наад нэхээд байгаа цалинг бид өгөхгүй юм билээ” гэсэн. 2015 оны 8 дугаар сард өмгөөлөгч К.С над руу залган “чи шүүхэд хандсан байна тэгвэл би чамтай өөрөөр ярина” гэж дарамтлаад миний тайлбарыг ч сонсохгүй утсаа шидсэн.

Би маш их айсан. 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр “Чи хүүхэд асрах чөлөөтэй байгаа чамайг ажилдаа ороход дарга чинь солигдоод байхгүй болсон ч чамайг би зүгээр өнгөрөөхгүй, шинэ даргад чинь хүртэл хэлнэ” гэж сүрдүүлсэн. 2015 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр “Шүүгч та хоёр хэрэгт орвоо, намайг байхгүй үед хуралдаж шийдвэр гаргасан байна лээ. Наад мөнгийг чинь чамд олгохгүй” гэж хэлсэн. Энэ өмгөөлөгч намайг үнэхээр дарамталж, айлган сүрдүүлж, хөдөлмөрлөх эрхэнд минь удаа дараалан халдаад байгаа учраас арга хэмжээ авч намайг гомдолгүй болгож өгнө үү” гэжээ.

Өмгөөлөгч К.С гаргасан тайлбартаа: “...2016 оны 3 дугаар сарын 23-нд болсон ЧДЭМТ-ийн УЗ-ийн хурлаар Ц.Э-г өөрийн хүсэлтээр ажилд авч, тохирох ажилд нь томилсон болно. Миний хувьд Ц.Э рүү түүний бичсэнчлэн удаа дараа утасдаж, заналхийлж, орилж хашгичиж, утсаа шиддэг асуудал байхгүй. Надад Ц.Э хувийн өш хонзон, үл ойлголцол, хувийн харилцаа байхгүй болно. Ц.Э-ийн энэ гомдол өмгөөлөгч миний хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай огт холбоогүй тул түүний гомдлыг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн захиргаа, хүний нөөцийн албаны дарга Д.Н гаргасан тайлбартаа: “...Ц.Э нь тус байгууллагад хүний нөөцийн менежерээр ажиллаж байгаад ажилдаа тэнцэхгүй шалтгаанаар 2013 онд ажлаас халагдсан. Ц.Эн нь Улсын Дээд шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн тогтоогдсон тул түүнийг ажилд нь авахаар шийдвэрлэж дээд сургууль төгссөн диплом, төрийн албан хаагчийн анкет, ажлын байрны тодорхойлолтоо авчирч өгөхийг Ц.Э-д мэдэгдсэн боловч тэрээр өөрөө сураггүй болсон. Манай байгууллагын хуулийн зөвлөх К.С нь Ц.Э-тэй биечлэн уулзаж түүнийг эргээд ажилдаа ороход нь ажлын байрны тодорхойлолтын дагуу зохих материалаа бүрдүүлж өгөх ёстой гэдгийг хэлж байсан. Бидний болон манай байгууллагын хуулийн зөвлөхийн зүгээс Ц.Э-тэй зүй бусаар харьцсан зүйл байхгүй. Харин ч Ц.Э нь биднийг ёс бусаар дайрч хэл амаар доромжилж байсныг тэмдэглэн хэлж байна” гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч дүгнэлтдээ: “...Хариуцагч К.С нь иргэн Ц.Э дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэл болон иргэний хэрэг хянан шийлвэрлүүлэхэд нь хүндрэл учруулж, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-д заасан эрхийг нь зөрчиж утсаар залгаж дарамтлан, мөрдөн мөшгиж, сурч хөдөлмөрлөж байсан сургууль, албан байгууллагад нь очиж иргэн Ц.Э-н гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдоогүй байхад гэмт хэрэг үйлдсэн гэх мэдээллийг тараасан, хууль зүйн “Ниса” ХХК-н захирал болон Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвд хуулийн зөвлөхөөр тус тус ажиллагад ажилладаг атлаа давхар өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байгаа зэрэг үйлдлүүд нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан “өмгөөлөгч, багшлах, эрдэм шинжилгээний болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхийг хориглоно”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2-д “...эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах...”, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-д заасан “...гэрчид хууль

бусаар нөлөөлөх”, 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хуульч үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, эсвэл тухайн этгээдийн эрхийг зөрчиж нотлох баримтыг бүрдүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн нь мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч К.С-н үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзээд Мэргэжлийн дүгнэлт үйлдэн холбогдох баримт сэлтийн хамт маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шилжүүлсүгэй” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч К.С нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан “өмгөөлөгч, багшлах, эрдэм шинжилгээний болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхийг хориглоно” гэх заалтыг зөрчсөн гэх үндэслэл нотлогдон тогтоогдохгүй байна.

Харин маргааны материалд авагдсан нотлох баримтаас үзэхэд хариуцагч К.С нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2-т “...эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах...”, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-д заасан “...гэрчид хууль бусаар нөлөөлөх”, 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хуульч үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, эсвэл тухайн этгээдийн эрхийг зөрчиж нотлох баримтыг бүрдүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн нь гомдол гаргагч Ц.Эн тайлбар, хариуцагч К.С-н тайлбар, маргааны материалд авагдсан шат шатны хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрүүд, гэрчүүдийн тайлбар, бусад баримтуудаар нотлогдон тогтоогдсон байна.

Хариуцагч К.С нь гомдол гаргагч Ц.Э Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд хүний нөөцийн менежерийн ажлаас үндэслэлгүйгээр халсан болохыг тогтоож, түүнийг ажилд нь эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговорт 10.319.300 төгрөгийг олгуулахаар шийдвэрлэсэн Монгол Хяналтын шатны шүүх иргэний хэргийн шүүх хуралдааны 2014 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 497 дугаартай тогтоол гаргаснаас хойш одоог хүртэл шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, Ц.Э-г ажилд нь эргүүлэн томилохгүй байгаа асуудлаар Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн удирдлагуудад зөвлөх байдлаар иргэн Ц.Э эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах, залхаах байдлыг удаа дараа гаргасан нь дээрх хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул түүний үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзэж хариуцлага хүлээлгэх нь үндэслэлтэй байна.

Иймд хариуцагч К.С нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2, 4.4 дүгээр зүйлийн 1.2, 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т зааснаар түүнд шүүхэд төлөөлөх эрхийг 6 сарын хугацаагаар

түдгэлзүүлэх хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэлтэй гэж маргааныг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн дүгнэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2, 4.4 дүгээр зүйлийн 1.2, 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т зааснаар хуульч К.С шүүхэд төлөөлөх эрхийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Хуульч, өмгөөлөгч Б.Л-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Т.Баярсайхан даргалж, гишүүн Ц.Оч, Л.Данзанноров, М.Алдар, Д.Даваасүрэн нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын Холбооны хуралдааны танхимд нээлттэй явуулж Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс Б.Л-д холбогдуулан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн байж болзошгүй” тухай дүгнэлт үйлдэж ирүүлснийг хүлээн авч хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Хуралдааны хэлэлцүүлэгт дараах баримтуудыг хэлэлцүүлэв. Үүнд.

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 71 дүгээр саналд: Хариуцагч Б.Л нь хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, 234 дүгээр зүйлийн 234.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн яллагдагч Б.Д-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгуулна, өмгөөлнө, батлан даалтанд гаргуулна гэсэн гол нөхцлийг Г.Ж, Б.Д, Ш.Б нартай тохиролцон ам хэлцэл хийж өмгөөллийн хөлсөнд бүгд 7 сая төгрөг авсан боловч хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно.”, мөн хэсгийн 27.1.8 “үйлчлүүлэгчийнхээ ... эд хөрөнгийг ... бусад аргаар олж авах” гэснийг, Б.Д-д хууль зүйн үйлчилгээ үзүүлэх болон өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг тохиролцохдоо бичгээр гэрээ байгуулаагүй нь мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Өмгөөлөгч ... өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг... гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна.” гэснийг тус тус зөрчсөн байж болзошгүй тул Мэргэжлийн дүгнэлт үйлдэх санал гаргаж байна гэжээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн Д.Б 2016 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 2/82 дугаар захирамжаар: Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд иргэн А.Ж-с хуульч Б.Л-н хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдолд тус хорооны сахилгын шинжээчээс маргаан үүсгэн, мэргэжлийн дүгнэлт үйлдэх санал ирүүлснийг хянавал Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн

хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар сахилгын шинжээчийн саналыг хүчингүй болгох, эсхүл өөрчлөх үндэслэл тогтоогдохгүй байна. Иймд хуульч Б.Л нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлан дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн гэх асуудалд Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээчийн 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 71 дугаартай Мэргэжлийн дүгнэлт үйлдэх саналыг хэвээр үлдээж, материалыг Хорооны ажлын албанд хүргүүлэхээр шийдвэрлэжээ.

Ажлын албаны 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн МД/16/006 дугаар Мэргэжлийн дүгнэлтээр: Хариуцагч Б.Л нь:

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, 234 дүгээр зүйлийн 234.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн яллагдагч Б.Д-г “өмгөөлнө, батлан даалтанд гаргуулна, хэргийг хэрэгсэхгүй болгуулна” гэсэн гол нөхцлийг Г.Ж, Б.Д, Ш.Б нартай тохиролцон ам хэлцэл хийж 2014 оны 12 дугаар сард өмгөөллийн хөлсөнд бүгд 7 сая төгрөг авсан боловч хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно.”, мөн хэсгийн 27.1.8 “үйлчлүүлэгчийнхээ...эд хөрөнгийг...бусад аргаар олж авах” гэснийг,
2. Д хууль зүйн үйлчилгээ үзүүлэх болон өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг тохиролцоходоо бичгээр гэрээ байгуулаагүй нь мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Өмгөөлөгч...өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг...гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна.” гэснийг тус тус зөрчсөн байж болзошгүй нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байх тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шилжүүлэн ирүүлсэн талаар.
3. Хариуцагч нарт холбогдох маргааны зарим хэсгийг хэрэгсэхгүй болгох тогтоол зарим хариуцагчид холбогдох маргааныг хэрэгсэхгүй болгох 26 дугаартай тогтоол, эрүүгийн хэргээс хуулбарлан авсан энэ маргаанд холбогдох нотлох баримтууд болон хариуцагч, хуульч Б.Л “ дүгнэлт хүргүүлсэн тухай” 2016 оны 08 дугаар сарын 03 ны өдрийн 03/456 дугаартай албан бичиг, бусад материалуудыг хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Б.Л нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуульчдын нэгдсэн бүртгэлийн дугаарт, 2013 оны 08 дугаар сарын 16- ны өдөр шүүхэд төлөөлөх эрхтэй хуульчдын дугаарт тус тус бүртгэгдсэн байна.

1. Б.Ж-с Монголын Хуульчдын холбооны Сахилга, ёс зүйн хороонд хандаж гаргасан өргөдөлд: “Б овогтой Ж миний төрсөн дүү Б овогтой Д-д АТГ-т Эрүүгийн хуулийн 268.2-т заасан зүйлчлэлээр яллагдагчаар татагдаж байх хугацаандаа хуульч,

өмгөөлөгч Т.М-тэй 2014 оны 8 сарын 11 өдөр өмгөөллийн гэрээ, 2014 оны 10 сард хуульч Б.Л нэмж өмгөөлөгчөөр авч гэрээ хийгээгүй болно. Энэ хоёр хүн нь хуульч, өмгөөлөгчийн үүргээ эс биелүүлж, дүүг минь өмгөөлөх цагаатгах ажил огт хийгээгүй. Харин өмгөөллийн хөлсийг ажлаа хийхээс өмнө авна гээд тус тус 5, 5 сая төгрөг авсан. М нь өмгөөлөгчийн гэрээ байгуулсан атлаа, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээр үл барам дүүг минь мөрдөн байцаалт өгөхөд өмгөөлөх, мөн хэргийн талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэхийн оронд хуруугаа ч хөдөлгөөгүй. Тэрээр шүүх хуралтай эсвэл завгүй байна гэх шалтаг хэлэн миний дүүг өмгөөлөхгүй байсан. Б гэх хүн нь олон жил хуулийн багш хийсэн хүний хүү нь учир түүний тусламжтайгаар хэргийг нь өмгөөлж, цагаатгана гэж байсан Л амлалт өгч байсан болно. Гэвч тэрээр мөнгө шилжүүлж авснаас хойш утсаа авахгүй зугтаах болсон. Бид мөнгөө нэхэхэд эхнэрээрээ утсаа авхуулан Хөх хот руу эмчилгээнд явсан үхлүүт хэвтэж байна гэж худал ярьж байсныг хожуу мэдсэн юм. М 2015 оны 5 сарын 13-ны өдөр миний ээж Д-н данс руу 500 000 төгрөг шилжүүлснээс өөр мөнгө өгөхгүй утсаа авахгүй байна. Зовлон тохиолдсон үед сайхан амлалт өгөн биднээс хууран мэхэлж авсан мөнгийг буцаан авахын тулд манай гэр бүлийнхэн дээрх хоёр хүнтэй удаа дараа холбогдон өмгөөллийн хөлсөө эргүүлж авах гэсэн боловч биднээс зугтааж байна. Хүнд тохиолдсон зовлонг жаргал болгон залилан мэхэлж дүүг минь өмгөөлнө, цагаатгана гэж хууран өмгөөлөгч, хуульчийн тангаргаа зөрчин жирийн иргэдийн оюун санаагаар тоглон мөнгөний хойноос хуулийн нэр барин залилангийн хэрэг үйлдэж буй дээрх хүмүүст хариуцлага ногдуулан бидний хохирлыг барагдуулж өгнө үү. Мөн бидний адил байдлыг олон хүнд учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг танай байгууллагаас хүсч байна. Хуульч, өмгөөлөгч гэх нэр хүндийг нийгмийн дунд унагааж бусдын зовлонгоор мөнгө хийн хөрөнгөжих сонирхолтой шударга хуульч гэх гуншинтай шударга бус үг, үйлдэлтэй М, Л нараас дүүгээ өмгөөлүүлж, хэргийг нь хөнгөрүүлэх гэж итгэж өгсөн 4.5, 5 сая төгрөгийг гаргуулж өгнө үү. Шаардлагатай тохиолдолд өргөдөлд дурьдаагүй зүйлчийг биечлэн мэдүүлж болно.” гэжээ.

2. Б.Д тайлбартаа: “... Л-тэй мөнгө төгрөг тохиролцож гэрээ хийсэн зүйл ч байхгүй ... танил талынхаа хүрээнд хөөцөлдөж хэрэгсэхгүй болгуулна л гэж утсаар ярьж тохирсон... гэрээ байгуулаагүй ... хууль зүйн ямар нэг туслалцаа огт үзүүлээгүй ... худлаа хэлж 5 сая төгрөг авсан... Батлан даалтанд гарсаны дараа 2-3 удаа уулзсан ... мөнгө хэрэг болоод байна гэхээр нь 200.000 төгрөг өгсөн... хоол, архиныхаа мөнгийг надаар төлүүлсэн... Батлан даалтанд гаргах талаар надтай яриагүй. ... Батлан даалтанд гарсан асуудалд Н.Л холбоогүй, хамааралгүй” гэжээ.
3. Г.Ж: “...2014 оны 9 дүгээр сард Д-г батлан даалтанд гаргаж магадгүй гэж өмгөөлөгч М хэлсэн боловч тэр нь бүтээгүй учир Б буюу Э уруу утсаар холбогдож Д хэрэгт холбогдсон талаар хэлэхэд “Л гэдэг хүн их тусалсан” гэхээр нь түүнтэйгээ холбоод өгөөч гэсэн...2014-09-10-ны үеэр Л уулзахад “олон хүн хамарсан юм байна, судлах хэрэгтэй, мэдээ сонсогдвол Бамбарт хэлнэ.” гээд салсан. 2014-12-01-нд Бамбар “1,5 сая төгрөг өгвөл даалтанд гаргах боломжтой гэж байна” гэхээр хадам ээж үрүү ярьж тэд мөнгийг шилжүүлсэн...Д суллагдсан.

Үүнээс хойш Л Д байн байн дуудаж шоудан зардлаа даалгаж эхэлсэн. “Даалтанд гаргасан, Б-г хэргээс салгасан тул энэ хүн хэрэг болох юм байна” гэж итгэсэн. 2014-12-14-нөөс хойш Л “энэ бол хэрэг биш ээ. Хэргийг хөнгөрүүлэх талаар ажиллах хэрэгтэй...5 сая төгрөгний хэрэг байна” гэж байн байн утасдсан...Мөнгө байхгүй учир Д эгч үрүүгээ ярьж эгч нь мөнгийг шилжүүлсэн. Үүнээс хойш Лх ярих нь багасан аажмаар холдсон. Гэрээ байгуулах гэхэд өмгөөллийн эрх аваагүй.” гэсэн тайлбар;

4. Ш.Б-н: “Миний хүү Д-р ангид хоригдож байх хугацаанд Л “батлан даалтанд гаргаж өгнө. 2 сая төгрөг өгчих” гэж Н.Б-аар дамжуулан байн байн утсаар яриад байхаар нь эхнэр Д-г яаруулан байж 2 сая төгрөг өгүүлсэн...2014 оны 12 дугаар сард “ах нь өмгөөлж өгье...хэрэг биш, аргалж өгнө...5 сая төгрөг шилжүүлчих...”гээд байхаар нь охин Ж уруу ярьж Л-ийн данс уруу 5 сая төгрөг шилжүүлүүлсэн. Л мөнгө авсанаасаа хойш...таг чиг болсон” гэсэн тайлбар;
5. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч Ч.Ж-н; ...Л өмгөөлөгчтэй найз нөхдийн холбоо, харилцаатай байдаг...Тэрээр 2014-2015 оны өвөл нэг удаа ажил дээр ирж уулзсан...Өвөрхангай аймгийн нэг залууг танай байгууллага цагдан хорьсон. Уг залуу нь миний талийгаач ээжийн хамаатан,...”батлан даалт” таслан сэргийлэх арга хэмжээ авч болох уу” гэж асуусан. Манай байгууллагын хувьд мөрдөн байцаагч нар бие биедээ нөлөөлөхийг хориглодог, бие биенээсээ хэрэг материал асуух, санал тавих хориотой,...дуу дүрсийн камертай, мөрдөн байцаагч бусдын нөлөөнд автах, ашиг сонирхлын зөрчилд өртөх нөхцлийг хязгаарласан байдаг талаар хэлээд явуулсан. Л 7 хоногийн дараа мөрдөн байцаагч Э.Г-тай уулзана гээд сууж байсан, уулзсан эсэхийг мэдэхгүй. Ямар хэрэгт холбогдсон хэн гэдэг хүнийг даалтанд гаргуулахаар хөөцөлдөж байгааг нь мэдээгүй.” гэсэн тайлбар;
6. Мөн газрын мөрдөн байцаагч Э.Г-н: “2014 оны 12 дугаар сард өөрийгөө өмгөөлөгч гэж танилцуулсан Л өрөөнд орж ирээд Д-ийн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэхээр оролцож байгаа өмгөөлөгч гэж хэлэхэд нь “...туслалцаа үзүүлэх гэрээ байна уу” гэхэд “байхгүй” гэсэн. “Д-г хэзээ даалтанд гаргах болон хэргийн талаар тайлбарлах боломжгүй гэж тайлбарлаад явуулсан.” гэсэн тайлбар;
7. Мөн газрын мөрдөн байцаагч М.Э-ны: “...би...М.Т, Б.Д нарт холбогдох...хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах ажлын хэсгийн гишүүн, мөрдөн байцаагчаар ажиллах хугацаанд...Б.Д-д эрх зүйн туслалцаа үзүүлэхээр Б.Лх гэх өмгөөлөгч байцаан шийтгэх ажиллагаанд оролцохоор амаар болон бичгээр ямар нэг хүсэлт тавьж байсан зүйлгүй, Б.Л гэх өмгөөлөгчтэй уулзаж байгаагүй, түүнийг танихгүй...
Ч.Ж-с... Д-д авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэхээр хүсэлт тавьсан зүйлгүй, хэргийн нөхцөл байдлын талаар асууж тодруулж байгаагүй болно.” гэсэн тайлбар;
8. Хариуцагч Б.Л-н “...Д-н хэрэгт миний нэг танил Б надад хандаж Авлигын хэргээр хоригдчихсон байгаа, энийг гаргаж өгч туслалцаа үзүүлээч ээ, мөнгө төгрөгийг нь өгнөө гэж хэлсэн...Д батлан даалтанд гарсаны дараа баярлалаа гэж утасдахаар

нь төлбөрөө дуусгаарай гэхэд 5 сая төгрөг ХААНБ дахь миний 5003439404 дансанд орж ирсэн. Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй. Бичгээр хүсэлт гаргаагүй...байцаан шийтгэх ажиллагаанд огт оролцоогүй. Оролцохын завдалгүй осолд орсон. Даалтанд гаргаж өгнө гэж л тохиролцсон. Мөрдөн байцаагч, прокурортой биечлэн уулзсаны үр дүнд цагдан хорих хугацааг сунгуулахгүй батлан даалтанд гаргасан гэж үзэж байна. Батлан даалтанд гарсаныхаа дараа 5 сая төгрөгийг шилжүүлсэн. Би тэднээс 5 сая төгрөг авна гэж хэлээгүй. Д 5 сая төгрөгөө буцааж авъя гэж утсаар ярьсан. Түүнийг даалтанд гаргаж үүргээ гүйцэтгэсэн учир 5 сая төгрөгийг өгөхгүй.” гэсэн тайлбар;

9. Б.Л, Б.Д-д хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн тухай бичгийн баримт М.Т, Б.Д нарт холбогдох эрүүгийн дугаартай хэргийн материалд байхгүй байгаагаар;
10. Б.Ж 2014 оны 12 дугаар сарын 17-нд Голомт банк дахь 3000005994 тоот данснаасаа Б.Л-н ХААН Төв банк дахь дансанд 5 сая төгрөг шилжүүлсэн баримтын хуулбар болон Б буюу Ж.Э, Д, хариуцагч Т.М нарын тайлбар;
11. Хариуцагч Б.Л-н “...Би АТГ очиж мөрдөн байцаагчтай уулзаж хэргийн талаар явж байгаагаа хэлээд батлан даалтанд гаргах боломж байна уу...гэхэд мөрдөн байцаагч “Та батлан даалтанд гаргахаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байна уу” гэж асуусан. Тухайн үед цагдан хорих хугацааг 14 хоногоор сунгасан... Хугацаа дуусах үеэр ...мөрдөн байцаагч Ж болон прокурортой нь уулзаж хорих санал битгий гаргаач...гэсэн. Ж...шалгаж байгаа мөрдөн байцаагчтай нь уулзая гэсэн...дээрх 14 хоног сунгасан байсан нь өнгөрч батлан даалтанд гарсан...” гэсэн боловч энэ нь мөрдөн байцаагч Ч.Ж, Э.Г, М.Э нарын тайлбараар үгүйсгэгдсэн, түүнчлэн Б.Д 2014-08-08-ны өдрөөс мөн оны 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд цагдан хоригдсон байх ба прокуророос “...яллагдагч Б.Д болон түүний ар гэрээс удаа дараа прокурорын газарт хүсэлт ирүүлсэн бөгөөд цаашид цагдан хорих үндэслэлүүд нь арилсан байх тул цагдан хорихоор авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх...” гэсэн санал гаргасныг шүүгч 2014-12-05-ны өдөр хүлээн авч хянаад “...прокурорын саналыг хүлээн авах нь зүйтэй...” гээд 700-5 дугаартай захирамж зэргээс үзэхэд Б.Л-н тайлбарын холбогдох хэсгүүд нь нотлогдохгүй байх тул хариуцагч Б.Л-н зөрчилд хариуцлага тооцох нь үндэслэлтэй.

Мөн дээрхи баримтуудаар хариуцагч Б.Л нь:

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, 234 дүгээр зүйлийн 234.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн яллагдагч Б.Д-г “өмгөөлнө, батлан даалтанд гаргуулна, хэргийг хэрэгсэхгүй болгуулна” гэсэн гол нөхцлийг Г.Ж, Б.Д, Ш.Б нартай тохиролцон ам хэлцэл хийж 2014 оны 12 дугаар сард өмгөөллийн хөлсөнд бүгд 7 сая төгрөг авсан боловч хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно.”, мөн хэсгийн 27.1.8 “үйлчлүүлэгчийнхээ...эд хөрөнгийг...бусад аргаар олж авах” гэснийг,
2. Д хууль зүйн үйлчилгээ үзүүлэх болон өмгөөллийн үйлчилгээний хөлсний

хэмжээг тохиролцоходоо бичгээр гэрээ байгуулаагүй нь мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “Өмгөөлөгч...өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг...гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна.” гэснийг тус тус зөрчсөн байж болзошгүй нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байх тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн сахилгын мэргэжлийн дүгнэлт үндэслэлтэй байна гэж дүгнэв. Хариуцагч нь маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд өөрийн биеэр оролцох эсэх талаар тайлбар ирүүлээгүй болохыг тэмдэглэе.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйл, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 1-5 дахь заалтыг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг, Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар Урианхан овгийн Б.Л хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй түдгэлзүүлсүгэй.
2. Энэ маргаанаар нотлогдсон гомдол гаргагч Б.Ж-с өгсөн өмгөөллийн хөлс болох долоон сая төгрөгийг “түдгэлзүүлэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш арав хоногийн дотор үзүүлээгүй үйлчилгээндээ зориулан авсан хөлсөө буцаан төлөхийг хариуцагч Б.Л-д үүрэг болгосугай.
3. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
4. Энэ тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Хуульч Д.Ц-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Т Энхжаргалын илтгэснээр гишүүн Э.Ариунаа, Г.Батбаяр, Д.Очмандах, У Солонго нарын бүрэлдэхүүнтэй, Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж, хуульч Д.Ц /хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн нэгдсэн бүртгэлийн дугаар зөвшөөрөлтэй, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн дугаартай/-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Эрдэнэсүрэнгийн саналыг 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн саналд:

Хариуцагч Д.Ц нь Г.Б нэхэмжлэлтэй, “Нүүдэл.мн” зэрэг 6 сайтад холбогдох “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээх, учруулсан гэм хорыг арилгуулах” тухай иргэний хэрэг маргаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор Г.Б гэрээ байгуулж, урьдчилгаанд 1,500,000 төгрөгийг бэлнээр авсан боловч тодорхой шалтгааны улмаас эрх зүйн туслалцаа үзүүлэх үүргээ үзүүлээгүй байна.

Хариуцагч нь дээрх үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг гийм үйлдэл хийхэд туслах, хатгах”, 27.1.2-т “хуульчийн үнэн шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”, 38 дугаар зүйлийн 38.1.1-д “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн, тууштай хамгаалах”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1.3-т “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, зөрчлийн улмаас иргэн Г.Б-д учруулсан 1,500,000 төгрөгийг төлж, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн тул Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Д.Ц-д сахилгын “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулах санал гаргаж байна гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Гомдол гаргагч Г.Б тус хороонд гаргасан гомдол, тайлбартаа: "...Өмгөөлөгч шаардлагатай болсон тул эрх зүйн туслалцаа авахаар өмгөөлөгч гэх Д овогтой Ц-г 3,500,000 төгрөгөөр хөлсөлж авч гэрээ байгуулан урьдчилгаа 1,500,000 төгрөгийг 2015 оны 10 дугаар сарын 13-нд бэлнээр гаргуулан өгсөн болно. Гэтэл иргэдийн итгэл алдаж, хүмүүнлэг сэтгэл, хууль эрх зүйн боловсролынхоо чин шударга үйлдлийг энэ өмгөөлөгч гэх Д.Ц надад үзүүлээгүй болно. Д.Ц миний шүүх хуралдаанд суугаагүй" юм.

Танай байгууллагад өгсөн гомдлынхоо дагуу холбогдогч өмгөөлөгч Д.Ц-с надад өгөх ёстой 1,500,000 төгрөгийг хүлээн авлаа гэжээ.

2. Хариуцагч Д.Ц тус хороонд ирүүлсэн тайлбар, хүсэлтдээ: Миний бие иргэн Г.Б нэр төрийг нь гутаасан мэдээлэл цацагдсан тухай асуудлаар өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр 2015 оны 11 дүгээр сард гэрээ байгуулж, урьдчилгаанд 1,500,000 төгрөгийг авсан, би гэрээ байгуулсан өдрөөс эхлэн материал цуглуулан иргэний хэрэг үүсгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл бичиж, шүүх хуралдаан зарлагдахгүй хойшилсоор 2016 оны 3 дугаар сарын 20-ны өдөр болоход би Солонгос Улс руу магистрын сургалтад суух хугацаа болсон учир арга буюу явсан юм. Шүүх хуралдаан зарлагдах үед ирж оролцох бодолтой байсан ч онгоцны зардлаас болж ирж чадаагүй, ингээд үйлчлүүлэгч Г.Б надад нэгэнт шүүх хуралдаанд ороогүй болохоор би өгсөн мөнгөө буцааж авья гэхэд нь би зөвшөөрч өгөхөөр болсон. Гэвч би сургуульд сурч байсан болохоор эдийн засгийн хүндрэл гарч мөнгийг нь өгч чадахгүй удаасан нь миний буруу. Одоо би Г.Б 1,500,000 төгрөг бэлнээр хүлээлгэн өглөө. Би мөнгийг нь өгч чадахгүй удаасандаа Г.Б-с уучлалт гуйсан болно.

Г.Б-н хохирол болох 1,500,000 төгрөгийг төлж барагдуулсан ба мэргэжлийн хариуцлагагүй байдал гаргасандаа чин сэтгэлээсээ гэмшиж байгаа болно. Иймд надад хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү гэжээ.

3. Г.Б-н,, дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд:

"...өмгөөлөгчид төлсөн ажлын хөлс болох ... төгрөг /өмгөөлөгчтэй байгуулсан гэрээ болон ажлын хөлс төлсөн санхүүгийн баримтыг хавсаргав/" гэжээ.

4. Өмгөөлөгч Д.Ц-н иргэн Г.Б-тай 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан "Иргэн, байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ"- ний нэмэлт нөхцөл хэсэгт: "Өмгөөллийн хөлс нийт 3,500,000 төгрөгийг 5020954627 тоот дансанд шилжүүлэхээр тохиролцов" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс өмгөөлөгч Д.Ц нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн бөгөөд тэрээр гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, зөрчлийн улмаас иргэн Г.Б-д учруулсан

1,500,000 төгрөгийг төлж, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн тул “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулах саналыг ирүүлжээ.

Өмгөөлөгч Д.Ц нь 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр иргэн Г.Б “Иргэн, байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж Г.Б нэхэмжлэлтэй, “Нүүдэл.мн” зэрэг 6 сайтад холбогдох “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээх, учруулсан гэм хорыг арилгуулах” тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор, өмгөөллийн хөлсийг 3,500,000 төгрөгөөр тохирч, урьдчилгаанд 1,500,000 төгрөгийг Г.Б нь Д.Ц хүлээлгэн өгсөн болох нь гомдол гаргагч, хариуцагч нарын тайлбараар тогтоогдож байна.

Иргэн Г.Б-н гаргасан гомдлын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульч Д.Ц нь гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшиж, Г.Б түүнд өмгөөллийн хөлсөнд төлсөн 1,500,000 төгрөгийг Г.Б-д буцаан төлж, хаалттай сануулах шийтгэл ногдуулж өгөхийг хүссэн байх бөгөөд энэхүү нөхцөл байдал нь Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дахь хэсгийн 2.3 дахь зохицуулалтад нийцжээ.

Хариуцагч Д.Ц-н үйлдэл нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалтай ажиллана”, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтын “хуульч үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх” гэснийг тус тус зөрчсөн үйлдэл мөн гэж дүгнэв.

Энэхүү зөрчил нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

Д.Ц нь Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3-т зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн, учруулсан хохирлоо нөхөн төлсөн байх тул сахилгын шинжээчийн хариуцагчид “Хаалттай сануулах” сахилгын шийтгэл оногдуулах тухай саналыг үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Хариуцагч нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авсан, хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн саналыг зөвшөөрсөн буюу тухайн маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй байх тул сахилгын шинжээчийн саналыг бүрэлдэхүүн хянан үзэж хуралдаан хийхгүйгээр зөвлөлдөж шийдвэрлэх үндэслэлтэй нь Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудаар тодорхойлогдсон байна.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар хуульч Д.Б-д “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Хуульч Д.Б-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн У.Солонгын илтгэснээр гишүүн Д.Очмандах, Г.Батбаяр, Т.Энхжаргал, Э.Ариунаа нарын бүрэлдэхүүнтэйгээр Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч Д.Б-д хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Должинсүрэнгийн саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

Хариуцагч Д.Б нь иргэн Х.Б-н нэхэмжлэлтэйийн засаг даргад холбогдох захиргааны хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэхээр гэрээ байгуулаж ажиллаж байхдаа Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчээр томилогдон ажиллах болсноо үйлчлүүлэгч Х.Б-д мэдэгдээгүй, хэргийг эцэслэн шийдвэрлэтэл хууль зүйн туслалцаа үзүүлээгүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй болсноо Х.Б-д мэдэгдээгүй, энэхүү үйлдлийн улмаас Х.Б нь Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний 12.3-т зааснаар хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэж дуустал өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх нь зөрчигдсөн.

Хариуцагч Д.Б нь дээрх үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, “Мэргэжлийн дүрмийг зөрчих . . . хориглоно” мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 “Мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 2.3 дугаар зүйлийн 1.3 “Үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон Хариуцагч Д.Б-д сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв.

Үүнд:

Гомдол гаргагч Х.Б нь тус хороонд гаргасан гомдолдоо:

“Төрийн өмчийн хорооны 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн тоот тогтоолоор төрийн өмчийн объектыг дуудлага худалдаагаар аваад мөн газрыг нь

цуг хамтад нь миний мэдэлд өгсөн. Гэтэл орц гарц гаргахгүйгээр өөр нэг хувийн компани хашаа барьсан асуудал үүссэн. Дээрх асуудлаас үүдэж өмгөөлөгч Б гэдэг хүнээс хууль зүйн туслалцааг авахаар болсон. Ингээд өмгөөлөгч анх л уулзаад өргөдөл бичихэд 40.000 төгрөг хэрэгтэй, мөн өнөөдрөөс ажил эхлэх гэж байгаа тул өмгөөллийн үйлчилгээний хөлс урьдчилгаа 500.000 төгрөг өг гэж хэлсэн. Энэ өдрийнхөө орой нь би дээрх нэхсэн нийт 540.000 төгрөгийг гэртээ дуудаж ирүүлээд бэлнээр өгсөн. Гэтэл тухайн үед нэг ч шүүх хуралдаан болоогүй хэрэг хняан шийдвэрлэх ажиллагаа эхлээд явж байтал дахиад 500.000 төгрөг өг, таны бичиг баримт юм хумыг хөөцөлдөөд явж байна гэж хэлээд авсан. Энэ мөнгийг Төв номын санд хоёулахнаа уулзалдаад бэлнээр өгсөн. Ингээд нийтдээ 1.040.000 төгрөгийг өмгөөлөгч Бүрнээд өгсөн. Тэгээд байж байтал 3 удаагийн шүүх хурал болоход дандаа миний эсрэг талд буюу "....." ХХК-ны талд үйлчлээд байсан. Удалгүй Б нь Булган аймгийн шүүхийн шүүгчээр томилогдоод явсан гэж дуулсан. Ингээд л ямар нэгэн холбоо байхгүй болсон. Төлбөрийг минь гаргуулж өгнө үү" гэжээ /ММ-н 10-12 хуудас/

Иргэн Х.Б тус хороонд өгсөн хүсэлтэндээ: "Миний бие нь Д.Б-д гомдол санал байхгүй, цаашид ямар нэгэн гомдол санал байхгүй, 600.000 төгрөг авлаа" /ММ-н 37 хуудас/ гэжээ.

Хариуцагч Д.Б тус хороонд ирүүлсэн хүсэлтдээ: ". . . Миний бие шүүгчийн албан тушаалд томилогдонгуутаа үйлчүүлэгчид шүүгчээр томилогдсон тухай болон уг хэрэгт цаашид үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тухай түүнд эргэж мэдэгдээгүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг гүйцэд хийгээгүйн үлдэгдэл төлбөрийг буцааж өгөөгүй хуульчийн ёс зүйгүй асуудал гаргасан гэм буруугаа чин санаанаасаа гэмшиж байгаа учир хаалттай сануулах хариуцлагын арга хэмжээ хүлээхэд татгалзах зүйлгүй" гэжээ. /ММ-н 28-29 хуудас/

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс "Д.Б нь Х.Б-н нэхэмжлэлтэй Нийслэлийн засаг даргад холбогдох захиргааны хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэхээр гэрээ байгуулаж ажиллаж байхдаа Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчээр томилогдон ажиллах болсноо үйлчлүүлэгч Х.Б-д мэдэгдээгүй, хэргийг эцэслэн шийдвэрлэтэл хууль зүйн туслалцаа үзүүлээгүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй болсноо Х.Б-д мэдэгдээгүй, энэхүү үйлдлийн улмаас Х.Б нь Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний 12.3-т зааснаар хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэж дуустал өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх нь зөрчигдсэн үндэслэлээр түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах" санал гаргасан ба хариуцагч Д.Б нь "Миний бие шүүгчийн албан тушаалд томилогдонгуутаа үйлчүүлэгчид шүүгчээр томилогдсон тухай болон уг хэрэгт цаашид үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тухай түүнд эргэж мэдэгдээгүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг гүйцэд хийгээгүйн үлдэгдэл төлбөрийг буцааж өгөөгүй хуульчийн ёс зүйгүй асуудал гаргасан гэм буруугаа чин санаанаасаа гэмшиж байгаа учир хаалттай сануулах хариуцлагын арга хэмжээ хүлээхэд татгалзах зүйлгүй" гэж тайлбарлаж байгаа нь гомдол гаргагчийн гомдол, тайлбар, хариуцагчийн гэм буруугаа хүлээсэн тайлбар, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний хуулбар, 2003 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн тоот Төрийн өмчийн

хорооны Өмчлөгчийн эрх олгох тухай тогтоол, худалдагдсан барилга хүлээлгэж өгсөн 2003 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн нотломж,-ийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газраас орц гарц гаргах талаар иргэн Х.Б-н хүсэлтүүдийг шийдвэрлэж хариу өгч байсан албан бичгийн хуулбаруудаар тус тус нотлогдож байна.

Хариуцагч Д.Б нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, шүүхэд төлөөлөх эрхээ 2015 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс түдгэлзүүлсэн болох нь Монголын Хуульчдын холбооны Бодлого зохицуулалтын хэлтсийн даргын 2016 оны 06 дугаар сарын 28-ны 2/542 албан бичгээр тогтоогдож нэхэмжлэгчийн гаргасан гомдлыг Хуульчдын холбоо хүлээн авсан нь хуульд нийцнэ.

Хариуцагч Д.Б нь дээрх үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, "Мэргэжлийн дүрмийг зөрчих . . . хориглоно" мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 "Мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх", 2.3 дугаар зүйлийн 1.3 "Үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх" гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

Д.Б нь Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн, учруулсан хохирлоо нөхөн төлсөн байх тул сахилгын шинжээчийн "Хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай" саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Хариуцагч нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авсан, хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн саналыг зөвшөөрч өөрийн дугаарын утаснаас мэдэгдэж тухайн маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй. зөрчилдөө гэмшиж тайлбар өгч байсан тул гомдол гаргахгүй. ямар нэгэн санал хүсэлт байхгүй гэж мэдэгдсэн сахилгын шинжээчийн тэмдэглэл байх тул саналыг бүрэлдэхүүн хянан үзэж хуралдаан хийхгүйгээр зөвлөлдөж шийдвэрлэх үндэслэлтэй нь Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудад тодорхойлогджээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар хуульч Д.Б-д "Хаалттай сануулах шийтгэл" оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн браимтгүй хянан шийдвэрлэж ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Өмгөөлөгч А.З-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Х.Батсүрэн даргалж, гишүүн Г.Есөн-Эрдэнэ, Ш.Сүхбат, М.Алдар, Д.Мөнгөнцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, сахилгын шинжээч Б.Эрдэнэсүрэн, хариуцагч А.З, гомдол гаргагч Ж.О, гомдол гаргагч Ж.О өмгөөлөгч н.Б, гэрч н.А, нарийн бичгийн дарга А.Хулан нарыг оролцуулан, иргэн Ж.О “2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “The BNN” халуун тогооны рестораны ViP өрөөнд өмгөөлөгч А.З шүүхийн 2-3 ажилтан, Б.Г нарын хамт улсын иргэн Н.Ё болон нэр бүхий бусад 5 хүмүүсийн хамт хоол идээд сууж байхад нь “шүүхийн мэдэгдэх хуудас”-г иргэн Ж.О-т гардуулах үйлдэл хийж өмгөөлөгчийн чиг үүрэгт хамааралгүй, гуравдагч этгээдэд хүндрэл учруулсан” гэх гомдлыг хянасан Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн МД16-008 дугаартай дүгнэлтийн дагуу Монголын Хуульчдын Холбооны хуралдааны танхимд нээлттэй хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Ж.О гомдол, тайлбартаа: Б.Н болон түүний өмгөөлөгч А.З нар нь улсын иргэнд иргэний хэрэг үүсгүүлж, ажиллагаа хийлгүүлэхийн тулд хаа хамаагүй гэрээнд орчуулагч хийсэн намайг хамтран хариуцагчаар татаж, нэг этгээдэд нь нэхэмжлэлийн хувийг гардуулснаар иргэний хэрэг үүсгүүлж чадсан. Улмаар миний бие энэ нэг жилийн хугацаанд эд хөрөнгө, сэтгэл санаа, цаг хугацаагаар ихээхэн хохирсон. Улмаар тус шүүхийн 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 102/ШШ2016/01972 дугаар шийдвэрээр Ж.О намайг хариуцагч биш гээд Н. Ё оршин суух хаяг тодорхойгүй гэдэг үндэслэлээр энэхүү иргэний хэрэг нь дуусгавар болсон. Гэтэл А.Зүмбэрэл нь дахин 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр.... дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “The BNN” халуун тогооны ресторанд Япон улсын иргэн Н 2017 оны 02 дугаар сарын 02 өдөр Ё, Ж.О миний бие болон нэр бүхий бусад 5-аад хүмүүс хоол идээд сууж байхад хуучнаар,, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 3-4 ажилтантай хамт ViP өрөөнд орж ирэн шүүхийн мэдэгдэх хуудсыг гардуулах гэсэн... эхлээд ганцаараа өмгөөлөгч А.З нь 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн огноотой “Шүүхийн мэдэгдэх хуудас” гэх Э.А шүүгчийн гарын үсэг бүхий /Э.А шүүгчийн албан ёсны гарын үсгээс тэс ондоо дуурайлган зурсан байсан/ мэдэгдэх хуудсыг өгчулсын иргэн Н.Ёд гардуулах гэж оролдсон. Улмаар энэ хүнтэй бид ойлголцож чадахгүй байна, энэ хүн бидний энэ бичгийн утгыг ойлгохгүй байна гээд намайг орчуулга хийхийг шаардсан. Миний бие тухайн 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөр огноолсон бичгийг хараад энэ бичгийн хугацаа өнгөрчихсөн байна

ш дээ гэхэд төд удалгүй гарч орж ирээд 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 09 цагт ир гэсэн байна гэтэл өнөөдөр 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн ажлын цаг дуусч байна яаж ийм мэдэгдэх хуудас гардуулах гээд байгаан гэхэд хэрэг 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдөр үүссэн “та нарыг дуудаад байхад ирэхгүй байсаар байгаад энэ мэдэгдэх хуудасны хугацаа дуусчлаа” гэсэн саяхан энэ хэргийн давж заалдах хурал болж дууссан та нар дахиад хэзээ завандаа нэхэмжлэл гаргачихваа гэхэд 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдөр нэхэмжлэл гаргасан гэсэн бөгөөд нэхэмжлэл өгсөн өдөр иргэний хэрэг үүсгэсэн юм уу? гэхэд тийм гэсэн. Миний бие наад хугацаа дууссан мэдэгдэх хуудсыг авахгүй гэхэд 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөр огноолсон бичгийг сольж 10 минутын дараа Б овогтой П гэх бичиг хүргэгчийн үнэмлэхтэй хүн орж ирсэн. Миний бие энэ “Э.А шүүгчээр ийм хурдан гарын үсгийг нь зуруулчиж байгаа юм уу” гэхэд тийм гээд дахин 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөр огноолсон мэдэгдэх хуудсыг дахин гардуулах гэж оролдсон. Та нар яаж биднийг энд хоол идэж байгааг мэдэж байгаа юм бэ? гэхэд энэхүн рүү залгасан гэсэн бөгөөд ямар дугаар луу залгасан бэ? гэхэд хэлэхгүй байсан. Миний бие энэхүү дахин үүсгэгдсэн гэх хэргийг Баянгол дүүргийн шүүхээс лавлахад Э.А шүүгч нь тус иргэний хэргийг үүсгээгүй “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан” захирамжийг гаргасан байсан. Тэгэхээр А.З нь өмгөөлөгч атлаа шүүхийн ажилчидтай хамтран нэхэмжлэлийг гардуулах гэсэн бөгөөд Э.А шүүгчийн гарын үсгийг дурайлгасан мэдэгдэх хуудсыг гардуулах гэж оролдсон бөгөөд “Иргэний хэрэг үүсгэгдээгүй” байхад иргэний хэрэг үүсгэсэн мэт ярьж, хариуцагчаар оролцох мэдэгдэх хуудсыг гардуулах гэж оролдсон “хуульчийн ёс зүйн дүрэм” дээрх хэд хэдэн заалтуудыг ноцтой зөрчсөн байх тул хуульч А.З-н энэхүү үйлдлийг шалгаж арга хэмжээ авч өгнө үү” гэжээ. /5-7 хуудас/

Хариуцагч А.З нь тайлбартаа: “Миний бие өмгөөлөгч А.З нь 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Б.Н-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсаар өдий хүрлээ. 3 өрөө орон сууцны өмчлөгчөөр Б.Н тогтоож, Улсын бүртгэлийн газарт өмчлөгчөөр бүртгэхийг даалгаж өгнө үү гэсэн үндэслэлээр нэхэмжлэл гаргасан боловч хариуцагч Н.Ё нь өнөөдрийг хүртэл олдохгүй, шүүхээс улсын дээд шүүхэд даалгавар явуулсан боловч биелэгдэж ирдэггүй, Монголд ирэхэд нь уулзах, шүүхэд дуудаж байгаа талаар нь хэлэхэд шүүхийг илтэд үл хүндэтгээд очдоггүй, шүүхийн зарлан дуудах хуудсыг гардан авдаггүй байдлаас шалтгаалан шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй нөхцөл байдал үүсч, улмаар Монгол Улсын иргэн Б.Н хууль ёсны эрх, ашиг сонирхол ноцтойгоор зөрчигдөж, орох оронгүй болох нөхцөл байдал үүсч байна. Энэ талаар Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч Б.М хариуцагчийн эрэн сурвалжлах тухай шүүхийн захирамж гарч Тахарын Ерөнхий газар шүүхийн захирамжийн дагуу даалгавар гүйцэтгэж байгаа болно. 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс хойш 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдөр хүртэл Монголд орж ирэхгүй, оршин суух хаяг нь тодорхойгүй хариуцагч Н.Ё нь 2016 оны 5 дугаар сарын эхээр нэхэмжлэгчийн охин Б.Х нэг онгоцоор ирсэн талаар мэдэгдэхэд давж заалдах журмаар хянагдсан 2015 оны 3 дугаар сард нэхэмжлэл гаргасан иргэний хэргийн магадлал гардан аваад хяналтын журмаар гомдол гаргах нь цаг хугацаа

алдах нөхцөл байдал үүссэнээс шинээр шүүхэд дахин нэхэмжлэл гаргасан. Дээрх нэхэмжлэлтэй холбоотой хилийн хориг тавиулах хүсэлтийг шүүхэд гаргасан боловч хангаагүй. Улмаар нэхэмжлэгчийн зүгээс Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах халуун хоолны ресторанд хоол идэж байна гэснээр шүүгчийн туслахад мэдэгдэхэд бичиг хүргэгчээ хамт явуулсан. Дээрх ресторанд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, шүүхийн бичиг хүргэгч хамт явсан бөгөөдулсын иргэн Н.Ё шүүхийн бичиг хүргэгчид зааж өгөхөд орчуулагч н.О , н.Анар нь хоол идэж байна, хүлээж бай гэсэн. Улмаар гадаа нь хүлээж байхад өмгөөлөгч нь ороод ир гээд ярилцсан. Өмгөөлөгч А.З нь миний бие Хан-Уул, Баянгол, Баянзүрх дүүргийн шүүхэд бичиг хүргэгч, шүүгчийн туслах, ерөнхий шүүгчийн туслахаар ажиллаж байгаад өмгөөлөгчөөр ажиллах болсон нь ажил мэргэжилээ чөлөөтэй сонгох үндсэн хуулиар олгогдсон эрх юм. Гэтэл гомдол гаргагч намайг дээрх шүүхэд ажиллаж байсан гэх бөгөөд шүүхийн ажилтнуудтай хамтран хууль бус үйлдэл хийж байна гэж миний ажил хэргийн нэр хүндэд ноцтой халдаж байна. Түүнчлэн гомдол гаргагчийн шүүгчийн гарын үсгийг дуурайлган зурсан, он, сар өөрчлөгдсөн мэдэгдэх хуудас байсан талаар миний мэдэх асуудал биш тул шүүхээс нь тодруулж өгөхөөс гадна үл хөдлөх хөрөнгийн газраас маргаан бүхий орон сууцыг шилжүүлсэн талаарх баримт, хуучнаар дүүргийн Иргэний хэргийндугаар шүүхээс хэрэгсэхгүй болгосон хэргийн материалыг, Хан-Уул дүүргийн шүүхээс хариуцагчийн эрэн сурвалжилсан захирамж,дүүргийн цагдаагийн хэлтэст гаргасан өргөдөл /хэрхэн шийдвэрлэсэн нь тодорхой байна/ зэргийг нотлох баримтын шаардлага гаргуулан авч гомдлыг үнэн зөв, шударгаар шийдвэрлэж, үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хуульд заасан арга хэлбэрүүдээр хамгаалах боломжоор хангаж, өмгөөлөгчийн ажил хэргийн нэр хүндэд халдсан үйлдлийг таслан зогсоож өгнө үү” гэжээ. /21-22 хуудас/

Гэрч Л.А тайлбартаа: “Л.А миний бие өөрийн ажилладаг “Ниш” ХХК-ийн захирал Н.Ё-тай 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр халуун тогоонд олон хүмүүстэй оройн хоол идэж сууж байтал Баянгол дүүргийн шүүхээс гэсэн хэсэг бүлэг хүмүүстэй хамт өмгөөлөгч А.З гэх хүн орж ирсэн. Ийнхүү гэв гэнэт олон хүмүүс орж ирсэнд гайхаж, юун хүмүүс бэ гэсэн чинь шүүхийн мэдэгдэх хуудас гардуулах гэсэн юм гэж тайлбарлацгаасан. Тэгэхээр нь би “бид хоол ундаа идэж байнаа та нар гарч байхгүй юу” гэсний дагуу бүгдээрээ гарч явсан бөгөөд хэдэн хормын дараа өмгөөлөгч А.З нь шүүхийн мэдэгдэх хуудас бариад орж ирсэн. Орж ирэнгүүтээ “орчуулга хий, энэ мэдэгдэх хуудсыг гардаж ав” хэмээн тулгаж эхэлсэн. Ж.О зүгээс та нар өөрсдөө эрх бүхий байгууллагаас явж байгаа бол орчуулагч юм уу эсхүл энэ бичиг баримтаа тухайн улсын хэл дээр өөрсдөө орчуулсан байх ёстой биздээ би орчуулга хийж чадахгүй, өмнө нь орчуулга хийснийхээ төлөө бүтэн 1 жил шүүхээр “хариуцагч” болж явсан” гээд орчуулга хийхээс татгалзсан. Гэтэл А.З нь 2016.05.10-ны өдөр ийнхүү хоол идэж байхад орж ирсэн атлаа 2016.05.05-ны өдрөөр огноолсон, хугацаа нь өнгөрсөн мэдэгдэх хуудсыг гардуулах гэж байсан. Энэ мэтээр уг мэдэгдэх хуудсыг гардаж авах боломжгүй, энэ хүн наад бичгийг чинь ойлгохгүй байна гэхэд “мэдэгдэх хуудсыг гардаж авахгүй бол цагдаа дуудаад, баривчлуулна шүү” гэх мэтээр айлгаж эхэлсэн. Тухайн үед хамт хоол идэж байсан хүмүүс энэхүү өмгөөлөгч хүний үйлдлийг хараад Япон улсын иргэн Н. Ё болон ажилчин биднийг буруугаар ойлгох,

гэмт хэрэгтэн мэтээр ойлгох нөхцлийг бүрдүүлж, хүмүүсийн дунд хэцүү байдалд оруулсан. Ийнхүү он, сар, өдөр нь өнгөрсөн бичгээ дахин авч орж ирэхдээ бичиг хүргэгч гэх өөр охинтой орж ирсэн бөгөөд тус бичиг дээрх шүүхэд хүрэлцэн ирэх “цаг нь өнгөрсөн” буюу 2016.05.10- ны өдрийн өглөөний 09 цагт хүрэлцэн ирэх утгатай бичиг байсан. Мөн бидний зүгээс энэхүү үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан бөгөөд та нар энэ шүүгч гэсэн хүний гарын үсгийг ямар хурдан зуруулаад энэ бичгээ өөрчлөөд авиад ирвээ гэсэн чинь “юу ч хэлж чадахгүй” байсан. Энэ мэтээр А.З гэдэг хүнийг шүүхийн ажилтан юм уу өмгөөлөгч юм уу гэдгийг ойлгоход хүндрэлтэй бөгөөд жирийн иргэн хүмүүсийг дарамт шахалтанд оруулж, ёс зүйгүй муухай харьцаж, бусдын өмнө буруугаар ойлгуулах нөхцөл байдлыг бүрдүүлсэн зэрэгт гомдолтой явдаг” гэжээ. /85-86 хуудас/

Гэрч Б.Г мэдүүлэхдээ: “2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр... дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Тие ВиИ” халуун тогооны ресторанд... улсын иргэн Н. Ё нь хоол идэхээр орж байхыг миний төрсөн эгч Б.Х харсан байдаг. Энэ үед эгч надад утсаар хэлэхээр нь би өөрийн өмгөөлөгч А.З мөн утсаар хэлж хоёр талаасаа тухайн “Тие ВиИ” халуун тогооны ресторанд очсон. Намайг очиход өмгөөлөгч А.З нь БГД-н Иргэний хэргийн шүүхийн туслах ажилтан /нэрийг нь мэдэхгүй/ гэх эмэгтэй хүнтэй хамт хоёулаа зогсож байсан. Тэр үед А.З Н. Ё зүс танихгүй учраас миний бие хамт дотогш орж энэ хүн байгаа юмаа гэж зааж өгсөн. Дотогшоо орох үед шүүхийн туслах ажлын байр нь ойрхон байсан учраас шүүгчид бичиг оруулж өгчихөөд ирье гэж хэлээд явчихсан байсан учраас өмгөөлөгч А.З бид хоёр дотогшоо орсон. Би Н. Ё өмгөөлөгч А.З зааж өгчихөөд хамт эргэж гарсан. Гараад удаагүй байж байтал зөөгч гарч ирээд саяны хүнийг дуудаж байна гэхээр нь өмгөөлөгч А.З ганцаараа орсон. Дотор ямар асуудал болсон, юу ярьсан талаар мэдэхгүй. Шүүгчийн туслах нь ирж 2016.05.05-ны өдрийн Шүүхийн мэдэгдэх хуудас танилцуулж гарын үсэг зуруулахаар дотогшоо өгөхөөр орсон боловч О нь өмгөөлөгч байхгүй байна хүлээж авахгүй гэж хэлээд буцаасан байсан. Өөр асуудал болоогүй гарч ирээд явцгаасан” гэжээ. /18-19 хуудас/

Мэргэжлийн Хариуцлагын Хорооны сахилгын шинжээч 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн МД16-008 дугаартай дүгнэлтдээ: 1. Хариуцагч А.З нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “хуульчийн үнэнч шударга, итгэл, даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх...”, 27.1.6-д “шүүгч болон шүүхийн ажилтныг шүүхийн хууль тогтоомжийг санаатайгаар зөрчихөд хүргэх, туслах”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дүгээр зүйлийн 2-т “...эсрэг тал эрхээ хамгаалахад саад учруулах, залхаах”, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д “...бусад материалыг хууль бусаар өөрчлөх...эсхүл ийм үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвтгөх, туслах”, 5.2 дугаар зүйлийн 1-д “Хуульч нь өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг этгээдтэй түүний хуульчийг байлцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой асуудлаар харилцахыг хориглоно”, 5.4 дүгээр зүйлийн 1-д “хуульч нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, ...хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч А.З-н үйлдлийг Хуульчийн

Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзжээ. /х 100- 104 хуудас/

Тус маргаантай холбоотойгоор маргааны материалд авагдсан гомдол гаргагч болон хариуцагчаас Мэргэжлийн хариуцлагын хорооны Сахилгын шинжээчид өгсөн тайлбарууд, хариуцагчийн бичгээр гаргасан тайлбар, зэрэг баримтуудыг шинжлэн судлаад

ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн Ж.О “2016 оны 5 дугаар сарын 10-ны өдөр өмгөөлөгч А.З нь Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 3-4 ажилтантай хамт ...дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “The ВиП” халуун тогооны ресторанд VIP өрөөнд хооллож байсан ...улсын иргэн Н.Ё-д 2016 оны 5 дугаар сарын 05, 5 дугаар сарын 10-ны өдрийн огноотой “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг хуудсыг гардуулах гэсэн... Улмаар энэ хүнтэй бид ойлголцож чадахгүй байна, энэ хүн бидний энэ бичгийн үсгийг ойлгохгүй байна гээд намайг орчуулга хийхийг шаардсан. Иймд “хуульчийн ёс зүйн дүрэм” дээрх хэд хэдэн заалтуудыг ноцтой зөрчсөн байх тул хуульч А.З-н энэхүү үйлдлийг шалгаж арга хэмжээ авч өгнө үү” гэж гомдол гаргажээ.

Дээрх гомдлын дагуу Мэргэжлийн Хариуцлагын Хорооны сахилгын шинжээч 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн МД16-008 дугаартай: 1. Хариуцагч А.З нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “хуульчийн үнэнч шударга, итгэл, даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх...”, 27.1.6-д “шүүгч болон шүүхийн ажилтныг шүүхийн хууль тогтоомжийг санаатайгаар зөрчихөд хүргэх, туслах”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дүгээр зүйлийн 2-т “...эсрэг тал эрхээ хамгаалахад саад учруулах, залхаах”, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д “...бусад материалыг хууль бусаар өөрчлөх...эсхүл ийм үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвтгөх, туслах”, 5.2 дугаар зүйлийн 1-д “Хуульч нь өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг этгээдтэй түүний хуульчийг байлцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой асуудлаар харилцахыг хориглоно”, 5.4 дүгээр зүйлийн 1-д “хуульч нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, ...хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч А.З-н үйлдлийг Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэх дүгнэлт гаргажээ. /х 100-104 хуудас/

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн дүгнэлтэд дурдсан “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “хуульчийн үнэнч шударга, итгэл, даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх...”, 27.1.6-д “шүүгч болон шүүхийн ажилтныг шүүхийн хууль тогтоомжийг санаатайгаар зөрчихөд хүргэх, туслах”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дүгээр зүйлийн 2- т “...эсрэг тал эрхээ

хамгаалахад саад учруулах, залхаах”, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д “...бусад материалыг хууль бусаар өөрчлөх...эсхүл ийм үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвлөх, туслах”, 5.2 дугаар зүйлийн 1-д “Хуульч нь өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг этгээдтэй түүний хуульчийг байлцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой асуудлаар харилцахыг хориглоно” гэх хариуцагч А.З-д огт хамааралгүй үндэслэлээр дүгнэлт гаргажээ.

Өөрөөр хэлбэл хариуцагч А.З нь өөрийн үйлчлүүлэгч Б.Н-тэй байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлж байсан ба шүүхэд оршин суух хаяггүй гэх хариуцагч..... улсын иргэн Н.Ё-д мэдэгдэх хуудас гардуулахад тусласан түүний үйлдлийг буруутгах үндэслэлгүй байна. Харин шүүхийн бичиг хүргэгч нар мэдэгдэх хуудсыг хүргэхдээ тухайн гадаад иргэний мэддэг хэл дээр орчуулга хийх болон өөрсдийн орчуулагчаар тайлбарлан өгөх байсан ба өмгөөлөгч А.З нь иргэн Ж.О-ийг хэлмэрчилж өгөхийг шаардсан нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 5.4 дүгээр зүйлийн 1-д “хуульч нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, ...хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн нь маргааны материал болон талуудын тайлбараар тогтоогдож байна.

Маргааны материалд авагдсан, хуралдааны явцад шинжлэн судлагдсан баримтуудаар хуульч, өмгөөлөгч А.З-ийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 27.1.1, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 5.4 дүгээр зүйлийн 1-д заасныг тус тус зөрчсөн гэм буруутайд тооцож, түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй байна.

Учир нь: Бүрэлдэхүүн тухайн маргааныг хянан шийдвэрлэхдээ шүүхийн ажилтан ажил үүргийн болон хэргийн хөдөлгөөний стандартад заагдсан ажпаа хийхдээ алдаа гаргасан, хариуцагч А.З нь ялимгүй зөрчил анх удаа гаргаснаас гадна Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журамд “хаалттай сануулах” шийтгэлийг хуралдаанаас авч болохгүй гэж заагаагүй байна.

Өмгөөлөгч А.З нь Монголын Хуульчдын холбооны Маргаан хянан шийдвэрлэх журам"-ын 1.4-д заасан хариуцагчаар оролцох этгээд мөн бөгөөд маргааныг иргэн Ж.О болон Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн МД16-008 дугаартай дүгнэлтийн хүрээнд шийдвэрлэсэн болно.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Өмгөөлөгч А.З-ийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 27.1.1, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 5.4 дүгээр зүйлийн 1-д заасныг тус тус зөрчсөнд тооцож, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар “Хаалттай сануулах шийтгэл” ногдуулсугай.

2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тогтоогдоогүй, эд мөрийн баримтаар 2 ширхэг дүрс бичлэгийн хуурцаг авагдсаныг тус тус дурдсугай.
3. Тогтоолыг эс зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцопт тэдгээрийг төлөөлөгч Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 02

Дугаар 06

Улаанбаатар хот

Хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх гуравдугаар бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Х.Б даргалж, М.А, Г.Е, Ш.С, Д.М нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж, сахилгын шинжээчээс хариуцагч, өмгөөлөгч Д.Э-т “хаалттай сануулах” сахилгын шийтгэл оногдуулах санал гаргасан маргааныг хорооны хуралдааны танхимд хянаж зөвлөлдөөд

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Иргэн Н.Ө-ээс: “...2016 оны 12 дугаар сарын 03-ны өдөр өмгөөлөгч Д.Э-тай “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г байгуулж, өөрийн нөхөр Д.Б эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа авахаар харилцан тохиролцож, өмгөөллийн хөлсөнд 2,000,000 төгрөгийг төлсөн. Гэтэл өмгөөлөгч Д.Э өмгөөллийн гэрээ байгуулж, төлбөр авсан атлаа хууль зүйн туслалцааг үзүүлээгүй тул энэ хүнийг олж өгч асуудлыг шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Өмгөөлөгч Д.Э Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбартаа: “... Н.Ө нөхрийн холбогдсон эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэхээр гэрээ байгуулж, төлбөрт 2,000,000 төгрөг авсан нь үнэн. Би архи уугаад эрүүл мэндийн байдал муудаж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс “Донтох эмгэг судлалын клиник”-т хэвтэн эмчлүүлж байгаа бөгөөд тухайн асуудалд гэмшиж байна. Энэ байдлыг харгалзан үзэж “хаалттай сануулах” сахилгын арга хэмжээ авч өгөхийг хүсье” гэжээ.

Сахилгын шинжээчийн 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар саналаар “Өмгөөлөгч Д.Э-т сахилгын хаалттай сануулах” шийтгэл оногдуулах саналыг гаргасан байна.

Сахилгын шинжээчийн цуглуулсан баримт сэлтийг бүрэлдэхүүн хянаад

ҮНДЭСЛЭХ НЬ:

Хариуцагч, өмгөөлөгч Д.Э нь 2016 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г иргэн Н.Ө-тэй байгуулж, түүний нөхөр Д.Б холбогдсон Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлд заасан эрүүгийн хэргийн мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн шатанд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр харилцан тохиролцон, 2,000,000 төгрөг авсан боловч үйлчилгээ үзүүлээгүй болох нь тогтоогдсон, энэ нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1,7-д “Хуульч мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана” гэснийг зөрчсөн байна.

Өмгөөлөгч Д.Э нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч

гэмшижбайгаагаа илэрхийлсэн тул сахилгын шинжээчийн саналыг үндэслэлтэй гэж үзэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 3.6 дугаар зүйлийн 1, 10.11 дүгээр зүйлийн 4, 14.4, 14.5, 14,6 дугаар зүйлүүдийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн хариуцагч, өмгөөлөгч Д.Э “хаалттай сануулах” сахилгын шийтгэл оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
3. Тогтоолыг хариуцагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Хариуцагч Ж.Х-д холбогдох маргааны тухай

Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.Д зөрчил шалгуулах тухай 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 1/80 дугаартай албан бичигт: “ ... Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Ж.Х нь ... шүүх хуралдааны товыг мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх тодорхой шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулж, Г.Г-т холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд саад учраад байна. ... Иймд өмгөөлөгч Ж.Х-н шүүх, хэргийн оролцогчдыг үл хүндэтгэн шүүх хуралдаанд ирээгүйгээс шүүх хуралдаан хойшилж, хэргийн бусад оролцогчдыг чирэгдүүлж байгаа асуудлыг нь ёс зүйн зөрчилд тооцуулахаар холбогдох баримтыг хүргүүлэв” гэжээ. /ММ-н 4-р хуудас/

2017 оны 1 дүгээр сарын 5, 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн ...эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны товыг мэдэгдсэн тухай баримт, /ММ-н 5-6-р хуудас/,

...эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн шүүх хуралдааныг хойшлуулах тухай 4 дүгээр тогтоолд: “Г.Г-т холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдаан 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 9 цагт болох талаар шүүгдэгч Г.Г-н өмгөөлөгч Ж.Х-д 2017 оны 1 дүгээр сарын 5, 11, 12-ны өдрүүдэд тус тус мэдэгдсэн боловч тус шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй байна... Г.Г-т холбогдох эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл хойшлуулсугай” гэжээ. /ММ-ын 8-р хуудас/

Хариуцагч Ж.Х тус хороонд өгсөн тайлбартаа: “... миний эгч хөдөө орон нутагт нас барж ажил явдлыг гүйцэтгэхээр байж байтал.....шүүхийн н.Ц гэгч туслах 1-р сарын 11-ний өдөр маргааш хуралтай гэж зарлахад миний бие оршуулгын ажилтай тул очих боломжгүй гэдгээ утсаар мэдэгдсэн бөгөөд Тээврийн прокурор н.О-д мөн хэлсэн юм. Уг давах шатны хурал нь прокурорын эсэргүүцэл бичсэн хурал байсан бөгөөд прокурор өөрөө эсэргүүцлээ тайлбарлаж яриад хурлыг хийх боломжтой байсан гэж үзэж байна. ... өмгөөлөгч шалтгаангүйгээр хурал хойшлуулсан мэтээр ойлгож бидний ажлыг хүндрүүлж байгаа нь зохисгүй гэж үзэж байна” гэжээ. /ММ-н 9-р хуудас/

Хариуцагч Ж.Х тус хороонд ирүүлсэн хүсэлтдээ: “МХХ-ний гишүүн өмгөөлөгч Ж.Х миний бие Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд товлогдсон 2017.1.12-ны өдрийн Г.Г-т холбогдох шүүх хуралд ажил /буяны/ гарсан учир оролцоогүй болно. 2017.1.5-ны товыг мэдсэн боловч холбогдох баримт хүсэлтийг

шүүхэд хүргүүлээгүйгээ хүлээн зөвшөөрч гэмшиж байгаа тул хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэжээ. /ММ-н 10-р хуудас/

Тээврийн прокурорын газрын хяналтын прокурор н.Ц.-ээс тус хороонд гаргасан тайлбарт: “... яллагдагч Г.Г холбогдох эрүүгийн 201624000759 дугаартай хэргийг нэмэлт мөрлөн байцаалтанд буцаасныг эс зөвшөөрч прокурорын эсэргүүцэл бичсэн билээ. ... Эсэргүүцлийг хэлэлцэх давж заалдах шатны шүүх хурал 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 5 дахь хурал болон товлон зарлагдсан юм. Миний бие 3 дахь хурал орж байхад ... давж заалдах шатны шүүхэд очсон бөгөөд энэ үед яллагдагч Г.Г-н өмгөөлөгч Ж.Х миний утас руу залгаж “...надад ажил явдал гарсан тул шүүх хуралд очиж чадахгүй боллоо” гэдгийг хэлсэн ба уг хурал яллагдагчийн өмгөөлөгч ирээгүй шалтгаанаар хойшилсон болно” гэх тайлбар /ММ-ын 14-р хуудас/

Шүүгчийн туслах н.Ц тус хороонд гаргасан тайлбартаа: “...өмгөөлөгч Ж.Х-д 2017 оны 1 дүгээр сарын 5, 11, 12-ны өдрүүдэд тус тус шүүх хуралдааны тов мэдэгдсэн болно. 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр өмгөөлөгч Ж.Х-н дугаарын утсанд шүүх хуралдааны тов мэдэгдэж, ирж байгаа эсэхийг асуухад “...ажил явдал гарсан, хөдөө явж байна. Намайг оролцуулахгүйгээр шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ үү гэсэн” гэжээ. /ММ-ын 12-р хуудас/

Маргааны материалд цугларсан баримтуудыг хэлэлцээд

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс “Хариуцагч Ж.Х нь бичиг, үсэг мэдэхгүй шүүгдэгч Г.Г-н өмгөөлөгчөөр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байхдааэрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй, холбогдох баримт, хүсэлтээ шүүхэд хүргүүлээгүйгээс шүүх хурал хойшлогдсон гэсэн үндэслэлээр түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах” санал гаргасан ба хариуцагч Ж.Х “....эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд товлогдсон 2017.1.12-ны өдрийн Г.Г-т холбогдох шүүх хуралд /буяны ажил/ гарсан учир оролцоогүй болно. 2017.1.5-ны товыг мэдсэн боловч холбогдох баримт хүсэлтийг шүүхэд хүргүүлээгүйгээ хүлээн зөвшөөрч гэмшиж байгаа тул хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэж тайлбарласан байна.

Өмгөөлөгч Ж.Х нь эрүүгийн хэргийн яллагдагч болох Г.Г-ийн өмгөөлөгчөөр ажиллаж байхдаа.... эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр товлогдсон шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй, холбогдох баримт, хүсэлтээ шүүхэд хүргүүлээгүй болох нь.....эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.Д-ийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 1/80 дугаартай зөрчил шалгуулах тухай албан бичиг, 2017 оны 1 дүгээр сарын 5, 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн... эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны товыг мэдэгдсэн тухай баримт,... эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн шүүх хуралдааныг хойшлуулах тухай 4 дүгээр тогтоол, хариуцагч Ж.Х-н 2017

оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан хүсэлт зэрэг нотлох баримтуудаар тус тус нотлогдож байна.

Хариуцагч Ж.Х өөрийн эгчийн буяны ажилд оролцох болсон шалтгаанаа шүүхэд огт мэдэгдээгүй үйлдэл нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байна.

Ж.Х Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн байх тул хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай сахилгын шинжээчийн саналыг үндэслэлтэй байна гэж дүгнэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт тус тус зааснаар Ж.Х хаалттай сануулах шийтгэл оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
3. Тогтоолыг хариуцагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 31

Дугаар 12

Улаанбаатар хот

Өмгөөлөгч С.Б холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх тавдугаар бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Ш.Одонсүрэн даргалж, гишүүн Д.Байгалмаа, Н.Одонтуул, Б.Сугар, Д.Цэндсүрэн нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны 402 тоот хуралдааны танхимд сахилгын шинжээч Б.Э, хариуцагч С.Б, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Б, хуралдааны нарийн бичгийн дарга А.Х нарыг оролцуулан хийж, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Д 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн МД17/003 дугаартай дүгнэлттэйовгийн С.Б холбогдох "иргэн С.Ү хууль зүйн туслалцаа үзүүлэх явцдаа хариуцагч Г.О-тай эвлэрлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгоогүй байхад эвлэрлийн гэрээ байгуулан 5.000.000 төгрөг авсан атлаа үйлчлүүлэгч С.Ү өгөөгүй" гэх гомдлыг хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

С.Ү итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Б тус хороонд гаргасан гомдолдоо: "Юу Би Би Ди" брокер диллерийн ХХК-ийн захирал Г.О нь өөрийн танил болох үйлчлүүлэгч Монгол Улсын иргэн С.Ү компаний хувьцаа авч өгье, их ашигтай байгаа" гэж хуулийн болон хувьцааны талаар мэдлэггүйг нь шалтаглан ятгаж итгүүлсний үндсэн дээр 93,000,000 төгрөг шилжүүлэн авч залилсан хэрэгт хууль зүйн туслалцаа авах зорилгоор Монголын Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч С.Б 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж С.Б 3,000,000 төгрөгийг урьдчилгаа болгож өгсөн байдаг. Мөн С.Б эвлэрэх эрхгүйгээр итгэмжлэл олгосон байдаг. Гэтэл өмгөөлөгч С.Б нь Г.О эрүүгийн хэрэг үүсгүүлж, мөрдөн байцаалтын шатанд хэрэг шалгагдаж байхад үйлчлүүлэгч С.Ү зөвшөөрөлгүйгээр Г.О эвлэрч, гэрээгээ болон эвлэрэх эрх олгогдоогүй итгэмжлэлийг үндэслэн түүнээс хохирлын 93,000,000 төгрөгийн урьдчилгаанд төлсөн 10,000,000 төгрөгийг Чингэлтэй дүүргийн цагдаа дээр мөрдөн байцаалтын шатанд, 2,000,000 төгрөгийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын гадаа, 3,000,000 төгрөгийг эвлэрлийн гэрээ байгуулах үед бэлнээр тус тус авч нийтдээ 15,000,000 төгрөгийг Г.О-аас С.Ү төлөөлж аваад үлдсэн 78,000,000 төгрөгөнд нь иргэний журмаар эвлэрлийн гэрээ зөвшөөрөлгүйгээр байгуулж, үйлчлүүлэгчдээ нэг ч төгрөг өгөөгүй байна" гэжээ. /ММ-н 3-5-р хуудас/

С.Ү тус хороонд гаргасан тайлбартаа: "миний бие өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч Ж.Б-р дамжуулан 2016 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд хуульч, өмгөөлөгч С.Б мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан гомдол гаргасан юм.

...Г.О-д залилуулсан болохоо ойлгож хуулийн байгууллагад хандахаар шийдэн энэхүү хэрэгт эрүүгийн хэрэг үүсгүүлж, хууль зүйн туслалцаа авах зорилгоор өмгөөлөгч С.Б-тай 2015 оны 03 дугаар сарын 6-ны өдөр Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж С.Б-т 3,000,000 төгрөгийг урьдчилгаа болгож өгсөн. Мөн С.Б-нь эд мөнгө хүлээж авахгүй, эвлэрэх эрхгүйгээр итгэмжлэл олгосон. Ингээд өмгөөлөгч С.Б нь Г.О эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр Чингэлтэй дүүргийн цагдаагийн газарт гомдол гаргаж, прокуророос эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан хэмээн надад хэлсэн. Миний хувьд наад шийдвэрийг чинь хүлээн зөвшөөрөхгүй дараагийн шатны прокурорын байгууллагад гомдол гаргахаар өмгөөлөгч С.Б хэлсэн боловч өөрийн үйлчлүүлэгч болох миний зөвшөөрөлгүйгээр Иргэний хэргийн шүүхэд намайг төлөөлөн нэхэмжлэл гаргаж, улмаар Г.О эвлэрч, гэрээгээ болон эвлэрэх эрх олгогдоогүй итгэмжлэлийг үндэслэн тэр үеийн долларын ханшаар ойролцоогоор 93,000,000 төгрөгөнд тохиролцсон байсан. Ингээд өмгөөлөгч С.Б нь эргээд надтай холбогдохгүй алга болсон. Мөн Г.О алга болсон. Надтай эргэж гэрээгээ дүгнэж тайлангаа тавихгүйгээр алга болчихоор нь арга буюу шинээр өмгөөлөгч Ж.Б дамжуулан С.Б холбогдуулан гомдол гаргахад Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст тайлбар гаргахдаа С.Б нь Г.О-аас төлсөн 10,000,000 төгрөгийг Чингэлтэй дүүргийн цагдаа дээр мөрдөн байцаалтын шатанд, 2,000,000 төгрөгийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн гадаа, 3,000,000 төгрөгийг эвлэрлийн гэрээ байгуулах үед бэлнээр тус тус авч нийтдээ 15 сая төгрөгийг Г.О-аас С.Ү төлөөлж аваад үлдсэн 78,000,000 төгрөгөнд нь иргэний журмаар эвлэрлийн гэрээ байгуулж, 10,000,000 төгрөгийг нь С.Ү өөрт нь өгсөн, үлдсэн 5,000,000 төгрөгийг нь Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнийхээ үлдэгдэлд авсан хэмээн мэдүүлсэн байна. Энэ тайлбар нь ор үндэсгүй худал тайлбар бөгөөд миний нэрийг барьж төлөөлөн Г.О-аас 15 сая төгрөгийг завшсан байна. Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэс энэхүү асуудлыг гүйцэд шалган тодруулалгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан санал гаргаж, дүүргийн прокурор энэхүү хүсэлтийг хангаж шийдвэрлэсэнд иргэн миний бие гомдолтой байгаа тул дараагийн шатны прокурорт хандаад байна. Өмгөөлөгч С.Б нь өмгөөлөгч Ж.Б цагдаагийн газар би 10,000,000 төгрөгийг С.Ү өгсөн, харин 5 сая төгрөг нь надад байгаа, маргааш өгье. Харин урьдчилгаа болгон авсан 3 сая төгрөгний 1,5 сая төгрөгийг нь С.Ү буцааж өгье, би тодорхой хэмжээнд ажиллагаа хийсэн тул 1,5 сая төгрөгийг өөртөө үлдээе гэж хэлсэн байсан. Гэсэн ч одоог хүртэл утсаа салгаад алга болсон байна. Мөн С.Б нь өмгөөлөгч Ж.Б би нэг компанид хуулийн зөвлөх давхар хийдэг тэндээ 5 сая төгрөгөө хадгалсан байгаа гэсэн байсан. Иргэн миний хувьд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийн тулд өмгөөлөгч С.Б-аас хууль зүйн туслалцаа авч урьдчилгаа төлсөн боловч Г.О-аас 70,000 ам доллараа одоог хүртэл гаргуулж авч чадаагүй, мөн дундаас нь 15 сая төгрөгөө өмгөөлөгч С.Б алдаад байна. Өмгөөлөгч С.Б нь иргэн надтай байгуулсан гэрээгээ биелүүлээгүйгээр барахгүй итгэмжлэлээр олгогдоогүй эрхийг ашиглан намайг төлөөлөн хариуцагчтай эвлэрлийн гэрээ байгуулан, улмаар надад шууд өгүүлэлгүйгээр дундаас нь 15 сая төгрөг, гэрээний урьдчилгаа 3 сая төгрөг нийт 18 сая төгрөгөөр хохироосон гэмт хэрэг үйлдсэн нь тодорхой байна. Хуульч хүнд байж боломгүй ёс зүйгүй үйлдлийг хийж байгаад нь хариуцлага тооцож өгнө үү” гэжээ. /ММ-н 6-р хуудас/

С.Ү тус хороонд гаргасан нэмэлт тайлбартаа: “Миний итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Б өмгөөлөгч С.Б нь нэг удаа уулзахдаа Г.О-аас авсан 15 сая төгрөгний 10 сая төгрөгийг бэлнээр С.Ү аваачиж өгсөн, 5 сая нь бэлэн байгаа, урьдчилгаа болгон авсан 3 саяын хагас буюу 1,5 саяыг буцааж өгье, нийлээд 6,5 саяыг өнөө орой аваачаад өгье гэж хэлээд одоог хүртэл утсаа авахгүй алга болсоор байна. Миний бие 10 сая төгрөгийг миний бараг хэрэглэдэггүй банкны дансанд хийсэн болохыг сая 2017 он гарч байж ...мэдсэн. Үлдсэн миний хууль ёсны өмч болох 5 сая төгрөгийг авч үрэгдүүлж, үйлчлүүлэгчийгээ хохироож байгаа өмгөөлөгч С.Б энэхүү үйлдэлд хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэн дахин өөр иргэдийг хохироохоос сэргийлж өгнө үү” гэжээ. /ММ-н 58-р хуудас/

Хариуцагч С.Б тус хороонд өгсөн тайлбар болон маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд гаргасан тайлбартаа: “...миний үйлчлүүлэгч нь Г.О-д 70,000 ам доллар биш, монгол мөнгөөр 93,000,000 төгрөгийг Г.О-д шилжүүлсэн байсан. Энэ асуудал нь Цагдаагийн байгууллагаас шалгаад тогтоосон байгаа. ...С.Ү би өөрөө очиж авмааргүй байна. Чи миний өмгөөлөгч юм чинь очоод авчих гэхээр нь би, та бид 2-ын хооронд хийсэн итгэмжлэлд эвлэрч болохгүй, мөнгө хүлээж авч болохгүй гэж биччихсэн байгаа учраас би мөнгө төгрөгний асуудалд оролцохгүй ээ гэж хэлсэн 10 сая төгрөгийг хүлээж аваад шууд С.Ү аваачиж өгсөн. Тухайн үед С.Ү Хаан банкинд сууж байсан ба хажууд нь теллер 10.000.000 төгрөгийг нь тоолж авсан...С.Ү Г.О надтай ирээд нэг уулз гэж хэлээрэй, ер нь эвлэрчих гэж хэлсэн Г.О нь ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дээр эвлэрэх үед 5 сая төгрөг өгсөн, энэ мөнгөнөөс өмгөөллийн хөлсний үлдэгдэл 3 сая төгрөгөө авнаа, таньд одоо 2 сая төгрөгийг нь хүлээлгэж өгье гэж хэлсэн чинь С.Ү уурлаад эхэлсэн. ...Чи наад эвлэрэхдээ авсан 54 сая төгрөгөө өөрөө ав, би наад хүнээс чинь мөнгө авахгүй, наад хүнээс чинь өөр юм авах гээд байгаа юм, наад хүн чинь над руу холбогдохгүй байна гэж О хэлж байсан...Миний Хаан банкны дансанд 5 сая төгрөг бүрэн байгаа. Мөнгийг өгье гэхээр С.Ү наад мөнгө чинь хамаагүй О шоронд явуул, би наад хүнээс чинь өөр юм хүсээд байгаа юм гээд авахгүй байгаа. Тийм учраас миний дансанд мөнгө нь бүрэн байгаа” /ММ-н 13-15-р хуудас/

“...Би 5,000,000 төгрөгийг өгье гэсэн боловч С.Ү аваагүй, Г.О-д хариуцлага хүлээлгэнэ гэсэн тул надад байж байгаад би зарцуулчихсан. Одоо 2017 оны 05 дугаар сард багтаан төлж барагдуулах талаар С.Ү-тэй тохиролцсон болно. Би зөрчил гаргаагүй...” гэв.

С.Ү, С.Б нарын хооронд 2015 оны 3 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан 4/19 дугаартай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ /ММ-ийн 17-19-р хуудас/

С.Ү С.Б 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан 834 дугаартай эвлэрлийн гэрээ /ММ-н 21-р хуудас/

С.Ү-с С.Б 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдөр олгосон итгэмжлэл /ММ-н 20-р хуудас/

С.Б 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Г.О-с 10,000 төгрөг хүлээн авсан баримт /ММ-н 22-р хуудас/

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Г.Д-н дүгнэлтэнд: “Хариуцагч С.Б нь С.Ү хууль зүйн туслалцаа үзүүлэх явцдаа хариуцагч Г.О-тай эвлэрлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгоогүй байхад эвлэрлийн гэрээ байгуулан 50,000 төгрөг авсан атлаа үйлчлүүлэгч С.Ү өгөөгүй үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих...хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардпагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх ...хориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 4 “Хуульч зөвхөн үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй зөвшөөрлөөр хэрэг, маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх ажиллагааг явуулна”, 2.7 дугаар зүйлийн 1 “Хуульч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харш, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөртөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэн авахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй” гэжээ. /ММ-н 60-63-р хуудас/

С.Ү нь Г.О-тай эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан эвлэрлийн гэрээ байгуулж, уг гэрээгээ шүүхээр баталгаажуулсан гэж дүгнэн прокуророос хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолыг хэвээр үлдээсэн Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 1/333 дугаартай прокурорын тогтоол /ММ-н 47-48-р хуудас/ зэрэг баримтыг шинжлэн судлаад

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч С.Б нь Монголын Хуульчдын холбооны нэгдсэн бүртгэлийн, шүүхэд төлөөлөх эрхийн дугаарт бүртгэлтэй хуульч, өмгөөлөгч болох нь Монголын хуульчдын холбооны 2017 оны 02 дугаар сарын 07- ны өдрийн 2/147 дугаартай албан бичгээр тогтоогдож байх тул маргааны хариуцагчаар оролцох этгээд мөн болно.

Өмгөөлөгч С.Б нь иргэн С.Ү эрх ашгийг хамгаалахаар гэрээ байгуулан иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд тус тус оролцож байсан нь хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, шүүхэд төлөөлөх итгэмжлэл, гомдол гаргагч С.Ү болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Б нарын тайлбар зэрэг баримтуудаар нотлогдож байна. С.Б нь иргэний хэрэгт нэхэмжлэгчийг төлөөлж оролцохдоо хариуцагчтай эвлэрэхгүй, мөнгө, эд хөрөнгө, төлбөр тооцоо хүлээн авахгүй гэх шүүхэд төлөөлөх итгэмжлэлээр хориглосон заалтыг зөрчин, Г.О-аас хохирлын мөнгө гэж хохирогч С.Ү өгүүлсэн 15 сая төгрөгнөөс 5 сая төгрөгийг өөрийн үйлчлүүлэгч С.Ү өгөлгүй хувьдаа завшсан болох нь шүүхэд төлөөлөх итгэмжлэл, эвлэрлийн гэрээ, гомдол гаргагч, хариуцагч нарын тайлбар зэргээр нотлогдож байна.

Түүний энэ үйлдэл нь сахилгын шинжээчийн дүгнэлтэнд тусгагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих...хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардпагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх ...хориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1

дүгээр зүйлийн 4 “Хуульч зөвхөн үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй зөвшөөрлөөр хэрэг, маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх ажиллагааг явуулна”, 2.7 дугаар зүйлийн 1 “Хуульч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харш, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөртөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэн авахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэлээ.

Харин гомдол гаргагчийн С.Б-аас 5,000,000 төгрөг гаргуулж өгнө үү гэх гомдлын шаардлага нь Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүн шийдвэрлэх харъяаллын асуудал биш, Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хариуцагч хуралдаанд оролцоходоо 5,000,000 төгрөг төлөхөө зөвшөөрч байгаа боловч зөрчил гаргаагүй гэж тайлбарласан болохыг дурьдах нь зүйтэй.

Өмгөөлөгч С.Б холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлын талаарх баримт нь маргааны материалд авагдаагүй байна.

Бүрэлдэхүүн тухайн маргааныг хянан шийдвэрлэж шийтгэл ногдуулахдаа хариуцагч С.Б нь сахилгын зөрчлийг анх удаа гаргасан, хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн, гомдол гаргагч хөнгөн шийтгэл оногдуулж өгөх талаар хуралдаанд тайлбар гаргасан, хариуцагч зөрчлөө хүлээн зөвшөөрөөгүй нөхцөл байдлыг харгалзсан болно.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Өмгөөлөгч С.Б-ыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих...хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэххориглоно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 4 “Хуульч зөвхөн үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй зөвшөөрлөөр хэрэг, маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх ажиллагааг явуулна”, 2.7 дугаар зүйлийн 1 “Хуульч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харш, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөртөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэн авахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөнд тооцож, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт зааснаар “Нээлттэй сануулах” шийтгэл ногдуулсугай.
2. Ёс зүйн болон нөлөөллийн сургалтанд албадан суулгах нэмэгдэл шийтгэл ногдуулсугай.
3. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүй, эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүйг дурьдсугай.
4. Тогтоолыг Холбооны тогтмол хэвлэл цахим хуудсанд нийтлэхийг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албанд үүрэг болгосугай.

5. Тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Хариуцагч Ж.Ц-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх нэгдүгээр бүрэлдэхүүний хуралдааныг гишүүн Э.Ариунаа даргалж, гишүүн Н.Одонтуул, Т.Энхмаа, Х.Цогтсайхан, У.Солонго нарын бүрэлдэхүүнтэйгээр Монголын Хуульчдын холбооны 402 тоот хуралдааны танхимд хийж, сахилгын шинжээч Б.Э, хариуцагч Ж.Ц, хуралдааны нарийн бичгийн дарга А.Х нарыг оролцуулан, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э 2017 оны 04 сарын 17-ны өдрийн 005 дугаартай дүгнэлттэй, өмгөөлөгч Х овгийн Ж.Ц холбогдох, “үйлчлүүлэгчийнхээ эрх зүйн байдлыг дордуулсан, яллагдагчийн гэм буруутай эсэх талаар хувийн үзэл бодлоо илэрхийлсэн” гэх гомдлыг хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Б.О, М.Ө, Ц.У нар тус хороонд ирүүлсэн гомдолдоо: “Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд Б.О, Ц.У, М.Ө нарт холбогдох хэрэгт прокурорын шатанд Монголын Өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч Ж.Ц-тэй 2016 оны 6-р сард 750000 төгрөгөөр эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, бид өмгөөлөгчөөрөө авсан. М.Ө нь өмгөөлөгч Ж.Ц-тэй 2016 оны 11-р сарын 18-ны өдрийн шүүх хуралд өмгөөлүүлэхээр гэрээ байгуулсан ба шүүх хурлын өдөр хэргийг хэрэгсэхгүй болгох саналаа хэлнэ гээд өмгөөллийн хөлс 250000 төгрөг авсан. Гэтэл уг шүүх хурлын үеэр “Би худлаа өмгөөлөл үзүүлж чадахгүй, М.Ө прокуророос өгсөн 300 цагийн албадан ажил хийлгэх ялыг 240 цаг болгож өгнө үү” гэж хэлсэн нь М.Ө намайг болон биднийг гэмт хэрэг үйлдсэн болгож шууд ялласан нь Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуулийн 26-р зүйлийн 26.1.6, 38-р зүйлийн 38.1.2, Хуульчдын Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.7, 4.5 дахь хэсэгт зааснаар “Яллагдагчийн гэм буруутай эсэхэд хувийн бодлоо илэрхийлэхийг хориглоно” гэсэн заалтыг ноцтойгоор зөрчсөн...” гэжээ. /ММ-н хуудас 3/

М.Ө тус хороонд гаргасан нэмэлт тайлбартаа:

“2016 оны 11-р сарын 18-ны өдрийн шүүх хуралд өмгөөлөгч Ж.Ц хэлэхдээ “би худлаа өмгөөлөл явуулж чадахгүй” гэж хэлсэнд би туйлын их гомдолтой байгаа...” гэжээ. /ММ-н хуудас 8/

Хариуцагч Ж.Ц тус хороонд өгсөн тайлбар болон маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Би гомдол гаргагч 3 үйлчлүүлэгчийг өмгөөлж 4 удаа шүүх хуралд оролцсон. Эхний 2 хурал дээр шинжээчийн дүгнэлт гаргуулах, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах санал гаргаж шүүх хүсэлтийг хүлээн авсан.

... Үйлчлүүлэгчийн зүгээс хэргийг хэрэгсэхгүй болгож чадна гэсэн амлалтыг надаас авах оролдлого хийж гэрээг зөрчиж байсан. Сүүлийн хурлын хувьд шүүгдэгчийн гэм буруугүйг нотлох, цагаатгах талын нотлох баримт хавтаст хэргийн хүрээнд бүрдэж ирээгүй тул прокурорын шүүхэд тавьсан 300 цагийн албадан ажил хийлгэх ялыг багасган 240 цаг болгох чиглэлээр өмгөөлөл явуулсан нь үнэн. Өмгөөллийн хөлсөнд энэ хүмүүсээс 1 000 000 төгрөг авсан..." гэжээ. /ММ-н хуудас 14- 16, 75-76/

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Эрдэнэсүрэнгийн дүгнэлтэнд:

"Хариуцагч Х овгийн Ж.Ц нь иргэн Б.О , М.Ө , Ц.У нартай "Хууль зүйн туслалцаа үзүүлэх" гэрээ байгуулж хууль ёсны эрх ашгийг нь хамгаалах явцдаа буюу анхан шатны шүүх хуралд оролцож, өмгөөллийн үгэндээ "үйлчлүүлэгч М.Ө нь хэрэг үйлдсэн болохоо хүлээн зөвшөөрөөгүй байхад, "М.Ө нь эрүүгийн хэрэгт холбогдолтой болох нь бусад нотлох баримтаар нотлогдож байна, худлаа өмгөөлөл явуулж чадахгүй. ... прокурорын санал болгосон 300 цагийн албадан ажлыг нааш нь татаж 240 цагаар тогтоож өгнө үү" гэж үйлчлүүлэгчийнхээ эрх зүйн байдлыг дордуулсан, яллагдагчийн гэм буруутай эсэх талаар хувийн үзэл бодлоо илэрхийлсэн байна.

Дээрх байдал нь гомдол гаргагч иргэн Б.О, М.Ө, Ц.У нараас тус хороонд ирүүлсэн гомдол, тайлбар, Мэргэжлийн хариуцлагын хорооны шалгагч Н.Б 2017 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 11 дугаартай тэмдэглэл, Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 82 дугаартай "Б.О, Ц.У, М.Ө нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай" тэмдэглэл, Багануур дүүргийн шүүхийн тамгын газраас 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 30 дугаартай албан бичиг, шүүх хуралдааны видео бичлэг зэрэг бичгийн нотлох баримтуудаар нотлогджээ" гэжээ.

Маргааны материалаас гомдол гаргагч М.Ө-аас авсан тайлбар /хуудас 7-8/, Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 82 дугаартай, "Б.О, Ц.У, М.Ө нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай" тэмдэглэл /хуудас 25, 32, 45/ хуулбар хүсэх тухай албан бичиг /хуудас 55/, шинжээч томилж шүүх хуралдаан хойшлуулсан Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 125 дугаартай захирамж /хуудас 56-57/, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах тухай Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 130 дугаартай захирамж /хуудас 58-59/, шүүх хуралдаан хойшлуулах тухай Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 172 дугаартай захирамж /хуудас 61-62/ зэрэг нотлох баримтыг шинжлэн судлаад

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч Х овгийн Ж.Ц нь Монголын Хуульчдын холбооны нэгдсэн бүртгэлийн 956, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн 456 дугаарт тус тус бүртгэгдсэн "хуульч-өмгөөлөгч" болох нь Монголын хуульчдын холбооны 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 2/118 дугаартай албан бичгээр тогтоогдож байх тул Ж.Ц маргааны хариуцагчаар оролцох хуульч мөн гэж үзлээ.

Иргэн Б.О, М.Ө, Ц.У нараас тус хороонд ирүүлсэн гомдол нь “Өмгөөлөгч Ж.Ц нь өмгөөлөгчийн ёс зүйг баримтлаагүй, үйлчлүүлэгчийнхээ эрх зүйн байдлыг дордуулж өмгөөллийн үйл ажиллагаа явуулсанаас хийгээгүй хэргийн төлөө анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн” гэсэн агуулгатай байна.

Бусдыг маажиж, зодож нүдээгүй гэж үйлчлүүлэгч М.Ө шүүх хуралдаанд мэдүүлсэн /хуудас 32-33/, “3 шүүгдэгчийг цагаатгах талын нотлох баримт миний хувьд олдсонгүй, иймд худлаа өмгөөлөл явуулж чадахгүй... шүүгдэгч М.Ө хувийн байдлыг харж үзээд 240 цагийн албадан ажил хийгэх ял оногдуулж өгнө үү” гэж хариуцагч Ж.Ц өмгөөллийн үгэндээ хэлсэн зэрэг нь Ж.Ц гаргаж буй тайлбар болон шүүх хуралдааны тэмдэглэлээр /хуудас 45/ давхар нотлогдож байна.

Маргааны материалд өмгөөлөгч Ж.Ц-ээс үйлчлүүлэгч Б.О, М.Ө, Ц.У нартай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, өмгөөллийн хөлс авсан тухай баримт авагдаагүй байгааг дурдах нь зүйтэй.

Өмгөөлөгч Ж.Ц нь дээрх үйлчлүүлэгч нарт холбогдох эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд удаа дараа оролцож байсан болох нь Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 125, 130, 172 дугаартай захирамж, 82 дугаартай шийтгэх тогтоолоор нотлогдож байх ба тэрээр үйлчлүүлэгч нараас өмгөөллийн хөлсөнд нийт 1 000 000 төгрөг авсанаа хүлээж, энэ талаар маргаагүй болно.

Хариуцагч Ж.Ц гаргасан үйлдлийг Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзсэн Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э 2017 оны 04 сарын 17-ны өдрийн 005 дугаартай дүгнэлтийг үндэслэлтэй байна, зөрчил гаргагч Ж.Ц “нээлттэй сануулах” хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Өмгөөлөгч Ж.Ц нь сахилгын зөрчлийг анх удаа гаргасан, гаргасан зөрчлөө хүлээн зөвшөөрч байгааг хариуцлага хүлээлгэхдээ харгалзсан болно.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.2 Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 1, 4, 4.5 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн 2.7-д заасныг тус тус зөрчсөн өмгөөлөгч Ж.Ц Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт заасан “нээлттэй сануулах” шийтгэл ногдуулсугай.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүй, эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүйг дурьдсугай.
3. Тогтоолыг маргааны оролцогчдод хүргүүлж, Холбооны тогтмол хэвлэл, цахим хуудсаар тогтоолыг нийтэд зарлахыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албанд үүрэг болгосугай.
4. Тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 06 сарын 02

Дугаар 18

Улаанбаатар хот

Өмгөөлөгч Х.О холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн У.Солонгын илтгэснээр гишүүн Э.Ариунаа, Н.Одонтуул, Т.Энхмаа, Х.Цогтсайхан нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч Х.О хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э саналыг хүлээн авч хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

Хариуцагч: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо, 25-52 тоотод нөхөр хүүхдийн хамт амьдрах, эмэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, 1971 оны 09 дүгээр сарын 12-нд төрсөн, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн нэгдсэн бүртгэлийн 192 дугаар бүртгэлтэй, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн 367 дугаарт тус тус бүртгэгдсэн Ц овогт Х. О нь “Холдинг” ХХК-нд хууль зүйн туслалцаа үзүүлж байх хугацаандаа иргэн Ч.О “иргэн А эзэмшлийн хашаа байшинг 5 сая төгрөгөөр худалдан авч уг хашаа байшинг “Трейдинг”-д өгч өрийг чинь барагдуулна” гэж худал мэдээллээр хангаж, өөрийн охин Г.Э эзэмшлийн хашаа байшинг Ч.О худалдсан болох нь:

Гомдол гаргагч Ч.О гомдолдоо: “Холдинг ХХК-ны Номин стандарт салбарт 2006-2015 оны хооронд зохион байгуулагчаар ажиллаж байсан. Ажиллаж байх хугацаандаа 9.000.000 төгрөгний бараа бүтээгдэхүүн дутаасан үндэслэлээр ажлаас халагдсан. Ажлаас халагдсаны дараа Холдингийн эрх зүйч н.О байгууллагын өр барагдуул чамтай хамт өрийн асуудалтай хүмүүсийг СХД-н цагдаагийн хэлтэст шалгуулж байна яаралтай П.И гэж өмгөөлөгчтэй уулз гэсний дагуу уулзаж 2.000.000 төгрөгөөр өмгөөлөх гэрээ хийж мөнгө төлсөн. Өрөө дарвал тушаал бууруулж ажиллуулж болно. Би Номингийн итгэмжлэгдсэн хүн байна гэж байсан. Үүнээс хойш Х.О, П.И нар нь ШШГЕГ-н хураагдсан хашаа байшинг н.А гэдэг хүнтэй ярьж байгаад 5.000.000 төгрөгөөр худалдан аваад уг хашаа байшинг Трейдинг-д өгч миний өрийг дарж асуудалгүй болгоно гэсний дагуу 5.000.000 төгрөгийг шилжүүлж төлсөн. Үүнээс хойш О-аас газрыг шилжүүлсэн тухай тодруулж асуухаар...өрийг чинь хаасан одоо асуудалгүй болсон ... өөрийн нэр дээр газар байгаа эсэхийг СХД-н газрын албанаас тодруулахад н.А гэж хүн биш Б.Э гэсэн өөрийн охины газрыг шилжүүлсэн байсан. Гэтэл Трейдингд өр маань барагдаагүй газар нь ч миний нэр дээр шилжигдээгүй байна. Гомдолтой байна” гэжээ.

Гомдол гаргагч “Номин Холдинг” ХХК-н эрх зүйн газрын захирал Л.Б гомдол, тайлбартаа: “Өмгөөлөгч П.И, Х.Отгончимэг нар эрх зүйн газарт ажиллаж байсан. Тус өмгөөлөгч нар хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг ноцтой зөрчиж цагдаа болон шүүхийн байгууллагад Холдинг ХХК-н эсрэг цагдаагийн байгууллагад өргөдөл гаргах, шүүхэд нэхэмжлэл өгөх зэрэг болон Холдинг ХХК-н цагдаа болон шүүхийн байгууллагад гаргасан өргөдөл, нэхэмжлэлийн эсрэг иргэдийг төлөөлж шүүх хуралдаанд оролцож байна. Өмгөөлөгч Х.О нь Холдинг ХХК-ийн эрх зүйн газрын авлага барагдуулах хуульч албан тушаалд ажиллаж байгаад 2016.07.20 ний өдөр халагдсан ба халагдах хүртлээ эрүү, иргэний хэрэгт компанийг төлөөлөн ажиллаж байсан. Харин ажлаас халагдмагцаа авлага барагдуулах хуульчаар ажиллаж байхдаа өөрөө шалгаж байсан зарим хэрэг, маргаан дээр “Холдинг” ХХК-ний эсрэг талд өмгөөлөл, хууль зүйн үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Тухайлбал: Өмгөөлөгч Х.О нь “Трейдинг” ХХК-ний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг хүлээсэн үедээ буюу 2015.12.30-нд СХД-ийн Цагдаагийн Хэлтэст эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулах тухай” 2015/02 тоот албан бичиг өгсөн байна. Уг албан бичгийн товч утга нь: “Стандарт салбарын нягтлан О.Б, нярав н.О, зохион байгуулагч Ч.О нар нийлэн хуйвалдаж дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнийг бэлнээр зарж борлуулан нийт 63.850.980 төгрөгийг хувьдаа завшсан байна. Иймд нэр бүхий хүмүүсийг эрүүгийн хуулийн 150 дугаар зүйл анги, 266 дугаар зүйл ангид заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж компанид учирсан хохирлыг барагдуулж өгөхөөс гадна хууль тогтоомжид заасан ял шийтгэлийг оногдуулж өгнө үү” гэсэн байна. Иргэн Ч.О-ээс надад бичиж өгсөн зүйлийн товч утга нь: Холдингийн эрх зүйч Х.О нь “Байгууллагын өр барагдуул. Чамтай хамт өртэй асуудалтай хүмүүсийг СХД-ийн цагдаагийн хэлтэст шалгуулж байна. Яаралтай н.И гэж өмгөөлөгчтэй уулз гэсний дагуу уулзаж 2.000.000 төгрөгөөр өмгөөллийн гэрээ хийж мөнгөө төлсөн. хураагдсан хашаа байшинг н.А гэдэг хүнтэй ярьж байгаад 5.000.000 төгрөгөөр худалдаж аваад уг хашаа байшинг “Холдинг” ХХК-нд өгч чиний өрийг дарж асуудалгүй болгоно гэсний дагуу 5.000.000 төгрөгийг шилжүүлж төлсөн. Үүнээс хойш Х.О-ээс газрыг шилжүүлсэн тухай тодруулж асуухаар “Хэрэг хийчээд юу яриад байгаа юм. Хэрэг чинь дуусаагүй СХД-ийн цагдаад шалгуулж байгаа. Өрийг чинь хаасан, одоо асуудалгүй болсон. Өөрөө ажил олж хий” гэж хэлсэн. Газрын гэрчилгээний эх хувийг Х.О өөрөө авсан. Өөрийн нэр дээр нь тэр газар байгаа” гэснийг СХД-ийн газрын албанаас тодруулахад Б.Э гэсэн охиных нь нэр дээр бүртгэлтэй байсан. Гэтэл Номин трейдинг-д өр маань барагдаагүй, газар нь ч миний нэр дээр шилжигдээгүй намайг хууран мэхэлсэн” гэсэн мэдээллийг бидэнд өгсөн юм” гэжээ.

Хариуцагч Х.О тайлбартаа: “...Миний бие нь 2010 оны 09 дүгээр сараас 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээний дагуу авлага барагдуулах эрх зүйчээр, 2013 оноос 2016 07.01 хүртэл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний үндсэн дээр хуулийн зөвлөх албан тушаалд ажиллаж байсан. Миний би “Холдинг” ХХК-д ажиллаж байхдаа компанийн ажилчдад тавьсан үндэслэлгүй өр авлагыг барагдуулах компанийг төлөөлж шүүхэд хэргийн оролцогчоор, цагдаагийн байгууллагад иргэний нэхэмжлэгч хохирогчоор оролцож байсан бөгөөд компанийн эсрэг өргөдөл гомдол гаргаж компанийн эсрэг шүүх хуралд оролцож байгаагүй.

Гэтэл миний бие нь ажилчдад оногдуулсан үндэслэлгүй өрийг барагдуулж иргэн болон Номин холдинг ХХК-д ажиллаж амьдрал ахуйгаа залгуулж байсан ажилчдын эсрэг хууль бус үйл ажиллагаа явуулж Номингийн төлөө ажиллаж байснаас Номингийн эсрэг нэг ч удаа үйл ажиллагаа явуулж байгаагүй болно. “Холдинг” ХХК-д Х.О намайг ажиллаж байх хугацаанд 11.000.000 гаран төгрөгний бараа бүтээгдэхүүн болон касснаас бэлэн мөнгө ашигласан үйлдэлтэй “Трейдиг” ХХК-ийн “Стандарт” салбарын “Улаанбаатар Импекс” дэлгүүрт заал зохион байгуулагч, кассаар ажиллаж байсан Ч.О өрийг барагдуулах ажлыг хийж гүйцэтгэж байсан. Ч.О асуудлаар тухайн үед “Холдинг” ХХК-ийн Эрх зүйн газрын Авлага барагдуулах албаны дарга А болон Ч.О, Х.О нар ярилцаад нөхрийнх нь нэр дээр байсан газрыг буцаан өгч Ч.О нэр дээр газар шилжүүлэн авч компанид өгч эрүүгийн хэргээс чөлөөлж өгөхөөр тохиролцсон. Х.О миний хувьд компаний хохирлыг барагдуулах үүднээс Авлага барагдуулах албаны дарга А, Ч.О болон өмгөөлөгч П.И нартай ярьж тохиролцсоны үндсэн дээр Б.Э эрх шилжүүлэн авсан газрыг нь өрөнд хурааж авсан боловч нэгэнт эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаад Ч.О гэм буруу нь тогтоогдохгүй болохоор нь Ч.О нэр дээр гарсан газрын гэрчилгээг компанид өгөөгүй. Харин Ч.О энэ талаар мэдэгдсэн. Ч.О нь компанийн хөрөнгийг хувьдаа ашигласан нь үнэн өөрөө ч хүлээн зөвшөөрдөг юм. Гэвч Ч.О нь газартай холбоотой асуудлаараа Х.О хиных нь хамт, мөн өөрийн өмгөөлөгч П.И нарыг СХД-ийн цагдаагийн газарт өргөдөл өгч шалгуулсан. СХД-ийн Прокурорын газрын хяналтын прокурор Золзаяа хэргийг хянаж Ч.О . Б.Э нарын хооронд дахь асуудал иргэд хоорондын гэрээгээр шийдэгдсэн байна, харин Х.О , П.И нар нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байна гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болсон тогтоол гарсан” гэжээ.

2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд: “нэг талаас өмгөөлөгч П.И , нөгөө талаас Ч.О ...өмгөөлөгч эрүү, иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх...гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 2.000.000 төгрөг байна...” гэжээ.

2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн газар эзэмших эрх шилжүүлэх гэрээнд: “...нэг талаас Б.Э, нөгөө талаас Ч.О бид харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав. Шилжүүлэгч тал өөрийн эзэмшилд байгаа СХД-н 32-р хороо Шанд 5-20 байрлах 541 м.кв талбай бүхий газраас 541м.кв газрыг эрх шилжүүлэн авагчид шилжүүлнэ” гэжээ.

2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хууль зүйн туслалцаа үзүүлэх 44/45/56 дугаар гэрээнд: “нэг талаас хуульч, өмгөөлөгч П.И, нөгөө талаас “Холдинг” ХХК-ийг төлөөлж Хүний нөөц, захиргааны газар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав...энэхүү гэрээг 2013 оны 10 дугаар сарын 01-нээс 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 1 жилийн хугацаанд байгуулав...хуульч нь үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөг амаар болон бичгээр өгөх, шаардлагатай эрх зүйн баримт бичиг, гэрээ, дүрмийг боловсруулах, хянах, тодорхой асуудлаар эрх зүйн дүгнэлт, тайлбар гаргах, уулзалт, ярилцлага, сургалт хийх, эрх зүйн зөрчил, хэрэг, маргааныг шийдвэрлэхэд оролцох, үйлчлүүлэгчийг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, шүүхэд төлөөлөх,

гомдол хүсэлт, тайлбар, нэхэмжлэл гаргах зэргээр хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ...үйлчлүүлэгч болон түүнтэй нэгдсэн сонирхол бүхий этгээд /үйлчлүүлэгчийн захиалга зөвшөөрлийн үндсэн дээр төлөөлж/-ээс бусад иргэн, хуулийн этгээдэд хуульчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, тэднийг шүүхэд төлөөлөргүй” гэжээ.

2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Хууль зүйн туслалцаа үзүүлэх НН/45/60 дугаартай гэрээнд: “Нэг талаас хуульч, өмгөөлөгч Х.О, нөгөө талаас “Холдинг” ХХК-ийг төлөөлж Хүний нөөц, захиргааны газар дор дурдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав. Энэхүү гэрээг 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаанд байгуулав. Гэрээний хугацаа дуусгавар болоход талуудаас...хуульч нь үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөг амаар болон бичгээр өгөх, шаардлагатай эрх зүйн баримт бичиг, гэрээ, дүрмийг боловсруулах, хянах, тодорхой асуудлаар эрх зүйн дүгнэлт, тайлбар гаргах, уулзалт, ярилцлага, сургалт хийх, эрх зүйн зөрчил, хэрэг маргааныг шийдвэрлэхэд оролцох, үйлчлүүлэгчийг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, шүүхэд төлөөлөх, гомдол хүсэлт, тайлбар, нэхэмжлэл гаргах зэргээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ ...үйлчлүүлэгч болон түүнтэй нэгдсэн сонирхол бүхий этгээд /үйлчлүүлэгчийн захиалга зөвшөөрлийн үндсэн дээр төлөөлж/-ээс бусад иргэн, хуулийн этгээдэд хуульчийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, тэднийг шүүхэд төлөөлөөгүй” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс Х.О сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргасан ба хариуцагч Х.О нь “Охин Д.Э газрыг О-ийн нэр дээр шилжүүлж өгсөн үйлдэлдээ хариуцлага хүлээхэд гомдолгүй. Өөр ямар нэгэн Холдинг ХХК болон түүний охин компаниудын эсрэг хууль хяналт, шүүхийн байгууллагад төлөөлсөн асуудал байхгүй болно. Дээрх асуудалд хаалттай сануулах арга хэмжээ авахуулахад гомдолгүй. Уг үйлдэлд гэмшиж байна” гэсэн хүсэлт бичгээр гаргаж өгч байгаа нь гомдол гаргагчийн гомдол, тайлбар, хариуцагчийн гэм буруугаа хүлээсэн тайлбар, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний хуулбар зэрэг бичгийн баримтуудаар нотлогдож байх тул сахилгын шинжээчийн “Хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай” саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих”, 27.1.2-д “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д “Шударга ёсыг баримтлах”, 5.1 дүгээр зүйлийн 1-д “Хуульч нь гуравдагч этгээдэд хууль болон үйл баримтын талаар худал мэдээлэл өгөхийг хориглоно”, 5.4 дүгээр зүйлийн 1-д “Хуульч нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, эсхүл тухайн этгээдийн эрхийг зөрчиж нотлох баримт бүрдүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч, уг зөрчлийн улмаас бусдад

учруулсан хохирлоо төлсөн /Ч.О нэр дээр газар эзэмших гэрчилгээг шилжүүлж өгсөн/ байх тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5, 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3 дахь заалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Хуульч Х.О-т сахилгын хаалттай сануулах шийтгэл оногдуулсугай.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Өмгөөлөгч С.Ү холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдааныг тус хорооны гишүүн Б.Сугар даргалж, гишүүн Л.Амарсанаа, Д.Мөнгөнцэцэг, Ш.Одонсүрэн, Д.Очмандах нарын бүрэлдэхүүнтэйгээр Монголын Хуульчдын холбооны хуралдааны танхимд сахилгын шинжээч Б.Э, гомдол гаргагч Н.Д, хуралдааны нарийн бичгийн дарга А.Х нарыг оролцуулан, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э-н 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн МД17/006 дугаартай Мэргэжлийн дүгнэлт үйлдсэн, Монголын Хуульчдын Холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч С.Ү-д холбогдох 16/103, 17/11 дугаартай "Маргааны материал"-ыг хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Иргэн Н.Д бичгээр ирүүлсэн гомдолдоо: "Партнерс" ХХН, түүнийг төлөөлж С.Ү нь 2016-05-13-ны өдөр өмгөөлөл хийхээр гэрээ байгуулж төлбөрөө 100 хувь авсан юм ... давж заалдах гомдол гаргана гэж амласан боловч гаргасангүй, оршин суугчдаас зөвшөөрөл авч, тэднээс намайг итгэмжлэл авахуулж өргөдлөө дахин гаргана гэж амласан боловч энэ ажлыг хийсэнгүй ... шүүх хурлын маргаашаас эхлээд С.Ү утсаа авахгүй, ирж уулзахгүй 5 сар өнгөрч байна. Мөн хоёр хэргийн өмгөөлөгчөөр ажиллана гээд тэмдэгтийн хураамж төлүүлээд авч явсан боловч одоо болтол 5 сар сураггүй алга болсон юм. Түрүүчийн 7 хоногт надад мессэж ирүүлснээс өөр ажил хийсэнгүй. Иймд 1. Үлэмжийн сэтгэл мэдрэл эрүүл эсэхийг шалгаж өгнө үү, 2. Түүний өмгөөлөх эрхийг хүчингүй болгож өгнө үү, 3. Өмгөөллийн хөлсийг буцааж өгнө үү, 4. Өмгөөлөөгүйгээс болж бидэнд учирсан хохирлыг "Партнерс" ХХН-ээс гаргуулж өгнө үү" гэжээ.

2. Иргэн Н.Д өмгөөлөгч С.Ү-н тайлбарт өгсөн нэмэлт тайлбартаа:

"1/ С.Ү "Партнерс" нөхөрлөл нь манай сургуулийн мэдлийн байрны 2 өрөөг түрээслэсэн юм. Сарын 350 мянган төгрөгийн түрээс төлдөг юм. Өмгөөллийн хөлсөнд 3 сарын байрны төлбөр буюу 1 сая 50 мянган төгрөг өгөхөөр тохиролцсон бөгөөд бид 2016 оны 5-8 сарын байрны түрээс буюу 1 сая 50 мянган төгрөгөө аваагүй юм. Иймд өмгөөллийн хөлс 1 сая 50 мянган төгрөгөө бид Үлэмжээс эргүүлж авч өгөхийг хүсэлт гаргасан юм ... Нөгөө талаас МДС-ийн эзэмшилд хичнээн байр байгааг шалгуулсан байгаа юм. Энэ талаар өмгөөлөгч Үлэмж өөрийн талаас нотлох баримт гаргаж өгөх ажлаа хийсэнгүй. Учир нь энэ байрны инженерийн дэд бүтэц захиалагч МДС-ийн мэдэл байгаа бөгөөд конторт хүлээлгэж өгөөгүй байна. Мөн зарим байр хүн худалдаж аваагүй захиалагч МДС-ийн мэдэлд байгаа юм. Ийм материалуудыг тухайн үед нь өмгөөлөгч гаргаж өгөх үүргээ биелүүлсэнгүй.

2/ Шүүгчийн шийдвэрийг 7 хоногийн дотор давж заалдах гомдол гаргаж болно гэсэн байсныг Үлэмж давж заалдана гэж амалсан боловч энэ ажлыг хийсэнгүй.

3/ МДС-ийн нэрээр биш, оршин суугчдын нэрээр дахиж нэхэмжлэл гаргана гэж Үлэмж амалсан. Гэвч энэ амлалтаа биелүүлээгүй. Үлэмжийн идэвхигүй ажпаас болж нөгөө газрын маргаангүй болж барилгаа барьж эхэлсэн юм.

4/ Үлэмж өөр хоёр хэргийг өмгөөлнө гээд тэмдэгтийн хураамж төлүүлээд аваад явсан боловч бас ор сураггүй алга болсон юм”2 гэжээ.

3. Иргэн Н.Д хариуцагч С.Ү-н тайлбарт өгсөн хариу тайлбартаа: “Шүүх хурлын дараа би С.Үлэмжийн машинаар хамт байранд буцаж ирэхдээ дараах зүйлийг замдаа бид тохирсон юм. Үүнд: шүүгчийн захирамжийг С.Ү авч Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах ... үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газраас М.Ү очиж авч, шүүхэд гомдол гаргах ... МДС-н мэдэлд байгааг тодорхойлсон бичиг С.Ү авч шүүхэд гомдол гаргах, байрны оршин суугчдаас С.Ү итгэмжлэл авах, иргэний үнэмлэхийг нь авч аавынхаа нотариатаар баталгаажуулж, дахин шүүхэд гомдол гаргах, байрны СӨХ-г хуралдуулж шийдвэр гаргуулж С.Ү итгэмжлэл авч шүүхэд хандах, Өмгөөлөгч С.Ү дээрх 5 амлалтаа хэрэгжүүлээгүй, утсаа авахгүй 3 сар алга болсон юм. С.Ү “СӨХ-ийг би өмгөөлөхгүй” гэж надад хэлээгүй 3 сар алга болсон. Худлаа хэлж байна. Энэ СӨХ-ийн дарга нь би тул үргэлжлүүлээд өмгөөлнө гэж тохиролцсон. Хэрэв С.Ү цаашид өмгөөлөхгүй гэсэн бол би өөр өмгөөлөгч авах эсвэл өөрөө давж заалдах гомдол өгөх байсан. С.Үлэмж хариу өгөхгүй зориуд биднийг хохироосон. Хурал

2 16/103, 17/11 дугаартай “Маргааны материал”-ын 21 дэхтал.

Эхлэхийн өмнө С.Ү нөгөө талын өмгөөлөгчтэй удаан уулзсан. Тэд тамхилсан байж магадгүй. Давж заалдах гомдол гаргалгүй, ярихгүй /утсыг нь шалгана уу/ 3 сар алга болсон С.Ү өмгөөлөх эрхийг хасаж өгнө үү. Энэ хүний оюун ухаан эрүүл үү? Эн бол нөгөө талаас авилга авч, барилга барих боломжийг нь нээж өгсөн урвагч үйл ажиллагаа гэж би хардаж байна ... Шүүгч хэрэг үүсгэсэн учир энэ хурлын дараа бичгээр гэрээ хийнэ гэж тохирсон боловч 3 сар алга болсон. Иймд амаар тохиролцсон хэлцлээ биелүүлээгүй 2 дахь үйлдэлд нь бас хариуцлага тооцож нийтэд зарлаж өгнө үү ...”3 гэжээ.

4. Иргэн Н.Ц нь бичгээр гаргасан гомдолдоо болон нэмэлт тайлбарт: “... өмгөөлөт С.Ү-тэй уулзахад надад хууль зүйн туслалцаа үзүүлэхээр амласан бөгөөд өмгөөлөгч С.Ү надтай бичгээр ямар нэгэн гэрээ байгуулаагүй ... түүний туслах н.Д гэгч эмэгтэйд өөрийнхөө өмнөөс шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөн оролцох итгэмжлэлийг олгож байсан...миний бие эхлээд түүний шаардсаны дагуу эхлээд 200 000 төгрөг өгсөн юм ... маргаанд холбогдох мөнгө төлснөө нотолсон баримтуудаа танилцуулж, хэрэгтэй эсэхийг асуухад “шаардлагагүй” гэж байсан, түүгээр ч үл барам би өөрөө шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй байгааг хэлэхэд С.Ү болон түүний туслах Д нар надад шүүх хуралдааны товыг хэлээгүйгээс миний бие шүүх хуралдаанд оролцож чадаагүй өнгөрсөн юм. Дараа нь миний бие С.Ү-тэй уулзах үед тэрээр “шүүх хуралдаан болсон, манайх ялсан” гэж хэлэхэд би түүнд итгэж баярласан. Удалгүй С.Ү нь надад “хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар

шийдвэрлэнэ” гэж хэлээд нэмж 400 000 төгрөг авсан ба нийтдээ 600 000 төгрөгийг өмгөөллийн хөлсөнд төлсөн болно...гэтэл 2016 оны 10 сард Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас ... 27 сая төгрөгийг миний бие Н.Б төлөх тухай шүүхийн шийдвэр гарсан болохыг мэдэгдэж ... миний бие шүүхийн эдгээр шийдвэрүүдэд гомдолтой байгаагаас гадна надад худал мэдээлэл өгч мэхэлсэн, миний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, урвуулан ашигласан өмгөөлөгч С.Ү гэдэг хүнд гомдолтой байгаа ... Манай туслахад итгэмжлэл олгочих н.Д-д итгэмжлэл олгосон. Өмгөөлөгч С.Үлэмж таны асуудлыг зохицуулна ямар ч байсан ялна гэж хэлж байсан. Нотлох баримтууд шинэ ковшны төлбөр төлсөн баримт, бэлнээр болон дансаар мөнгө өгсөн баримт, Б-т ковш өгч байсан баримт зэрэг баримтыг өгсөн боловч өмгөөлөгч С.Ү баримтыг аваагүй наад баримтууд чинь хэрэггүй гэсэн...Шүүх хурлын талаар надад ямар ч мэдээлэл өгөөгүй...өмгөөлөгч С.Ү ямар нэг мэдээлэл өгөхгүй алга болсон...утсаа авахгүй ажлын байраа 3 удаа өөрчлөөд надтай уулзаагүй алга болсон. Би өмгөөлөгч С.Ү-ийн үйл ажиллагаанаас болж маш их хохирч байгаа тул гомдолтой байна ... гэрээ байгуулах талаар болон мөнгө өгсөн баримт өгөхгүй юм уу? гэхэд за яахав гээд өгөөгүй ... өмгөөлөгч С.Ү нь өмнө нь надад худал хэлж байсантайгаа нэгэн адил худал тайлбар гаргаж байгаад харамсаж байна...утсаар залгахад авдаггүй, ажлын байранд нь очиход нүүгээд явсан байсан тул хайж явсаар баруун 4 замын орчмоос олж уулзахад шинээр илэрсэн нөхцөл байдлын журмаар дахин шийдүүлж болно гээд миний өмгөөлөгчөөр дахин ажиллахаар болсон боловч надад байсан нотлох баримт зэргийг ч хэлсээр байхад авахгүй мөн л урьдын адил ямар нэгэн ажиллагаа явуулалгүй байсаар өнгөрсөн ..."4 гэжээ.

5. Хариуцагч С.Ү Мэргэжлийн хариуцлагын хороонд бичгээр ирүүлсэн тайлбартаа: "... Миний бие иргэн Н.Д буюу Монгол Дээд сургуультай харилцан тохиролцсоны хүрээнд хууль зүйн тусалцаа үзүүлэх гэрээ байгуулж тус байгууллагын багш ажилчдын орон сууцны урд байрлах талбайд газар эзэмших эрх олгосон засаг даргын захирамжийг эс зөвшөөрч, хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцсон болно. Гэвч захиргааны хэргийн анхан шатны шүүх хэргийг нэхэмжлэх эрхгүй этгээд гаргасан буюу нэхэмжлэгч Монгол Дээд сургуулийн хууль ёсны эрх ашиг хөндөгдөөгүй гэж үзэн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамжийг гаргасан. Миний бие үйлчлүүлэгчтэй харилцан зөвшилцөж шүүгчийн захирамжид гомдол гаргах тухай ярилцсан боловч тус байрны СӨХ-ийг хуралдуулж дахин нэхэмжлэл гаргах нь зөв гэж шийдсэн болно...

Иргэн Н.Ц анх 2014 онд танилцсан ... 2016 оны 04 сард над дээр ирж Б-ын нэхэмжлэлтэй зээлийн гэрээний маргаанд өмгөөлөгчөөр орохыг гуйсан боловч миний бие ажил ихтэй тул өмгөөлөгчөөр оролцох боломжгүй, та харин манай хуульч, эрх зүйч нартай харилцан тохиролцоод хууль зүйн тусалцаа авч болно гэж зөвлөсний дагуу манай байгууллагад туслахаар ажиллаж байсан Б.Д-тай тохиролцож итгэмжлэл хийж өгөн шүүх хуралдаанд оролцуулсан байдаг. Гэвч давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. Миний бие хяналтын шатны шүүхэд гаргах хяналтын гомдлыг бичиж өгсөн бөгөөд тэмдэгтийн хураамжийг бодож өгөн дансны дугаартай хамт Н.Ц-д өгсөн боловч гомдол гаргах

хугацааг хожимдуулсан байсан тул хяналтын шатны шүүх хүлээж аваагүй байсан... Миний бие Н.Ц-оос

Эрдэнэбулганы хэрэгтэй холбоотойгоор ямар нэгэн төлбөр аваагүй, гагцхүү Н.Ц нь "ах нь мөнгөтэй болохоороо гомдоохгүй өгнө" гэж хэлдэг байснаас өмгөөллийн хөлс гэж мөнгө өгөөгүй болно. Мөн Н.Ц-той байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байхгүй бөгөөд манай байгууллагын зүгээс үйлчлүүлэгчтэйгээ заавал гэрээ байгуулж өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг болно. Давж заалдах шатны шүүх хуралдаанд хүсэлтийн дагуу оролцсон бөгөөд тэмдэгтийн хураамжийг хувийн зүгээс төлсөн болно. Гэвч Н.Ц нь надаас болж шүүхэд ялагдсан мэтээр тайлбарлаж утсаар дарамтлах зэрэг үйлдэл хийж байсан тул миний бие танай байгууллагад хандахыг зөвлөж түүний утасны дугаарыг блоколсон болно.

Иймд миний зүгээс хуульчийн ёс зүй зөрчсөн үйлдэл байхгүй бөгөөд тус хороо өмгөөлөгч, хуульчдынхаа эрх ашгийг хамгаалж, хуулийн хүрээнд шийдвэр гаргана гэдэгт итгэж байна" гэжээ.

Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн гомдол гаргагч нар болон хариуцагчийн тайлбар, Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн МД17/006 дугаартай Мэргэжлийн дүгнэлт, өмгөөлөгч С.Ү холбогдох 16/103, 17/11 дугаартай "Маргааны материал" зэрэг баримтуудыг шинжлэн судлаад

ҮНДЭСЛЭХ нь:

Хариуцагч С.Ү нь Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч болох нь Монголын Хуульчдын Холбооны 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 2/425 дугаартай албан бичгээр тогтоогдож байх тул уг маргааны хариуцагчаар оролцох этгээд мөн болно.

А. Иргэн Н.Д-ийн гомдлын тухайд:

Өмгөөлөгч С.Ү нь "Монгол" Дээд сургууль, түүнийг төлөөлж иргэн Н.Д-тэй түүний эрх ашгийг хамгаалахаар гэрээ байгуулан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон болох нь талуудын тайлбар болон хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр нотлогдож байна.

Гомдол гаргагч Н.Д Мэргэжлийн хариуцлагын хороонд хандаж гаргасан гомдол7 болон нэмэлт тайлбарууддаа:

1-рт Үлэмжийн сэтгэл мэдрэл эрүүл эсэхийг шалгаж өгнө үү,

2-рт Түүний өмгөөлөх эрхийг хүчингүй болгож өгнө үү,

3-рт Өмгөөллийн хөлсийг буцааж өгнө үү,

4-рт Өмгөөлөөгүйгээс болж бидэнд учирсан хохирлыг "Үлэмж партнерс" ХХН-ээс гаргуулж өгнө үү,

5-рт Өмгөөллийн хөлсөнд 3 сарын байрны төлбөр буюу 1 сая 50 мянган төгрөг өгөхөөр тохиролцсон бөгөөд бид 2016 оны 5-8 сарын байрны түрээс буюу 1 сая 50

мянган төгрөгөө аваагүй юм. Иймд өмгөөллийн хөлс 1 сая 50 мянган төгрөгөө бид Үлэмжээс эргүүлж авч өгөхийг хүсэлт гаргасан юм,

6-рт Давж заалдах гомдол гаргалгүй, ярихгүй /утсыг нь шалгана уу/ 3 сар алга болсон С.Ү-ийн өмгөөлөх эрхийг хасаж өгнө үү,

7-рт Шүүгч хэрэг үүсгэсэн учир энэ хурлын дараа бичгээр гэрээ хийнэ гэж тохирсон боловч 3 сар алга болсон. Иймд амаар тохиролцсон хэлцлээ биелүүлээгүй 2 дахь үйлдэлд нь бас хариуцлага тооцож нийтэд зарлаж өгнө үү гэсэн нийт 7 /долоо/ гомдлын шаардлага гаргаж үндэслэлээ гомдолдоо тодорхой дурьджээ.

1-рт өмгөөлөгч С.Ү-ийн сэтгэл мэдрэл эрүүл эсэхийг шалгаж өгөхийг хүссэн хүсэлт нь тус хорооны харьяалан шийдвэрлэх маргаан биш байх тул харьяалах газар нь уг хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Мэргэжлийн хариуцлагын хороо нь зөвхөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлд заасан чиг үүргийг л гагц хэрэгжүүлэх үүрэгтэй болно.

2, 6, 7-рт дугаарлагдсан гомдлууд нь утга агуулгын хувьд адил тодруулбал өмгөөлөгч С.Ү-д хариуцлага тооцож, өмгөөлөх эрхийг хасах, хүчингүй болгуулах, тооцсон хариуцлагыг нийтэд зарлуулахыг хүсчээ.

Өмгөөлөгч С.Ү нь иргэн Н.Д-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байхдаа гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээний 1.2,1.3-т заасан үүргээ биелүүлээгүй, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангаагүй, захирамжийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргах болон үйлчлүүлэгчтэйгээ ярилцаж тохиролцсон үүргээ биелүүлээгүй, үйлчлүүлэгчээ мэдээлэл хүссэн үед мэдээлэл өгөөгүй, утсаа аваагүй, утсаа салгаж алга болсон зэрэг үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1,2-д “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”-тг хориглоно, 38 дугаар зүйлийн 38.1.1-д “үйлчлүүлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн тууштай хамгаалах”, 38.1.2-д “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12-д “мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн нь мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч С.Ү-ийн үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гаргасан гэж үзэж хуульд заасан хариуцлага ногдуулах үндэслэлтэй байна.

Харин 3, 4, 5 дугаартай гомдлууд нь утга агуулгын хувьд ижил буюу хохирол гаргуулах, өмгөөллийн хөлс 1.050.000 /нэг сая тавин мянган/ төгрөгийг гаргуулах тухай байх ба хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээндээ “хууль зүйн туслалцаа үзүүлсний хөлсийг үйлчлүүлэгч тал өмгөөлөгчид түрээсээр ажиллаж буй ХУД-н

3-р хороо Арьсний ширний 31-р байрны 9 тоотод байрлах үл хөдлөх хөрөнгийн 3 сарын түрээсийн төлбөрөөр тооцно”9 гэж тусгажээ. Өөрөөр хэлбэл “Монгол” Дээд сургуулийн мэдлийн байрыг 3 сар түрээслэх түрээсийн төлбөрөөр өмгөөллийн хөлсөө тооцохоор харилцан тохиролцож гэрээнд тодорхой тусгажээ. Гэсэн хэдий боловч хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээндээ 1 сарын түрээсийн төлбөр 350.000 /гурван зуун тавин мянган/төгрөг, 3 сарын түрээсийн төлбөр 1.050.000 /нэг сая тавин мянган/ төгрөг гэж түрээсийн төлбөрийг мөнгөн дүнгээрээ тодорхой тусгаагүй байна.

Хохиролтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 5.6 дугаар зүйлийн 1-д “Үйлчилгээний хөлс, зардал болон ... үйлчлүүлэгчээс хүлээн авсан эд хөрөнгийг хариуцагч нөхөн төлөхийг зөвшөөрсөн тохиолдолд бүрэлдэхүүн нь тухайн хохиролыг нөхөн төлөхийг даалгаж болно” гэж заасан байх бөгөөд өмгөөлөгч С.Ү нь өмгөөллийн хөлс гэж бэлэн мөнгө гар дээрээ хүлээн аваагүй, харин 3 сарын түрээсийн төлбөрөөр өмгөөллийн хөлсөө тооцохоор харилцан тохирчээ.

Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд өмгөөллийн хөлс нь 3 сарын түрээсийн төлбөр байхаар тохиролцсон байх боловч мөнгөн дүнгээр түрээсийн төлбөрийг илэрхийлээгүй байх тул өмгөөллийн хөлсний талаар дүгнэлт өгөх боломжгүй байна. Гомдол гаргагчийн С.Ү-ээс 1.050.000 /нэг сая тавин мянган/ төгрөг гаргуулж өгнө үү гэх гомдлын шаардлага нь Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүн шийдвэрлэх асуудал биш, харин иргэний хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан байна.

916/103, 17/11 дугаартай “Маргааны материал”-ын 19 дэх тал.

Иймд гомдол гаргагч Н.Д нь 3 сарын түрээсийн төлбөр болох 1.050.000 /нэг сая тавин мянган/ төгрөгийг гаргуулах тухай асуудлаа харьяалах иргэний хэргийн шүүхэд хандаж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Б. Иргэн Н.Ц гомдлын тухайд:

Өмгөөлөгч С.Ү нь Н.Б-ын нэхэмжлэлтэй Н.Ц-д холбогдох иргэний хэрэгт иргэн Н.Ц-ын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн өмгөөлөгчийн хувиар иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцсон болох нь а/ Н.Б-ын нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар С.Ү-ийг өмгөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахыг хүссэн 2016 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хүсэлт,

б/ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Б-ын нэхэмжлэлтэй иргэний хэргийн тухай” 1065 дугаартай тэмдэглэл ,

с/ Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Б-ын нэхэмжлэлтэй иргэний хэргийн тухай” 1065 дугаар магадлал ,

д/ тус магадлалыг өмгөөлөгч С.Ү гардан авсан тухай баримт 13 зэргээр тус тус батлагдан тогтоогдож байна.

Дээрх дурьдагдаж буй шүүх хуралдааны тэмдэглэл, магадлалд хариуцагч Н.Ц-ын өмгөөлөгч С.Ү гэж тодорхой дурьдагдсан байгаа болно.

Гомдол гаргагч Н.Ц тус хороонд гаргасан гомдол болон нэмэлт тайлбартаа: “Өмгөөлөгч, хуульч С.Ү-ийн буруутай үйлдлийг тогтоож, намайг хохироосон өмгөөлөгч

С.Ү-д хуульд заасан хариуцлага тооцож, миний хохирол гомдлыг барагдуулж өгнө үү” гэж гомдлын шаардлага тодорхойлжээ.

Өмгөөлөгч С.Ү нь Н.Ц-д хууль зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцсон, түүнийг төлөөлж өмгөөлөгчийн хувиар шүүх хуралдаанд оролцсон, магадлалыг гардаж авсан атлаа хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй, хэрэг нь давж заалдах шатны шүүхээр хэрхэн шийдвэрлэгдсэн талаар үйлчлүүлэгчдээ мэдэгдээгүй, мэдээллээр хангаагүй зэрэг үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх”-тг хориглоно, 38 дугаар зүйлийн 38.1.1-д “үйлчлүүлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн тууштай хамгаалах”, 38.1.2-д “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэгтэй”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “өмгөөлөгч өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчээс хөлс авах бөгөөд өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг өмгөөлөгч, үйлчлүүлэгч гэрээгээр харилцан тохиролцож тогтооно”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12-д “мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн нь мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч С.Ү-ийн дээрх буруутай үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзэж хариуцлага тооцох нь зүйтэй байна гэж бүрэлдэхүүн дүгнэлээ.

Харин гомдол гаргагчийн 600.000 /зургаан зуун мянган/ төгрөг гаргуулж өгнө үү гэх гомдлын шаардлагын талаар талуудын хооронд дурьдагдаж буй 600.000 /зургаан зуун мянган/ төгрөгийг өгсөн, авсан эсэх талаараа маргаантай байх тул Мэргэжлийн хариуцлагын хорооны харъяаллын шийдвэрлэх боломжгүй юм. Харин энэ 600.000 /зургаан зуун мянган/ төгрөгийг гаргуулах тухай асуудлаараа гомдол гаргагч нь харьяалах иргэний хэргийн шүүхэд хандах эрх нь нээлттэй байгаа болохыг дурьдах нь зүйтэй.

Бүрэлдэхүүн тухайн маргааныг хянан шийдвэрлэж шийтгэл ногдуулахдаа хариуцагч С.Ү нь сахилгын зөрчлийг анх удаа гаргаж байгаа биш өмнө нь тус Мэргэжлийн хариуцлагын хорооны 2015 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Хаалттай сануулах тухай” 15 дугаар тогтоолоор 16 хаалттай сануулах шийтгэл хүлээж байсан болохыг харгалзан үзсэн болно.

Иймд дээрх дурьдагдаж буй бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэж гомдол гаргагч нарын гомдлын шаардлагын зарим хэсэг нь үндэслэлтэй байх тул өмгөөлөгч

С.Ү-н шүүхэд төлөөлөх эрхийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн үзлээ.

Өмгөөлөгч С.Ү-д холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлын талаарх баримт маргааны материалд авагдаагүй.

1616/103, 17/11 дугаартай “Маргааны материал”-ын 71-72 дахь тал.

Хариуцагч С.Ү, гомдол гаргагч Н.Ц нар нь маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд өөрийн биеэр оролцох эсэх талаар тайлбар ирүүлээгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монголын Хуульчдын холбооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.2, 41 дүгээр зүйлийн 41.1, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-ыг тус тус зөрчсөн тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь хэсэгт зааснаар өмгөөлөгч С.Ү-н шүүхэд төлөөлөх эрхийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Энэ маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүй, эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүйг дурьдсугай.
3. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Хуульч, өмгөөлөгч Д.Г холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх хуралдааныг гишүүн Д.Очмандах даргалж, гишүүн Л.Амарсанаа, Б.Сугар, Ш.Одонсүрэн, Д.Мөнгөнцэцэг нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанд: Сахилгын шинжээч Б.Э, нарийн бичгийн дарга А.Х нарыг оролцуулан,

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн МД/17/007 тоот мэргэжлийн дүгнэлт үйлдсэн, хуульч Д.Г холбогдох материалыг хянан хэлэлцэв.

ТЭМДЭГЛЭХ нь:

Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э үйлдсэн мэргэжлийн дүгнэлтдээ:

Хариуцагч СХД дүгээр хороо АОС ... байранд оршин суух, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн бүртгэлийн, шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн дугаарт тус тус бүртгэгдсэн С.овогт Д. Г нь “Нээлттэй сануулах” сахилгын арга хэмжээ авагдсан байхдаа

Иргэн Ц.Б “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулахдаа мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд мөнгө өгч хэргийг чинь хэрэгсэхгүй болгож өгнө гэж урьдчилан амласан, үйлчилгээний хөлсийг 5 сая төгрөгөөр тохирохдоо үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцоогүй, үйлчилгээний явц болон хэргийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөөгүй, хэл амаар доромжилсон болох нь дараах баримт, тайлбаруудаар нотлогдоно.

Гомдол гаргагч Ц.Б тайлбартаа: “ 2016 оны 9 дүгээр сарын 19-нд гарсан хэргийн улмаас 10 дүгээр сарын 11-ний өдөр өмгөөлөгч Г-тай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан.Энэ хүн намайг өмгөөлөхөөр болоод өмгөөллийн хөлс 5 сая төгрөгөөр тохиролцсон.Гэрээнд 5 сая төгрөгөө бичихгүй юм уу? гэхэд энэ бол чи бид хоёрын асуудал, бичих шаардлага байхгүй гэсэн.Яагаад ийм үнэтэй өмгөөлдөг юм бэ гэж асуухад өмгөөлөгч Д.Г “байцаагчид нь мөнгө өгдөг, прокурор, шүүх гуравт мөнгө өгдөг тул ийм үнэтэй байгаа” гэж хэлсэн. Сүүлд 12 сард 1 сая төгрөгийн хөлс өгсөн.Надад хэлэхдээ чи аргагүй хамгаалалт хийсэн, чамайг ирж зодсон гэж хэлсэн миний дүү тайван гэртээ байж болно гэж намайг тайвшруулж байсан.2016 оны 12-р сарын 20-ны үед хэрэг прокурорт шилжсэн.Төв аймгийн хяналтын прокурор Г.Э-ын хэргийг хянаж байгаа.

Би 2017 оны 1-р сард прокурор Г.Э-тай уулзаж хэргийн материалтай танилцсан. Хэрэг 96.1-ээр хэвээр аргагүй хамгаалалт гэсэн зүйл байхгүй байсан.

Өмгөөлөгч Д.Г-тай утсаар ярьсан 96.1-р явж байгаа шүүх дээр очоод аргагүй хамгаалалт болгоод хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө гэж хэлсэн. 2017 оны 1-р сараас хойш утсаа авахаа байж байгаад нэг холбогдоход Говь-Алтайд явна гэж хэлсэн. 2017.01.13-нд ирээд прокурор дээр би өөрийн биеэр очоод зохицуулна чи ирэх хэрэггүй гэж хэлсэн. 2017.01.13-ны өдөр хэргийг прокурор шүүх рүү явуулна гэхээр нь би өөр өмгөөлөгч авч хэргийг мөрдөн байцаалтанд буцаах гэсэн хүсэлт тавиад шийдэгдээгүй байна. Энэ хүнээс татгалзсан гэдгээ хэлээд хөлсөө буцааж авах гэдэг талаар хэлэхэд өмгөөлөгч Д.Г “шоронгийн өрөөнөөсөө тоолж ав” гэж хэлсэн. Би гомдолтой байна. Надаас ийм их мөнгө авсан байж хууль зүйн туслалцаа үзүүлсэнгүй. Өмгөөллийн хөлсөө буцааж авах хүсэлтэй байна. Манай гэрт ирж архи ууж согтууран эхнэр хүүхдийг минь өмнөө сөгд гэж агсамнаж “Би та нарын авралын од та нар намайг хүндлэхгүй байна” гэж эхнэрийг минь өмнөө сөгдүүлж байсан энэ хуульч хүнд байх үйлдэл, ёс зүй мөн үү гэж гайхаж байна. Мэдээлэл өгч байгаа нь аргагүй хамгаалалт гэсэн зүйл ярьдаг. Айх юм байхгүй л гэдэг байсан. Бусдаар ямар нэг зүйл хэлдэггүй байсан. Сүүлийн 1.000.000 төгрөгийг өмгөөлөгч Д.Г-т надаас авахдаа шүүх прокурорынхон шинэ жилээ хийх гэж байна. Би тэднийг баярлуулахгүй бол хөдөлж өгөхгүй байна, энэ улсыг шоудуулж юманд оруулах хэрэгтэй байна” гэж хэлж авсан. Сүүлд 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Төв аймгийн прокурор дээр өмгөөлөгч Д.Г-тай уулзахдаа та намайг өмгөөлүүлэхээс татгалзсан байхад яагаад миний хэрэгт яваад байна вэ гэхэд, хүн юм чинь өөрийгөө хамгаалах ажил хийж явна” гэж хэлээд хүсэлтүүдээ надад үзүүлж байсан. Нэг хүсэлт нь цаад хоёрын зүйл ангийг хүндрүүлэх хүсэлт байсан. Намайг хэргийн материалтай танилцахад ийм хүсэлт байгаагүй...” гэжээ.

Хариуцагч Д.Г тайлбарлахдаа: “...Төв аймгийн Бүрэн сумын харьяат Ц.Б харилцан тохиролцож хууль ёсны эрх ашиг сонирхолыг хамгаалахаар 2016.10.11-ны өдөр гэрээ байгуулан ажиллах болсон. Гэрээ хийснээс хойш 2017.01.19-ний өдрийг хүртэл 3 сар гаруй хугацаанд миний бие Төв аймаг руу өөрийн унаагаар 8 удаа Төв аймгийн Бүрэн сум руу 2016 оны 11 дүгээр сарын дундуур цасан шуургатай өдөр төөрч будлин, ирэх очихын 700 км явж миний үйлчлүүлэгч Ц.Б хэзээ, хэрхэн яаж зодуулсныг, хохирсныг нотлох, Ц.Б-ийн ах дүүс, эхнэрийх нь ах дүүсийг байцаалгуулахаар мөрдөн байцаагч ахмад Ууганбаатарыг 3 хоногийн хугацаатай авч явсан. Ингэж явсны гол зорилго нь цас зуд ихтэй, хатуу ширүүн өвлийн хүйтэнд, хүн хүч муу, малчид болох олон гэрчийг Төв аймгийн төвд очуулж, байцаалт өгүүлж, хугацаа алдаж чирэгдүүлэхгүй гэсэн сайхан сэтгэл өвөрлөж явсныг Ц.Б болон түүний зөвлөх эгч хамт явсан н.Ц нь мэднэ. Явах болгондоо бензин шатахуун, хоол ундны зардлаа өөрөө дааж явж байсан. Хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа дуусч прокурорын шатанд 2017 оны 01 дүгээр сарын 02-ноос үндсэндээ шилжин очиж албан ёсоор хянагдсан. Энэ хугацаанд өмгөөлөгч миний бие 2016 оны 12 дугаар сарын 5-нд эхний удаа / хариугаа албан ёсоор авсан/, 2017 оны 01 дүгээр сарын 13-нд хоёрдох удаа, 2017.10.19-нд 3 дахь удаа аймгийн прокурорт тус тус гомдол гаргасан. Ингээд 2017.01.13-нд Төв аймгийн Прокурорын Газар очиж хяналтын прокурор Г.Э-тай өөрийн үйлчлүүлэгч Ц.Б нь өөр өмгөөлөгч нэмж авсан тухай сонсож мэдсэн. Энэ үед намайг татгалзсан гэдгийг мэдээгүй. Хэрэг прокурорын хяналтанд байсан одоо ч байгаа. Миний бие Ц.Б-ийн гомдолдоо бичсэнчлэн юу ч хийгээгүй, намайг

доромжилж “Хүний зовлонгоор жаргал хийсэн луйварчин, залилагч, гэмт хэрэгтэн” хэмээн дайрч давшилсныг хэзээ ч хүлээж авах боломжгүй. Харин зохих журмын дагуу шалгуулж өөрийн бичсэн тайлбараа нотлуулахыг хүсч байна...” гэжээ.

Гэрч Ж.Б тус хороонд өгсөн тайлбартаа: Д.Г өмгөөлөгч бидэнд хэлэхдээ Төв аймаг 6-8 удаа орно, Бүрэн сум 1-2 удаа орж хэрэг болсон газрыг хар зургаар гаргана тэгээд байцаагч, прокурор, шүүгч гээд шат шатанд нь мөнгө өгдөг, тиймээс ийм өндөр үнэтэй байгаа юм аа гэж хэлсэн... Д.Г нь өмгөөлөгч би том хүн надтай баргийн хүн харьцдаггүй би байцаагчийг чинь аргална чи хөдөө явж бай мал хуйгаа янзлаад ир 7 хоногийн чөлөө өгье гэсэн бид 2 хөдөө ирээд мал маллах хүн олоод малаа хүнд өгчихөөд 7 хоноод очиход байцаагч нь загнаад хорино гэж загнаад байхад Д.Г өмгөөлөгч юу ч хэлж чадахгүй хоригдохын даваан дээр таньдаг ахаараа яриулж байгаад батлан даалтанд авахуулж гарсан. 2016 оны 11 дүгээр сарын 20-нд байцаагчийг аваад Д.Г өмгөөлөгч Бүрэн суманд ирсэн “ах нарыг чинь байцаана, ах нарт чинь үг зааж өгнө” гэсэн боловч хэнд нь ч үг зааж өгөөгүй архи нилээн уугаад согтчихоод ах нарыгаа дуудаж байцаалт өгүүл, би байцаагчийг чинь авчирсан, би хийх юм аа хийсэн. Би та нарын авралын од, намайг хүндэлсэнгүй, миний өмнө сөхөр гэж загнаад би ханиа ялтан болгохгүйн тулд өмнө нь сөхөрсөн. Д.Г өмгөөлөгч би хувилгаан хүний хойд дүр, би та нарын амьдралыг яаж л бол яаж эргүүлнэ шүү гэж дарамтласан. Цагдаагийн ёолк 25-нд юм байна эд нарыг ёолкоор шоудуулахгүй бол болохгүйнээ 1.000.000 төгрөгөө 25-аас өмнө өг гэсэн, тэгээд би нээрээ тэгэх юм болов уу гээд 12 дугаар сарын 20-нд Д.Г өмгөөлөгчийн Хаан банкны 5034425463 тоот дансанд 1.000.000 төгрөгийг шилжүүлсэн. 12 дугаар сарын 25-нд Д.Г өмгөөлөгч рүү залгаад “... 25-нд очиж янзална гээд байсан чинь яваа гэхэд хуц пизда минь би ажлаа мэдэж байна, миний ажлыг битгий заагаад бай” гэж загнисанд айсандаа би утсаа тасалсан. 2017 оны 01 дүгээр сарын 05,06 залгахад Д.Г өмгөөлөгч утсаа аваагүй ... бид 2017 оны 01 дүгээр сарын 09-нд нэмэлтээр Шинэцэцэг өмгөөлөгчийг авч хавтаст хэрэгтэйгээ танилцсан. Д.Г өмгөөлөгч хавтаст хэргийн талаар юу ч танилцуулаагүй бүх мэдээлэл чиний талд эргэсэн гээд яриад байсан бүх юм худлаа байсан тул өмгөөлөгчид гомдож байна, хүний 5.000.000 төгрөг авчихаад арай ч дээ юу ч хийгээгүй дандаа худлаа ярьдаг ам ажил хоёр нь дандаа зөрдөг болохоор нь бид татгалзсан бөгөөд бидний мөнгийг өг гэхэд чи шоронд орчихоод шоронгийн өрөөнөөс надаас мөнгөө тоолж аваарай гэсэн. Биднийг татгалзсанаас хойш 2 удаа Төв аймаг орж 2 хүсэлт прокурорт өгсөн. Яагаад татгалзчихаад байхад юу хийгээд байгаа юм бэ гэхэд Монголын Хуульчдын холбоо гэж байдаг юм тэнд өргөдөл өг тэгсэн тохиолдолд би өргөдлөө зогсооно, тэр болтол хийсэн юмтай байх гэж өөрийгөө хамгаалж байна гэсэн. Монголын Хуульчдын холбоо чинь намайг хамгаалдаг байгууллага бараг “та нарын наад гомдол саналыг чинь хүлээж авахгүй, та нарыг тоохгүй, та нар юу ч олж долоохгүй, хоосон хоцорно” “ухааны юм хэлж байсан” гэжээ.

Төв аймгийн хяналтын прокурор Г.Э тайлбартаа:

“...Эрүүгийн хэрэгт хяналт тавьж ажиллах хугацаанд өмгөөлөгч Д.Г нь өөрийн үйлчлүүлэгч Ц.Б-ийн байдлыг хөнгөрүүлэх чиглэлээр тус аймгийн прокурорын газарт 3 удаа гомдол гаргасан байна. Гомдлын хариуг хуульд заасан хугацааны

дотор өмгөөлөгч Д.Г-д мэдэгдэж байсан юм. Харин өмгөөлөгч Д.Г-тай тус аймгийн прокурорын газрын прокурор, ажилчид болоод хяналтын прокурор Г.Э миний бие ямар нэгэн харилцаа холбоо байхгүй, Д.Г гэх хүнийг хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий өмгөөлөгч гэдгээр нь таних төдий, мөн манай хамт олон, миний бие өмгөөлөгч Д.Г-тай шинэ жилийн баярыг хамт тэмдэглэсэн асуудал байхгүй болохыг албан ёсоор хариуцлагатайгаар мэдэгдэж байна” гэжээ.

Төв аймгийн Прокурорын газрын 2017-02-16-ны өдрийн 5/195 дугаар албан тоот болон хавсралтанд: “...Гомдол хүсэлтийн бүртгэлийн дугаар 32 дугаарт “Д.Г 2017-01-13-нд гомдол гаргасыг 2017-02-02-нд гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн”, 25 дугаарт Д.Г 2017 оны 01 дүгээр 19-нд гомдол гаргаж 2017 оны 02 дугаар сарын 08-нд гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн” гэж бүртгэсэн байна. Мөн өмгөөлөгч Д.Г-ын зүгээс гаргасан гомдол, хүсэлтүүд, тэдгээрт өгсөн хариу зэргийг хавсаргажээ.

Төв аймгийн Цагдаагийн газрын мөрдөн байцаагч Т.У-ын тус хороонд ирүүлсэн тайлбарт: “... Д.Г өмгөөлөгч надад тэндээс наад хүмүүс чинь ирэх боломжгүй байна аа харин чи өөрөө асуучих би өөрийнхөө унаа тэргээр Төв аймгийн Бүрэн сумын нутаг руу явах гэж байна чи хамт явж ажиллагаа хийчих гэх амаар хүсэлт гаргасны дагуу түүний тээврийн хэрэгсэлтэй хамт явж Бүрэн сумын нутагт Цагдаагийн хэсгийн байранд гэрч нарыг дуудаж байцаасан юм. Ямар нэгэн албан томилолт аваагүй. Д.Г өмгөөлөгч гэрчийг байцаах ажиллагаанд оролцох талаар хүсэлт гаргаагүй... би Д.Г өмгөөлөгчтэй ямар ч харилцаа холбоо байхгүй ...” гэжээ.

Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэсэн бүрэлдэхүүний 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 10 дугаар тогтоолд: “... яллагдагч А.У-д хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ бичгээр гэрээ байгуулаагүй болох нь тогтоогдож байх ба энэ нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хуульч зүйн үйлчлэлгээ үзүүлэх гэрээ бичгээр байгуулна” гэснийг зөрчсөн нь нотлогдож байна... нээлттэй сануулах шийтгэл ноогдуулсугай...” гэжээ.

Иймд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзээд Мэргэжлийн дүгнэлт үйлдэн холбогдох баримтын хамт маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шилжүүлсүгэй гэсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Хуульчдын холбооны тамгын газраас ирүүлсэн албан тоотод: “Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч Д.Г /РД...../ нь Хуульчийн эрх зүйн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, 26.1.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу 2014 онд 5,5; 2015 онд 5,5; 2016 онд 4,5 багц цагийн сургалтанд тус тус хамрагдан 2016 оны 06 дугаар сарыг дуустал хугацааны гишүүний татвараа төлсөн байна” гэсэн байх тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 1.4-т заасан хариуцагчаар оролцох этгээд мөн байна.

Маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн гомдлын материалд авагдсан бичгийн нотлох баримт болон болсон үйл баримтыг шинжлэн судлаад дараах дүгнэлтийг хийлээ.

Өмгөөлөгч Д.Г нь иргэн Ц.Б-той 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж, эрх зүйн талаас нь мэргэжлийн туслалцаа үзүүлж байсан болох нь гомдлын материалын 9 дүгээр талд авагдсан “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”, 19, 25, 26 дугаар талд авагдсан Төв аймгийн прокурорт гаргасан гомдол, хүсэлт, түүний бүртгэл, прокурорын 2 удаагийн тогтоол, 2 удаагийн хариу мэдэгдэх хуудас, прокурорын Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан тайлбар зэрэг баримтуудаар нотлогдоно.

Мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд мөнгө өгч хэргийг чинь хэрэгсэхгүй болгож өгнө гэж урьдчилан амласан гэдэг нь баримтаар нотлогдоогүй, үйлчилгээний хөлсийг 5.000.000 төгрөгөөр тохирохдоо үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцсон, үйлчилгээний явцын талаар үйлчлүүлэгчдээ тухай бүрд нь мэдэгдэж байсан болох нь талуудын тайлбараар нотлогдож байна.

Харин Төв аймгийн Бүрэн сумын нутагт үйлчлүүлэгч Ц.Б-ийн гэрт очиж, архи уун, үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийнхэнд зохисгүй авир гаргасан, дараа нь үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн хүнийг утсаар болон биеэр хэл амаар доромжилсон үйлдэл гаргасан болох нь гомдол гаргагч Ц.Б-ийн гомдол, гэрч Ж.Б, н.Ц нарын Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдол, мэдүүлэг, хариуцагчийн өөрийнх нь хуралдаанд гаргасан архи ууснаа хүлээсэн тайлбар зэргээр нотлогдох бөгөөд энэхүү үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон Хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх хориглоно”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д “зарчимч байх”, 1.12-т “Мэргэжлийн үүрэгтэй үнэнч байх, Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 2.1 дүгээр зүйлийн 1-д “... Хуульч нь ... дарамт, шахалт үзүүлж болохгүй гэж заасныг тус тус зөрчсөн болох нь нотлогдож байна.

Хариуцагч хуульч, өмгөөлөгч Д.Г энэхүү үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч Д.Г үйлдлийг Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаарт зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзэж түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна гэж маргаан шийдвэрлэх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Хариуцагч Д.Г Мэргэжлийн хариуцлагын хорооны 2016 оны 03 дугаар сарын 11- ний өдрийн 10 дугаартай Маргаан шийдвэрлэсэн бүрэлдэхүүний тогтоолоор “Нээлттэй сануулах” сахилгын шийтгэл хүлээж байсан бөгөөд энэхүү зөрчлийг давтан гаргасан гэж үзэх үндэслэлтэй. Гомдол гаргагч Ц.Б өмгөөллийн хөлсөнд төлсөн 5.000.000 төгрөгийг гаргуулахыг гомдлоор шаардсан бөгөөд энэ талаарх гомдлоо нотлох баримтын үндсэн дээр иргэний журмаар жич шийдвэрлүүлэх эрх нээлттэй болохыг дурьдаж байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх тухай журмын 14.4 дүгээр зүйлийн 1, 14.5, 14.6 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульч өмгөөлөгч Д.Г-ын шүүхэд төлөөлөх эрхийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлэх шийтгэл ногдуулсугай.
2. Тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Хуульч Г.Г холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн Т.Энхжаргал даргалж, гишүүн С.Буд, Т.Дэлгэрмаа, Ш.Одонсүрэн, Г.Батбаяр нарын бүрэлдэхүүнтэй, тус хорооны танхимд хийсэн гомдол хянан шийдвэрлэх хуралдаанаар:

Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн МД/17/004 дугаартай Мэргэжлийн дүгнэлтийн дагуу хуульч Г.Г холбогдуулан гаргасан гомдлыг хянан хэлэлцэв.

Хуралдаанд: Сахилгын шинжээч Г.Д, гомдол гаргагч Э.Б, хуралдааны нарийн бичгийн дарга У.Г нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч Э.Б гомдол, тайлбартаа:

2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр өмгөөлөгч Г.Г-тай Э.Б- буюу дүүгээ төлөөлж Э.Б миний бие эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ хийсэн. Гэрээ хийсэн тухайн өдөр өмгөөлөгч Г.Г нь үйл ажиллагааны зардалд 2,000,000 төгрөг нэхэмжилснийг бэлнээр өгсөн. Өмгөөлөгч Г.Г нь байцаан шийтгэх ажиллагааны үеэр байцаалт өгөх үед удаа дараа ирээгүй утсаа авахгүй алга болсон. 2016 оны 11 дугаар сарын 11-ний өдөр миний дүү Э.Б 461 дүгээр анги руу явж хоригдох үед өмгөөлөгч Г.Г мөн л утсаа аваагүй, ирээгүй. 12 дугаар сарын 20-ны өдөр 461-ээстүр гарч сэтгэц үзүүлэхэд, мөн байцаагдахад ирнэ гэсэн боловч бас л ирээгүй, яллагдах тогтоол дээр өмгөөлөгчгүйгээр юу ч мэдэхгүй гарыг үсэг зурсан...удаа дараа биднээс дахин дахин 1,000,000 төгрөг нэхсэн. Иймд удаа дараа бидний өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа авах хүсэлтэй үеэр ирээгүй, цаг хугацаа алдаж үүргээ хангалттай биелүүлээгүй гэж үзэж маш их гомдолтой байна. Бидний гэхчээд товлосон цагтаа ирээгүй, уулзаагүй, нотлох баримтууд цуглуулах ажиллагаанд хүсэлт тавьж шалгуулж ажиллаагүй, хүсэлтийнхээ хариуг буцааж аваагүйгээс маш их хугацаа алдсан учраас бид бүгд маш их гомдолтой байна. Өмгөөлөгч Г.Г бид нар 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр татгалзаж байгаагаа хэлж өгсөн мөнгөнийхөө тал мөнгө буюу 1,000,000 төгрөг буцаан авах хүсэлт тавьсан боловч одоог хүртэл өгөөгүй, утсаа авахгүй байна гэжээ.

Хариуцагч Г.Г гомдолд гаргасан тайлбартаа:

...Өргөдөл гомдолтой танилцсаны үндсэн дээр дараах тайлбарыг гаргав. Үүнд:
1. Өргөдөл гаргагч иргэнтэй "Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ"-г байгуулсан. Гэрээ байгуулснаар бидний хооронд эдийн засаг, эрх зүйн харилцаа үүссэн. Эрх зүйн

туслалцаа авагч талаас 2,000,000 /хоёр сая төгрөг/ төгрөгийг үйлчилгээний хөлсөнд бэлнээр авсан. Эрх зүйн туслалцаа авагч тал өөрсдийн хамаатан садан болох өмгөөлөгчөөр өмгөөлүүлж эрх ашгаа хамгаалуулах болсноо, өмгөөлөгч надаас татгалзаж байгаа тухайгаа утсаар мэдэгдэн үйлчилгээний хөлсөнд өгсөн 2,000,000 /хоёр сая төгрөг/ төгрөгийн 50% болох 1,000,000 /нэг сая/ төгрөгийг буцааж авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Өмгөөлөгч миний зүгээс хүсэлтийг хүлээн авсан. Иргэн Э.Б-ээс мессэжээр ирүүлсэн дансанд 1,000,000 /нэг сая төгрөг/-ийг буцааж шилжүүлсэн болно... Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулж өмгөөлөгч миний бие эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон. Гэмтэл согог судлалын үндэсний төвд тархины мэс засалд орсон, ухаангүй байдалтай хэвтэн эмчлүүлж байгаа иргэнийг эмчлэгч эмчтэй нь өргөдөл гаргагч иргэн Э.Б хамт биечлэн уулзаж хохирогчийн биеийн байдлын талаар мэдээлэл авсан. Иргэн Э.Б нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон байсан. Шүүх шинжилгээний үндэсний төвийн шинжээчийн дүгнэлт гарснаар сэжигтэнийг яллагдагчаар татаж ял сонсгон байцаалт авсан, өмгөөлөгч миний бие оролцсон гэжээ.

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлтэд:

Хариуцагч Г.Г нь эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байсан Э.Б эрх, хууль ёсны эрх ашгийг нь хамгаалахаар иргэн Ж.Б-тэй тохиролцон “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж, үйлчилгээний хөлсөнд өөр ямар нэг үйлчилгээ үзүүлээгүй; Үйлчлүүлэгч мэдээлэл хүссэн үед мэдээлэл өгдөггүй, байцаалтанд дуудахаар ирдэггүй утсаа авдаггүй; Үндэслэлгүйгээр мөнгө нэхсэн зэрэг үйлдлүүд нь үйлдлээрээ Хуульчийн эрх зүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1.1 “Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих... хориглоно”, 27.1.2 “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх...хориглоно”, 38 дугаар зүйлийн 38.1.1-д “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн, тууштай хамгаалах”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1 “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай зохион байгуулалттай ажиллана”, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх”, 2.4 дүгээр зүйлийн 2-т “хуульч нь үндэслэлгүйгээр хөлс, зардал тогтоох, авахыг хориглоно”, 2.7 дугаар зүйлийн 3-т “хуульч нь үйлчлүүлэгчээс үйлчилгээний хөлс, зардлаас гадна бэлэг, шан харамж шаардах, шууд эсхүл шууд бусаар дарамт үзүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.1-ийн хориглосон үйлдэлд хамаарч байх тул хариуцагч Г.Г үйлдлийг Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гэж үзээд Мэргэжлийн дүгнэлт үйлдэн холбогдох баримт сэлтийн хамт маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шилжүүлэв гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Мэргэжлийн дүгнэлт үйлдэн, хуульч, өмгөөлөгч Г.Г нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил” гаргасан гэж үзэж маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд маргааны материалыг шилжүүлжээ.

Г овогтой Г нь Монголын Хуульчдын холбооны нэгдсэн бүртгэлийн №..., шүүхэд төлөөлөх эрхийн №....дугаарт бүртгэлтэй болох нь Монголын Хуульчдын холбооны 2017 оны 02 дугаар са(рын 07 дугаартай албан бичгээр тогтоогдож байна.

Сахилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлтээр

1. Өмгөөлөгч Г.Г нь эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байсан Э.Б эрх, хууль ёсны эрх ашгийг нь хамгаалахаар иргэн Ж.Б-тэй тохиролцон “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж, үйлчилгээний хөлсөнд 2,000,000 төгрөг авсан боловч байцаан шийтгэх ажиллагаанд 1 удаа оролцоноос өөр ямар нэг үйлчилгээ үзүүлээгүй,
2. Үйлчлүүлэгч мэдээлэл хүссэн үед нь мэдээлэл өгдөггүй, байцаалтанд дуудахаар ирдэггүй, утсаа авдаггүй,
3. Үндэслэлгүйгээр мөнгө нэхсэн гэсэн үйлдлүүд тогтоогдсон гэж үзсэн байна.

Хариуцагч Г.Г нь 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Э.Б “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-г байгуулж, Э.Б нь эрүүгийн хэрэгт эрх ашгаа хамгуулахаар, үйлчилгээний хөлсийг нэмэлт гэрээгээр зохицуулахаар харилцан тохиролцсон байна.

Баянзүрх дүүргийн Цагдаагийндугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Л.Б нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар үүсгэсэн эрүүгийн хэрэгт 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Сэжигтнээр тооцох тогтоол” үйлдэж, мөн өдөр Э.Б сэжигтнээр байцаахад өмгөөлөгчөөр Г.Г оролцсон болох нь “Сэжигтнээр тооцох тогтоол”, “Сэжигтнээр байцаасан тэмдэглэл” зэргээр тогтоогдож байна. / материалын 25-28 тал/

Мөн өмгөөлөгч Г.Г нь 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийндугаар хэлтэст хүсэлт гаргасныг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т зааснаар мөрдөн байцаагч хүсэлтийг бүрэн хангасан боловч Г.Г нь өөрөө ирж хүсэлтийн хариугаа аваагүй болох нь Г.Г-н хүсэлт, мөрдөн байцаагчийн тогтоол, мөрдөн байцаагчийн тайлбараар тогтоогдож байна. / материалын 86-88, 90 тал/

Ийнхүү Э.Б сэжигтнээр байцаахад болон нэг удаа бичгээр хүсэлт гаргаснаас өөр байдлаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хариуцагч Г.Г нь эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу оролцоогүй, өөр ажиллагаанд оролцсон гэж Г.Г нь тайлбартаа дурьдсан боловч уг тайлбар, татгалзлаа нотлоогүй байна.

Дээрхээс дүгнэвэл сахилгын шинжээчийн Мэргэжлийн дүгнэлтэд заасан хариуцагч Г.Г нь үйлчлүүлэгч мэдээлэл хүссэн үед нь мэдээлэл өгдөггүй,

байцаалтанд дуудахаар ирдэггүй, утсаа авдаггүй байсан болох нь маргааны материалд авагдсан бичгийн баримтаар тогтоогдож байх бөгөөд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1-д “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана”, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т “үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх” үүргээ хуульч, өмгөөлөгч Г.Г нь биелүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Талууд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу үйлчилгээний хөлсийг 2,000,000 төгрөгөөр тохирч, уг хөлсийг үйлчлүүлэгч талаас өмгөөлөгчид төлсөн, үйлчлүүлэгч нь Г.Г-с татгалзаж буйгаа илэрхийлж тал мөнгө болох 1,000,000 төгрөгийг буцаан авах хүсэлт тавьсаны дагуу мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол гаргаснаас хойш буюу 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хариуцагч Г.Г нь гомдол гаргагчид өмгөөллийн хөлсний буцаалт гэж 1,000,000 төгрөгийг шилжүүлсэн болох нь талуудын тайлбар, Хаан банкны орлогын мэдүүлэгийн баримтаар тогтоогдож байна. /материалын 17 тал/

Сaxилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлтэд дурьдсан “Үндэслэлгүйгээр мөнгө нэхсэн гэсэн үйлдэл”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.4 дүгээр зүйлийн 2, 2.7 дугаар зүйлийн 3 дахц хэсэгт заасан зөрчил нь маргааны материалд авагдсан бичгийн баримтаар тогтоогдсонгүй.

Иймд дээрх үндэслэлүүдээр хуульч, өмгөөлөгч Г.Г нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1, 2.3 дугаарзүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т тус тус заасныг зөрчсөн байх тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д зааснаар нээлттэй сануулах шийтгэлийг ногдуулах нь зүйтэй гэж маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн дүгнэв.

Маргаан хянан шийдвэрлэх хуралдааны товыг хариуцагч Г.Г-д 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр түүний 99118675 дугаарын утсаар мэдэгдсэн боловч тэрээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй байх тул Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 12.7 дугаар зүйлийн 3-т зааснаар түүний эзгүйд маргааныг хянан шийдвэрлэсэн болно.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4, 14.5, 14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар хуульч, өмгөөлөгч Г.Г-д “Нээлттэй сануулах” шийтгэл оногдуулсугай.
2. Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 17.1 дугаар зүйлийн 1-д зааснаар хариуцагч эсхүл сахилгын шинжээч бүрэлдэхүүний тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 34

Улаанбатаар хот

Сахилгын шийтгэл оногдуулах тухай

Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн Д.Очмандах даргалан, гишүүн Ш.Бат-Эрдэнэ, Д.Мөнгөнцэцэг, Ш.Одонсүрэн, Б.Баатар нарын бүрэлдэхүүнтэйгээр Сахилгын шинжээчээс хариуцагч, хуульч Б.Э-д сахилгын “Хаалттай сануулах” шийтгэл хүлээлгэх санал гаргасныг холбогдох нотолгоо баримтын хамт 2017 оны 11 сарын 08-ны өдөр хүлээн авч хянан үзээд,

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Хариуцагч: 1979 оны 3 сарын 31-ний өдөр төрсөн /РД:/, эрэгтэй, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуульчдын нэгдсэн бүртгэлийндугаарт, шүүхэд төлөөлөх эрх бүхий хуульчдын бүртгэлийн дугаарт тус тус бүртгэгдсэн, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч ажилтай Боржигон овогт Б.Э нь Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 7 сарын 03-ны өдрийн 10.00 цагт товлогдсон Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны товыг мэдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүйгээс шүүх хуралдаан хойшилсон байна.

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч тус хороонд ирүүлсэн гомдолдоо: “Өмгөөлөгч Б.Э-н энэ үйлдэл нь шүүхийг үл хүндэтгэсэн, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан, үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хохироосон, шүүх хуралдаанд дуудагдан ирсэн бусад оролцогч нарыг бухимдуулсан, улмаар шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхөд хүрсэн үйлдэл болсон. Иймд Б.Э-н нь өмгөөлөгчийн хувьд Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасныг зөрчсөн байж болзошгүй тул дээрх үйлдлийг шалгаж өгнө үү” гэжээ.

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017.07.03-ны өдрийн шүүх хуралдааны 275 дугаар тэмдэглэлд: “...Насанд хүрээгүй шүүгдэгч Д.М-ны өмгөөлөгч Б.Э-н шүүх хуралдаанд ирээгүй тухай хуралдааны ирцийг танилцуулахад тэмдэглэгдсэн, ...шүүх хуралдааныг 2017 оны 7 сарын 19-ний өдрийн 09 цагт хуралдуулахаар хойшлуулсан тухай тэмдэглэгдсэн байна. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 7 сарын 03-ны өдрийн 275 дугаар тогтоолоор тус шүүхэд хянагдаж байгаа Д.М нарын 22 хүнд холбогдох 201511000291 дугаартай эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшлуулжээ.

Хариуцагч Б.Э нь тус хороонд гаргасан тайлбартаа: “МХХ-ны гишүүн, өмгөөлөгч Б.Э миний бие Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд насанд хүрээгүй шүүгдэгч Д.М-ны хууль ёсны эрхийг хамгаалахаар томилогдон ажиллаж

байгаа болно. Миний бие шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тул хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хариуцлага хүлээхэд татгалзах зүйлгүй болно. Иймд надад хаалтай сануулах арга хэмжээ авч өгнө үү. Миний бие Д.М-ны эрхийг тууштай хамгаалах болно” гэсэн тайлбар гаргажээ.

Сахилгын шинжээчийн 2017 оны 10 сарын 30-ны өдрийн №70 санал: “Хариуцагч Б.Э нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “хуульчийн Мэргэжлийн дүрмийг зөрчих...”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлийн 1-д “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана”, 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхолд нийцүүлэн хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах талаар чармайн ажиллана”, 2.-т “Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих...зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн байх тул Маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д зааснаар Б.Э-д сахилгын хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргав” гэжээ.

Хариуцагч, зөрчил гаргаснаа шударгаар хүлээн зөвшөөрч чин сэтгэлээсээ гэмшин цаашид дахин зөрчил гаргахгүйгээ илэрхийлсэн, “үйлчлүүлэгч, олон нийт, хууль зүйн тогтолцоо, эсхүл Мэргэжлийн нэр хүндэд бодитой хохирол” учирсан нь тогтоогдоогүй тул Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон хариуцагч Б.Э-нд сахилгын хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргав.” гэжээ.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Э нь насанд хүрээгүй шүүгдэгч Д.М-ны хууль ёсны эрхийг хамгаалахаар томилогдон ажиллахдаа Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 7 сарын 03-ны өдрийн 10.00 цагт товлогдсон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны товыг мэдсэн боловч тухайн хуралдаанд оролцох боломжгүйгээ урьдчилж шүүхэд бичгээр мэдэгдээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй нь шүүх хуралдаан хойшлуулах үндэслэл болсон байна.

Хариуцагч Б.Э нь энэ үйлдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгүүдэд заасан хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах заалтыг болон 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандаж, хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллах заалтыг тус тус зөрчсөн мөн дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан байна гэж үзлээ.

Энэ зөрчил нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1.-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хориглосон үйлдэл болно.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан хариуцагч Б.Э нь гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрч, гэмшиж байгааг болон Сахилгын шинжээчийн 2017 оны 10 сарын 30-ны өдрийн Хаалттай сануулах саналыг бичгээр мэдэгдсэнийг хариуцагч Б.Э нь 2017 оны 11 сарын 03-ны өдөр хүлээн аваад Маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан 14 хоногийн дотор нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар тухай маргааныг шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй тул мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар сахилгын шийтгэлийг зөвшөөрснийг харгалзан хуульч Б.Э-нд сахилгын “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үзлээ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1., 63 дугаар зүйлийн 63.1., Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 10.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 14.4., 14.5., 14.6. дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1,-д заасныг баримтлан хуульч Б.Э-нд “Хаалттай сануулах” шийтгэл оногдуулсугай.
2. Зөрчлийн товч агуулгыг Хуульчдын холбооны цахим хуудаст нийтэлж болохыг дурдсугай.
3. Энэ тогтоолыг Б.Э-нд гардуулан өгөхийг Ажлын албанд даалгасугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 27 өдөр

Улаанбаатар хот

Хуульч Н.Г-т холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдийн зөвлөгөөнийг гишүүн Д.Мөнгөнцэцэгийн илтгэснээр гишүүн Б.Баатар, Ш.Бат-Эрдэнэ, Д.Очмандах, Ш.Одонсүрэн нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын холбооны хурлын танхимын зөвлөлдөх тасалгаанд хаалттай явуулж хуульч Н.Г хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээч Б.Э-н саналыг хянаад

ТОДОРХОЙЛОХ нь

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн санал:

“Хариуцагч Н.Г нь эрүүгийн тбт хэргийн сэжигтэн, яллагдагч Э.Т-д хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, үйлчилгээ үзүүлэх явцдаа тус эрүүгийн хэргийн хохирогч, иргэний нэхэмжлэгч Н.Ц-д хууль зүйн туслалцаа үзүүлж ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байна. Хариуцагч Н.Г нь дээрх үйлдлээрээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн 38.1.2-т “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.11-д “ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх”, 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... хуульч үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчид ашиг сонирхлын зөрчил бий болгохоор байвал үйлчилгээ үзүүлэхийг хориглоно”, 2 дахь хэсгийн 2.1-д “нэг үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчийн бусад үйлчлүүлэгчийнх нь шууд эсрэг байх” гэж заасныг тус тус зөрчсөн, гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн байх тул өмгөөлөгч Н.Г-н үйлдлийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэж үзлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныг удирдлага болгон Хариуцагч Н.Г-т сахилгын Хаалттай сануулах шийтгэл оногдуулах санал гаргаж байна” гэжээ.

Сахилгын шинжээчийн саналтай холбогдуулж дараах баримтуудыг хэлэлцэв.

Үүнд:

Гомдол гаргагч Ж.Ц нь тус хороонд гаргасан гомдолдоо: ... миний бие нь ... өөрийн өмч болох 1 ерөө байраа 2014 оны 8-р сард Э.Т гэгчид Капитал банкны барьцаанд тавьж 32.0 сая төгрөг бэлнээр өгч залилуулсан ... Э.Т нь бэлэн мөнгө авч явснаас хойш утсаа авахгүй, холбогдохгүй сураг тасарч, эхнэртэй нь уулзахад Баянгол дүүргийн цагдаагийн...хэлтэст шалгагдаж байгаа гэхээр нь БГД-ийн цагдаагийн

газар явж очтол Э.Т нь манай компанийн өмгөөлөгч /н.г/ гэгчтэй цуг явж байхад нь таарсан. Энэ хүн миний өмгөөлөгч бүгдийг мэдэж байгаа гээд утсыг нь өгсөн 2015 оны 5 сард Капитал банк Нийслэлийн иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан тухай Э.Т хэлэхэд өмгөөлөгчөө явуулна гээд Н.Г өмгөөлөгч 2015 оны 6 дугаар сарын 19-нд анхан шатны шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орж 3 шатны шүүхэд миний өмнөөс оролцсон ... давж заалдах, дээд шүүхийн тогтоолыг 2016 оны 8 сард авчирч өгсөн. Энэ хугацаанд Э.Т нь банкны мөнгийг төлөөгүй бөгөөд 2015 оны 12 сард Э.Т эрүүгийн хэрэг үүсгэн цагдан хорьсон ... 2015 оны 5 сараас Н.Г өмгөөлөгч надтай байнга уулзаж танай байрыг яаж ч байсан алдахгүй гэж итгүүлэн надаас 3 300 000 төгрөг бэлнээр авсан ... одоо 2016 оны 12 сараас Э.Т холбогдох эрүүгийн шүүх хурал зарлагдахад Э.Т-н өмгөөлөгчөөр оролцож байгаад би их гайхаж байна ..." гэжээ. /ММ-н 3-4-р хуудас/

Хариуцагч Н.Г тус хороонд ирүүлсэн тайлбартаа:

Өмгөөлөгч Н.Г би анх 2014 оны 4-р сард иргэн Э.Т-н хүсэлтээр Ж.Т, Б.Д нарт 34,5 сая төгрөгөө өгч хохирсон асуудалд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахад нь хууль зүйн туслалцаа үзүүлж өмгөөлөгчөөр нь ажилласан. Энэ хэрэг дээр ажиллаж байх явцад Э.Т-тэй өөртэй нь холбоотой бусдаас мөнгө төгрөг авсан тухай гомдлууд зарим дүүргийн Цагдаагийн хэлтсүүдэд иргэдээс ирж БГД-ийн Цагдаагийн... хэлтэс дээр түүнтэй хамт тайлбар мэдүүлэг өгөх үед нь оролцож явахад Ж.Ц гэх эмэгтэй Э.Т-тэй уулзаж байсан. Гэтэл түүнээс хойш Э.Т. Ж.Ц нар нь надтай олон удаа утсаар холбогдон уулзаж Ж.Ц-д банкнаас зээлийн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байгаа тул өмгөөлөгчөөр оролцож өгөхийг олон удаа гуйж хүссэн У.Ц, Э.Т нар нь надтай хэд хэдэн удаа уулзахдаа Ж.Ц-н байрыг барьцаалж банкнаас авсан зээлийн мөнгөөр компьютерийн тоглоомын газар ажиллуулж байсан боловч эрсдэлд орон мөнгөө төлж чадахгүй байгаа, шүүхээс банктай эвлэр гэж шаардаж загнаж, байраа алдахдаа тулаад байгаа тул шүүхийн маргаанд өмгөөлөгчөөр оролцож туслахыг гуйцгаасан. Ж.Ц нь би шүүхээс айж байна шүүгчийн туслах эмэгтэй намайг загнаад банктай хурдан эвлэр гээд би үг ч хэлж чадахгүй чичрээд гардаг, байрыг хураалгахгүй хугацаа хэрэгтэй байна, бид нар байраа хураалгахгүйгээр мөнгөө банкинд төлнө гэж ярьж байсан. Тэр 2 бид өр шир ихтэй, банкны мөнгө төлөх шаардлагатай байгаа тул одоогоор хөлс мөнгө төлөх боломжгүй байна гэсэн Эхлээд Ж.Ц-тэй өмгөөллийн гэрээ хийж шүүх хуралд орохоор болсон боловч Ж.Ц нь өдөр болгон ажилтай, шүүхээс айж байна гээд өөрийгөө төлөөлөн шүүхэд итгэмжлэлээр намайг оролцохыг гуйгаад байсан тул 2016.06.17-ны өдөр хариуцагч Ж.Ц-ийг 3 шатны шүүхэд төлөөлөх Итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлэн хэрэгт оролцсон. Итгэмжлэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцохгүйгээр зөвхөн 3 шатны шүүхэд төлөөлөхөөр тохиролцсон бөгөөд шүүхийн шатанд банкны зээлээ төлнө гэдгээ Э.Т, Ж.Ц нар амалцгааж байсан. Ингээд би Капитал банкны нэхэмжлэлтэй Ж.Ц-д холбогдох зээлийн маргаантай иргэний хэрэгт хариуцагч Ж.Ц-г итгэмжлэлээр төлөөлж 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл 3 шатны шүүхэд түүний хэлж ярьсныг үндэслэн тайлбар гомдлыг гаргаж оролцсон бөгөөд банкнаас анх нэхэмжилсэн 40,8 сая төгрөгийг 38,3 сая төгрөг болгон бууруулж Ж.Ц-г төлөх төлбөрийг багасгаж түүнд төлбөрийн хэмжээ болон цаг хугацааны хувьд ашигтай шийдвэрлүүлсэн ... Ж.Ц нь гомдолдоо хуралд

намайг залилуулсан хохирогч байгааг мэдсээр байж нэхэмжлэлийг намайг төлнө гэж гарын үсэг зурсан байсан. 2015 оны 05 дугаар сараас Н.Г өмгөөлөгч надтай байнга уулзаж танай байрыг яаж ч байсан алдахгүй гэж итгүүлэн надаас 3,3 сая төгрөг бэлнээр авсан гэж бичсэн нь огт үндэслэлгүй юм. Анх Ж.Ц, Э.Т нар 2015 оны 6-р сард надтай уулзахдаа банкнаас авсан зээлээр бизнес хийж байгаад бусдад залилуулсан гэж байсан намайг шүүх хуралд оролцож эхэлсэний дунд үеэс буюу 2015 оны 9-р сараас Ж.Ц би байраа барьцаалж 32 сая төгрөг аваад Э.Т зээлийг чинь төлөөд сар бүр 500 мянган төгрөг өгч байна гэхээр нь таньдаг үзмэрчээс асууж байгаад бүх мөнгөө өгчихсэн гэсэн ... Хэрэв банкнаас авсан зээлээ төлөхгүй бол 3 шатны шүүхийн шийдвэр гарсны дараа ШШГАЛбанаас Иргэний хууль болон ШШГТ хуульд зааснаар зээлийн барьцааны хөрөнгө болох байрыг чинь албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулж банкны мөнгийг төлүүлдэг, хэрэв байрыг чинь авахгүй бол банкны өмчлөлд шилжүүлэн өгдөг хуулийн заалт, зохицуулалттай өөр ямар ч арга байдаггүй юм гэдгийг маш олон удаа уулзах болон утсаар ярих болгондоо Дээд шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл хэлж, сануулж байсан бөгөөд энэ талаар үнэн байдлаа ах дүү, хүүхдүүддээ эртхэн хэлж шийдэх арга замаа олохыг зөвлөсөн. Харин би Э.Т-г 2015 оны 08 сарын 02-ны өдөр болон 2015 оны 09 сарын 22-ны өдрүүдэд 2 удаа Ж.Цэрэнчимэд, Э.Т нарын харилцан зөвшөөрснөөр Ж.Ц-н гэрт нь дагуулан очиж тэр 2-ыг уулзуулан үүсээд байгаа нөхцөл байдлын талаар болон хууль зүйн үр дагаврын талаар хэн хэнд тодорхой тайлбарлан ойлгуулсан бөгөөд тэр 2 анхан шатны шүүхийн шиш...эртэй танилцаж, Э.Т нь "өөрөө мөнгийг авсан тул давж заалдах гомдлын улсын тэмдэгтийн хураамж болон өмгөөллийн хөлс төлөх, Ж.Ц-н байрыг шүүхийн журмаар худалдан борлуулахгүйгээр авч өгнө гэсэн бичгүүдийг тухайн өдрүүдэд 2 удаа бичиж өгсөн төдийгүй тэр 2 бие биендээ байрныхаа мөнгийг олж төлнө гэж ярьцгааж байсан ... Ж.Ц-н бичсэнчлэн би түүнээс увуулж цувуулан 3,3 сая төгрөгийг огт аваагүй бөгөөд харин энэ талаар Ж.Ц нь 2016 оны 04 сарын 27-ны өдөр өөрийн гараар "өмгөөлөгч Н.Г ямар нэгэн хөлс төлөөгүй нь үнэн" гэж бичсэнээр нотлогдоно ... Би Ц-г төлөөлөн банкны маргаантай хэрэгт орохдоо түүний нэхэмжлэлийн мөнгийг төлнө гэж би гарын үсэг зураагүй харин тайлбарт Ж.Ц гарын үсгээ зурсан ... Ж.Ц нь Э.Т залилуулж мөнгө өгсөн гэж тэр 2 хоёулаа ярьж байсан. Энэ яриа тайлбараар нь ч би шүүхэд тайлбар гомдол гаргаж байсан ... би Э.Т холбогдох 9 хохирогчтой хэрэгт түүний өмгөөлөгчөөр оролцсон болохоос биш Ж.Ц-н эрх ашигтай холбоотойгоор энэ хэрэгт оролцоогүй бөгөөд би шүүх хурал дээр Ж.Ц-н эсрэг ганц ч үг яриа яриагүй, түүнээс Э.Т мөнгө аваагүй гэж, залилан мэхлээгүй гэж нэг ч үг хэлээгүй түүний эрх ашигт ямар ч хохирол учруулаагүй болно. Ж.Ц нь шүүх хуралд өөрөө н.Бгэх өмгөөлөгчтэй оролцсон бөгөөд Э.Т надаас өмнө мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч Б.Л, шүүхийн шатанд Б.Б зэрэг өмгөөлөгчид өмгөөлж байсан ба би зөвхөн шүүхийн шатанд өмгөөлөгч Б.Б-н хамт шүүх хуралдаанд оролцсон. Мөрдөн байцаалтын шатанд болон шүүх хурал дээр Э.Т нь Ж.Ц- с мөнгө авсан талаараа хүлээн зөвшөөрч мэдүүлэг өгч байсан, тэр хоёрын хооронд мөнгө өгч авсан талаар ямар нэгэн маргаан байхгүй байсан тул би энэ хэрэгт оролцсоноороо Ж.Ц-н эрх ашгийг хохироогоогүй гэж үзэж байна ..." гэжээ. /ММ-н 33-39-р хуудас/

Хариуцагч Н.Г-с тус хороонд ирүүлсэн хүсэлтдээ:

‘Өмгөөлөгч Н.Г би Э.Т-н өмгөөлөгчөөр хууль зүйн туслалцаа үзүүлж 2014 оны 4 сард Ж.Т, Б.Д нарт холбогдох иргэний хэрэгт оролцож байсан Гэтэл 2015 оны 5-р сард Э.Т Ж.Ц нар нь банкны зээлийн асуудлаар иргэний шүүхэд хариуцагчаар татагдсан тул Ж.Ц-г төлөөлж оролцохыг олон дахин гуйж хүссэн тул 2015.06.17-2015.12.08-ны хооронд 3 шатны шүүхэд оролцсон. Тухайн үед ... ашиг сонирхол нэгтэй хүмүүс мэт ярьж байсан. Гэтэл сүүлдээ Э.Т нь нэр бүхий 8 хүн залилсан хэрэгт яллагдагч болж ... Ж.Ц нь хохирогч болсон байсан. Би анх Э.Т-н өмгөөлөгчөөр 2014, 2015 онд ажиллаж байсан. 2015 онд Ж.Ц-н өмгөөлөгчөөр дээрх хэрэгт ажиллахдаа энэ 2 хүн дараа нь ашиг сонирхлын зөрчилтэй болох юм гэж урьдчилан мэдээгүй Гэхдээ би Э.Т, Ж.Ц нарын хэрэгт оролцсон нь буруу байсан байна. Буруугаа хүлээн зөвшөөрч байна. Надад хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэжээ. /ММ-н 40-р хуудас/

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс “өмгөөлөгч Н.Г нь ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, ашиг сонирхлын зөрчил бий болгохоор байвал үйлчилгээ үзүүлэхийг хориглох үндэслэлд хамаарч байх тул түүнд хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах” санал гаргасан ба хариуцагч Н.Г “би Э.Т, Ж.Ц нарын хэрэгт оролцсон нь буруу. байсан байна. Буруугаа хүлээн зөвшөөрч байна. Надад хаалттай сануулах арга хэмжээ авч өгнө үү” гэж тайлбарлаж байна.

Өмгөөлөгч Н.Г нь 2015 оны 06 сарын 02-ны өдөр иргэн Ж.Ц-тэй хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулж Капитал банк нэхэмжлэлтэй Ж.Ц-д холбогдох 40.716.228 төгрөг гаргуулах шаардлага бүхий иргэний хэрэгт хариуцагчийн төлөөлөгчөөр оролцож, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны...дугаар шүүхийн 2015 оны 06 сарын 19-ний өдрийн шүүх хуралдаан. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 10 сарын 02-ны өдрийн шүүх хуралдаан, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2015 оны 12 сарын 08-ны өдрийн шүүх хуралдаануудад оролцжээ.

Түүнчлэн тэрээр 2016 оны 11 сарын 14-ний өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т заасан гэмт хэрэгт холбогдсон иргэн Э.Т хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж, түүний өмгөөлөгчөөр оролцон Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 сарын 13-ны өдрийн шүүх хуралдаан, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 сарын 07-ны өдрийн шүүх хуралдаануудад тус тус оролцжээ.

Өмгөөлөгч Н.Г нь иргэн Ж.Ц эрх зүйн туслалцаа үзүүлснийхээ дараа Ж.Ц-н хохирогчоор тогтоогдсон, тухайн залилан мэхлэх үйлдэл гаргасан гэмт хэрэгт холбогдсон иргэн Э.Т эрх зүйн туслалцаа үзүүлсэн нь хоорондоо 1 асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй этгээдүүдэд аль алинд туслалцаа үзүүлсэн гэдэг нь гомдол, тайлбар, хариуцагчийн гэм буруугаа хүлээсэн тайлбар, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнүүдийн хуулбар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 08 сарын 26-ны өдрийн 102/Ш32015/22120 дугаар шүүгчийн захирамж, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2015 оны 06 сарын 19-ний өдрийн 102/ШШ2015/4049 дүгээр шийдвэр, Нийслэлийн

иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 10 сарын 02-ны өдрийн 1316 дугаар магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2015 оны 12 сарын 08-ны өдрийн 1071 дүгээр тогтоол, өмгөөлөгч Н.Г-н Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч Н.Х гаргасан хүсэлт, Чингэлтэй дүүргийн цагдаагийн...хэлтсийн мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Д.Б-гийн Ж.Ц-г хохирогчоор дахин байцаасан тэмдэглэл, өмгөөлөгч Н.Г-н Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гаргасан хүсэлт, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 сарын 13-ны өдрийн 224 дүгээр шийтгэх тогтоол, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 сарын 07-ны өдрийн 95 дугаар магадлал зэргийн хуулбаруудаар тус тус нотлогдож байна.

Хариуцагч Н.Г-н үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн 38.1.2-т “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх”, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.11-д “ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх”. 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... хуульч үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчид ашиг сонирхлын зөрчил бий болгохоор байвал үйлчилгээ үзүүлэхийг хориглоно”, 2 дахь хэсгийн 2.1-д “нэг үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчийн бусад үйлчлүүлэгчийнх нь шууд эсрэг байх” гэж заасныг тус тус зөрчсөн үйлдэл мөн гэж дүгнэв.

Энэ зөрчил нь Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүр: . .1н 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажь : эгааны зөрчилд хамаарч байна.

Өмгөөлөгч Н.Г нь Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн харг.уцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.3 дахь заалтуудад зааснаар гаргасан зөрчлөө шударгаар хүлээн зөвшөөрсөн, гаргасан зөрчилдөө чин сэтгэлээсээ гэмшсэн байх тул сахилгын шинжээчийн “хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулах тухай” саналыг үндэслэлтэй гэж дүгнэв.

Хариуцагч нь сахилгын шинжээчийн хаалттай сануулах тухай саналын талаарх мэдэгдлийг 2017 оны 10 сарын 23-ны өдөр хүлээн авсан, 2017 оны 11 сарын 02-ны өдөр санал, хүсэлт байхгүй гэдгээ илэрхийлсэн байх тул сахилгын шинжээчийн саналыг бүрэлдэхүүн хянан үзэж шийдвэрлэлээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 10.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 3дахьзаалт, 14.4-14.6 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.1 дэх заалт, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар өмгөөлөгч Н.Г-т хаалттай сануулах шийтгэл оногдуулсугай.
- 2 Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРОО МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОГТООЛ

2017оны 11 сарын 17 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Хуульч, өмгөөлөгч С.Ү-д холбогдох маргааны тухай

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх гуравдугаар бүрэлдэхүүний гуравдугаар хуралдааныг гишүүн С.Буд би даргалж, гишүүн Д.Цэндсүрэн, Л.Амарсанаа, М.Алдар, У.Солонго нарын бүрэлдэхүүнтэй Монголын Хуульчдын Холбооны 402 тоот хуралдааны танхимд нээлттэй явуулж Мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчээс С.Ү холбогдуулан “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн” тухай дүгнэлт үйлдэж ирүүлснийг хүлээн авч хянан хэл элцээ

ТОДОРХОЙЛОХ нь:

Хуралдааны хэлэлцүүлэгт дараах баримтуудыг хэлэлцүүлэв. Үүнд:

Монголын Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны сахилгын шинжээчийн 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 17/50 дугаартай саналд: Өмгөөлөгч С.Ү нь иргэн Ц.Э-тай хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж үйлчилгээний хөлс болон шүүхийн тэмдэгтийн хураамж авсан атлаа хууль зүйн үйлчилгээ үзүүлээгүй, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангаагүй үйлдэл нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д “Хуульчийн үнэнч шударга, итгэл даах байдал болон хуульчийн бусад шаардлагад сөргөөр нөлөөлөх хэрэг, зөрчил үйлдэх... хориглоно”, 38 дугаар зүйлийн 38.1.1-д “үйлчлүүлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгслийг ашиглан бүрэн тууштай хамгаалах”, Хуульчийн Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12-д “мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх”, 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д “үйлчилгээний явцын талаар тухай бүрд нь үйлчлүүлэгчид мэдээлэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шийдвэрлүүлэхээр сахилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлт үйлдүүлэх санал гаргажээ.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн Ш.Сүхбат 2017 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 2/57 дугаар захирамжаар:

Хуульч өмгөөлөгч С.Ү нь 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр иргэн Ц.Э-тай “Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” байгуулж үйлчилгээний хөлсөнд 1.000.000 төгрөг авсан атлаа хууль зүйн туслалцаа үзүүлж шүүхэд нэхэмжлэл гаргаагүй, үйлчлүүлэгчид ямар нэг мэдээлэл өгөөгүй зэрэг үйлдлүүд гаргажээ.

Сахилгын шинжээчийн саналд дурдсан зүйлүүдийг үндэслэн Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шийдвэрлүүлэхэр мэргэжлийн дүгнэлт үйлдэх тухай хорооны сахилгын шинжээчийн саналыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

С.Ү нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуульчдын нэгдсэн бүртгэлийн 0034, шүүхэд төлөөлөх эрхийн 01 дугаарт тус тус бүртгэгдсэн байна.

1. Ц.Э-аас Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд хандаж гаргасан өргөдөл: Би өмгөөлөгч С.Ү-тэй 2016 оны 07 дугаар сарын 28-ний өдөр Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулсан. Гэрээ байгуулснаас хойш нэг ч удаа эрх зүйн туслалцаа үзээлээгүй. Би тухайн үед С.Ү-н данс руу 1.400.000 төгрөгийг шилжүүлсэн боловч 2016 оны 10 дугаар сараас хойш утасаа авахгүй уулзахгүй алга болсон, залгахаар таслаад хуралтай байна гэж хэлдэг болсон. Сүүлдээ би холбоо барих гэж Ресебоок руу нь хүртэл мессеж бичсэн боловч намайг блок хийсэн байсан. Тэгээд сүүлд нь аргаа бараад С.Ү нь залуу хүний хувьд байж болохгүй зохисгүй үйлдэл гаргаж байна, надаас өөр хүмүүсийг мөн адил худал хэлж хуураад явах юм байна гэж ойлгоод хуульч хүнийх нь хувьд харицлага тооцуулахаар гомдол гаргасан юм. Сүүлд миний мөнгийг буцааж шилжүүлсэн. Заавал хариуцлага тооцуулах хүсэл алга байна, залуу хүнийх нь хувьд анхааруулга аваасай гэж бодож байна” гэжээ.
2. С.Ү тайлбартаа: “Миний бие иргэн Ц.Э-тай зээлийн гэрээтэй холбоотой маргаанд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг харилцан тохиролцсон. Гэвч эрүүл мэндийн шалтгаан болон яаралтай бөөрний хагалгаанд орох болсон бөгөөд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон. Ц.Э-тай байгуулсан гэрээний дагуу ямар нэгэн ажиллагаа хийгдээгүй бөгөөд Ц.Э-нд учирсан хохиролыг бүрэн төлж барагдуулах болно. Гэм буруугаа хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд хариуцлага хүлээхэд татгалзах зүйлгүй чин сэтгэлээсээ гэмшиж байна” гэжээ.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд хамаарч байх тул Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн сахилгын шинжээчийн мэргэжлийн дүгнэлт үндэслэлтэй байна гэж дүгнэв. Хариуцагчид маргаан хянан шийдвэрлэх хурлын товыг мэдэгдэхэд хуралдаандаа оролцоно гэж мэдэгдсэн боловч ирээгүй тул маргаан хянан шийдвэрлэх журмын 12.7 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар түүний эзгүйд маргааныг хянан хэлэлцэв.

Монголын Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 14.4 дүгээр зүйл, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 1-5 дахь заалтыг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг, Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тус тус зааснаар С овогтой С-ын Ү-н шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй түдгэлзүүлсүгэй.
2. Энэ маргаанд холбогдох эд мөрийн баримтгүй, хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тодорхойлогдоогүйг дурдсугай.
4. Энэ тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ,
ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

Удиртгал	195
Нэг. Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдол, түүний агуулга, төрөл, шийдвэрлэлт	196
Хоёр. Ёс зүйн зөрчил гаргасан хуульчдад хүлээлгэж буй сахилгын шийтгэл, түүний төрөл хэлбэр, сахилгын шийтгэл ногдуулсан байдал	214
Гурав. Ёс зүйн зөрчил гаргасан хуульчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл, түүний хэрэгжилтийг хангах асуудал үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдал.....	219
Дөрөв. Хуульчийн ёс зүйн зөрчлийн талаар иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхээр тогтоосон дүрэм, журмын хэрэгжилт.....	225
Дүгнэлт	228
Санал, зөвлөмж	231
Ашигласан материал	234

УДИРТГАЛ

МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороо, Азийн сангийн “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийн хооронд 2017 оны 11 дүгээр сарын 09-нд байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах чиглэлийн 1.2-т зааснаар хуульчийн мэргэжлийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдлыг судалж, санал, зөвлөмжийг боловсруулав.

Судалгааны ажлын зорилго:

Хуульчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдлын агуулга, түүнийг шийдвэрлэж буй байдал, ёс зүйн зөрчлийн бодит байдал, практикт гарч буй зөрчил, хуульчдад хүлээлгэсэн хариуцлага, хариуцлагын төрөл, ёс зүйн зөрчил болон хүлээлгэж буй хариуцлага хоорондын балансжуулалт, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын уялдаа холбоо, зохицуулалтын зарим асуудлыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны ажлын зорилт:

Судалгааны ажлын үндсэн зорилгод хүрэх үүднээс дараахь зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Ёс зүйн зөрчил гаргасан хуульчдад сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл, түүний хэрэгжилтийг хангах асуудал үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдлыг судлах;
- Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдол, түүний агуулга, төрөл, шийдвэрлэлтийг судлах;
- Хууль тогтоомжийн дагуу хуульчийн ёс зүйн зөрчлийн талаар иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхээр тогтоосон дүрэм, журам, практикийг судлах;
- Хуульчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэж буй сахилгын шийтгэл, түүний төрөл хэлбэр, сахилгын шийтгэл ногдуулсан байдлыг судлах;
- Хуульчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг хянан шийдвэрлэсэн Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал болон бусад холбогдох асуудалд дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Судалгааны арга зүй, хугацаа, гүйцэтгэгч:

Судалгааны баг кейс судалгааны арга болон баримт бичигт дүн шинжилгээ хийх, харьцуулах, ганцаарчилсан болон фокус ярилцлага, математик статистикийн аргыг ашиглаж, энэхүү судалгааны үр дүнг боловсруулав.

Судалгааны явцад мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаанд ажиглалт хийж, шийдвэрлэсэн маргааны агуулга, төрөл,

шийдвэрлэлтийн байдалд математик, статистикийн аргыг ашиглан шинжилгээ хийсэн болно.

Докторант Б.Өлзийсайхан ахлагчтай, докторант Б.Мөнхдорж, магистр В.Чимгээ нараас бүрдсэн судалгааны баг 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс 2018 оны 2 дүгээр сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны үр дүнгийн ашиглалт:

Уг судалгааны үр дүнд бий болсон дүгнэлт, санал, зөвлөмжийг МХХ-ны үйл ажиллагааг төлөвшүүлэх, хуулийг хэрэгжүүлэх явц болон судалгааны үр дүнд тодорхой болсон давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Хуульчийн эрх зүйн байдлын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгож, хуульчийн мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх болон тэдний нэр хүндийг хамгаалах зэрэг өргөн цар хүрээтэй үйл ажиллагаанд ашиглах боломжтой.

НЭГ. МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ХОРООНД ГАРГАСАН ГОМДОЛ, ТҮҮНИЙ АГУУЛГА, ТӨРӨЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хороонд 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 191 хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд холбоотой 170 гомдол (Хуульчдын холбооны Тамгын газарт 140, мэргэжлийн хариуцлагын хороонд 30) хүлээн авчээ.

МХХ-ны зөвлөлөөс 2014 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам”-ыг, 2014 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх шийдвэрлэх журам”-ыг тус тус баталж, 2014 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж, тус хорооны үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн байна.

МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хороо 2014 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн албан ёсоор гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байна.

1.1. Хүлээн авсан гомдол, мэдээлэл

2014-2017 он хүртэлх хугацаанд 791 нийт гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгаж, шийдвэрлэсэн байна.


Хүснэгт 1. Шалгаж, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл

Он	Шалгаж, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл	Үүнээс:		
		Харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлсэн	Маргаан үүсгэсэн	Маргаан үүсгэхээс татгалзсан
2014	170	24	31	115
2015	199	16	95	88

2016	216	32	97	87
2017	206	45	94	67
Бүгд	791	117	317	357
Эзлэх хувь		14.8	40.1	45.1

2014-2017 онд нийт 791 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 117 буюу 14.8 хувийг харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлсэн, 317 буюу 40.1 хувьд маргаан үүсгэсэн, 357 буюу 45.1 хувьд нь маргаан үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

График 1. Хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл



Мэргэжлийн хариуцлагын хороо нь сүүлийн 4 жилд нийт 791, жилд дунджаар 198 гомдол, мэдээлэл хүлээн авч, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу маргаан үүсгэж, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, зохих шийдвэрийг гаргасан байна.

Энэ процессын ажиллагааны нэг жилийн ачаалалд дүгнэлт хийж, ажлын албаны ачаалалыг тооцоолоход нэг сахилгын шинжээчид сард 17, нэг шалгагчид 8 гомдол, мэдээлэл ногдож байна.

Хүснэгт 2. Хүлээн авсан гомдол, мэдээлэл (Нутаг дэвсгэрээр)

Он	Гомдол, мэдээлэл	Нутаг дэвсгэрээр:	
		Улаанбаатар хот	Орон нутаг
2014	170	153	17
2015	199	160	39
2016	216	201	15
2017	206	188	18
Бүгд	791	702	89
Эзлэх хувь		88.7	11.3

Мэргэжлийн хариуцлагын хороонд ирж буй гомдол, мэдээллийн 90 орчим хувийг Улаанбаатар хотоос, үлдсэн хувийг хөдөө орон нутгаас хандаж гаргасан байна. Үүнээс үзэхэд орон нутгаас ирүүлж буй гомдол, мэдээллийн эзлэх хувь бага байгаа нь Мэргэжлийн хариуцлагын хорооны үйл ажиллагааны талаарх мэдээлэл, сурталчилгаа дутмаг байгаатай холбоотой.

1.2. Гомдол, мэдээлэлд холбогдсон субъектын ангилал

2014-2017 онд 791 гомдол, мэдээлэлд 933 хуульч холбогдсон ба эдгээрийн 751 буюу 80.5% нь өмгөөлөгч, 162 буюу 17.4% нь шүүгч, 20 буюу 2.1% нь прокурор байна.

Хүснэгт 3. Гомдол, мэдээлэлд холбогдсон субъектын ангилал

Он	Шалгаж, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл	Гомдолд холбогдсон субъект				
		Бүгд хуульч	Өмгөөлөгч	Шүүгч	Прокурор	Бусад хуульч
2014	170	205	146	49	10	-
2015	199	229	193	30	6	-
2016	216	250	213	36	1	-
2017	206	249	199	47	3	-
Бүгд	791	933	751	162	20	0
Эзлэх %			80.5	17.4	2.1	0

Шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо, прокурорын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Прокурорын ёс зүйн зөвлөл харьяаллын дагуу хүлээн авч шалган шийдвэрлэдэг.

Судалгааны явцад түүвэрлэн авсан 2016-2017 оны маргаан үүсгэсэн, маргаан үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийг гаргасан болон холбогдсон субъектээр ангилан авч үзлээ.

Хүснэгт 4.

Он	Бүгд	Маргаан үүсгэсэн	Маргаан үүсгэхээс татгалзсан
2016	174	97	87
2017	161	94	67
Бүгд	345	191	154

Дээрх ангиллыг субъект бүрээр ангилан авч үзвэл:

Хүснэгт 5. Гомдолд холбогдсон субъектын ангилал (2016-2017 он)

№	Гомдол, мэдээлэл гаргасан субъект	Гомдол, мэдээлэлд холбогдсон субъект					Бүгд	Эзлэх хувь
		Шүүгч	Прокурор	Өмгөөлөгч	Эсрэг талын өмгөөлөгч	Өмгөөллийн нөхөрлөл		
1	Иргэнээс	10	1	218	14		243	70.4
2	Хуулийн этгээдээс	1		12	7	1	21	6.1
3	Цагдан хорих 461-д хоригдож буй субъект			4	1		5	1.4
4	Цагдан хорих 461-р ангийн дарга			3			3	0.9
5	Өмгөөлөгчөөс				14		14	4.1
6	Цагдаагийн байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас			16			16	4.6
7	Прокуророос			12			12	3.5
8	Шүүгч, шүүхээс			27			27	7.8
9	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, тасгийн даргаас			3			3	0.9
10	Засаг даргын Тамгын газраас			1			1	0.3
	Бүгд	11	1	296	36	1	345	
	Эзлэх хувь	3.2	0.3	85.8	10.4	0.3		

Дээрх судалгааны үр дүнг илэрхийлсэн хүснэгт, 2016-2017 оны мэдээлэлд үндэслэн дүгнэхэд 70 хувь нь иргэдээс тус хороонд гомдол гаргаж, мөн нийт гомдлын 96.2 хувь нь өмгөөлөгчид холбогдуулан гаргасан гомдол байна. Энэ 2 жилийн хугацаанд өмгөөллийн үйлчилгээтэй холбогдуулан гаргасан зардал болон бусад нэмэгдэл зардалд хамаарах 59.7 сая төгрөгийг өмгөөлөгчөөс буцаан гаргуулах талаар гомдол, мэдээлэлдээ дурьдсан байна.

Хэдийгээр дээрх мөнгөн дүнг гомдол мэдээлэлд дурьдаж нэхэмжилсэн боловч өмгөөллийн үйлчилгээг хүссэн үр дүнд хүртэл үзүүлээгүй гэсэн үндэслэлээр үйлчилгээний хөлсөө 50-100 хувь буцаан авах сонирхолтой байдаг нь ажиллагаа хийгдсэн материалуудтай танилцах явцад уншигдаж байлаа.

Мөн дээрх хугацаанд цагдаагийн байгууллагаас 16, авлигатай тэмцэх байгууллагаас 3, прокуророос 12, шүүх, шүүгчээс 27 удаа өмгөөлөгчид холбогдуулан

гомдол, мэдээлэл гаргажээ. Харин эсрэг талын өмгөөлөгчид холбогдуулан 14 гомдол, мэдээлэл гаргасан байна.

2016-2017 оны маргаан үүсгэсэн болон үүсгэхээс татгалзсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэсэн байдал

Хүснэгт 6.

№	Гомдол, мэдээлэл гаргасан субъект	Маргаан хянан шийдвэрлэсэн байдал			Бүгд	Эзлэх хувь
		Шинжээчийн санал	Гишүүний захирамж	Бүрэлдэхүүний тогтоол		
1	Иргэнээс	1	76	166	243	70.4
2	Хуулийн этгээдээс		19	2	21	6.1
3	Цагдан хорих 461-д хоригдож буй субъект		5		5	1.4
4	Цагдан хорих 461-р ангийн дарга			3	3	0.9
5	Өмгөөлөгчөөс		9	5	14	4.1
6	Цагдаагийн байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас		11	5	16	4.6
7	Прокуророос		7	5	12	3.5
8	Шүүгч, шүүхээс	3	9	15	27	7.8
9	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, тасгийн даргаас		1	2	3	0.9
10	Засаг даргын Тамгын газраас			1	1	0.3
	Бүгд	4	137	204	345	
	Эзлэх хувь	1.2	39.7	59.1		

2016-2017 онд маргаан үүсгэсэн болон үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн 39.7 хувийг гишүүний захирамжаар, 1.2 хувийг шинжээчийн саналаар, 59.1 хувийг бүрэлдэхүүний^[1] тогтоолоор шийдвэрлэсэн байна.

¹ МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журмын 3.3 дугаар зүйл. Маргааныг шийдвэрлэх бүрэлдэхүүн 1. Хороо нь маргааныг шийдвэрлэх болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт гаргах чиг үүргээ бүрэлдэхүүнээр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд нийт зургаан бүрэлдэхүүнийг байгуулна. 2. Бүрэлдэхүүн нь Хорооны маргаан хянан шийдвэрлэх журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 3. Хороо нь нийт гишүүдийн хуралдаанаар энэ зүйлийн 5-д заасан журмын дагуу бүрэлдэхүүнийг зургаан сар тутам шинэчлэн байгуулах бөгөөд бүрэлдэхүүнийг нэгээс зургаа хүртэл дугаарлаж, дугаараар нь нэрлэнэ. 4. Бүрэлдэхүүн нь хорооны таван гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд хорооны шүүгч гишүүн гурав, прокурор гишүүн, өмгөөлөгч гишүүн тус бүр нэг байна. 5. Хорооны гишүүдийг 1, 2, 3, 4, 5, 6 тоог сугалуулах замаар бүрэлдэхүүнд хуваарилна.

Энэ нь Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 8.9 дүгээр зүйл. "Маргаан үүсгэхээс татгалзах 1. Гомдол, мэдээлэл, хүсэлтэд дурдагдсан үйл баримт нь үнэн байсан ч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил эсхүл мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй тухай маргаанд хамаарахааргүй бол сахилгын шинжээч маргаан үүсгэхээс татгалзах тухай саналаа зохих журмын дагуу томилогдсон гишүүнд хүргүүлнэ. 2. Гишүүн сахилгын шинжээчийн саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж захирамж гаргана. 3. Гишүүний гаргасан захирамжийг энэ журмын 3.8 дугаар зүйлийн 3.3-д заасан журмын дагуу гомдол гаргагчид хүргүүлж, тухайн захирамжид гомдол гаргах эрхээр хангана. 8.10 дугаар зүйл. Маргаан үүсгэхээс татгалзах тухай шийдвэрт гомдол гаргах 1. Гомдол гаргагч нь маргаан үүсгэхээс татгалзсан гишүүний захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо Хороонд гаргана. 2. Энэ зүйлийн 1-д заасан гомдлыг тухайн гишүүний харьяалагддаг бүрэлдэхүүний дараагийн дугаарын бүрэлдэхүүнд хуваарилна. 3. Бүрэлдэхүүн нь гишүүний захирамжийг хэвээр үлдээх, хүчингүй болгох эсхүл өөрчлөх тогтоолыг гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гаргана. 4. Бүрэлдэхүүний тогтоол илт үндэслэлгүй гэж үзвэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд Хороогоор дамжуулан гомдол гаргаж болно." гэсэн зүйлийн хэрэгжилтийг хангаж, хянан шийдвэрлэх ажиллагаа эрхэлдэг, мөн гомдол, мэдээлэл гаргаж буй субъектын давж заалдах гомдол гаргах эрхийг хангасан ажиллагаа явуулж буйг илтгэж байна.

1.3. Гомдол, мэдээллийн төрөл, агуулга:

Шалгаж шийдвэрлэсэн нийт гомдол, мэдээллийн 58.7% буюу 402 нь мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, 16.4% буюу 112 нь хуульч үүргээ хангалтгүй биелүүлсэн, 13.3% буюу 91 нь хуульчийн ёс зүйтэй холбоотой, 7.0% буюу 48 нь өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүй шүүх хурал тасалсанаас болж шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулсан, 4.7% нь хууль зөрчсөн, хууль бус үйл ажиллагаа явуулсан гэсэн агуулгатай.

Хүснэгт 7. Шалгаж, шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн төрөл

Гомдол, мэдээллийн төрөл	Бүгд	Эзлэх %	Он			
			2014	2015	2016	2017
Хуульч ёс зүйгүй байна	91	13,3	14	21	31	25
Хуульч үүргээ хангалтгүй биелүүлсэн	112	16,4	30	41	33	8
Хууль зөрчсөн, хууль бус үйл ажиллагаа явуулсан	32	4,7	14	12	3	3
Шүүх хуралдааныг үндэслэлгүй хойшлуулсан /Өмгөөлөгч/	48	7,0	7	9	19	13
Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил	402	58,7	85	100	97	120
Бүгд	685		150	183	183	169

Мэргэжлийн хариуцлагын хорооны 2014-2017 оны хооронд нийт хүлээн авсан гомдол, мэдээллээс харьяаллын дагуу шилжүүлсэн гомдол, мэдээллийг хасаж, үлдсэн гомдол, мэдээллийн төрлийг дээрх хүснэгтээр илэрхийлэн гаргасан болно.

Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэдэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж эсхүл энэ дүрмийн заалтыг өөрөө эсхүл бусдын үйл ажиллагаагаар дамжуулан зөрчих, зөрчихөөр завдах, эсхүл бусад этгээд зөрчихөд нь туслах, ятгах үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.²

Нээлттэй нийгэм форумын 2015 онд хийсэн судалгаанаас харахад шүүх хурал хойшилсон шалтгаан нь шүүгчээс 3.3, өмгөөлөгчөөс 52.5, 2017 онд шүүгчээс 3.6, өмгөөлөгчөөс 62.5 хувь нь хамаарч байжээ. Өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хурлыг 2-оос дээш удаа хойшлуулсанд шүүгчээс гомдол гаргасан нь 7.0 хувьтай байгаа ч хүндэтгэн үзэх шалтгаантай гэсэн үндэслэлээр шүүх хурал хойшуулсан тохиолдлыг дээрх судалгаанд хамтатган судалсныг анхааран үзэх нь зүйтэй. Судалгааны дүнгээс харахад жилээс жилд энэхүү зөрчлийн шинжтэй үйл ажиллагаа нэмэгдэж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулдаг жишиг бий болсныг илэрхийлж байна.

Хуульчийн ёс зүй, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай холбоотой дээрх гомдол, мэдээллийг холбогдох хууль, дүрэмд заасан төрлөөр нь ангилан гаргасан. Харин түүнийг нарийвчлан маргаан үүсгэсэн болон маргаан үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн агуулгыг 2016-2017 оны материалыг нэг бүрчлэн түүвэрлэн авч үзэж, агуулгыг дараахь байдлаар гаргав.

Хүснэгт 8. 2016-2017 оны маргаан үүсгэсэн болон үүсгэхээс татгалзсан гомдол, мэдээллийн агуулга

№	Гомдол, мэдээллийн агуулга	Гомдол, мэдээлэлд холбогдсон субъект					Бүгд	Эзлэх хувь
		Шүүгч	Прокурор	Өмгөөлөгч	Эсрэг талын өмгөөлөгч	Өмгөөллийн нөхөрлөл		
1	Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй, туслалцаа хангалттай үзүүлээгүй			74		1	75	21.7
2	Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм зөрчсөн ^[1]	4	1	50	4		59	17.1

² Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил

3	Шүүхийг үл хүндэтгэж шүүн таслах ажиллагаанд зориуд саад учруулсан, шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй	26		26	7.5
4	Үйлчилгээний хөлсөө буцаан гаргуулах	23		23	6.7
5	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулсан	16	5	21	6.1
6	Хэл амаар доромжилсон	16	5	21	6.1
7	Өмгөөлөгч нь хуулиар олгосон эрхээ хэтрүүлж ашигласан ёс зүйгүй авирласан	8	3	11	3.2
8	Үгсэн хуйвалдаж, ёс зүйгүй аашилсан	8	3	11	3.2
9	Хэл амаар доромжилж, гүтгэсэн, үйлчилгээний хөлсөө буцаан гаргуулах	8		8	2.3
10	Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэхийг тодруулж өгнө үү	8		8	2.3
11	Хуулийн мэдлэгтэйгээрээ далайлган сүрдүүлж, доромжилсон	5	2	7	2.0
12	Өмнө нь өмгөөлөгчөөр нь ажиллаж байгаад эсрэг талын өмгөөлөгчөөр ажиллаж, мэдээлэл зардуулсан		4	4	1.2
13	Нөгөө талд ажилласан хохирол бүрэн төлүүлээгүй	3		3	0.9
14	Өмгөөлөгчийн үүргээ шударгаар биелүүлээгүй удаа дараа компани хохироосон	3		3	0.9
15	Шүүх хуралдаанд согтуугаар ирж үйлчилгээ үзүүлж чадаагүй	3		3	0.9
16	Шүүх нотлох баримтыг зөв үнэлээгүй, шүүхийн шийдвэр шаардлага хангаагүй, буруу шийдвэр гаргасан	3		3	0.9
17	Цагдан хорих байрны дотоод журам зөрчсөн	3		3	0.9
18	Шүүгчийг таньдаг гэх зэргээр нөгөө талд үйлчилсэн	2		2	0.6
19	Ажил үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, шахаж шаардсан	2		2	0.6

20	Өмгөөллийн гэрээ байгуулан ажиллаж байгаад өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан			2		2	0.6
21	Өмгөөлөгч нь ур чадваргүй, өмгөөллийн ажлаа бүрэн хийгээгүй			2		2	0.6
22	Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй, худал мэдүүлэг зааж өгсөн			2		2	0.6
23	Итгэмжлэлгүй байж ШШГА-нд оролцсон			1	1	2	0.6
24	Дутуу, буруу материал цуглуулж хууль бус үйлдэл хийсэн			2		2	0.6
25	Ялыг нь хөнгөрүүлж өгнө гэж хэлээд тохиролцсон боловч туслалцаа үзүүлээгүй			2		2	0.6
26	Шүүгч нар хууль зөрчсөн болон ёс зүйн байдалд нь дүгнэлт гаргуулах	2				2	0.6
27	Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг нуун дарагдуулсан			1		1	0.3
28	Хууль зүйн зөвлөгөө авчихаад төлбөрөө буцаан авах гэлээ заргалдаад аваарай			1		1	0.3
29	Шөнийн цагаар бусдын орон байранд хүч хэрэглэн нэвтрэхийг үйлчлүүлэгчдээ ятгасан				1	1	0.3
30	Шүүхэд хуурамч баримт бүрдүүлж өгсөн гэж гүтгэсэн				1	1	0.3
31	7 хоногт багтаан батлан даалтад гаргана гэж 5 сая төгрөг авсан			1		1	0.3
32	Мөрдөн байцаалтын шатанд хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө гэж 4 сая төгрөг авсан			1		1	0.3
33	Иргэний хууль ёсны эрх, ашиг сонирхолыг ноцтой зөрчсөн үйлдэл гаргасан	1				1	0.3
34	Улсын өмгөөлөгч гэсэн мөртлөө 1 сая нэхсэн, ядарсан хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан			1		1	0.3

35	Үйлчлүүлэгчээ залилан мэхэлж, хохирогчтой тохиролцож чадна гэж өмгөөллийн хөлс дээр нэмж 1,5 сая төгрөг авсан	1		1	0.3
36	Иргэдийн эдийн засгийн чадвараар нь ялгаварлан хандаж хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг	1		1	0.3
37	Бусдын үл хөдлөх эд хөрөнгөд халдаж, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх байр болгон ашигласан		1	1	0.3
38	Өмгөөлөгчийн МХХ дахь бүргэлт өөрчлөлт оруулах, ёс зүйн боловсролыг нь дээшлүүлэх (прокурорын мэдэгдэл)	1		1	0.3
39	Шүүх бүрэлдэхүүнийг авлига авч хэрэг шийдвэрлэсэн сахилгын хороонд өгнө гэх зэргээр шүүх хуралдааны дэг зөрчсөн	1		1	0.3
40	Олон жил цагдаагийн удирдах албан тушаал хашиж байсан, танил тал эрх мэдлээ ашиглан мөрдөн байцаах үйл ажиллагааг удаашруулан хөндлөнгөөс оролцож саармагжуулсан		1	1	0.3
41	Гэмт хэрэгт гүтгэж, хууль бус ёс зүйгүй үйлдэл гаргасан	1		1	0.3
42	Цагдаад өгнө эрүү үүсгэнэ гэж хууль бусаар дарамталсан		1	1	0.3
43	Өмгөөлөгчид бие биенээ гүтгэн доромжилсон	1		1	0.3
44	Хоосон цаасан дээр гарын үсэг зуруулж аваад өмгөөлөгчөө сольсон гэж худал бичиж ДЗШШ-д гомдол гаргасан	1		1	0.3
45	Шүүгчийн туслахуудын нэгдсэн Фэйсбүүк хуудсанд шүүгчийг хариуцагчийн талд илтэд үйлчилж байна гэсэн мэдээлэл байршуулж шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн	1		1	0.3
46	Гэрээ байгуулаагүй, итгэмжлэлгүй байж шүүхэд нэхэмжлэл гаргасан	1		1	0.3

47	Шүүхийн ажилтануудтай нийлж хоол идэж байхад орж ирж нэхэмжлэл гардуулах гэсэн, мөн хариуцагчаар оролцох мэдэгдэх хуудас гардуулах гэж оролдсон	1	1	0.3
48	Нууцаар яриа бичиж авч түүнийгээ шүүхэд нотлох баримтаар гаргаж өгөх гэж байгаа	1	1	0.3
49	Хуурч гэрээ байгуулж залилсан	1	1	0.3
50	Шүүгч хүүтэйгээ нийлж бусдад нөлөөлж шийдвэр гаргуулдаг, ёс зүйгүй ашигласан	1	1	0.3
51	Бараг туслалцаа үзүүлээгүй байж өмгөөллийн хөлс нэмж 2 сая, алданги гэж 1 сая төгрөг нийт 3 сая төгрөгийн гэрээ хийсэн гэж засвартай гэрээ хавсаргаж шүүхэд нэхэмжлэл гаргасан	1	1	0.3
52	Прокурорын шатанд хэрэг нь хэрэгсэхгүй болно гэсэн боловч шүүх рүү шилжихэд 2, 3 таньдаг шүүгч байгаа гэж хэлчээд шүүх хурал болох өдөр чи хэргээ хүлээчих гэж хэлсэнд гомдолтой байна	1	1	0.3
53	Прокуророос дутагдлаар халагдсан боловч удаагүй өмгөөлөгч хийж байгаа асуудлыг шалгаж өгнө үү	1	1	0.3
54	Шүүгчтэй уулзаж хувийн харилцаа тогтоож түүнийгээ давуу байдал болгож ашигласан	1	1	0.3
55	Надад мэдэгдээгүй байж ээжээс өмгөөллийн хөлс нэмж авсан	1	1	0.3
56	30-40-н том биетэй залуу дагуулж ирж манай компаны ажилчдыг айлгаж, эд зүйл эвдэж бүлэглэн дээрэмдсэн	1	1	0.3
57	Өмгөөлөгчөөр сонгож аваагүй байхад цагдан хоригдсон этгээдүүдтэй уулзаж яллагдагчаар татагдсан этгээдүүдийн хооронд мэдээлэл зөөсөн	1	1	0.3

58	Хариуцагчтай эвлэрэх зөвшөөрөл өгөөгүй байхад эвлэрэх гэрээ байгуулж 5 сая төгрөг авчихаад өгөөгүй			1		1	0.3
59	Гэрээ байгуулахдаа мөрдөн байцаагч, шүүгч, прокурорт мөнгө өгч хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө гэж урьдчилан амалсан			1		1	0.3
60	Шүүгчид нэхэмжлэгч талд чиглэсэн асуулт асууж өмгөөлөгчийг минь загнасан	1				1	0.3
61	Шүүгч, мөрдөн байцаагч нарт мөнгө өгнө гэж нэмж авсан			1		1	0.3
62	АТГ-ын ОНЗ-д МХХ-ны хуульчид сонгогдсон нь цаашид БША-нд оролцох боломжтой эсэхийг тодруулж өгөх			1		1	0.3
63	20 сая төгрөг зээлж авчихаад одоо болтол өгөхгүй байна			1		1	0.3
64	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байхдаа гэмт хэрэг үйлдсэн				1	1	0.3
		11	1	296	36	1	345

Мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн 2016-2017 оны нийт 345 гомдол, мэдээллийг дээрх 64 агуулгын хүрээнд судлан үзэхэд өндөр хувь үзүүлэлт бүхий 8 агуулгад:

- хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй, туслалцаа хангалттай үзүүлээгүй 21.7 хувь,
- мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм зөрчсөн 17.1 хувь,
- шүүхийг үл хүндэтгэж шүүн таслах ажиллагаанд зориуд саад учруулсан, шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй 7.5 хувь,
- үйлчилгээний хөлсөө буцаан гаргуулах 6.7 хувь,
- эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулсан, мөн хэл амаар доромжилсон гэсэн агуулга бүхий гомдол 6.1 хувь тус тус байгаа нь гомдол, мэдээллийн 65.2 хувийг эзэлж байна.

Тухайлбал: Үйлчилгээний хөлсөө буцаан гаргуулах талаарх агуулга бүхий гомдлыг ихэвчлэн хорих ялаар шийтгүүлсэн үйлчлүүлэгч нь болон түүний ар гэрээс гаргасан байх бөгөөд өмгөөллийн үйлчилгээг хүссэн үр дүнд хүртэл тууштай үзүүлээгүй учир өмгөөллийн үйлчилгээний зардлаа 50-100 хувь хүртэлх хувиар буцаан авах зорилготой байх бөгөөд энэхүү агуулга бүхий гомдолд ихэвчлэн маргаан үүсгэхээс татгалзсан шийдвэр гаргасан байна.

Мөн дээрх 64 агуулга бүхий гомдол, мэдээллийн 34.8 хувийг эзэлж буй 58 агуулга бүхий гомдол, мэдээллийн дийлэнх олонхийг өмгөөлөгчтэй холбогдуулан гаргажээ. Энэхүү агуулгаас ашиг сонирхлын зөрчилд тооцох боломжтой гомдол, мэдээлэл 2.8 хувьтай (шүүгч, мөрдөн байцаагч нарт мөнгө өгнө гэж нэмж авсан, мөрдөн байцаалтын шатанд хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө гэж 4 сая төгрөг авсан гэх мэт) байх бөгөөд ихэвчлэн нотлогдоггүй тул маргаан үүсгэхээс татгалзсан шийдвэр гаргасан байна.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс суртахууны хэм хэмжээ, зарчим, шаардлага зэргийг хуульчийн ёс зүйн салбар гэж үздэг. Хуульчийн ёс суртахууны нийтлэг зарчмууд нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шударга ёсыг баримтлах, хууль дээдлэх, алагчлахгүй байх, бодитой, ухаалаг хандах, хараат бус байх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хүндэтгэх, хамгаалах, мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх^[3] зэрэг болно. Эдгээр зарчимд тулгуурласан ёс зүйн дүрэмтэй байх нь тухайн мэргэжлийн нэр хүнд, үйлчлүүлэгчийн итгэл, үнэлэмжийг дээшлүүлэхэд дэмжлэг болох учиртай.

Өмгөөлөгчтэй холбоотой гомдол, мэдээллийн агуулга:

Хөлсөө авсан мөртөө туслалцаа үзүүлдэггүй буюу зохих ёсоор үзүүлээгүй, элдэв шалтгаан зааж мөрдөн байцаалт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдоггүй, мэдээлэл өгдөггүй, хоёр талд ажилладаг, худал амлан итгэл үнэмшил төрүүлдэг, мэдлэг чадваргүй, харьцааны соёлгүй буюу ёс зүйгүй, нууцыг задруулдаг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг санаатайгаар удаашруулдаг гэх мэтээр буруутган өгсөн хөлс зардлаа буцааж авах хүсэлт гаргажээ. Тухайлбал,

Кэйс-1. “Миний хүү А нь эрүүгийн хэрэгт холбогдож БЗД-ийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэст шалгагдаж Цагдан хоригдсон. Тандаг хүнээрээ дамжуулан өмгөөлөгчөөр Б -г авч хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж өмгөөллийн хөлсийг нийт 1 000 000 /нэг сая төгрөг/-өөр тохиролцож урьдчилгаа 500 000 /таван зуун мянган төгрөг/-ийг бэлнээр өгсөн боловч ямар ч туслалцаа үзүүлээгүй. Анх мөнгө төгрөг авахдаа хэргийг чинь хэрэгсэхгүй болгуулж өгнө, батлан даалтанд гаргуулж өгнө гэж амлаж байсан ч мөнгө авсаны дараа утсаа авахгүй, хааяа утсаа авахаараа хөдөө явж байна, хуралтай байна, завгүй байна гэж хэл амаар доромжилон загнадаг болсон. Сүүлдээ утсаа ч авахгүй байна. Иймд өмгөөлөгч А-гаас өмгөөллийн хөлсийг буцааж гаргуулж, арга хэмжээ өгнө үү” гэх.

Шийдвэрлэсэн байдал:

Хаалттай сануулах арга хэмжээ авсан.

Кэйс №2. “Миний бие В нь Төв аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Хуулийн мэдлэггүй учир өмгөөлөгч Д-г авсан. Гэтэл миний өмгөөлөгч Д нь миний зөвшөөрөлгүйгээр хариуцагчтай эвлэрч мөн шүүхийн шийдвэр гарснаас хойш шийдвэрийг 1 сарын дараа өгсөн. Эвлэрлийн гэрээг хууль

³ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. Хууль, дүрмийн эмхтгэл. Монголын хуульчдын холбоо. 2014

мэдэхгүйг далимдуулан хийснээс болж маш их хохирсон. Дээрх асуудлаар давж заалдах гэсэн боловч хугацаа хэтэрсэн гээд шүүх хүлээж авахгүй байгаа. Иймд өмгөөлөгч Д-д маш их гомдолтой байгаа тул хариуцлага тооцож арга хэмжээ авч өгнө үү” гэх мэт.

Шийдвэрлэсэн байдал:

Тус маргааныг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Зарим хуульчидтай ярилцлага хийх явцад өмгөөлөгчид холбогдуулан гаргаж байгаа гомдлын агуулга нь хууль эрх зүйн туслалцаа үзүүлээгүй буюу зохих ёсоор үзүүлээгүй, ам хэлээр доромжилдог, ажлын хөлснөөс гадна мөнгө, үйлчилгээ шаарддаг, худал мэдүүлэхийг нөлөөлдөг, эсрэг талд үйлчилдэг, цагдан хорих байрны дотоод журам зөрчсөн, шүүх хуралдаанд ирдэггүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шийдвэрлэгдээгүй хэрэг маргааны талаар мэдэгдэл хийдэг, өмгөөллийн хөлсөнд төлсөн мөнгө буцааж авах гэх мэт зөрчлүүд гаргаж байгааг мэргэжлийн хүмүүс хэлж байгааг оруулах нь зүйтэй.

Шүүгч нартай холбоотой гомдол, мэдээллийн агуулга нь: Мэдлэг чадвар дутмаг, нэг талыг барьдаг, хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагааг удаашруулан нөгөө талд үйлчилдэг, танил тал хээл хахуулиар хэрэг маргааныг шийдвэрлэдэг, хууль зөрчдөг, хуулийг өөрийн дураар тайлбарладаг, оролцогч нарыг загнах зэргээр ёс зүйгүй авирладаг, албан ёсны шийдвэр нь үг үсэг, утга найруулгын алдаатай, хариуцлагагүй зэрэг байдлаар гомдол гаргадаг байна.

Кэйс №3. “Миний бие Х орон байраа Н-д залилуулаад БЗД-ийн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүхэд удаа дараа хүсэлт гаргасан боловч миний хүсэлтүүдийг хүлээж авахаас татгалзаж, давж заалдах эрхийг минь хассан шийдвэр гаргасанд гомдолтой байна. Иймд шүүгч О нь эсрэг талд үйлчилж буруу шийдвэр гаргасанд гомдолтой байгаа тул шүүгчийн шийдвэрийг шалгаж хянаж давж заалдах эрхийг минь сэргээж өгнө үү” гэх мэт.

Шийдвэрлэсэн байдал:

Уг маргаан нь тус хорооны үйл ажиллагаанд хамаарахгүй тус маргаан үүсгэхээс татгалзаад буцаасан.

Прокурортой холбогдуулан гаргасан гомдлын агуулга нь: Харилцааны соёлгүй, нэг талыг барьдаг, хууль дүрмээ мэддэггүй, гомдол хүсэлтэд хариу өгдөггүй, хүнд сурталтай, шат дамжлаг ихтэй, хорьж цагдахаар дайлайлган сүрдүүлдэг, хууль зөрчдөг, хахууль авдаг гэсэн нийтлэг утгатай байна. Ихэвчлэн прокурорын ёс зүйгүй үйлдэл гаргасан хэмжээн гомдол гаргадаг байна.

Шүүгч, прокурорт холбогдуулан гаргаж байгаа гомдлын нийтлэг агуулга нь “Хууль буруу хэрэглэсэн, тайлбарласан, хууль зөрчдөг, нотолгоонд тулгуурлаагүй шийдвэр гаргадаг, нэг талыг барьдаг, ашиг сонирхлын зөрчилтэй, мэдлэг чадваргүй” зэрэг зөрчил нийтлэг байдаг гэж зарим судлаач, мэргэжилтэн үздэг байна.

Мэргэжлийн хариуцлагын хороонд АТГ-аас өмгөөлөгчид холбогдуулан гаргасан гомдол мэдээллийн талаар дараахь илтгэлд дурдсан байна.

Авлигатай тэмцэх газрын ахлах мөрдөгчийн мэдээлснээр өмгөөлөгчид авлига, албан тушаалын гэмт хэрэг дээр “хуульчийн мэргэжлийн дагуу ажиллахгүй, хууль бусаар ажилладаг, авлигын гэмт хэргийг шалгахад хуульд заасны дагуу өмгөөллийн үйлчилгээг үзүүлдэггүй, ял шийтгүүлсэн хүн өмгөөлөгч хийж байна” гэв. Энэ асуудлаар МХХнд гомдол гаргасан боловч өөр хүнд хамаарах гомдлын агуулгатайгаар таны гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосон тухай тайлбар ирүүлсэн байна. Энэ байдлаас үзэхэд өмгөөлөгчдийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагыг сайжруулах, нөгөө талаас гомдлыг шалгаж шийдвэрлэж буй байдлын чанар, үр дүнд анхаарах шаардлага байгаа нь ажиглагдав^[4].

Түүнчлэн, Хүний эрхийн Үндэсний комисст өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн алдаа, дутагдалтай холбоотой багагүй гомдол, мэдээлэл ирдгийг хууль зүйн доктор П.Оюунчимэг илтгэлдээ дурьдаж байв^[5].

Мөн шүүгч нартай холбоотой анхаарах асуудал бол 2015 оны Эрүүгийн хууль 2017 оны 5 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орж, 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж байгаа билээ. Хууль мөрдөгдөж эхлэхээс өмнө Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуучин хуулиар баривчлах ял, эсхүл өөр гэмт хэрэгт үйлдсэн этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулж, шинэ хуульд нийцүүлэн тэдгээрийг ялаас чөлөөлсөн тухай тохиолдол, хуулийг дээдлэх зарчим алдагдсан, түүний цаана авлига, ашиг сонирхлын зөрчил бий эсэхийг холбогдох байгууллагууд нарийвчлан судалж, нягтлах нь зүйтэй. Тодруулбал, Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ хуулиар баривчлах, албадан ажил хийлгэх ялыг хассан.

1.4. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:


Гомдлыг шалгаж, шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл 14.8 хувийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн, 40.1 хувийг маргаан үүсгэсэн, 45.1 хувийг маргаан үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4 Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн давхардал хийдлийг арилгах, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах зорилгоор Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль хамтран 2018 оны 3 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулсан “Эрүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаархи хэлэлцүүлэг”-т Авлигатай тэмцэх газрын ахлах мөрдөгч Ч. Жаргалбаатарын хэлэлцүүлсэн “Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэлээс.

5 Мөн тэнд “Эрүүгийн хууль тогтоомж дахь хүний эрхийн нөхцөл байдал” илтгэлээс.

График 2. Гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн байдал (2014-2017)




Мэргэжлийн хариуцлагын хорооноос маргаан үүсгэсэн 317 гомдол, мэдээллийн 232 буюу 73.2 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, 43 буюу 13.6 хувийг хаалттай сануулах сахилгын шийтгэл оногдуулсан, 33 буюу 10.4 хувийг мэргэжлийн дүгнэлт үйлдсэн, одоогоор 9 нь ажиллагаанд байгаа гэсэн тайлан гаргажээ.

Хүснэгт 9. Маргааныг шалгаж, шийдвэрлэсэн байдал

Он	Marгаан үүсгэсэн гомдол, мэдээлэл	Үүнээс:			
		Marгааныг хэрэгсэхгүй болгосон	Хаалттай сануулсан	Мэргэжлийн дүгнэлт үйлдсэн	Ажиллагаанд байгаа маргааныг үлдэгдэл
2014	31	26	1	5	-
2015	95	70	12	9	-
2016	97	71	11	9	-
2017	94	65	19	10	-
Бүгд	317	232	43	33	9
Эзлэх %		73,2	13,6	10,4	2,8

Нийт хүлээн авсан 791 гомдол, мэдээллийн 317 буюу 40.1 хувийг маргаан үүсгэсэн боловч маргаан үүсгэсэн гомдол, мэдээллийн 232 буюу 73.2 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

График 3. Маргааны шийдвэрлэлт (2014-2017)

Дээрх графикаас үзэхэд 791 гомдол, мэдээллийг шалгасаны эцэст 43-д нь хаалттай сануулж, 33-д нь мэргэжлийн дүгнэлт үйлдэж, нийтдээ 9.6 хувьд нь арга хэмжээ авчээ. Энэ нь хуульчдын ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа гаргасан байдалд хэрхэн хариуцлага тооцож буйг илэрхийлж байна.

Бид 2016-2017 онд харьяаллын дагуу шилжүүлсэн гомдол, мэдээллийг нарийвчлан үзлээ.

Хүснэгт 10. Харьяаллын дагуу шилжүүлсэн байдал

Он	Харьяаллын дагуу шилжүүлсэн гомдол, мэдээлэл	Үүнээс:					Гомдол, гаргагчдад	
		Шүүхийн ёс зүйн хороонд шилжүүлсэн	Шүүхийн мэргэжлийн хороонд шилжүүлсэн	Прокурорын ёс зүйн зөвлөлд шилжүүлсэн	Гомдол, гаргагчдад			
					Албан бичгээр	Бусад хэлбэрээр		
2016	32	11	1	1	3	16		
2017	45	13		1	6	25		
Бүгд	77	24	1	2	9	41		
Эзлэх хувь		37.1				64.9		

Мэргэжлийн хариуцлагын хорооноос зарим гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлдэг байна. Судалгаанаас үзэхэд 2016-2017 онд 24 гомдол, мэдээллийг Шүүхийн ёс зүйн хороонд, 2 гомдол, мэдээллийг Прокурорын ёс зүйн зөвлөлд тус тус шилжүүлсэн бол 64.9 хувийг гомдол гаргагчид албан бичгээр, болон бусад хэлбэрээр мэдэгдсэн гэсэн судалгааны дүн гарсан.

Бусад хэлбэрээр гэсэн агуулгад 2016 онд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл гэсэн үндэслэлээр цагдаагийн байгууллагад 2017 онд 2 гомдол, мэдээллийг прокурорын байгууллагад тус тус шилжүүлсэн байна. Гэхдээ гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж буй процессын ажиллагааг бүртгэлжүүлэх, нэгдсэн мэдээлэлтэй байх зэрэг асуудал тулгамдаж буй нь судалгааны явцад ажиглагдлаа.

Хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах асуудлыг Эрүүгийн хуульд хуульчлан тогтоожээ. Тухайлбал; 2015 онд шинээр батлагдан мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн 21.8 дугаар зүйлд Хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх гэмт хэргийг хуульчлан өгсөн байна^[6]. Хуульчийн мэргэжлийн нэрийг хэрэглэх эрхгүй хүн хуульчийн мэргэжлийн нэрийг ашигласан, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны улмаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заажээ.

Мөн Эрүүгийн хуулийн 21.14 дүгээр зүйлд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах гэмт хэргийг хуульчилсан байна^[7].

Тодруулбал; Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, эсхүл прокурор өөртөө, бусдад давуу байдал бий болгох зорилгоор илт хууль бус шийдвэр гаргасан бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

Прокурор, эсхүл өмгөөлөгч хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад өөртөө, бусдад давуу байдал бий болгох зорилгоор мэргэжлийн үйл ажиллагаагаа хууль бусаар явуулсан бол хүндрүүлэн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооноос шалгаж буй гомдол, мэдээлэлд хамаарах хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд гарч буй алдаа, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй байх аваас хуулийн холбогдох байгууллагад нэн даруй шилжүүлэх, оногдуулсан ял шийтгэлийн хэрэгжилтийг хангахад хамтран ажиллаж байх нь зүйтэй. Одоогоор ийм практик байхгүй ч ийм тохиолдол гарч болзошгүйг анхаарах учиртай.

6 <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

7 <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

Түүнчлэн хуульч, тэр дундаас прокурор, шүүгч нар хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах, улмаар авлигын гэмт хэрэгт холбогдох ашиг сонирхлын зөрчил гаргаж болзошгүй үйлдлийг Мэргэжлийн хариуцлагын хороо анхааралдаа авч Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүгчээс гэмт хэрэгт холбогдсон асуудлыг шалгах эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах шаардлага үүсч болзошгүй байна.

ХОЁР. ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ ГАРГАСАН ХУУЛЬЧДАД ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ САХИЛГЫН ШИЙТГЭЛ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ ХЭЛБЭР, САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛСАН БАЙДАЛ

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д зааснаар хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн хуульчид Мэргэжлийн хариуцлагын хороо дор дурдсан төрлийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Үүнд:

1. Хаалттай болон нээлттэй сануулах^[8];
2. Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;
3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;
4. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох.

Мөн МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмын 2.6 дугаар зүйлийн 1-д “Хариуцагчийн гаргасан зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнээс хамаарч бүрэлдэхүүн ёс зүйн болон нөлөөллийн сургалтанд албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг нөлөөллийн арга хэмжээ болгон хэрэглэж болно” гэсэн нэмэгдэл шийтгэл оногдуулахаар зохицуулсан байна.

2015-2017 онд нийт 52 хуульчид хариуцлага хүлээлгэсэн бөгөөд эдгээр хуульчид бүгд өмгөөлөгч байжээ. Харин шүүгч, прокурорт хариуцлага хүлээлгэсэн тохиолдол гараагүй байна.

Хүснэгт 11. Өмгөөлөгчид хариуцлага оногдуулсан байдал

Хариуцлагын төрөл	Бүгд	2014	2015	2016	2017
Бүгд	52	-	16	25	11
Хаалттай сануулсан	31		10	16	5
Нээлттэй сануулсан	12		2	7	3
Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй түдгэлзүүлсэн	2		-	1	1


⁸ Зөрчил гаргасан хуульчид өөрт нь ганцаарчлан сануулахыг хаалттай сануулах, нийтэд зарлаж сануулахыг нээлттэй сануулах гэнэ.

Хариуцлагын төрөл	Бүгд	2014	2015	2016	2017
Шүүхэд төлөөлөх эрхийг 3 сараар түдгэлзүүлсэн	1		-	-	1
Шүүхэд төлөөлөх эрхийг 6 сараар түдгэлзүүлсэн	3		1	1	1
Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 6 сараар түдгэлзүүлсэн	1		1	-	-
Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар хүчингүй болгосон	1		1	-	-
Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгосон	1		1	-	-

2015 онд 16, 2016 онд 25, 2017 онд 11 хуульч-өмгөөлөгч нарт Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хариуцлага оногдуулжээ.

Сахилгын шийтгэл оногдуулсан 52 (давхардсан тоогоор) хуульчийн 20 буюу 38.5 хувь нь эмэгтэй, 32 буюу 61.5 хувь нь эрэгтэй байна.

График 4. Өмгөөлөгчдөд хариуцлага оногдуулсан байдал (шийтгэлийн төрөл)



Дээрх графикаас харахад хаалттай сануулах, нээлттэй сануулах шийтгэлийг түлхүү практикт хэрэглэсэн байна. Гэвч судалгааны явцад мэргэжлийн хүмүүстэй ярилцлага хийхэд “хаалттай сануулах” нь хариуцлагын хувьд үр нөлөөтэй байж чадахгүй байгааг дурьдаж байв. Энэ нь 1 өмгөөлөгчид 3 удаа шийтгэл хүлээлгэсэн байх бөгөөд хаалттай сануулсан, шүүхэд төлөөлөх эрхийг 6 сар түдгэлзүүлсэн, шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй түдгэлзүүлсэн бол 1 өмгөөлөгчид 3 удаа хаалттай сануулсан, 3 өмгөөлөгчид хаалттай сануулсан, шүүхэд төлөөлөх эрхийг 6 сар түдгэлзүүлсэн зэрэг хариуцлага хүлээлгэсэнээс хаалттай сануулах хариуцлагын төрлийн үр нөлөөг дүгнэж болох юм.

Ёс зүйн болон нөлөөллийн сургалтанд албадан суулгах нэмэгдэл шийтгэл хүлээлгэсэн тохиолдол 1 байна.

Хариуцагчийн гаргасан зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнээс хамаарч мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүн ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг хэрэглэсэн. Энэхүү нэмэгдэл шийтгэлийг өнөөдрийн байдлаар хэрэгжүүлэх, нөхцөл бүрдээгүй.

/Сахилгын шинжээчтэй хийсэн ярилцлагаас/

Сахилгын шийтгэл хүлээсэн хуульчдын гаргасан зөрчлийн агуулга:

Хүснэгт 12.

Зөрчлийн агуулга	Тоо
Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж төлбөр авчихаад гэрээний үүргээ биелүүлээгүй	28
Шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй	10
Цагдан хорих байрны дотоод журам зөрчсөн	4
Хэргийн талаар урьдчилан амлалт өгсөн	2
Дарамталж хэл амаар доромжилсон	2
Хууран мэхэлсэн	2
Ашиг сонирхолын зөрчил үүсгэсэн, хоёр талд үйлчилсэн	1
Шүүгчээр томилогдон туслалцаа үзүүлэх боломжгүй болсноо үйлчлүүлэгчдээ мэдэгдээгүй	
Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдож тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялаар шийтгүүлсэн	1
Давж заалдах гомдол гаргах хугацааг хэтрүүлснээс болж үйлчлүүлэгч нь давж заалдах эрхээ эдэлж чадаагүй	1

Хариуцлага хүлээлгэсэн хуульчид буюу өмгөөлөгчид гэмт хэрэг үйлдэж тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялаар шийтгүүлсэн, үйлчлүүлэгчдээ эрх зүйн туслалцаа үзүүлээгүй, гэрээ байгуулаагүй, цагдан хорих байрны дотоод журмыг зөрчсөн, согтуугаар үйл ажиллагаа явуулсан, шүүхийг үл хүндэтгэх,

хуурч мэхлэх, үйлчлүүлэгчтэйгээ үгсэн тохирсон зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулан саад учруулсан, шүүхийг хууран мэхэлсэн, үйлчлүүлэгчээ төөрөгдүүлэх, урьдчилан амлах, мэхлэх зэргээр их хэмжээний хөлс зардал тогтоож авсан, үйлчлүүлэгчийнхээ эрх, ашиг сонирхлыг тууштай хамгаалаагүй зэрэг үйлдэлд буруутгагджээ.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд хэргийн шийдвэрлэлтийн талаар урьдчилан амлалт өгсөн, ашиг сонирхлын зөрчил үүсгэж, хоёр талд үйлчилсэн тохиолдлоор 3 өмгөөлөгч хариуцлага хүлээсэн байгаа нь энэ салбарт авлига, ашиг сонирхлын зөрчил, хууль бус үйлдэл байгааг харуулж байна.

Кэйс №4. “Өмгөөлөгч Г нь хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулахдаа мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд мөнгө өгч хэргийг чинь хэрэгсэхгүй болгож өгнө гэж амлаж үйлчилгээний хөлсөнд 5 сая төгрөг авсан. Үйлчилгээний хөлсөө харилцан тохиролцоогүй. Мөн хэргийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөөгүй, хэл амаар доромжилсонд гомдолтой байна.

Шийдвэрлэсэн байдал: Хариуцагч өмгөөлөгч Г нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.4 дүгээр зүйлийн 1-д “Хуульч үйлчилгээний хөлс, зардлыг үйлчлүүлэгчтэйгээ харилцан тохиролцож тогтооно” гэснийг зөрчсөн тул шүүхэд төлөөлөх эрхийг 3 сар түдгэлзүүлэх хариуцлага хүлээлгэсэн байна.

Кэйс №5. “МХХ-ны гишүүн өмгөөлөгч И, О нар нь “Н” ХХК-ийн эрх зүйн газарт ажиллаж байсан ба тус өмгөөлөгч нар нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг ноцтой зөрчиж Цагдаа болон шүүхийн байгууллагад манай компаний эсрэг өргөдөл, нэхэмжлэл гарган, мөн манай компаний цагдаа болон шүүхэд гаргасан өргөдөл, нэхэмжлэлийн хариуцагчийг төлөөлж шүүх хуралдаанд оролцож Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг ноцтой зөрчиж байна. Иймд эдгээр өмгөөлөгчдийн гаргасан зөрчлийг шалгаж өгнө үү?

Шийдвэрлэсэн байдал: Хариуцагч өмгөөлөгч О нь “Н” ХХК-д хууль зүйн туслалцаа үзүүлж байх хугацаандаа иргэн О-д иргэн А-ийн эзэмшлийн хашаа байшинг 5 сая төгрөгөөр худалдан авч уг хашаа байшинг “Н” ХХК-д өгч өрийг чинь байрагдуулна” гэж худал мэдээллээр хангаж, өөрийн охин Э-ийн эзэмшлийн хашаа байшинг О-д худалдсан болох нь тогтоогдож хариуцагчид хаалттай сануулах сахилгын шийтгэл хүлээлгэсэн байна.

Кэйс №6. Өмгөөлөгч Л нь батлан даалтанд гаргуулна, хэргийг чинь хэрэгсэхгүй болгож өгнө гэж тохиролцож амаар хэлцэл хийж 7 сая төгрөг авчихаад хууль зүйн туслалцаа үзүүлэхгүй, утасаа авахгүй, хэргийн матерталтай ч ирж танилцахгүй байгаад гомдолтой байна. Мөн өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг тохиролцохдоо бичгээр гэрээ байгуулаагүй.

Шийдвэрлэсэн байдал: Хариуцагч өмгөөлөгч Л нь дээрх үйдлээрээ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д заасан “Хуульч нь үйлчлүүлэгчтэйгээ тогтомол, ойлгомжтой харилцаа холбоотой байх” , 2.2 дугаар зүйлийн 2-д “Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна”

гэснийг зөрчсөн тул шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй хүчингүй болгох шийтгэл хүлээлгэсэн байна.

Кэйс №7. Иргэн Г нь гомдолдоо “сэжигтэний өмгөөлөгч А нь урьд нь Цагдаагийн байгууллагад өндөр албан тушаалд ажиллаж байсан байдлаа хууль бусаар урвуулан ашиглаж, эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулж, мөрдөн байцаалтын ажиллагаанд хөндлөнгөөс дур мэдэн оролцож, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг мушгин гуйвуулах, сэжигтэн этгээдийн хууль бус үйлдлийг илтэд үндэслэлгүйгээр хаацайлах, худал хардлага сэрдлэгийг үүсгэн төрийн албан хаагчийн нэр төрд халдах зэргээр өмгөөллийн үйл ажиллагааг хууль зөрчсөн, ёс зүйгүй байдлаар хэрэгүүлж байгааг хүлээн зөвгөөрөхгүй байна. Арга хэмжээ авч өгнө үү” гэжээ.

Шийдвэрлэсэн байдал: Өмгөөлөгч А нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн болох нь тогтоогдохгүй байна гэж үзээд маргаан үүсгэхээс татгалзсан байна.

Кэйс №8. АТГ-ийн албан тушаалтан гомдолдоо “Авилгатай тэмцэх газраас Гаалийн улсын байцаагч, гаалийн ахлах байцаагч нар бусдаас хээл хахууль авсан үйлдэлтэй эрүүгийн ... дугаартай хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна. Хэргийн зарим холбогдогч нарыг мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулж болзошгүй үндэслэлээр цагдан хорьсон. Өөрийг нь сэжигтэн, яллагдагч нарын зүгээс өмгөөлөгчөөр сонгон аваагүй байхад цагдан хоригдсон этгээдүүдтэй нэр бүхий өмгөөлөгч нар нь шүүхэд төлөөлөх эрхийн үнэмлэхээ ашиглан уулзаж, “хээл хахууль өгөх”, “хээл хахууль авах” гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан этгээдүүдийн дунд мэдээлэл зөөх, мэдүүлэг зааж өгөх зэргээр хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах зорилго бүхий үйлдлүүдийг гаргаж байгаа тул арга хэмжээ авч өгнө үү” гэжээ.

Шийдвэрлэсэн байдал: Өмгөөлөгч нар нь нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм зөрчсөн болох нь тогтоогдохгүй байх тул маргааныг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Судалгааны явцад төрийн зарим байгууллагад хандаж, тоон мэдээлэл авч үзвэл: Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээр 2016 онд 2 шүүгч, 2 прокурор, 2017 онд 1 шүүгч гэмт хэрэгт холбогдон цагдаагийн байгууллагад шалгагдсан байна. Үүнээс 2016 онд 1 шүүгч нь гарын үсгийн хуурамчаар зурсан байна. Бусад нь зам тээврийн осол гаргаж, хүн мөргөсөн, мөн бусдын бие махдбодид гэмтэл учруулах гэмт хэрэгт холбогдсон байна.

Авилгатай тэмцэх газрын мэдээллээр 2016 онд шүүгчтэй холбоотой 22, прокурортой холбоотой 9, 2017 онд шүүгчтэй холбоотой 36, прокурортой холбоотой 23, 2018 оны 1, 2 дугаар сарын байдлаар шүүгчтэй холбоотой 12, прокурортой холбоотой 11 гомдол, мэдээлэл тус тус хүлээн авсан байна.

Дээрх гомдол, мэдээллийн дийлэнх ерөнхий шинж байдал, утгаар нь авч үзвэл “албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон” гэх утга бүхий мэдээлэл байна.

Хуульчдаас шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүгч, прокурорын ёс зүй, хууль бус үйлдэл, шүүх эрх мэдлийн салбар дахь авлига, хүнд суртлыг гүнзгийрүүлэн судлах нь хуулийн салбарт сайн засаглал тогтоох, шударга ёсыг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг давж заалдсан байдал

Мэргэжлийн хариуцлагын хорооны маргааныг хянан шийдвэрлэсэн бүрэлдэхүүний тогтоолыг эс зөвшөөрвөл маргааны ороцогч болон сахилгын шинжээчид Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхийг холбогдох хуулийн зохицуулалтаар олгосон байна.

Уг эрхийнхээ хүрээнд маргааны оролцогчдоос бүрэлдэхүүний тогтоолыг эс зөвшөөрч 10 гомдол гаргаснаас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 5 маргааныг хянаж 1 маргааныг хэрэгсэхгүй болгож, 3 маргааныг хэвээр үлдээж, 4 маргааныг шийдвэрлээгүй байна.

ГУРАВ. ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ ГАРГАСАН ХУУЛЬЧИД САХИЛГЫН ШИЙТГЭЛ ХҮЛЭЭЛГЭХ ҮНДЭСЛЭЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АСУУДАЛ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ

Хууль тогтоомж дахь зохицуулалт

Хуульчийн^[9] ёс зүйн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага, ёс зүйн зөрчилд гомдол гаргах, хянан шийдвэрлэх ажиллагааг “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль^[10], МХХ-ны дүрэм, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам, МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам” -аар зохицуулж байна.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт

Хуульчийн ёс зүйн зөрчил гаргасан хуульчтай холбоотой гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх процессыг холбогдох хууль тогтоомжид дараахь байдлаар зохицуулжээ.

9 Хуульч гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг; //Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1. Монгол Улсын хэмжээнд 2017 оны 9 дүгээр сарын 18-ны байдлаар 5303 хуульч бүртгэлтэй байна. Үүнээс шүүгч 512, прокурор 506, өмгөөлөгч 2077, бусад хуульч 2208.

10 <http://www.legalinfo.mn/law/details/8661?lawid=8661>

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, хэм хэмжээ:

№		Хуулийн зохицуулалт Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
1	Мэргэжлийн хариуцлагын хорооны ^[2] чиг үүрэг	63.1.Мэргэжлийн хариуцлагын хороо нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд Хуульчдын холбооны хүсэлтээр дүгнэлт гаргах, хуульч энэ хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэх болон Хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргаан / цаашид "маргаан" гэх/-ыг гомдлын дагуу хянан шийдвэрлэх, хуульчид энэ хуулийн 29.1-д заасан хариуцлага хүлээлгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
2	Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим	64.4.Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг ^[3] жишиг болгосон журмаар явагдах бөгөөд уг журмыг Зөвлөл ^[4] батална.
3	Мэргэжлийн хариуцлагын хорооны хянан шийдвэрлэх маргаан	64.5.Мэргэжлийн хариуцлагын хороо дараах маргааныг хянан шийдвэрлэнэ: 64.5.1.өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг үйлчлүүлэгчийн гомдлоор; 64.5.2.шүүгч, прокурор, өмгөөлөгчийн Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн тухай болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэнтэй холбоотой үүссэн маргааныг шүүгч, прокурор, өмгөөлөгчийн гомдлоор; 64.5.3.хуульч энэ хуулийг болон Хуульчдын холбооны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгаврыг зөрчсөнтэй холбоотой маргааныг Хуульчдын холбооны хүсэлтээр.
4	Маргаан үүсгэх	64.1.Мэргэжлийн хариуцлагын хороо нь энэ хуулийн 63.1-д заасан маргааныг зохих этгээдийн гомдол, хүсэлтээр үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. 64.2.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой иргэний болон эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаа явагдаж байгаа эсэхээс үл хамааран тухайн хуульчтай холбоотой гомдол, хүсэлт ирсэн бол Мэргэжлийн хариуцлагын хороо маргаан үүсгэх эрхтэй.
4	Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн	63.8.Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба бүрэлдэхүүнд шүүгч гурав, прокурор, өмгөөлөгч тус бүр нэг байна. 63.9.Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хуваарилах болон маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилохтой холбогдсон журмыг Зөвлөл батална.

5	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд[5] хүлээлгэх хариуцлага	<p>29.1.Энэ хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн хуульчид Мэргэжлийн хариуцлагын хороо дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:</p> <p>29.1.1.хаалттай болон нээлтэй сануулах;</p> <p>29.1.2.шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;</p> <p>29.1.3.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх;</p> <p>29.1.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох</p> <p>29.2.Зөрчил гаргасан хуульчид өөрт нь ганцаарчлан сануулахыг хаалттай сануулах, нийтэд зарлаж сануулахыг нээлттэй сануулах гэнэ.</p>
---	--	--


Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны журам

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа:

№	Явагдах ажиллагаа	Хугацаа	Үндэслэл
Нэг. МХХ-д гомдол ирснээс шийдвэрлэх хүртэлх процесс			
1.	Гомдол, мэдээлэл, хүсэлтийг зохих журмын дагуу сахилгын шинжээчид мэргэжлийн хариуцлагын хороо хуваарилан, сахилгын шинжээч 14 хоногт багтаан хянан үзэж, маргаан үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.	14 хоногийн дотор, шаардлагатай бол Ажлын албаны дарга 7 хоногоор сунгаж болно	Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам, 2.1. дүгээр зүйл. Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 8.6. зүйлийн 1
2.	Сахилгын шинжээч нь зөрчил гаргасан эсхүл мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй тухай гомдол, хүсэлт эсхүл бусад эх сурвалжаас ирсэн мэдээллийг шалгах, нотлох үндсэн дээр дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж, энэ тухай гомдол гаргагчид мэдэгдэнэ:		Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 8.7. зүйлийн 1
	1.1.маргаан үүсгэх;		
	1.2.маргаан үүсгэхээс татгалзах санал гаргах.		

№	Явагдах ажиллагаа	Хугацаа	Үндэслэл
3.	Сахилгын шинжээч маргаан үүсгэсэн бол тогтоолыг 24 цагийн дотор Ажлын албаны даргад танилцуулж, маргааны дугаар авна.	24 цагийн дотор	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 8.8. зүйлийн 3
4.	Гомдол, мэдээлэл, хүсэлтэд дурдагдсан үйл баримт нь үнэн байсан ч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил эсхүл мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй тухай маргаанд хамаарахгүй бол сахилгын шинжээч маргаан үүсгэхээс татгалзах тухай саналаа зохих журмын дагуу томилогдсон хорооны гишүүнд хүргүүлнэ.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 8.9. зүйлийн 1
5.	Хорооны гишүүн сахилгын шинжээчийн саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж захирамж гаргана.	14 хоног	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 8.9. зүйлийн 2
6.	Маргаан үүсгэх тухай тогтоол гаргасны дараа зөрчил гарсан эсхүл мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй эсэхийг шалгах ажиллагааг эхлүүлнэ.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.1. зүйлийн 1
7.	Зөрчил болон мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй байдлыг шалгах ажиллагааг маргаан үүсгэснээс хойш 60 хоногийн дотор гүйцэтгэнэ. Маргааны ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан сахилгын шинжээч энэ хугацааг дахин 30 хүртэл хоногоор сунгах санал гаргаж, энэхүү саналыг хорооны гишүүн хянаж шийдвэрлэнэ.	60 хоног, 30 хоногоор сунгах	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.2 зүйлийн 1, 2
8.	Сахилгын шинжээч нь маргааны талаар хариуцагчид мэдэгдэж баримтжуулан, хариу тайлбар гаргах боломж олгоно.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.6. зүйлийн 1

№	Явагдах ажиллагаа	Хугацаа	Үндэслэл
9.	Сахилгын шинжээч нь шалгах ажиллагааг явуулж дуусгасны дараа маргааныг хэрэгсэхгүй болгох, хаалттай сануулах, мэргэжлийн дүгнэлт үйлдэх, мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй учир хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх санал гаргана.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.8. зүйлийн 1
10.	Маргааныг хэрэгсэхгүй болгох, мэргэжлийн дүгнэлт үйлдэх, мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй учир хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлдүүлэх тухай сахилгын шинжээчийн саналыг зохих журмын дагуу гишүүн хянан. Гишүүн нь сахилгын шинжээчийн саналыг хэвээр үлдээх, хүчингүй болгох эсхүл өөрчлөх захирамжийг 14 хоногийн дотор гаргана.	14 хоног	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.10. зүйлийн 1
11.	Сахилгын шинжээч хаалттай сануулах санал гаргасан бол энэ тухай хариуцагчид бичгээр мэдэгдэх бөгөөд энэхүү мэдэгдэлд тухайн саналыг зөвшөөрөхгүй бол 14 хоногийн дотор нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар тухайн маргааныг шийдвэрлүүлэх хүсэлтийг бичгээр гаргах эрхтэй болохыг заана.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.11. зүйл
12.	Маргааныг нээлттэй хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэх бол сахилгын шинжээч нь зөрчлийн мөн чанарыг хангалттай, бодитой тодорхойлсон мэргэжлийн дүгнэлтийг бичгээр үйлдэнэ.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 10.12. зүйл



№	Явагдах ажиллагаа	Хугацаа	Үндэслэл
Хоёр. Маргааныг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх			
13	Мэргэжлийн дүгнэлт үйлдсэнээс хойш бүрэлдэхүүний тогтоол гарах хүртэл хариуцагч нь сахилгын шийтгэлийн тодорхой төрөл, хэмжээг хүлээж, мэргэжлийн дүгнэлтийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө гэсэн тохиролцоог сахилгын шинжээчтэй хийж болно. Бүрэлдэхүүн тохиролцоог хянаж, түүнээс татгалзах эсхүл батлах тогтоол гаргана.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 15.1. зүйл
14	Мэргэжлийн дүгнэлтийг үйлдэхээс өмнө хаалттай сануулах шийтгэлийг хүлээн зөвшөөрсөн тохиролцоог хийсэн бол уг тохиролцоог гишүүн хянаж, батлах эсэх захирамж гаргана.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 15.1. зүйлийн 4
15	Бүрэлдэхүүн нь сахилгын шийтгэлийг хүлээн зөвшөөрсөн тайлбарыг хянаж тохиролцооноос татгалзах эсхүл хариуцагчид сахилгын шийтгэл оногдуулах тогтоол гаргана.	-	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 15.3. зүйл
Гурав. Давж заалдах гомдол гаргах			
16	Хариуцагч эсхүл сахилгын шинжээч бүрэлдэхүүний тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах[б] шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй. Гомдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.	Хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гомдол гаргана.	Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам 17.1. зүйл

**ДӨРӨВ. ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТАЛААР ИРГЭН, АЛБАН
ТУШААЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН
ХОРООНД ГАРГАСАН ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭЭР
ТОГТООСОН ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ**

Дүрэм, журам	Чиг үүргийн хороод	Мэргэжлийн хариуцлагын хороо	Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо
Хуульчдын холбооны дүрэм (Хуульчдын анхдугаар Их хурлын 2013 оны 3 дугаар тогтоол)	8.2.1. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд Хуульчдын холбооны хүсэлтээр дүгнэлт гаргах, хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэх болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзэсэн тухай маргааныг гомдлын дагуу хянан шийдвэрлэх, хуульчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.	8.5.1. дугаар зүйл. ... хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон хуульчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах ... Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.	
Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм	20.5. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шийтгэл хүлээлгэнэ.		
МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам (МХХ-ны зөвлөлийн 2014 оны 79 дүгээр тогтоол)	2.1.2. Хороо нь хуульчийн мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй байдал болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг шалгах, нотлох болон шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.		

<p>МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам</p> <p>(МХХ-ны зөвлөлийн 2014 оны 86 дугаар тогтоол)</p>	<p>1.4.1.Хороо нь дор дурдсан зөрчил гаргасан этгээдэд сахилгын шийтгэл оногдуулна:</p> <p>1.1. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан хуульч;</p> <p>1.2. дараах тохиолдолд өмнө нь хуульчийн зөвшөөрөлтэй байсан этгээд:</p> <p>1.2.1. хуульчийн зөвшөөрлийг түдгэлз үүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох эсхүл мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй учир түдгэлзүүлэхээс өмнө явуулсан үйл ажиллагаа тай нь холбогдуулан;</p> <p>1.2.2. хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хугацаатай хүчингүй болгосон эсхүл мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй учир түдгэлзүүлснээс хойш хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан эсхүл зөрчил гаргасантай нь холбогдуулан.</p>	<p>2.6.1. Хариуцагчийн гаргасан зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнээс хамаарч бүрэлдэхүүн ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг нөлөөллийн арга хэмжээ болгон хэрэглэж болно.</p> <p>19.2.2. Сахилгын шинжээч нь өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор дүгнэлт гаргуулахаар өргөдлийн хуулбарыг Ёс зүйн хороонд хүргүүлнэ.</p> <p>19.6.1. Ёс зүйн хороо шүүхэд төлөөлөх эрх эсхүл хуульчийн зөвшөөрлийг хугацаагүй түдгэлзүүлсэн шийтгэл хүлээсэн хуульчийн эрх, зөвшөөрлийг сэргээхэд ёс зүйн хувьд харшлах шалтгаан байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргаж, Хорооноос тогтоосон хугацаанд ирүүлнэ.</p>
--	---	--

Хуульчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмаар зохицуулсан ба хэрэгжүүлэхэд дараах хүндрэл гардаг байна. Үүнд:

- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3-д “Мэргэжлийн хариуцлагын хороо нь нэр хүндтэй хуульчдаас бүрдэх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд шүүгчдийн төлөөлөл 18, прокурор, өмгөөлөгчдийн төлөөлөл тус бүр 6 байна. . . .” мөн 63 дугаар зүйлийн 63.8-д “Мэргэжлийн хариуцлагын хороо нь маргааныг таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ба бүрэлдэхүүнд шүүгч 3, прокурор, өмгөөлөгч тус бүр нэг байна” гэж заасан ба маргааныг шийдвэрлэхэд оролцож байгаа гишүүдийн тооны харьцаа тэнцүү

биш байгаа нь бүрэлдэхүүний хурлыг товлосон хугацаанд хийхэд хүндрэлтэй байдаг.

- Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим баримталж явагддаг учир процессын хувьд хэт нөсөр, шалгагч болон сахилгын шинжээчийн ачаалал их, хорооны гишүүдийн хувьд үндсэн ажлын ачаалал их байдаг.
- Тодорхой эрх зүйн зохицуулалт байхгүйгээс Мэргэжлийн хариуцлагын хорооноос шалгаж буй гомдол, мэдээлэлд холбогдуулан нотлох баримт, бусад материал, лавлагаа, мэдээллийг холбогдох байгууллагуудаас хүсэхэд хууль сахиулах, прокурор, шүүхийн байгууллага хариу ирүүлдэггүй хүндрэл учирдаг байна. Ялангуяа цагдаагийн байгууллагаас хариу ирдэггүй, шүүхээс эрүүгийн хэргийн оролцогч бус учраас өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлдэг. Мөн Хил хамгаалах ерөнхий газраас хувь хүний нууцтай холбоотой гэх шалтгаанаар өгдөггүй хүндрэл гардаг.
- Иргэд МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол, мэдээлэл гаргах тохиолдолд тус холбооны Тамгын газраар дамжихгүйгээр шууд Мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол, мэдээллээ гаргадаг байх нь үйл ажиллагааны хувьд давхардал үүсэхгүй, иргэдэд үйлчилгээ үзүүлэх шат дамжлага багасах, санхүүгийн хувьд хэмнэлтийн горимоор ажиллахад чухал нөлөөтэй.

ДҮГНЭЛТ

Хуульчийн ёс зүйн зөрчил, түүний шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийгээд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Мэргэжлийн хариуцлагын хороо үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдэж, 2013 оноос үйл ажиллагаа нь идэвхжиж иржээ.

МХХ нь хуульчийн мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, хуульчдын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах зорилго бүхий хуульчдын заавал гишүүнчлэлтэй, тэдний өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болохын хувьд чиг үүргийн хороодоор дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бэхжүүлж өгчээ. Гэвч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар бүх хуульчдад хариуцлага тооцох ёстой боловч зөвхөн өмгөөлөгчид хариуцлага тооцож байна. 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасны дагуу Ажлын хэсэг ажиллаж байна. Үүнтэй зэрэгцэн Өмгөөллийн тухай хуулийн төслийн ажлын хэсэг ажиллаж байна. Эдгээр хуулийн зохицуулалтаар практикт учирч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, хуульчид хариуцлага тооцох, тэдний ёс зүй, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх эрх зүйн үндсийг тусгаж өгөх нь зүйтэй.

2. Мэргэжлийн хариуцлагын хорооны Ажлын албаны бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай.

Мэргэжлийн хариуцлагын хороо маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын албатай. Ажлын алба нь дарга, сахилгын шинжээч, шалгагч, хуралдааны нарийн бичгийн дарга, бичиг хэрэг, архивын ажилтан болон бусад ажилтнаас бүрдэж байгаа нь хорооны чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүний нөөцийг бүрдүүлсэн гэж үзэж болно. Гэвч энэ нь хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг хангахгүй байгаа нь ажлын албаны ачааллаас харагдаж байна. Ажлын ачааллын тэнцвэрт байдлыг хадгалахын тулд хорооны зохион байгуулалт хийгээд чиг үүрэгт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж дүгнэхэд хүрлээ.

3. Хуульчидтай холбоотой гомдол, мэдээлэл, зөрчил, тэдэнд шийтгэл оногдуулсан талаарх бүртгэл, мэдээлэл, тайлан боловсронгуй бус байна.

Мэргэжлийн хариуцлагын хорооны үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн шаардлагатай мэдээлэл, тайлан боловсруулалт тогтмолжоогүй байгаа нь судалгааны багт хүндрэлтэй байсан бөгөөд үүнийгээ хүний нөөцийн дутагдалтай байдалтай холбон тайлбарлаж байв.

Ажлын байрны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоо бүрдээгүй, хорооны ажиллах журамд заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хүсэлт, мэдээлэл, өргөдлийг хүлээн авах, маргаан үүсгэх,

хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшин хангалтгүй байдлыг шалгах, нотлох, бүрэлдэхүүнээс маргааныг шийдвэрлэх ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажил үүргийн хуваарь тодорхойгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

4. Хуульчдад хаалттай сануулах хариуцлага тооцож буй нь үр нөлөөтэй байж чадахгүй байна. МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороо нийт хүлээн авсан 791 гомдол, мэдээллийн 317 буюу 40.1 хувийг маргаан үүсгэсэн боловч маргаан үүсгэсэн гомдол, мэдээллийн 232 буюу 73.2 хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Эдгээр 791 гомдол, мэдээллүүдийг шалгасны эцэст 43 нь хаалттай сануулж, 33 нь мэргэжлийн дүгнэлт үйлдэж, нийт 9.6 хувьд нь арга хэмжээ авчээ. Энэ нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд тооцож буй хариуцлагын арга хэмжээ үр нөлөө багатай байгааг илтгэж байна. Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар 52 хуульчдад хариуцлага оногдуулсан байгаагийн 12 буюу 24 хувь нь 2-3 удаа сахилгын шийтгэл хүлээсэн байна.
5. МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороо нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй нийт хуульчдын ёс зүйг дээшлүүлэх, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, нэр хүндийг нэмэгдүүлэх өргөн хүрээг хамарсан чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой боловч зөвхөн өмгөөлөгчдийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангуулж байгаа байдал ажиглагдав. Прокурор, шүүгчтэй холбогдуулан гаргасан гомдол, мэдээллийг Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын ёс зүйн зөвлөлд харьяаллын дагуу шилжүүлдэг байна.
Нийт хуульчдын 40 орчим хувь нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлсэн гомдол, мэдээллийн 80 орчим хувийн хариуцагч нь өмгөөлөгч байна.
6. Эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс Мэргэжлийн хариуцлагын хорооноос шалгаж буй гомдол, мэдээлэлд холбогдуулан нотлох баримт, бусад материал, лавлагаа, мэдээллийг холбогдох байгууллагуудаас хүсэхэд хууль сахиулах, прокурор, шүүхийн байгууллага хариу ирүүлдэггүй, хэргийн оролцогч биш гэсэн үндэслэлээр мэдээлэл лавлагаа өгөхөөс татгалздаг зэрэг хүндрэл учирдаг байна.
7. Иргэд Мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол гаргах тохиолдолд МХХ-ны Тамгын газраар дамжихгүйгээр шууд Мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол, мэдээллээ гаргадаг байх нь үйл ажиллагааны хувьд давхардал үүсэхгүй, иргэдэд үйлчилгээ үзүүлэх шат дамжлага багасах боломжтойг цаашид анхааран зохицуулж өгөх шаардлагатай.
8. Хуульчид гэмт хэрэгт холбогдож, тэдний хууль бус үйлдлийн талаар цагдаа, авлигатай тэмцэх газраас шалгах ажиллагаа явагддаг байна. Үүнд шүүгч, прокурортой хамаарал бүхий асуудал багагүй байдгийг холбогдох байгууллагаас авсан судалгааны ажилд тусгасан мэдээллээс харж болно. Харин прокурор, шүүгч гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд шүүхээр шийдвэрлэгдсэн асуудал

ховор, байсан ч шийдвэрлэхгүй удаадаг, гацаадаг хандлага практик байгааг Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн давхардал хийдлийг арилгах, хуулийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах зорилгоор Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль хамтран 2018 оны 3 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулсан “Эрүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаархи хэлэлцүүлэг”-г хэлэлцүүлсэн илтгэлүүдээс дэлгэрүүлэн танилцаж болно. Энэхүү судалгаанд энэ тухай тэмдэглэн оруулсан нь хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй өмгөөлөгч, прокурор, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ажлын уялдаа холбоо, ёс зүйн үнэлэмжийн асуудлыг хэрхэн хамтран дээшлүүлэх, төлөвшүүлэх зэрэг үр нөлөөтэй ажлыг жишиг болгон хэрэгжүүлэх нийгэм дэх хуульч мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх олон талын ач холбогдол бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага буйг илэрхийлж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгаж өгөх;
2. МХХ нь гишүүдийнхээ дэмжлэгээр тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага учраас нийт хуульчдын ёс зүй, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг байхаар чиг үүргийг тодорхой болгох;
3. МХХ-ны одоогийн Ёс зүйн хорооны чиг үүргийг Мэргэжлийн хариуцлагын хороонд шилжүүлэх;
4. Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын ёс зүйн зөвлөлд Мэргэжлийн хариуцлагын хорооны нэгээс доошгүй гишүүн байхаар хуульчлах;
5. Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын ёс зүйн зөвлөлөөс тухайн салбарынхаа хуульчдад Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хариуцлага тооцсон тохиолдолд ажлын 5 хоногийн дотор МХХ-ын Мэргэжлийн хариуцлагын хороонд хүргүүлж, тус хороо олон нийтэд хүргэх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, хуульчдын нэр хүндийг өсгөхөд чиглэсэн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бий болгох;
6. Мэргэжлийн хариуцлагын хороо нь хуульчдын ёс зүй, мэргэжлийн мэдлэг, ур чадварын байдалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргадаг байх зохицуулалтыг хуульчлах;
7. Хуулийн салбарт сайн засаглал тогтоох, шударга ёсыг төлөвшүүлэх, хуульчдын нэр хүндийг дээшлүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилгоор хуульчид дундаас шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүгч, прокурорын ёс зүй, хууль бус үйлдэл, шүүх эрх мэдлийн салбар дахь авлига, хүнд суртлыг гүнзгийрүүлэн судалж, шийдлийг боловсруулах;
8. Өмгөөлөгч, прокурор, шүүгчтэй холбоотой асуудлаар Хүний эрхийн Үндэсний комисст гаргасан гомдол, мэдээлэл, түүний мөрөөр хамтран ажиллах;
9. Мэргэжлийн хариуцлагын хорооны үндсэн чиг үүрэг нь хуульч “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа” эрхлэхдээ зөрчил гаргасан эсэхийг шалгаж шийдвэрлэх явдал. Ёс зүйн зөрчил гаргасан, мэргэжлийн алдаа, дутагдал гарсан байдлыг шийтгэл ногдуулж буй шийдвэртээ дурдаж, энэ талаар бүртгэл, судалгааг сайжруулах;
10. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1. “хаалттай болон нээлтэй сануулах” гэсэн хариуцлагын төрлийн “хаалттай сануулах” гэсэн хэсгийг хасах;

11. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил нь нийтийн болон хувь хүний эрх, ашиг сонирхолд хохирол учруулдаг, зөрчигдсөн эрхийг сэргээх нь хорооны үүрэг тул зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг сунгах^[11];
12. Хороо нь хуульчийн “мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргаан”-ыг хянан шийдвэрлэхээр хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 болон бусад зүйл хэсгүүдэд заасан. “Мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргаан” гэдгийг журмын 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1б-д “...хуульч бие махбодийн эсхүл сэтгэцийн байдлын улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх чадамжгүй болсны улмаас хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсэх маргааныг;” гэж тодорхойлсон. Өнгөрсөн хугацаанд энэ төрлийн маргаан үүсгэх тухай гомдол, мэдээлэл ирээгүй. Хүний бие, сэтгэцийн эрүүл эсэхийг эмч, эмнэлгийн байгууллага оношилж эмчлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоох хууль тогтоомж үйлчилж байхад хороо үүнд оролцох шаардлагагүй. Одоо үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд хорооны сахилгын шинжээчийн шийдвэрээр хүний бие болоод сэтгэц эрүүл эсэхэд шинжилгээ хийх тухай заалт байхгүй. Бие, сэтгэцийн өвчний улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүйг эрх бүхий байгууллага тогтоосныг үндэслэн МХХ зөвшөөрлийг түдгэлзүүлэхээр хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан зэргийг үндэслэн хуулийн 63.1 болон бусад зүйл хэсэг дэх “мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн маргаан” гэсэн өгүүлбэрийг хасах;
13. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулаад МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам, Хорооны ажиллах журам, түүнчлэн Холбооны болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай ба Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албыг хүний нөөцөөр бэхжүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, техник хэрэгслээр хангах, үйл ажиллагааны шаардагдах зардлыг нэмэгдүүлэх;
Хуульчидтай холбоотой гомдол, мэдээллийн тусгай программ зохиож, нэвтрүүлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, шаардлагатай судалгаа, мэдээлэл, тайланг саадгүй гаргах боломжийг бүрдүүлэх;
14. МХХ-ны Мэргэжлийн хариуцлагын хорооноос шалгаж буй гомдол, мэдээлэлд хамаарах хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд гарч буй алдаа, дутагдал нь Хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах гэмт хэргийн шинжтэй байх аваас хуулийн холбогдох байгууллагад нэн даруй шилжүүлэх. Түүнчлэн, хуульч, тэр дундаа прокурор, шүүгч нар хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар

¹¹ Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, мөн хэсгийн 5.1.3, 5.1.5-д заасныг үндэслэн Хуульчдын холбоо нь захиргааны байгууллагад, гаргаж байгаа шийдвэр нь захиргааны актад тус тус хамаарна гэж ойлгосон бөгөөд үүнтэй уялдуулан Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх болон Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн шийтгэлгүйд тооцох хугацаануудыг жишиг болгон дурдсан хугацаануудыг хуульд оновчтойгоор тодорхойлох хэрэгтэй байна.

хэрэглэх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах, улмаар авлигын гэмт хэрэгт холбогдох, ашиг сонирхлын зөрчил гаргаж болзошгүй үйлдлийг Мэргэжлийн хариуцлагын хороо анхааралдаа авч, Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүгчээс гэмт хэрэгт холбогдсон асуудлыг шалгах эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах;

15. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.5.3.хуульч энэ хуулийг болон Хуульчдын холбооны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгаврыг зөрчсөнтэй холбоотой маргааныг Хуульчдын холбооны хүсэлтээр, 64 дүгээр зүйлийн 64.7.Энэ хуулийн 64.5.3-т заасан Хуульчдын холбооны хүсэлтийг зохих хороод гаргах бөгөөд хорооноос бусад Хуульчдын холбооны бүтэц гомдол гаргах бол Тамгын газар түүнийг төлөөлнө гэснийг хасаж, Мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол, мэдээллээ шууд гаргах эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Үндсэн хууль. 1992 он
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2016 он
3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012 он
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
5. Хуульчийн эрх зүйн байдлын тухай болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоол
6. Хуульчдын холбооны дүрэм. 2013 он
7. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. 2012 он
8. МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам. 2014 он
9. МХХ-ны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам. 2014 он
10. МХХ-ны 2014-2017 оны үйл ажиллагааны тайлан
11. МХХ-ын Мэргэжлийн хариуцлагын хорооны 2014-2017 оны үйл ажиллагааны тайлан
12. Нээлттэй нийгэм форум “Шүүх хуралдааны ажиглалт” судалгааны тайлан 2017 он
13. <https://huulichmn.blogspot.com/2018/02/3.html>
14. Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль хамтран 03 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулсан “Эрүүгийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаархи хэлэлцүүлэг”-т хэлэлцүүлсэн илтгэл, түүнээс гарсан санал, зөвлөмж